



Нээлттэй
Нийгэм
Форум



МУИС-ийн
Эдийн Засгийн
Сургууль

Монгол Улсын Эдийн засгийн эрх чөлөөний тойм - 2007

Монгол Улсын зах зээлийн өрсөлдөөний
өнөөгийн байдал, үр нөлөө, цаашдын төлөв

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ч.ХАШЧУЛУУН	МУИС-ийн ЭЗС-ийн захирал, доктор
Х.ЦЭВЭЛМАА	МУИС-ийн ЭЗС, доктор
Б.ЭНХЦЭЦЭГ	МУИС-ийн ЭЗС, доктор
М.УЯНГА	МУИС-ийн ХЗС, докторант
Т.ОЮУНБААТАР	МУИС-ийн ЭЗС, магистр
Д.БЯМБАСҮРЭН	МУ-ын Ерөнхий сайд асан, профессор
Б.МӨНХСОЁЛ	ННФ-ын Эдийн засгийн асуудал хариуцсан менежер

Улаанбаатар, 2007 он

DDC
338,9'517
M-692

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-48, Монгол Улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>

Уг судалгаанд хийсэн дүгнэлт, гаргасан саналууд нь зөвхөн судалгааны багийн дүгнэлт, үзэл бодлыг илэрхийлнэ.

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл ННФ-ын хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Тайланг сонирхсон байгууллага, хувь хүмүүст номын арын хавтсан дээр бичсэн хямдралтай үнээр борлуулна.

ISBN 978-99929-0-429-1

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

ГАРЧИГ

<i>Хүснэгтийн жагсаалт</i>	5	3.3. Газрын тосны бүтээгдэхүүний зах зээл	69
<i>Зургийн жагсаалт</i>	6	3.4. Мах, махан бүтээгдэхүүний зах зээл	73
<i>Хураангуй</i>	7	3.5. Ноолуурын зах зээл	78
ОРШИЛ		3.6. Нийтийн тээврийн зах зээл	82
2007 оны эдийн засгийн эрх чөлөөний тойм судалгааны зорилго	12	3.7. Үүрэн холбооны зах зээл	86
Эдийн засгийн эрх чөлөөний 2007 оны тоймын бүтэц	14	3.8. Салбаруудын төвлөрөл	90
1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ 2006 ОНД		3.9. Түүвэр судалгааны гол үр дүн	91
1.1. Фрейзер Институтын эдийн засгийн эрх чөлөөний индекс	16	4. ТЕНДЭР, ГАЗАР, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨРСӨЛДӨӨН	
1.2. Херитэж сангийн эдийн засгийн эрх чөлөөний индекс	19	4.1. Газрын зах зээл	101
1.3. Монгол улсын засаглалын чанар	21	4.2. Уул уурхайн салбарын өрсөлдөөн	108
1.4. Монгол улсын эдийн засгийн өнөөгийн байдлын тойм	24	4.3. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн тухай	111
2. ЗАХ ЗЭЭЛИЙН ӨРСӨЛДӨӨН БА ЗОХИЦУУЛАЛТ		5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	
2.1. Эдийн засгийн эрх чөлөө, засаглал ба өрсөлдөөн	29	5.1. Дүгнэлт	120
2.2. Өрсөлдөөний бүтэц ба шударга бус өрсөлдөөн	31	5.2. Бодлогын зөвлөмж	123
2.3. Өрсөлдөөний зохицуулалт, дэлхийн туршлага	38	АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ 129	
2.4. Монголын зах зээлийн өрсөлдөөн, зохицуулалтын хөгжил	53	ХАВСРАЛТУУД	
3. САЛБАРУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ СУДАЛГАА		1. Хавсралт: Зах зээлийн төвлөрөл ба бүтцийн зохицуулалтын индексүүд	133
3.1. Судалгааны аргачлал	65	2. Хавсралт: Түүвэр судалгааны үр дүнгийн хүснэгтүүд	137
3.2. Монополь салбар дахь өрсөлдөөн: цахилгаан, дулаан	66	3. Хавсралт: Тайлангийн хэлэлцүүлгийн тэмдэглэл	169

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.1: Монгол улсын засаглалын чанар, 1996-2006	18	Хүснэгт 3.9: Ноолууран бүтээгдэхүүний экспорт, 1996-2006	69
Хүснэгт 1.2: Хүнсний хэрэглээний хувь, хүнсний импорт, 1995-2006	22	Хүснэгт 3.10:Ноос, ноолуур угаах, самнах үйлдвэрлэлийн хүчин чадал, тн 2000, 2005	71
Хүснэгт 3.1: Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, 2003-2006	57	Хүснэгт 3.11:Улаанбаатар хотын нийтийн тээврийн салбар дахь аж ахуйн нэгж, тээврийн хэрэгслийн тоо, чиглэлээр, 2005	72
Хүснэгт 3.2: Цахилгаан эрчим хүчний салбарын аж ахуйн нэгжүүд	57	Хүснэгт 3.12:Нийтийн тээврийн салбарын эдийн засгийн үзүүлэлт	73
Хүснэгт 3.3: Монгол улсын хэмжээнд импортлосон газрын тосны бүтээгдэхүүн, 2005.	60	Хүснэгт 3.13:Автобус ба такси үйлчилгээний зах зээлийн төвлөрөл	73
Хүснэгт 3.4: Монгол улсын хэмжээнд импортлосон газрын тосны бүтээгдэхүүн, 2005 /компаниар	61	Хүснэгт 3.14:Судалгаанд сонгогдсон салбаруудын зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөн, үнэ	79
Хүснэгт 3.5: Хүнсэнд хэрэглэсэн малын тоо, малын төрлөөр, мян.тол, 1990-2006	64	Хүснэгт 3.15:Өрсөлдөгчөөс хүлээж болох хамгийн гол гурван эрсдэл, салбараар	83
Хүснэгт 3.6: Мах үйлдвэрлэлт, экспортлосон мах, мян.тн, 1990-2006	64	Хүснэгт 4.1: Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн үйлдвэрлэл, 2000-2006	95
Хүснэгт 3.7: Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тн, 2005	65	Хүснэгт 4.2: Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт ба шинээр олгогдсон лицензийн тоо, 1997-2004	97
Хүснэгт 3.8: Ямаан сүргийн тоо ба бэлтгэсэн ноолуур, 1999-2005	68		

ЗУРАГ

Зураг 3.1:	А-76 шатахууны үнэ болон ХҮИ-ийн түвшин, 1996-2006	62	Зураг 3.7:	Судалгаанд хамрагдсан өрх/ өрхийн гишүүдийн ихэвчлэн зорчдог нийтийн тээврийн хэрэгсэл	74
Зураг 3.2:	А-76 шатахууны үнэ болон хэрэглээний сагсны үнийн өсөлтийн хувь, 1996-2006	62	Зураг 3.8:	Үүрэн холбооны зах зээлийн хэрэглэгчид	75
Зураг 3.3:	Махны үнэ болон ХҮИ, хүнсний барааны үнийн түвшин, 1991-2006	66	Зураг 3.9:	Үүрэн холбооны зах зээлийн үнийн тариф, суурь хураамжийн динамик, 1996-2007	76
Зураг 3.4:	Мах болон ХҮИ, хүнсний барааны өсөлтийн хувь, 1996-2006	66	Зураг 4.1:	Уул уурхай, олборлох үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувь, 2003-2006	95
Зураг 3.5:	Мах, махан бүтээгдэхүүн чанарын шаардлага хангаж чадахгүй байгаа шалтгаан	67	Зураг 4.2:	Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь, 1991-2008	100
Зураг 3.6:	Ноолуурын үнийн динамик, 2000-2006	70			

ХУРААНГУЙ

1990 оноос хойш Монгол улсад зах зээлийн өрсөлдөөний өөр орчин бий болж эхэллээ. Зах зээлийн эдийн засагт шилжээд 17 жил болоход Монголын нүүдлийн соёл иргэншлийг зах зээлийн тогтолцооны суурин соёл иргэншилтэй хослуулан хөгжүүлэх, улмаар зах зээлийн өрсөлдөөний өөрийн онцлог хэлбэрийг төлөвшүүлэх үе ирлээ гэж үзэж болох юм. Манай улс нийгэм, эдийн засгийн нөхцөлдөө тохирсон, зах зээлийн зохицуулалтын дэлхийн тэргүүний туршлагыг агуулсан зах зээлийн тогтолцоотой байх шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын зах зээлийн зарим салбарын өрсөлдөөн шударга бус шинжтэй болж, зах зээлд бараа, бүтээгдэхүүний үнэ зохиомлоор хэт өндөр түвшинд хадгалагдах, зарим барааны үнэ шалтгаангүй өсөх, тендэрт хамгийн өндөр чанартай, хямд үнэтэй нийлүүлэгч бус, танил талын, авилгын, эсвэл нууц тохиролцооны аргаар илүү өндөр үнэтэй, муу чанартай бараа бүтээгдэхүүн нийлүүлэгдэх зэрэг зах зээлийн гажуудал үүсэж, улмаар аж ахуй эрхлэгчид болон хэрэглэгчид ихээр хохирох боллоо. Иймд шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх, хуулийг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг сайжруулах асуудал зүй ёсоор нийгэм, эдийн засгийн хамгийн хүнд, тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа энэ үед уг судалгаа хийгдсэн нь цаг үеэ олсон ажил боллоо.

Монгол улсын эдийн засгийн эрх чөлөө 2006 онд

“Дэлхийн эдийн засгийн эрх чөлөө 2007” тайланд Монгол улс өмнөх онтой харьцуулахад эдийн засгийн эрх чөлөөний индекс 6.2-оос 7.1 болж, дэлхийд 44-р байранд оржээ. Монгол улсын үнэлгээг Херитеж сангийн индексийн шинэ аргачлалаар тооцоход 2007 оны нийт үзүүлэлтээр Монгол улс дэлхийд 78-р байранд, Ази тивдээ 30 орноос 11-т орсон.

2006 онд нийт бизнесийн орчны үзүүлэлтээр Монгол улс дэлхийд нилээд дээгүүр буюу 45-р байранд орж чадсан. Харин 2007 онд нийтлэгдсэн судалгааны дүнгээс Монгол улс Ази Номхон далайн орнуудын дотор 8-р байранд, харин дэлхийд 52-р байранд орж, долоон байраар ухарсан.

Монгол улсын хувьд дэлхийн дунджаас ихээхэн доогуур байгаа үзүүлэлтүүд нь нэг хүнд ногдох орлоготой харьцуулсан компани (бизнесийг) байгуулахад шаардлагатай хөрөнгийн хэмжээ (дэлхийд 62-р байр), хил дамжин худалдаа хийх (168-р байр), татвар төлөх (90-р байр), өмчийг бүртгүүлэх (64-р байр) гэх зэрэг юм. Дэлхийн хөгжлийн түвшнээс хоцорч байгаа дээр дурдсан асуудлуудад түлхүү анхаарал тавих шаардлагатай байна.

Зах зээлийн өрсөлдөөн ба зохицуулалт

Монгол улс жижиг нээлттэй эдийн засагтай бөгөөд өөрийн гэсэн өрсөлдөөний онцлог шинж чанаруудтай. Социализмын үед Монголд бүх бараа, үйлчилгээний үнийг төрөөс хатуу хянаж, үнэн хэрэг дээр бараг бүхий л салбарт улсын өмчийн монополиуд оршиж, Монгол улсад өрсөлдөөн огт байгаагүй гэж хэлэхэд хилсдэхгүй.

Зах зээлийн хомсдол ихээхэн хүчтэй болсон үед “ганзагын” гэх наймааны үе эхэлж, урьд нь төвлөрсөн байдлаар гадаадаас хангадаг байсан барааг наймаачид гадаадаас нийлүүлж эхэлсэн. Үүний зэрэгцээ тохиролцооны олон дэлгүүр нээгдэж, зах зээлийн өрсөлдөөн илэрч эхэлсэн. Энэ үеэс эхлэн Монгол улсад хувийн сектор бүрэлдэн тогтож, бизнесийн янз бүрийн чиглэлүүд хөгжиж эхэлсэн. Үйлдвэрлэлийн салбараас худалдаа, үйлчилгээний газрууд илүү хурдацтай хөгжиж, хүнс ба хөнгөн үйлдвэрийн салбарт жижиг болон дунд үйлдвэр эрхлэгчдийн тоо нэмэгдэн, яваандаа үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, тэдгээрт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх асуудал чухал болсон.

Монголд бий болж буй зах зээлийн өрсөлдөөн зарим салбарт шинэчлэлт, өөрчлөлтийг дэмжсэн боловч зарим салбарт компаниуд үгсэж хуйвалдах, тухайн зах зээлд борлуулах бүтээгдэхүүний үнийг тохиролцоо явдал далд байдлаар бэхжиж эхэлсэн. Ийм нөхцөлд өрсөлдөөнийг оновчтойгоор зохицуулах, шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх хууль эрх зүйн болон зохион байгуулалтын үйл ажиллагаа улам ихээр шаардагдаж ирлээ.

Эрх зүйн шинэчлэлийн ажил нь 1992 онд Үндсэн хуулийг баталснаар эхэлсэн. 1993 онд “Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах

тухай” хууль, “Дампуурлын тухай” хууль тус тус батлагдаж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн. 1993 онд анх удаа Монголын түүхэнд шударга өрсөлдөөний талаар бие даасан хуулийг баталсан бөгөөд гол зорилго нь шударга бус өрсөлдөөнийг хориглох явдал байв. Уг хуульд 1995, 2000, 2005 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон.

Зах зээлийн шударга өрсөлдөөнд хууль эрх зүйн зохицуулалт хийхдээ орчны өөрчлөлтийг соргог мэдэрдэг байх нь маш чухал. Хувийн секторт ажиглагдаж буй үгсэн хуйвалдах, буруу зар мэдээлэл явуулах, давамгайл байдлаа урвуулан ашиглах, хэрэглэгчийн эрх ашгийг зөрчиж буй үйл явцыг эдийн засгийн арга хэрэглэн таслан зогсоох эрхийг хууль ёсны байгууллагад өгвөл хариуцлагын тухай хууль, гэм хорын эрх зүйн зохицуулалт бодит утгаараа хэрэгжих болно. Зах зээлийн өрсөлдөөнд компаниудын зах зээлд эзлэх хувь, компанийн төвлөрлийг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлсэн. Мөн өрсөлдөөний зөв бодлого, өрсөлдөөний зөв стратеги зайлшгүй чухал болж байна. Өрсөлдөөний бодлогыг аж үйлдвэрийн бодлоготой зөв хослуулах шаардлага гарч ирлээ.

Зах зээлийн өрсөлдөөний өнөөгийн байдал

Судалгаанд зах зээл дээр хүчтэй монополь эрх мэдэл бүхий буюу хуулийн хэллэгээр зүй ёсны монополиуд болох цахилгаан, дулааны салбар; төгс бус өрсөлдөөнтэй салбарууд болох газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүн, үүрэн холбоо, мах, ноолуур, нийтийн тээврийн салбар; шударга бус өрсөлдөөн гүнзгийрч буй төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээг худалдан авч байгаа процесс (тендэрийн үйл ажиллагаа); төрийн зохицуулалт, лиценз, зөвшөөрөл

олгогддог уул уурхайн салбар, газрын зах зээлийг сонгосон.

Салбаруудын төвлөрлийг тооцоход ноос, ноолуурын зах зээлийн хувьд дунд зэргийн төвлөрөлтэй, бүтцийн хандлагын хувьд зах зээлийн өрсөлдөөн хязгаарлагдмал байгаа бол мах, махан бүтээгдэхүүний салбар өрсөлдөөнтэй, харин газрын тосны зах зээл хамгийн өндөр төвлөрөлтэй, өрсөлдөөнгүй салбар байна. Судалгаанд сонгогдсон таван салбарын аж ахуйн нэгжүүдээс үүрэн холбооны зах зээл хамгийн өрсөлдөөнтэй, газрын тосны импортын зах зээл, ноолуур, мах, махан бүтээгдэхүүний зах зээл дунд зэрэг өрсөлдөөнтэй, нийтийн тээврийн зах зээлийг өрсөлдөөнгүй гэв. Эдгээр салбаруудаас сүүлийн таван жилд үүрэн холбооны зах зээлийн өрсөлдөөн хамгийн ихээр нэмэгджээ.

Өрсөлдөөний илрэл: Зах зээлийн өрсөлдөөн үнэ, борлуулалтын хэмжээ, зах зээлийн хүрээ, чанар, үйлчилгээ зэрэг үзүүлэлтүүдээр илэрч байна. Ялангуяа үүрэн холбоо, газрын тосны импортын зах зээл дээр үнээр өрсөлдөх явдал хамгийн түгээмэл байгаа бол мах, махан бүтээгдэхүүний зах зээл дээр үнэ, борлуулалтын хэмжээ, чанар; харин ноолуурын зах зээл дээр зах зээлийн хүрээ, үнэ, борлуулалт, үйлдвэрлэлийн хүчин чадлаар өрсөлдөөн илэрч байна. Нийтийн тээврийн салбарт өрсөлдөөн илрэх хэлбэрт үнэ, борлуулалт, зах зээлийн хүрээ, патент, лиценз эзэмших эрх, хүчин чадал, чанар, үйлчилгээ зэргийг нэрлэж болно.

Зах зээлд нэвтрэх бэрхшээл: Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн талаас илүүд нь тухайн зах зээлд анх нэвтрэн ороход ямар нэгэн бэрхшээл тохиолдсон байна. Хамгийн гол бэрхшээлүүд нь хөрөнгө санхүү, дүрэм, журам, зохицуулалт, ажиллах хүч, бүртгэлийн асуудал байна. Түүнчлэн аж

ахуйн нэгжийн ихэнх тухайн компанийн эрхэлж буй үйл ажиллагааны зах зээл дээр шинэ компани нэвтрэн ороход ямар нэгэн бэрхшээл бий гээд зардал өндөр, ажиллах хүч дутмаг, бусад компанийн зүгээс үзүүлэх дарамт, зохицуулалт их, зах зээлийн багтаамж бага, хэрэглэгчдийг татах хэцүү гэсэн бэрхшээлүүдийг дурьджээ.

Өрсөлдөөний аргууд: Нийт салбарын хувьд демпинг¹, технологийн шинэчлэл, далд сүлжээ, зар сурталчилгаа явуулах, бүтээмжийн өсөлт, үнэ бууруулах, мэргэжилтэн, ажилтныг урвуулах, урамшуулал, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх зэрэг эрсдэлүүдийг аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөгчөөсөө хүлээж болох эрсдэлүүдгэж хэлж болохоор байна. Мөн өрсөлдөөн ихтэй, зах зээлийн багтаамж муу, хууль эрх зүйн орчин муу, санхүүгийн чадавхи муу, мэргэжилтэн хангалтгүй зэрэг нь зах зээл дээр оршин тогтнож, үйл ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс болж байна.

Өрсөлдөөний давуу талууд: Зах зээл дээр өрсөлдөөн нэмэгдсэнээр чанар сайжирна, үнэ буурна, бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэнэ, компанийн нэр хүнд өснө, барааны стандарт сайжирна, үйлчилгээ сайжирна гэсэн эерэг үр дагаврууд гарна гэдгийг аж ахуйн нэгжүүд тодорхойлсон.

Өрсөлдөөний стратеги: Зах зээлийн өрсөлдөөнд баримталдаг стратеги салбараар нилээд ялгаатай байна. Үүрэн холбоо, газрын тосны импортын аж ахуйн нэгжүүд хоорондоо төстэй буюу үйлчилгээгээрээ ялгарах, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, үнийн бодлогоор өрсөлддөг бол мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, үйлчилгээгээрээ ялгарах,

¹ Өөрийн өртгөөс хэт доогуур үнээр бүтээгдэхүүнээ борлуулж, өрсөлдөгч нарыг шахан зайлуулах, дампууруулах арга

үнийн бодлогоор өрсөлддөг. Ноолуурын зах зээл бусдаас арай өөр буюу бүтээгдэхүүний чанарыг чухалчилдаг. Харин нийтийн тээврийн аж ахуйн нэгжүүд үйлчилгээгээр ялгарах, нийлүүлэгчид/хэрэглэгчдээ татах, чанарыг сайжруулах, компани бие даан өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх стратегийг баримталж байна.

Шударга бус өрсөлдөөний талаар:

Аж ахуйн нэгжүүдийн талаас илүү нь зах зээл дээр шударга бусаар өрсөлдөх явдал гардаг гэжээ. Шударга бус өрсөлдөөн нь үүрэн холбооны зах зээл дээр зар сурталчилгаа, зах зээлийн хил хязгаарын хуйвалдаан, хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүргэх замаар илэрдэг бол газрын тосны импортын зах зээлийн өрсөлдөөн үнийн хуйвалдаан, эрх мэдэлтний шийдвэрээр илэрдэг. Мах, махан бүтээгдэхүүний зах зээл дээр стандартын бус бүтээгдэхүүн, үйлчилгээгээр, ноолуурын зах зээл дээр түүхий эдийн зах зээлийн үнийн хуйвалдаанаар илэрдэг.

Сонирхолтой нь, судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн 44 хувь бусад компанитай тохиролцоо хийдэг гэжээ. Газрын тосны импорт болон ноолуурын зах зээл дээр тохиролцоо хийдэг гэж хариулсан хувь хамгийн өндөр байна. Тэд үнэ, бүтээгдэхүүний чанар, үйлчилгээ, зах зээлийн хувь, бараа бүтээгдэхүүний чанар зэрэгт тохиролцоонууд хийдэг.

Шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх нь:

Тухайн зах зээл дээр шударга бусаар өрсөлдөх явдал гардаг гэсэн аж ахуйн нэгжүүдийн тал орчим хувь нь шударга бус өрсөлдөөн гарсан тохиолдолд салбарын зохицуулах газарт хандана гэсэн бол гуравны нэг орчим хэнд ч ханддаггүй/мэдэхгүй гэжээ. Мөн тодорхой хэсэг нь ШБӨХЗГ, шүүх цагдаад хандана гэсэн байна. Шударга бус өрсөлдөөн бий болохоос сэргийлэхийн тулд хууль, эрх зүйн

зохицуулалт сайн байх, хуулийн хэрэгжилт сайн байх, компани өөрөө бие даасан, чадвартай байх, бодлогын зохицуулалттай байх, төрийн оролцоогүй байх, бизнес улс төрөөс ангид байх хэрэгтэй гэжээ.

Бараа бүтээгдэхүүний стандартууд:

Аж ахуйн нэгжүүдийн үндэсний стандартыг дагаж мөрдөж буй хувь олон улсын стандартыг дагаж мөрдөж байгаагаас арай илүү, гэхдээ аль аль стандартыг дагаж мөрдөж байгаа хувь хангалттай түвшинд байхгүй байна гэж хэлэхээр байна. Салбараар тийм ч их ялгаа байхгүй хэдий ч үүрэн холбооны зах зээлийн олон улсын болон үндэсний бараа бүтээгдэхүүний стандартыг дагаж мөрдөж байгаа хувь хамгийн өндөр, харин нийтийн тээврийн салбарынх хамгийн бага байна.

Зардал ба үнэ:

Нэгжийн дундаж зардал, өрсөлдөгчийн үнэ тогтоолт, хэрэглэгчийн худалдан авах чадвар, засгийн газрын зохицуулалт, нефть, шатахууны үнийг үйлдвэрлэлийн нэгжийн зардлыг тогтооход нөлөөлдөг хүчин зүйлс гэж тодорхойлсон ба судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тал орчим хувь өрсөлдөгч компани бүтээгдэхүүнийхээ нэгжийн үнийг бууруулбал үнээ дагаж бууруулна гэжээ.

Өрсөлдөөн нэмэгдэхгүй гэж үзэж байгаа шалтгаан:

Хуулийн зүйл ангиудын уялдаа холбоо муу байгаа нь монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдал эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн өөрчлөлттэй уялдаж чадахгүй байгаагийн гол шалтгаан гэж үзэж байна. Түүнчлэн тогтсон ёс заншил зах зээлийн өөрчлөлтийг даган өөрчлөгдөж чадахгүй байгаа, дүрэм журам зохицуулалт муу байгаа зэрэг нь бас нэг гол шалтгаан гэж хэлж болохоор байна. Монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдлыг сайжруулахын тулд хуулийг сайн хэрэгжүүлэх, хяналтыг

сайжруулах, хуулиа засаж сайжруулах, хуулиа дээдлэх, ухамсар, хариуцлагыг өндөржүүлэх, бизнес улс төрөөс ангид байх хэрэгтэй гэж үзэж аж ахуйн нэгжүүд үзэж байна.

Тендэр, уул уурхайн салбар, газрын өрсөлдөөн: Нийгмийн бүхимдлыг бий болгосон өөр томоохон асуудлууд бол уул уурхайн салбар, газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлүүд юм. Өнөө үед Монголын төр улсын хамгийн том худалдан авагч болсонтой холбогдуулан төрийн худалдан авалт манайх шиг жижиг зах зээлд олон талын нөлөө үзүүлж байгаа юм.

Газар, уул уурхайн салбарын зах зээлийн эрэлт, нийлүүлэлт нь үнээр зохицуулагдах бус, “хамгийн түрүүнд” лиценз хүсэж, материал бүрдүүлсэнд нь олгох зарчмаар явагдсан нь шударга өрсөлдөөн явагдаагүй гэж дүгнэхэд хүргэж байгаа юм. Энэ утгаараа газар, уул уурхайн салбарт анхнаасаа шударга өрсөлдөөний аргаар бус, захиргааны аргаар хуваарилах зарчим зонхилж, гажуу зах зээл үүсч, дамлан худалдах явдал, авилга, лицензийн хууль бус наймаа газар авчээ. Энэ нь эргээд Монгол улсад их хохирол учруулж байна.

Хэдийгээр 1990-ээд оноос хойш Монгол улс дэлхийн жишигт нийцүүлэн нээлттэй эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх, шударга өрсөлдөөнийг хангах зорилтыг тавьж, эрх зүйн таатай орчинг тодорхой хэмжээгээр бүрдүүлсэн гэж үздэг ч бодит байдал дээр шударга өрсөлдөөний нөхцөл бүрэн хангагдаагүй байна гэж дүгнэж болно.

Шударга өрсөлдөөний нөхцлийг үр дүнтэйгээр бүрдүүлэхэд нэн түрүүнд эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай. Шударга өрсөлдөөний талаар хууль тогтоомжийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд шударга өрсөлдөөний тухай хуульд бусад хуулийг нийцүүлэх, нөгөө талаасаа тэдгээрийн хоорондын уялдааг хангах, институцийн хувьд зохион байгуулалттай байх байдлыг нь хангах ёстой. Энэ нөхцөлд компанийн тухай хууль, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, татварын тухай хуулиуд, тендэртэй холбоотой хуулиуд, зар сурталчилгааны тухай хууль, стандартчиллын тухай хуулийг шударга өрсөлдөөний хуультай нийцүүлэх шаардлагатай байна.

ОРШИЛ

2006 оноос эхлэн Нээлттэй Нийгэм Форум ба МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн хамтарсан судалгааны баг Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм тайланг гаргахаар болсон.

Тус тойм олон нийтэд өнөөгийн эдийн засгийн байдлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй тооцоо судалгааг толилуулах, үнэн зөв мэдээлэл, бодит баримтад тулгуурлан бодлого боловсруулагчдад санал зөвлөмж гаргаж өгөх зорилготой ажлуудын нэг юм.

Энэ жилийн судалгааны багийн зөвлөхөөр Монгол улсын Ерөнхий сайд асан, профессор Д.Бямбасүрэн, судалгааны багийн гишүүдээр ННФ-ын талаас эдийн засгийн бодлогын асуудал хариуцсан менежер, бизнесийн удирдлагын ухааны магистр Б.Мөнхсоёл, МУИС-ийн ХЗС-ийн багш, хууль зүйн ухааны магистр, докторант М.Уянга, МУИС-ийн ЭЗС-ийн талаас эдийн засгийн ухааны докторууд Х.Цэвэлмаа, Б.Энхцэцэг, Ч.Хашчулуун, магистр Т.Оюунбаатар нар ажиллалаа.

Баримт, тоо мэдээ олж өгөх, аргачлал боловсруулах болон бусад талаас Монгол улсын “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар”-ын удирдлага, ажиллагсад, Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн газар туслалцаа үзүүлэн хамтран ажилласан ба түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалтын ажилд МУИС-ийн ЭЗС-ийн төгсөх ангийн оюутнууд оролцсон.

Түүнчлэн тус судалгааны сэдэв, хүрээг тодорхойлоход Нээлттэй Нийгэм Форумтай хамтран ажилладаг эдийн засагч, судлаачид, эрдэмтэд болон төр засгийн төлөөлөгч нар оролцож, үнэтэй санал, зөвлөмж өгсөн.

2007 оны эдийн засгийн эрх чөлөөний тойм судалгааны зорилго

Эдийн засгийн эрх чөлөөний тоймын сэдвийг тухайн үед Монгол улсын эдийн засагт хамгийн их анхаарал татаж буй, мөн эдийн засгийн өсөлтөд хамгийн их саад бэрхшээл учруулж буй асуудлыг судалсны үндсэн дээр сонгодог бөгөөд тайланд энэ чиглэлээр хийсэн судалгаа, шинжилгээ, дүгнэлт, бодлогын зөвлөмжийг оруулдаг.

Сүүлийн үед Монголын зах зээлийн зарим салбарт өрсөлдөөн шударга бус шинжтэй болж, улмаар аж ахуй эрхлэгчид болон хэрэглэгчид хохирч байгаа асуудлууд хурцаар тавигдах боллоо.

Монголын зах зээлд олон бараа, бүтээгдэхүүний үнэ зохиомлоор хэт өндөр түвшинд хадгалагдаж, зарим барааны үнэ шалтгаангүй байнга өсч, тендэрт хамгийн өндөр чанартай, хямд үнэтэй нийлүүлэгч бус, танил талын, авилгын эсвэл нууц тохиролцооны аргаар илүү өндөр үнэтэй, муу чанартай бараа бүтээгдэхүүн нийлүүлэгдэж, татвар төлөгчид, хэрэглэгчид олноор илт хохирч байгаа явдал газар авч байна.

Шударга бус өрсөлдөөний асуудал ийнхүү сүүлийн жилүүдэд эрс хурцадсан нь хэд хэдэн шалтгаантай.

Нэгдүгээрт, 1990-ээд оноос эхлэн авч хэрэгжүүлсэн эдийн засгийг либералчилах, шударга өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих бодлого тууштай хэрэгжихээ больсон. Жишээ нь, үүрэн холбооны салбарт аль нэг компанийн давамгайл байдал, түүний хэт их ашгийг хамгаалсан байдал үүсч, үүнийг төрийн зохицуулалтаар болиулахын оронд бүр тусгай гэрээгээр өөгшүүлж байсан.

Хоёрдугаарт, эдийн засгийн олон чухал салбарт улсын үйлдвэр, компаниуд хувьчлагдаж, зах зээлийн шилжилт явагдсан ч өрсөлдөөн бий болгохгүйгээр монополь эрхийг хэвээр үлдээсэн. Эдгээр салбаруудад цахилгаан холбоо, нефть, газрын тосны салбар зэргийг нэрлэж болно.

Гуравдугаарт, 1990 оны дундаас эхлэн зарим салбарт үүсч, хурдацтай өссөн дотоодын цөөн тооны томоохон компаниуд зах зээлд илт давамгайлж эхлэн, төрөл бүрийн шударга бус өрсөлдөөний аргуудыг ашиглан жижиг өрсөлдөгч нарыг зах зээлээс шахан гаргах, боймлох алхмуудыг хийж эхэлснийг төрөөс ямар нэгэн аргаар зохицуулаагүй, шударга бус өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлэхгүйгээр орхисон. Энэ нь эргээд Монгол улсын олон салбарт хуйвалдааны шинжтэй томоохон компаниудын олигополь, картелийн тохиролцоо үүсэх шалтгаан болсон.

Дөрөвдүгээрт, макро эдийн засгийн байдал сайжирч, төсвийн орлого, зарлагын аль аль нь өсч байгаа өнөө үед төсвийн зарлага дотоодын нийт бүтээгдэхүүний 47%-тай тэнцэх болж, төр манай улсын зах зээлийн хамгийн том худалдан авагч болж хувирсан. Уг нь зах зээлийн эдийн засгийн жам ёсоор төрийн оролцоо аажмаар буурах ёстой атал

Монгол улсад төр төсвийн хөрөнгөөр бараа, бүтээгдэхүүнийг худалдан авдаг томоохон зах зээл болж хувирсан нь өөрийн компанийн барааг худалдах, тендэрийн мөнгийг өрсөлдөөнгүй авах явдлыг өөгшүүлсэн. Ийнхүү төсвийн зарлага ихээхэн өссөнтэй холбогдуулан тендэрийн хуулийн дагуу шударгаар өрсөлдөх ёстой компаниуд улс төрийн аргаар аль нэг төрийн яам, агентлагийг эрх мэдэлдээ оруулж, төсвийн хөрөнгө, барааг худалдан авахад зориулсан мөнгийг шударга бусаар хуваарилах, өөртөө авах байдал газар авчээ.

Монгол улсын төр, засаг улс төрчидтэй холбоотой компаниудыг тэжээдэг саалийн үнээ болон хувирч, улс төр шударга бус бизнесийн төлөөх тэмцэлдээний талбар болж ялзрах аюул тулгараад байна. Өнөөдөр улс төрчид улс орны хөгжлийн төлөө санаа тавихаас илүү сонгуулийн компанид мөнгө өгч, ивээн тэтгэсэн компанид хэрхэн улсын хөрөнгөөс шударга бус аргаар хөрөнгийг хуваарилж өгөх, улсын мэдлийн үйлдвэрийг өөрийн хяналтад оруулж, түүнээс өөрийн аж ахуйн нэгжид ашиг унагаах, төрийн агентлагуудыг өөрийн мэдлийн байгууллага болгож, бизнесийн салбар болгон хувиргасан тухай олон материал, мэдээлэл нийтлэгдэх боллоо.

Эдгээр зөрчлүүдийг олон нийтийн хэвлэл мэдээлэл, радио телевиз, хохирогч компаниуд, холбогдох төрийн агентлагуудын талаас ил зарлаж мэдэгдэж байхад одоо хүртэл тендэрийн хуулийн шударга бус хэрэгжилт, зөрчилтэй холбогдсон асуудлыг нэг ч удаа шүүхээр хэлэлцээгүй, харин ч эдгээр зөрчлүүдийн тухай ярьж байгаа сэтгүүлчдийг шүүхээр дамжуулан дарамталж байгаа зэрэг нь өнөөгийн Монголд зах зээлийн эдийн засгийн зарчмуудыг бүдүүлгээр илт мушгин зөрчиж байгаагийн илрэл болж байна.

Аж ахуй эрхлэгч болон хэрэглэгч, татвар төлөгч нарын ашиг сонирхол ноцтойгоор илт зөрчигдөж буй өнөө үед шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх, хуулийг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг сайжруулах асуудал зүй ёсоор нийгэм эдийн засгийн хамгийн хүнд, тулгамдсан асуудлуудын нэг боллоо.

Ийнхүү Монгол улсад өрсөлдөөн хэр зэрэг шударга явагдаж байгаа, түүнийг ямар хууль эрх зүйн актаар зохицуулж байгаа, мөн энэ байдлыг хэрхэн сайжруулж болох талаар судалгаа хийх шаардлагатай гэж үзээд 2007 оны тоймын гол сэдвээр эдийн засгийн эрх чөлөөний тулгуур ойлголт болох зах зээлийн өрсөлдөөнийг сонгосон.

2007 оны эдийн засгийн эрх чөлөөний тойм судалгааны гол зорилго нь:

- Эдийн засгийн эрх чөлөөний ач холбогдлыг харуулах;
- Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөний өөрчлөлт, өрсөлдөөний зохицуулалтыг бусад оронтой харьцуулан судлах;
- Монгол улсын зах зээлийн өрсөлдөөний өнөөгийн байдлыг судлах;
- Шударга өрсөлдөөний талаарх эрх зүйн зохицуулалт ба бодлогын зөвлөмжийг боловсруулж, танилцуулахад оршино.

Тойм судалгаагаа нэгдсэн онол, концепци, судалгааны үндэслэлтэй тайлан хэлбэрээр бэлтгэж, бодлого боловсруулагчид, эрдэмтэд судлаачид, олон улсын байгууллагууд болон олон нийтэд толилуулж байна.

Эдийн засгийн эрх чөлөөний 2007 оны тоймын бүтэц

2007 оны Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм тайлан дараах бүтэцтэй.

Нэгдүгээр бүлэгт эдийн засгийн эрх чөлөөний тухай үндсэн ойлголт, эдийн засгийн эрх чөлөөний индекс болон эдийн засгийн өнөөгийн үзүүлэлтүүдийг авч үзсэн. Монгол улсын 2006 оны эдийн засгийн эрх чөлөөний индексийг 2004, 2005 оны үзүүлэлттэй харьцуулж, өөрчлөлтийг судалсан. Эрх чөлөөний индексүүд, засаглалын индексүүдээр Монгол улсын институцийн хөгжлийг бусад оронтой харьцуулан дүгнэсэн.

Хоёрдугаар бүлэгт зах зээлийн өрсөлдөөн ба зохицуулалтын талаарх судалгааны үр дүнг багтаалаа. Мөн зах зээлийн өрсөлдөөнийг дэмжихийн ач холбогдол (онолын болон олон улсын практик, эрх зүйн орчин), Монгол улсын зах зээлийн өрсөлдөөний хөгжлийн тойм, өрсөлдөөний зохицуулалт болон олон улсын харьцуулсан судалгаа орсон.

Гуравдугаар бүлэгт Улаанбаатар хот болон зарим аймгуудад сонгосон салбаруудын өрсөлдөөн, зах зээлийн төвлөрлийн байдлыг судалсан түүвэр судалгааны үр дүнг толилууллаа.

Дөрөвдүгээр бүлэгт сүүлийн үед олны анхаарлыг татаж байгаа тендэрийн хуулийн хэрэгжилт, уул уурхай болон газрын зах зээл дэх шударга бус өрсөлдөөнтэй холбоотой асуудлыг авч судалсан.

Тавдугаар бүлэгт Монгол улсын зах зээлийн өрсөлдөөний өнөөгийн байдалд дүгнэлт өгч, эрх зүйн зохицуулалт болон өрсөлдөөний бодлогын талаар зөвлөмж боловсруулсан.

Хавсралтад түүвэр судалгааны үр дүн, өрсөлдөөнийг хэмждэг аргачлал болон энэхүү тайлангийн хэлэлцүүлгийн тэмдэглэл орсон болно.

БҮЛЭГ 1.

Монгол улсын Эдийн засгийн эрх чөлөө 2006 онд

Эдийн засгийн эрх чөлөө - зах зээлийн эдийн засгийн тулгуур ойлголт мөн. Эдийн засгийн эрх чөлөө *хувь хүний сонголтын эрх чөлөө, хувь хүмүүсийн солилцооны эрх чөлөө, өрсөлдөөний эрх чөлөө, хувь хүн болон түүний эд өмчийн эрхийн халдашгүй эрх чөлөө*г агуулдаг бөгөөд энэ эрх чөлөө ямар нэгэн байдлаар хязгаарлагдсан тохиолдолд эдийн засагт гажуудал үүсч, улмаар үр ашиггүй зардал, хэт өндөр үнэ, зах зээлд дангаар ноёрхох явдал зэрэг үзэгдлүүд үүсч, хэрэглэгчид болон үйлдвэрлэгчдэд ихээхэн хэмжээний хохирол үүсдэг.²

Эдийн засгийн эрх чөлөөг дээдэлсэн нийгэм хувь хүмүүсийн эд баялгийг хамгаалах, хүмүүст чөлөөтэй сонголт хийх, эд бараа, баялгийг чөлөөтэй солилцох боломжийг олгох, шинэ ажлын байруудыг бий болгох, хувийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, урамшуулах, хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэхэд анхаардаг. Түүний эсрэгээр эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах оролдлогууд эдийн засгийн үйл ажиллагаанд саад тотгор учруулж, өсөлтийг бууруулж, улмаар ядуурлыг бий болгож

байдгийг олон зуун жилийн дэлхийн түүх олон орны жишээн дээр баталсан.

Дээрх хязгаарлалтын улмаас хувийн хөрөнгө оруулалт багасах, эдийн засгийн өсөлтийн хувь буурах зэрэг сөрөг үр нөлөө бий болдог. Эдийн засгийн эрх чөлөө хангагдах нь зах зээлийн эдийн засгийн эрүүл өсөлт, хөгжлийн гол нөхцөл болдог. Тиймээс аль болохоор эдийн засгийн эрх чөлөөг хөгжүүлэх нь хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг бий болгох гол арга замуудын нэг юм.

Эдийн засгийн эрх чөлөө хангагдах нь эдийн засгийн өсөлтийн маш чухал нөхцөл болж байгааг “Эдийн засгийн эрх чөлөөний тойм 2006”-д тайлбарласан бөгөөд энд гол санааг товч дурдахад, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг бий болгохын тулд хувийн хэвшилд эдийн засгийн эрх чөлөөг хангаж өгөх, үйл ажиллагаанд шаардлагатай үед зохицуулалт хийх, бусад үед нь хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өмчийг хамгаалж өгөх, шударгаар өрсөлдөх боломжийг олгох хэрэгтэй.

² Эдийн засгийн эрх чөлөөний тухай дэлгэрэнгүй мэдэллийг “Эдийн засгийн эрх чөлөөний тойм 2006”, “2005 оны эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ийн судалгаанаас үзнэ үү.

1.1. ФРЕЙЗЕР ИНСТИТУТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС

Эдийн засгийн эрх чөлөө, түүний хөгжлийг дэлхийд хэд хэдэн аргачлалаар хэмждэг бөгөөд үүний нэг нь хамгийн түгээмэл болон олон орныг хамаарсан Фрейзер институтын эдийн засгийн эрх чөлөөний индекс юм.³ 20 жилийн өмнө уг индексийг боловсруулах судалгааны ажил эхэлсэн бөгөөд анхны эдийн засгийн эрх чөлөөний тайлан гарснаас хойш 11 жил өнгөрч, өдгөө 70 гаруй орнуудын эрдэм шинжилгээний байгууллагууд уг индексийг тооцоход хамтран оролцдог болсон.

Уг индексийг боловсруулахдаа Фрейзер институт гурван зарчмыг баримталдаг. Үүнд:

1. Аливаа субъектив үнэлгээ, экспертүүдийн үнэлгээгээс илүү объектив шинж чанартай буюу бодит тоо, үзүүлэлтийг ашиглахыг эрхэмлэдэг.
2. Олон орнуудыг хамарсан тоо, өгөгдлийг ашиглахыг зорьдог. Тухайлбал, Олон улсын валютын сан, Дэлхийн банк болон Дэлхийн эдийн засгийн форум зэрэг олон улсын байгууллагуудын тоон өгөгдлүүд 100 гаруй орнуудыг хамарсан байдаг бөгөөд харьцуулах боломжтой. Индексийг боловсруулж байгаа судлаачид эдгээр байгууллагуудаас авсан тоонд аливаа нэмэлт, өөрчлөлт хийдэггүй.
3. Үнэлгээ, индексийг тооцохдоо ашигласан тоо баримт, аргачлалыг ил тод болгож, бүх ашигласан өгөгдөл болон эх үүсвэрүүдээ судлаачдад зориулан өөрийн гаргасан тайлан болон вэбсайтад байрлуулдаг.⁴

³ Тус индексийн тухай дэлгэрэнгүй мэдэллийг “Эдийн засгийн эрх чөлөөний тойм 2006”, 2005 оны эдийн засгийн эрх чөлөөний индексийн судалгаанаас үзнэ үү.

⁴ <http://www.freetheworld.com>

Энэ жилийн эдийн засгийн эрх чөлөөний индекс таван гол хэсэг, 23 дэд хэсгээс бүрдэж, түүнийг тооцоход 42 төрлийн тоон, мэдээллийн өгөгдлийг ашигласан. Эдгээр таван гол хэсгүүд нь:

Төр засгийн хэмжээ

- Нийт хэрэглээнд улсын байгууллагуудын хэрэглээний эзлэх хувь,
- Дотоодын нийт бүтээгдэхүүнд (ДНБ) татаас, урсгал шилжүүлгийн эзлэх хувь,
- Нийт үйлдвэрлэлтэд улсын үйлдвэрүүдийн болон нийт хөрөнгө оруулалтанд улсын хөрөнгө оруулалтын эзлэх хувь,
- Татварын дээд хувь хэмжээ (орлогын хамгийн өндөр татварын түвшин, хамгийн өндөр орлого болон цалингийн татварын түвшин, татвар ноогдуулах орлогын түвшин).

Эрх зүйт төр

- Шүүхийн шударга үйл ажиллагаа,
- Өмчлөх эрхийн хамгаалагдсан байдал,
- Хууль дээдлэх болон улс төрд цэрэг хүчний оролцооны түвшин,
- Эрх зүйн тогтолцооны боловсронгуй байдал,
- Гэрээний хэрэгжилт,
- Үл хөдлөх хөрөнгийн худалдаа хязгаарлагдсан байдал.

Эрүүл мөнгө хүртэх боломж

- Сүүлийн таван оны мөнгөний нийлүүлэлтийн жилийн дундаж өсөлтөөс хасах нь сүүлийн арван оны ДНБ-ий жилийн дундаж бодит өсөлт,
- Сүүлийн таван жилийн инфляцийн стандарт өөрчлөлт,
- Өнөөгийн инфляцийн түвшин,
- Дотоодод болон гадаадад гадаад валютын данс эзэмших эрх.

Олон улсын худалдаанд оролцох эрх чөлөө

- Олон улсын худалдааны татвар,
- Олон улсын худалдааны эргэлтэнд олон улсын худалдааны татварын орлогын эзлэх хувь,
- Дундаж тарифын хэмжээ,
- Тарифын хэмжээний стандарт хазайлт,
- Худалдааны саад хоригийн зохицуулалт,
- Импортын далд саад, хориг,
- Импортын зардал,
- Худалдааны секторын бодит ба хүлээгдэж буй хэмжээний харьцаа,
- Валютын хар захын ба албан ханшийн хоорондын зөрүү,
- Олон улсын хөрөнгийн зах зээлийн хяналт,
- Гадаадын хөрөнгийн зах зээлд дотоодын иргэдийн, дотоодын хөрөнгийн зах зээлд гадаад иргэдийн оролцох боломж,
- Тухайн улсын иргэдийн гадаадын иргэдтэй хамтран хөрөнгийн зах зээлд оролцох эрх чөлөө.

Зээл, хөдөлмөрийн ба бизнесийн зохицуулалт

Банкны зээлийн салбарын зохицуулалтыг хэмжихэд

- Банкны өмчлөл,
- Өрсөлдөөн,
- Хувийн хэвшилд олгосон зээл,
- Сөрөг зээлийн хүү,

Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг хэмжихэд

- Хөдөлмөрийн хөлсний доод түвшингийн нөлөө,
- Ажилд авах болон ажлаас халах процесс,

- Цалин нь төвлөрсөн хамтын хэлэлцээрээр тодорхойлогддог ажиллах хүчний эзлэх хувь,
- Ажилд авахад зайлшгүй гаргах зардал (2007 онд шинээр нэмэгдсэн),
- Ажилгүйдлийн тэтгэмж,
- Цэргийн алба,

Бизнесийн үйл ажиллагаа хэр зэрэг эрх чөлөөтэй байгааг хэмжихэд:

- Үнийн хяналт,
- Зохицуулалтын шаардлагууд,
- Хүнд сурталтай холбогдсон зардал (2007 онд шинээр нэмэгдсэн),
- Шинээр бизнес эхлэх,
- Нэмэлт төлбөр,
- Лицензийн хязгаарлалт (2007 онд шинээр нэмэгдсэн),
- Татварын зохицуулалтын зардал (2007 онд шинээр нэмэгдсэн) гэсэн үзүүлэлтүүдийг авч үздэг.

Индекс болгоны үзүүлэлтүүдийг 0-10 онооны системээр дүгнэж, нийт оноог гаргадаг.⁵ Индексийн таван гол хэсгийг тооцохдоо, хэсэг болгоны дэд хэсгүүдийг тооцоод дараа нь хэсгийн оноог гаргадаг. Хэсэг болгон өөрийн зорилготой байдаг бөгөөд эдгээрийг дүнгээр харахад тухайн эдийн засгийн эрх чөлөөг салбараар болон олон талын үзүүлэлтээр нь дүгнэж болдог.

- “Төр засгийн хэмжээ”-ний үзүүлэлтийн гол зорилго нь эдийн засаг дахь нийт бараа, аж ахуйн эргэлтэд төрийн эзэлж байгаа хувийг тооцож, эдийн засаг дахь баялгийн хуваарилалтад төр хэр оролцож байгааг дүгнэхэд оршиж байгаа юм.

⁵ Индексийн утга 0 рүү ойртох тусам эрх чөлөө байхгүй, 10 руу ойртох тусам эрх чөлөөтэй байгааг харуулдаг. Таван үзүүлэлтийн индексийг тус бүрд нь тооцсоны эцэст арифметик дунжийг нь тооцоолон эдийн засгийн эрх чөлөөний нэгдсэн индексийг гаргадаг.

- “Эрх зүйт төр”-ийн индексээр (2007 оны тайланд “Эрх зүйн орчны бүтэц ба өмчлөх эрхийн халдашгүй байдал” гэж тодорхойлсон байгаа) зах зээлийн эдийн засгийн маш чухал хэсэг болох хууль, эрх зүйн тогтолцооны ажиллагааг хэмжих, зах зээлийн эдийн засгийн тулгуур ойлголт болох өмчлөх эрхийн хамгаалагдсан байдлыг дүгнэдэг.
- “Эрүүл мөнгө хүртэх боломж”-д үнийн тогтвортой байдлыг урт хугацаанд хангахад мөнгөний бодлого хэр зэрэг тууштай болон үр өгөөжтэй байгааг, мөн хөрөнгийн урсгал, валютын урсгал хэр чөлөөтэй хийгддэг эсэхийг хэмждэг.
- “Олон улсын худалдаанд оролцох эрх чөлөө” нь олон улсын худалдаа, солилцооны эрх чөлөөг олон талаас хэмжихэд оршдог. Тухайлбал, энэ хэсгийн оноо нь доогуур байвал, тухайн улс гадаад худадааны хувьд гаалийн тариф өндөртэй, тарифын бус хязгаарлалтууд болон худалдааны далд саад ихтэй, өөрөөр хэлбэл, худалдааны эрх чөлөө нь ихээхэн хязгаарлагдсан байна гэсэн үг. Харин өндөр оноотой улсын хувьд эсрэгээрээ гаалийн тарифын хэмжээ доогуур, худалдааны эргэлт ихтэй, гаалийн зохицуулалт хялбар, валют нь чөлөөтэй хөрвөдөг ба хөрөнгийн урсгал хязгаарлалт багатай байна гэсэн үг.
- “Зээл, хөдөлмөр ба бизнесийн зохицуулалт” хэсгийн гол зорилго нь (банкны) зээлийн, хөдөлмөрийн болон бизнесийн зохицуулалт зах зээлийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж, эрх чөлөөтэй болгож байгааг харуулахад оршдог. Энэ бүлэгт үндсэндээ гол үйлдвэрлэлийн хүчин зүйлс болох хөдөлмөр, капиталын зах

зээлүүд хэрхэн чөлөөтэй ажиллаж байгааг судалдаг бөгөөд бизнесийн зохицуулалтын үзүүлэлт нь бусад бүх зах зээлийн үйл ажиллагааг хэмждэг.

2007 оны эдийн засгийн эрх чөлөөний индекст шинээр найман дэд хэсэг нэмэгдэж, зарим нь хасагдсан учраас өмнө 38 дэд хэсэгтэй байсан индекс энэ жил 42 дэд хэсэгтэй болсон. Шинээр нэмэгдсэн хэсгүүд Дэлхийн банкнаас гаргадаг “Doing Business” судалгааны тоо, өгөгдлүүдийг ашигласан үзүүлэлтүүд юм.

Анх 2005 онд Нээлттэй Нийгэм Форумын санаачилгаар Фрейзер институтын аргачлалд үндэслэн Монголын эдийн засгийн эрх чөлөөний индексийг дотооддоо тооцсон бөгөөд түүнд Монголын олон сургалт судалгааны хийгээд академийн байгууллагууд оролцож Монголын эрх чөлөөний индексийг тооцсон.

Харин 2006 онд Монгол улс анх удаа Фрейзер индексийн зэрэглэлд орж, 2004 оны байдлаар авч болох 10 онооноос 6.2 оноо авч, 130 орноос 74 дүгээр байранд орсон байна. Эдийн засгийн эрх чөлөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдэд Монгол улсын 2006 онд авсан оноог харуулбал:

- Төр засгийн хэмжээ: 6.5 (47 дугаар байр)
- Эрх зүйт төр: 2.2 (123 дугаар байр)
- Эрүүл мөнгө хүртэх боломж: 8.8 (56 дугаар байр)
- Олон улсын худалдаанд оролцох эрх чөлөө: 7.1 (53 дугаар байр)
- Зээл, хөдөлмөрийн ба бизнесийн зохицуулалт: 6.3 (49 дүгээр байр)

Үүнээс харахад Монгол улс эрүүл мөнгө хүртэх боломж гэсэн үзүүлэлтээр харьцангуй өндөр байрыг эзэлсэн боловч эрх зүйт төр, зах зээлийн зохицуулалт гэсэн үзүүлэлтээр

нилээд доогуур орсон. Энэ байдлыг Фрейзерийн индексээс гадна бусад олон засаглалын үзүүлэлтүүд баталсан юм. (Эдийн засгийн эрх чөлөөний тойм 2006)

2007 онд нийтлэгдсэн “Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний тайлан”-д Монголын эдийн засгийн эрх чөлөөний байдал дараах байдлаар өөрчлөгджээ. Монгол 7.1 оноотойгоор дэлхийд 44-р байранд орсон бөгөөд индексийн үзүүлэлтүүд тус тусдаа дараах байдалтай байна.

- Төр засгийн хэмжээ: 6.3
- Эрх зүйт төр: 5.8
- Эрүүл мөнгө хүртэх боломж: 8.7
- Олон улсын худалдаанд оролцох эрх чөлөө: 7.2
- Зээл, хөдөлмөрийн ба бизнесийн зохицуулалт: 7.4

Өмнөх онтой харьцуулахад Монголын эдийн засгийн эрх чөлөөний үнэлгээ 6.2-оос 7.1 болж өссөн байна. Нийт дүнгээр Монголын үзүүлэлт сайжирсан нь Эрх зүйт төрийн үзүүлэлт 2.2-оос 5.8 болж өссөнтэй холбоотой. Гэхдээ энэ үзүүлэлт ийнхүү сайжирсны гол шалтгаан нь урьд тооцож байгаагүй зарим үзүүлэлтүүдийг шинээр индекст оруулсантай мөн холбоотой. Эдгээр нэмэгдэн орсон Фрейзерийн индексийн хэсгүүд бол Монголын нөхцөлд өмнө хэмжиж байгаагүй *цэрэг дайны саад, шүүхийн тогтолцооны шударга байдал, гэрээний хэрэгжилт, үл хөдлөх хөрөнгийн худалдаан дахь зохицуулалтын хязгаарлалт* гэх зэрэг үзүүлэлтүүд юм.

Эдийн засгийн эрх чөлөөний индексийн 2005 оныг 2004 онтой харьцуулан бусад хэсгүүдийг авч үзэхэд зээл, хөдөлмөрийн зах зээл болон бизнесийн зохицуулалтын үзүүлэлт сайжирч (6.3-аас 7.4 болж өссөн), түүнд зээлийн хүүний зохицуулалт буюу зээлийн хүү сөрөг болох гэсэн дэд үзүүлэлт

8-аас 9 болон, лицензийн хязгаарлалт 4.1-ээс 4.7 болон, ажилд авах болон ажлаас халах дэд үзүүлэлт ялимгүй сайжирсан зэрэг өөрчлөлтүүд нөлөөлсөн байна.

2007 оны эдийн засгийн эрх чөлөөний жагсаалтыг үзэхэд Монгол улсын 44-р байр нь Монголын эдийн засгийн эрх чөлөө дэлхийд нилээд өндрөөр үнэлэгдсэнийг харуулж байгаа юм. Монгол улс эдийн засгийн эрх чөлөөгөөр Итали (52), Франц (52) зэрэг өндөр хөгжилтэй орнуудаас, Чех (52), Болгар (56), Польш (56) зэрэг шилжилтийн орнуудаас, Ази тивд эрчимтэй хөгжиж байгаа Малайз (60), Тайланд (60), Индонези (86) зэрэг орнуудаас дээгүүр гарсан байна. Манай хоёр хөрш Хятад (86), ОХУ (112) аль аль нь эдийн засгийн эрх чөлөөгөөр манай улсаас хол хоцорсон байна.

Ирэх оны эдийн засгийн эрх чөлөөний индексд 2006 болон 2007 оны Монголын эдийн засгийн өөрчлөлтүүд тусгагдах болно. 2006 оны хамгийн том бодлогын алхам татварын багц хуулийн өөрчлөлт бөгөөд энэ алхам манай улсын эдийн засгийн эрх чөлөөний үнэлгээг сайжруулах нь гарцаагүй. Цаашид манай улсын эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүд сайжрах найдвартай байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд улсын төсвийн хэмжээ ихээхэн өсч, төрийн эдийн засагт эзлэх байр суурь, хувь улам өсч байгаа нь манай улсын эдийн засгийн эрх чөлөөний үнэлгээнд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

1.2. ХЕРИТЭЖ САНГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС

Херитэж сан нь 1995 оноос “Уолл стрит журнал” сэтгүүлтэй хамтран улс орнуудын эдийн засгийн чөлөөт байдлыг хэмжиж, “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ийн тайлан гаргадаг нэр бүхий томоохон

байгууллага юм. Уг сан дэлхийн улс орнуудын эдийн засгийн эрх чөлөөг судлан тогтоож, жил бүр тайлан хэвлүүлж байна.

Зарчмын хувьд Фрейзер институтын дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний индекс болон Херитэж сангийн эдийн засгийн эрх чөлөөний индексүүдийн аль аль нь эдийн засгийн эрх чөлөөг ижил төстэй аргачлалаар хэмждэг ба гол ялгаа нь хамрагдсан улсуудын тоо, зарим үзүүлэлтийн сонголт, бүлэглэлд байдаг. Иймээс эдгээр индексүүдийг судлахдаа гол нь индексийн абсолют хэмжээнд анхаарахаас илүү бусад орнуудтай харьцуулахад өөрийн орны байдал, жагсаалтанд эзэлж байгаа байр болон энэ үед эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөж байгааг тоон мэдээлэл, статистикийн үзүүлэлтээр харах боломжтой оршиж байгаа юм.

2007 оноос эхлэн Херитэж сангийн эдийн засгийн эрх чөлөөний 10 үзүүлэлт болгоныг 0-ас 100 хүртэл оноогоор дүгнэдэг болсон.⁶ Энэ индекс 100 оноо (хувь) хамгийн их өндөр эрх чөлөөний утгыг харуулдаг. Жишээ нь, гадаад худалдаандаа тэг хувийн татвар ноогдуулдаг бөгөөд тарифын бус хязгаарлалтгүй тохиолдолд тус улсын гадаад худалдааны эрх чөлөөний үзүүлэлт 100 оноотой байх болно.⁷ Тус индекс дараах үзүүлэлтүүд ордог:

- Бизнесийн эрх чөлөөний үзүүлэлт нь аливаа шинэ бизнес, аж ахуйн үйл

ажиллагааг эхлэх, явуулах ба татан буулгах боломж, нөхцлийг тооны аргаар хэмжиж, төрийн зохицуулалтын үр өгөөжийг харуулдаг.⁸

- Гадаад худалдааны эрх чөлөөг тооцохдоо импорт, экспортын гаалийн татварын хувь, тарифын бус худалдааны хязгаарлалтыг авч үздэг.
- Сангийн эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтэд аж ахуйн нэгжийн болон хувь хүмүүсийн орлогын татварын дээд хувь, ДНБ-д эзлэх нийт татварын орлого зэргийг хэмжиж, татварын дарамтын хувийг харуулдаг.
- Засгийн газрын оролцоог хэмжихэд ДНБ-д засгийн газрын хэрэглээ (улсын төсвийн зарлага) эзлэх хувь ба улсын орлого дахь төрийн өмчийн үйлдвэрүүдийн орлогын эзлэх хувийг тооцдог.
- Мөнгөний эрх чөлөөний үзүүлэлт нь мөнгөний тогтвортой ханш, мөнгөний бодлогын тууштай, тогтвортой байдлыг хэмждэг ба инфляцийн түвшинг тусгадаг. Тус үзүүлэлт сүүлийн гурван жилийн инфляцийн түвшин, үнийн хяналт байгаа эсэхийг харуулдаг.
- Хөрөнгө оруулалтын эрх чөлөө гадаадын хөрөнгө оруулалтын эрх чөлөөг хэмжиж, тухайн улсын нийт хөрөнгө оруулалтын орчинг тусгадаг. 100%-ийн үзүүлэлт нь гадаад, дотоодын

⁶ Өмнөх жилүүдэд Херитэж сан индексээ тооцохдоо 1-5 хоорондын онооны интервалыг ашигладаг байсан. Тухайн улсын эдийн засгийн эрх чөлөөг тодорхойлогч үндсэн 10 хүчин зүйл бүр 1-5 гэсэн түвшнээр үнэлэгдэнэ. “1” гэсэн үнэлгээ нь эдийн засгийн орчин буюу бодлогын цогц нь эдийн засгийн эрх чөлөөнд хамгийн сайнаар нөлөөлж байгаа, түлхэц болж байгааг, харин “5” гэсэн үнэлгээ нь эсрэг байдлыг тэмдэглэнэ. Үүнээс гадна хүчин зүйл тус бүрийн үнэлгээг “илүү сайн” (эрх чөлөөний хүчин зүйл сайжирсан), “муу” (эрх чөлөөний хүчин зүйл муудсан), “тогтвортой” (эрх чөлөөний хүчин зүйл өөрчлөгдөөгүй) гэж тодорхойлдог байсан.

⁷ Энэ аргачлалыг ашиглан өмнөх жилүүдийн эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлтүүдийг мөн 100%-ийн системд шилжүүлж болно. Тухайлбал, өмнөх жилд 3 оноотой байсан орны үзүүлэлтийг шинэ аргачлалаар 50%-ийн үзүүлэлттэй гэж үзнэ.

⁸ Төрийн зохицуулалт бизнесийн үйл ажиллагааг түргэн шуурхай эсвэл эсрэгээр цаг хугацааг их алдаж явуулахад асар их нөлөөтэй бөгөөд хүнд суртал ихтэй бизнесийн орчин аж ахуйн нэгжүүдэд төрөл бүрийн дарамт, нэмэлт зардлыг бий болгодог. Зохицуулалтын дотор лиценз, зөвшөөрөл олгох ажил нь хамгийн чухал гэж үздэг. АНУ-д зарим тохиолдолд бизнесийн зөвшөөрөл авах зардал нь ердөө л өргөдлөө шуудангаар төрийн агентлаг руу явуулах шуудангийн зардлаас хэтрэхгүй байдаг, мөн Хонг Конг зэрэг газруудад шинэ компанийг бүртгүүлэх нь нэг анкетыг бөглөж бүртгэлийн хураамжийг төлөх болон хэдхэн цаг хүлээх ажлаас бүрддэг бол Өмнөд Африкт ижил үйл ажиллагаа жил гаруй хугацааг шаарддаг.

хөрөнгө оруулагчдыг ялгаварлахгүй, үндэсний аюулгүй байдал ба үл хөдлөх хөрөнгийн салбарт аливаа хязгаарлалт байхгүй, оршин суугчид ба түр оршин суугчид гадаад валютаар чөлөөтэй гүйлгээ хийх боломжийг харуулна.

- Санхүүгийн эрх чөлөөний үзүүлэлт нь банкны болон санхүүгийн салбарын нээлттэй байдлыг харуулдаг. Үүнд тус салбарын төрийн зохицуулалтын хүрээ болон төрийн оролцооны түвшинг тооцож, санхүүгийн салбарын нээлттэй байдал ба зах зээл дэх төрийн нөлөөг тооцдог.
- Өмчийн эрхийн үзүүлэлт нь эд хөрөнгө өмчлөх эрх чөлөөт зах зээлийн эдийн засгийн тулгуур ойлголт бөгөөд тус үзүүлэлтээр тухай улсын засгийн газар, хуулиуд нь хувийн өмчийг хэрхэн дархлан хамгаалдгийг хэмждэг.
- Авилгын үзүүлэлт нь засаглалын системийн доголдол, бусдын эрх ашгийг хөндөж, хууль бусаар хождог байдлыг харуулдаг.
- Хөдөлмөрийн эрх чөлөө цалингийн доод түвшин болон хөдөлмөрийн эрх зүйн орчны мэдээллийг тусгадаг.

Монгол улсын үнэлгээг Херитэж сангийн индексийн шинэ аргачлалаар тооцоход 2007 оны нийт үзүүлэлтээр Монгол улс дэлхийд 78-р байранд орж, Ази тивдээ 30 орноос 11-т орсон. Энэ жил Монголын бизнесийн эрх чөлөөг 73.1%, худалдааны эрх чөлөөг 70%, төсвийн эрх чөлөөг 81%, засгийн газрын эрх чөлөөг 56.9%, мөнгөний эрх чөлөөг 74.3%, хөрөнгө оруулалтын эрх чөлөөг 60%, санхүүгийн эрх чөлөөг 60%, хөдөлмөрийн эрх чөлөөг 65.9%-тай, харин өмчийн эрхийг дөнгөж 30%, авилгын эсрэг эрх чөлөөг мөн 30% гэж дүгнэсэн байна.

1.3. МОНГОЛ УЛСЫН ЗАСАГЛАЛЫН ЧАНАР

Аль нэг улсын засгийн эрх хэрэгжүүлдэг байгууламж болон уламжлалт төрийн тогтолцоог засаглал гэж тодорхойлдог. *Засаглал гэсэн ойлголтод төр, засгийн газрыг сонгох, хянах болон солих процесс, төр, засгийн газрын бодлого боловсруулж хэрэгжүүлэх чадвар, төрийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог хангах, тэдгээрийн хоорондох эдийн засаг, нийгмийн харилцаанууд бүгд ордог.*⁹

Монголын институци болон засаглалын олон үзүүлэлтүүдийн байдал өнгөрсөн оны байдлаар төдийлөн сайжраагүй, олон тохиолдолд дордож байгааг харуулсан.

Засаглалын чанар нь төр, засгийн үйл ажиллагааны чанар, нээлттэй байдал, үр өгөөжийг харуулдаг. Засаглалын чанарыг олон талаас нь дүгнэж, судалж болно. Жишээлбэл, ардчилал ба эдийн засгийн өсөлтийн хоорондох уялдаа юм. Хятад, Сингапур зэрэг улсуудад эдийн засгийн өсөлт авторитар дэглэмийн дор өндөр байсан бол ардчилсан нийгэм эдийн засгийн өсөлт илүү өндөр байдаг гэсэн онолууд байдаг.

Сүүлийн үед засаглалыг олон орноор судалж, харьцуулсан судалгаа хийж байгаа байгууллага нь Дэлхийн банк юм. Дэлхийн банк засаглалыг олон түвшинд, олон үзүүлэлтээр 1996 оноос хойш судалж, судалгааны дүнгээ байнга нийтэлж ирсэн бөгөөд улс орнуудын засаглалын чанарыг үндсэн зургаан талбараар хэмждэг. Үүнд:

1. Үг хэлэх эрх ба хариуцлагатай байдал / Voice and Accountability/ нь улс төрийн, соёлын болон хүний эрхийн чухал хэмжүүр болдог.
2. Улс төрийн тогтворгүй байдал ба хүчирхийллийн /Political Stabil-

⁹ Засаглалын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Дэлхийн банкны судалгаанаас, “Эдийн засгийн эрх чөлөөний тойм 2006”-аас авч болно.

ity and Violence/ талбар нь терроризм, хүчирхийлэлд өртөх, эсвэл Засгийн газрын солигдох магадлалыг хэмждэг.

3. Засгийн газрын үр ашигтай байдал /Government Effectiveness/ нь хүнд суртал болон төрийн үйлчилгээний чанарыг хэмждэг.
4. Зохицуулалтын дарамт /Regulatory Burden/ нь төрийн бодлогын зах зээлд учруулж буй дарамтыг хэмждэг.
5. Хууль дээдлэх ёс /Rule of Law/ нь шүүх, цагдаа, гэрээний хүчин төгөлдөр байдлын чанарыг хэмждэг
6. Авилгын хяналт /Control of Corruption/ нь төрийн эрх мэдлийг хувьдаа завших байдлыг хэмждэг.

Дэлхийн банкны судалгаагаар засаглалын чанар доод түвшнээс дундаж түвшинд хүрч сайжрахад тухайн улсын хүн амын орлого 4 дахин өсч, эрүүл мэнд болон боловсролын үзүүлэлтүүд нь сайжирна гэсэн дүгнэлтийг гаргасан.¹⁰

Дэлхийн банкны тус судалгаанд Монголын засаглалын чанарын талаарх тоо, баримтууд 1996 оноос хойш орсон байдаг. Эдгээр судалгаа, тайлангаас харахад Монголын төрийн засаглалын чанар сүүлийн үед дордсоор байна.

Дэлхийн банкны “Governance Matters IV: Governance Indicators for 1996-2004” тайланд¹¹, мөн 2007 онд нийтлэгдсэн “Засаглал 2007” судалгааны материалд Монголын засаглалын чанарыг Хүснэгт 1.1 байдлаар харуулжээ.

2000 оноос хойш Монголд *үг хэлэх эрх, хариуцлагатай байдал* +0.47-оос +0.1 болж буурсан байна. *Хуулийн хэрэгжилт* +0.07-гоос -0.32, *авилгын хяналт* +0.37-гоос -0.54 хүртэл унажээ. Дэлхийн банкны “Засаглал 2007” судалгааны дүнгээс харахад сүүлийн 2 жилд Монгол улсын *үг хэлэх эрх ба хариуцлагатай байдлын үзүүлэлт, засгийн газрын үр ашиг, хуулийн хэрэгжилт, авилгын хяналтын үзүүлэлтүүд* буурсан байдалтай гарчээ. 1996 оноос хойш засаглалын чанарын зургаан үзүүлэлтээс гурван үзүүлэлт, 2004 оноос хойш дөрвөн үзүүлэлт дордсон гэсэн дүгнэлт гарчээ. Үүний дотор эдийн засгийн эрх чөлөөг тодорхойлох чухал үзүүлэлтүүд болох авилгын хяналт ба хуулийн хэрэгжилт хамгийн ихээр буурсан.

Үүнээс гадна Дэлхийн банкнаас тогтмол нийтэлдэг бизнесийн орчин, засаглалын чанарын судалгаа нь “Doing Business” бөгөөд 150 гаруй орнууд судалгаанд хамрагддаг.¹² Энэ харьцуулсан судалгааны гол зорилго нь зохицуулалт, дүрэм журмууд тухайн улсын бизнесийн хөгжилд хэрхэн нөлөөлдгийг тоон байдлаар илэрхийлэх, бизнесийн хөгжилд саад болж байгаа зохицуулалтын дутагдлыг илрүүлэхэд оршдог.

2006 онд бизнесийн орчны ерөнхий үзүүлэлтээр Монгол улс дэлхийд нилээд дээгүүр буюу 45-р байранд орж чадсан. Харин өмнө дурдсанчлан 2007 онд Монгол

¹⁰ Үүний гол шалтгаан нь засаглал зах зээлийн эдийн засагт хэд хэдэн сувгаар шууд нөлөө үзүүлдэгт оршиж байгаа юм. Нэгдүгээрт, засаглал сайн хөгжсөн улсад сонгогчид илүү идэвхтэй, сайн ажилладаг засгийг сонгуулиар бий болгодог, засаг нь илүү оновчтой эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх магадлалтай. Хоёрдугаарт, засаглал сайтай улс орон эдийн засгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх улс төрийн болон хуулийн эмх замбараагүй байдал, тодорхой бус байдал гарах магадлал багатай. Гуравдугаарт, засаглал илүү хөгжсөн оронд хувийн эрх, гэрээний биелэлтийн зардал бага учраас хувийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг илүү хийж, эдийн засгийн өсөлтийг дэмжих болно. Дөрөвдүгээрт, засаглал сайтай оронд хахууль, авилга бага байдаг учраас зах зээлийн өрсөлдөөн илүү шударга явагдаж, компаниуд хээл хахуульд илүү зардал гаргахгүй, бизнесийн үйл ажиллагаа нь илүү идэвхтэй байх болно гэж үздэг.

¹¹ Уг индексийг Дэлхийн банк 1996 оноос эхлэн гаргасан бөгөөд голлон боловсруулагчид нь Д.Кауфман (Daneil Kaufmann), А.Край (Aart Kraay), М.Маструцци (Massimo Mastuzzi) нар юм.

¹² Тус судалгааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Эдийн засгийн эрх чөлөөний тойм 2006”-аас үзнэ үү.

Хүснэгт 1.1. Монгол улсын засаглалын чанар, 1996-2006

	1996	1998	2000	2002	2004	2006
Үг хэлэх эрх ба Хариуцлагатай байдал						
Үнэлгээ	+0.47	+0.52	+0.37	+0.36	+0.24	+0.1
Хувь	61.7	64.4	58.7	58.7	56.7	53.4
Улс төрийн тогтворгүй байдал ба Хүчирхийлэл						
Үнэлгээ	+0.58	+0.39	+0.79	+1.06	+0.77	+0.78
Хувь	63.9	58.2	73.6	85.1	70.2	71.6
Засгийн газрын үр ашигтай байдал						
Үнэлгээ	-0.53	-0.33	-0.34	-0.2	-0.42	-0.46
Хувь	33.2	45	45.5	53.6	39.8	36.5
Зохицуулалтын чанар, дарамт						
Үнэлгээ	-0.69	+1.17	-0.04	-0.07	-0.39	-0.31
Хувь	22	52.2	50.2	50.2	39	42
Хуулийн хэрэгжилт						
Үнэлгээ	+0.07	-0.04	-0.03	+0.22	+0.07	-0.32
Хувь	55.7	55.2	53.8	59.2	56.2	46.7
Авилгын Хяналт						
Үнэлгээ	+0.37	-0.32	-0.31	+0.06	-0.43	-0.54
Хувь	65	45.6	47.1	58.3	44.2	37.4

Эх үүсвэр: «Governance Matters IV: Governance Indicators for 1996-2006», Дэлхийн банк

улс Ази Номхон далайн орнуудын дотор 8-р байр, дэлхийд 52-р байранд орж, 7 байраар ухарсан дүнтэй гарлаа. Монгол улсын бизнесийн орчны нийт үнэлгээгээр Азид 8-р байранд орохдоо Вьетнам, Лаос, Камбоджи зэрэг шилжилтийн, Филиппин, Индонез болон БНХАУ зэрэг хүн ам ихтэй, зах зээлийн эдийн засаг харьцангуй олон жил хөгжсөн орнуудаас дээгүүр орсон боловч Ази Номхон далайн бүс нутагт эрчимтэй хөгжиж байгаа Тайланд, Малайз, Гонконг, Тайван зэрэг орнуудын ард орсон байна.¹³

Дэлхийн жагсаалтанд ийнхүү Монголын үзүүлэлтүүд 2007 оны тайланд буурсан үзүүлэлттэй гарсан шалтгааныг авч үзэхэд бизнесийн орчны 11 үзүүлэлтээс Монгол улсын хувьд 9 үзүүлэлт нь дордсон байдалтай гарсан бөгөөд зөвхөн *татвар төлөлт* ба *лиценз олгох үзүүлэлт* сайжирсан байна. Өмнөх онтой харьцуулахад 2007 оны тайланд ихээхэн дордсон бизнесийн орчны үзүүлэлтүүд бол *ажил олгох* (-4 оноогоор муудсан), *зээл авах* (-6 оноогоор) гэсэн хоёр үзүүлэлт байлаа.

¹³ Дэлхийд 52-р байранд орохдоо, Монгол улс адилхан шилжилтийн Эстони, Гүрж, Литви, Болгар, Унгар зэрэг орнуудаас доогуур үзүүлэлттэй боловч Итали, Чех, Турк, Словени зэрэг орнуудаас илүү сайн бизнесийн орчинтой гэсэн дүнтэй гарчээ. Харьцуулбал, манай хөрш зэргэлдээ

Казахстан, ОХУ болон Хятад улсууд 71, 106 болон 83-р байруудад орсон байна. Ази тивээс дэлхийд хамгийн дээгүүр буюу 4-р байранд Гонконг шалгарч, хамгийн доогуур буюу 164-р байранд Лаос орж, хамгийн сүүлийн 173-178-р байруудыг Африкийн орнууд эзэлжээ.

Дэлхийн дунджаас доогуур байгаа бусад үзүүлэлтэд компани (бизнес) байгуулахад шаардлагатай хөрөнгийн хэмжээ, нэг хүнд ногдох орлого (62-р байр), хил дамжин худалдаа хийх (168-р байр), татвар төлөх (90-р байр), өмчийг бүртгүүлэх (64) гэх зэргийг нэрлэж болно. Энэ нь эдгээр асуудлуудад түлхүү анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

1.4. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТОЙМ

Өнгөрсөн онуудын эдийн засгийн өсөлтийг авч үзэхэд уул уурхайн салбар болон бүтээгдэхүүнийх нь дэлхийн зах зээл дэх үнийн өсөлт Монголын өнөөгийн эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл болоод байгаа бөгөөд бусад салбарт хувийн хэвшил 2000 оноос хойш дорвитой хөгжиж чадаагүй байгаа тухай өнгөрсөн жилийн тайланд судалсан билээ. 2006-2007 онд Монголын эдийн засгийн өсөлтийн ерөнхий дүр төрх 2005 оноос төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд уул уурхайн салбарын эзлэх хувь, нөлөө улам өссөөр ирлээ. Энэ нь манай улс цөөн тооны барааны дэлхийн зах зээлийн үнээс хэт хараат болох, байгаль орчин, экологийн тэнцвэр алдагдах, тус салбартай холбоотой авилга нэмэгдэх аюулыг улам тод болгож байна.

Эдийн засгийн бодлогын хүрээнд 2006 онд Монголын төр 1997 оноос хойш хамгийн том өөрчлөлтийг хэрэгжүүлж, аж ахуйн нэгжийн болон хувь хүний, нэмэгдсэн өртгийн татварын түвшинг ихээхэн бууруулж, татварын дарамтыг эрс багасгав. Энэхүү татварын тогтолцооны өөрчлөлт Монголын эдийн засгийг Ази тивд төдийгүй, дэлхийд бизнесийн хамгийн таатай орчинтой орнуудын тоонд оруулсан.

Дэлхийн зах зээлд экспортын гол барааны үнэ өндөр байсан нь 2006 онд Монголын эдийн засаг маш эрчимтэй өсөх, ДНБ 3714.9 тэрбум төгрөгт хүрэх, ДНБ-ий өсөлт 8.6% гарах бололцоог бүрдүүлсэн. Эдийн засгийн өсөлтийн 4.8% нь үйлчилгээний салбарт, 2.1% үйлдвэрлэлийн салбарт, 1.6% хөдөө аж ахуйд, 1.4% нь уул уурхайн салбарт бий болсон.¹⁴ Зах зээлийн эдийн засгийн шилжилт эхэлснээс хойш анх удаа нэг хүнд ногдох ДНБ оны үнээр/ тухай үеийн валютын ханшаар тооцоолон 1440 мянган төгрөг буюу ойролцоогоор 1000 ам долларт хүрчээ.¹⁵

Манай улсын голлох салбар болоод байгаа уул уурхайн салбар 2006 онд 6.3% өсч, цайрын баяжмал, зэсийн баяжмал болон молибдений үйлдвэрлэл 2.8-18.2% өсчээ. Уул уурхайн салбарт шинээр гэнэтийн ашгийн (68%) татварыг бий болгосон нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч нарт сэрэмжлүүлэх дохио өгч, Монголын эдийн засгийн бодлого эрс өөрчлөгдөх эрсдэлтэй байгааг харуулж байна. Хэдийгээр тус 68%-ийн татварт олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид шүүмжлэлтэй хандаж байгаа боловч одоогийн байдлаар зэсийн үйлдвэрлэлд тус татварын сөрөг нөлөө төдийлөн гараагүй. Дотоодын боловсруулах үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг эерэг талууд ч бас байгаа. Сөрөг үр дагавар нь алтны олборлолт, Монголбанкинд алт тушаах үйл явцад илэрч, тогтсон журмын дагуу Төв банкинд олборлосон алтыг худалдахын оронд алтыг барьцаанд байрлуулж, зээл авах явдал ихэсчээ. Үүний үр дүнд улсын нөөцөнд орсон алтны хэмжээ эрс буурч, алтны

¹⁴ Монгол улсын Сангийн яам, Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил 2006 онд

¹⁵ Монгол улсын Сангийн яам, Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил 2006 онд

үйлдвэрлэл өнгөрсөн оноос 6.5%-иар бууран 22.5 тн болжээ.¹⁶

2006 онд Монголын гол баялаг болох малын тоо 34.8 сая толгойд хүрч, 2005 оноос 14.4%-иар өсч, газар тариаланд хүнсний ногооны үйлдвэрлэл 9.8%, төмсний үйлдвэрлэл 31.6%, үр тарианы үйлдвэрлэл 83.6%-иар тус тус өсч, нэг га-аас авсан үр тарианы хэмжээ 2005 оноос 2 дахин өсчээ.

Боловсруулах салбар тус онд 26.6%, ноолуурын үйлдвэрлэл 83%-иар өсч, 2004 оноос хойш уналтанд байсан сүлжмэл 31.3%, худалдаа 15.3%-иар өслөө. Хүн амын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 12%-иар өссөн. Худалдааны салбар 15.3%, зочид буудал, зоогийн газрын салбар 9.9%, тээвэр, холбооны салбар 12.1%-иар өсч, үндсэндээ 2006 онд Монголын бодит үйлдвэрлэл, үйлчилгээ өндөр өсөлттэй байсан.

2006 оны 11 дүгээр сард Монгол улс Польш улсад төлөх өрийн 90 хувийг хүчингүй болгож (ОХУ-ын өртэй ижил аргаар), үлдсэн 10 хувийн хөрөнгөөр буцаад Монголд хөрөнгө оруулалт хийх гэрээг байгуулахаар шийдвэрлэж, гадаад валютын нөөц 600 сая ам.долларт хүрлээ. 2006, 2007 онд Монголын эдийн засгийн өсөлтийн хурд өндөр, эдийн засаг үргэлжлэн эрчимтэй өсч байгааг олон улсын байгууллагууд тэмдэглэжээ. Тухайлбал,

¹⁶ Ойрын жилүүдэд дэлхийн зах зээл дэх зэс, алтны үнэ өндөр хэвээрээ байх тохиолдолд энэхүү эрчимтэй эдийн засгийн өсөлтийн хурд төдийлөн саарахгүй бөгөөд Таван Толгой, Оюутолгой зэрэг орд ашиглалтад орсноор манай улсын эдийн засгийн өсөлт улам нэмэгдэх төлөвтэй байна. 2007, 2008 онд Монголын эдийн засгийн өсөлтийг Засгийн газар 9% болон 9.4%-д хүргэж, нэг хүнд ноогдох ДНБ-ий нэрлэсэн хэмжээг 2008 онд 1574 ам.долларт хүргэхээр тооцоолж байна. 2008 оны Үндсэн чиглэлийн төсөлд эдийн засгийн бодит өсөлтийг 9.4%, ДНБ-ийг 5.4 триллион төгрөгт, инфляцийг нэг оронтой тоонд барих, гадаад валютын цэвэр албан нөөцийг 1 580.0 сая ам.долларт хүргэх, экспортын хэмжээг 13% өсгөх, гадаад худалдааны тэнцэл 49.4 сая ам.долларын ашигтай байх, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 9.2%-иар өсгөх, хүүхдийн мөнгө, шинэ гэр бүл, шинээр төрсөн хүүхдэд олгох тэтгэмжийн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх, тэтгэврийн хэмжээг 15%-иар, төрийн албан хаагчдын цалинг 20% нэмэх зэрэг бодлого тусгагджээ. “АЭ” /№184/.

Хонконг, Сингапурт байрладаг олон улсын зэрэглэлийн Фитч компани Монголын зэрэглэл/рейтингийг В+ түвшинд тогтоожээ. В болон В+ гэсэн үзүүлэлттэй бусад орнуудын дундажтай харьцуулахад Монголын эдийн засгийн байдал илүү сайн байгааг тус агентлаг тэмдэглэсэн байна.¹⁷ Энэ нь дэлхийн зах зээл дэх уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлт манай эдийн засагт ихээхэн ашигтай байсан, улмаар төсөв, гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсны үр дүн юм.

2006 онд мөнгөний нийлүүлэлт 34.8%-иар өсч, 1536 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 41.4%-тай тэнцлээ. Нийт хадгаламж 38.3%-иар өсч, 1204 тэрбум төгрөгт, хувийн салбарт олгосон зээлийн хэмжээ 44.8%-иар өсч, 1093 тэрбум төгрөг болов. Долларжилт буюу гадаад валютын нийт хадгаламжид эзлэх хувь 2005 оны 39%-иас 33% хүртэл буурсан байна. Зээлийн хүү 2006 онд (төгрөгийн жигнэсэн дундаж) 24.5% хүртэл буурч, гадаад валютын зээлийн хүү 15.5% болж, 0.7%-иар өссөн байна. 2007 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлт 47.1%¹⁸, зээлийн жилийн өсөлт 48.8%, Төв банкны үнэт цаасны хүү жилийн 6.4% байна. 2007 онд Монголбанкнаас арилжааны банкуудад байх төгрөгийн болон валютын заавал байлгах нөөцийг 5% хүртэл бууруулж, банкуудын зээлдүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэв.

Нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тэтгэврийн доод хэмжээг 40000 төгрөг болголоо. Төсвийн байгууллагад ажиллагсдын цалинг 30,0 хувь нэмэгдүүлэв.¹⁹ Нийгэм-эдийн засгийн хүрээнд Засгийн газар 2008 онд цалин хөлсийг 20%-иар нэмэгдүүлж,

¹⁷ Rating Agency Finds Mongolia's Economy Powering Ahead, UB Post, 2007.10.3

¹⁸ 2008 оны төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэл, Монголбанк, 2007

¹⁹ Монгол улсын эдийн засаг-нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн тухай

хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээг 300 мянган төгрөгт хүргэхээр төлөвлөжээ.

Гэхдээ 2006 оноос төсвөөс ихээхэн хэмжээний хөрөнгийг үр өгөөж муутайгаар тараах нийгмийн бодлогууд хэрэгжлээ. Шинээр мэндэлсэн хүүхэд болгонд 100 мянган төгрөг, өрх бүл нэмсэн хос болгонд 500 000 төгрөгийн тусламж үзүүлэх болсон нь зарим олон улсын байгууллагуудын үзэж байгаагаар зохиомлоор төрөлтийг өсгөж, өнгөрсөн онуудад тогтмол буурч ирсэн эх, нялхсын төрөлтийн эндэгдлийг анх удаа өсгөсөн дүнтэй гаргахад хүргэлээ.

2006 оны хэрэглээний барааны үнийн индекс оны эцсийн байдлаар 6%-ийн өсөлттэй буюу харьцангуй доогуур үзүүлэлттэй гарсан.²⁰ Гэвч 2007 онд инфляци өсч, 8-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс өмнөх жилээс үсрэнгүй өсч, оны эхнээс 10.6%-иар (2007 оны 6-р сард 6.4% байсан), өмнөх жилийн мөн үеэс 11.3% хүртэл өсч, улмаар 9-р сард 13.2% болсон. Зөвхөн 8-р сард гэхэд л үнийн түвшин өмнөх сараас 3.3%-иар өсөв.

ХҮИ-ийн сагсыг шинэчилж, 287 бараа бүтээгдэхүүн оруулан тооцоход, хамгийн их жин эзэлдэг хүнсний барааны үнэ 8-р сарын байдлаар 2006 оны 12-р сараас 21.4%-иар өссөн. Оны эхнээс хонь, үхрийн махны үнэ 44.7% болон 35.6%-иар өссөн. 2007 оны эхний 8 сарын инфляцийн бараг 50% нь зөвхөн мах болон нефть гэсэн хоёр барааны үнийн өсөлтөөс хамаарч, сүүлийн зургаан жилд махны үнэ бараг 3 дахин, шатахууны үнэ 2.4 дахин өссөнийг Монголбанкнаас гаргасан 2008 оны төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тэмдэглэсэн байна. Энэ хоёр барааны үнийн өсөлт 2007 оны эхний улиралд эхэлснийг

Сангийн яам тэмдэглэсэн байсан.²¹ 2007 оны 6-р сар гэхэд мах, махан бүтээгдэхүүний үнэ 2006 оны 12-р сараас 31.1%-иар өссөн.

2007 оны 8-р сард нэг сарын дотор гурил, будааны үнэ өмнөх жилээс огцом буюу 13%, өөх тосны үнэ 16.8%-иар тус тус өсчээ. Мөн хугацаанд нүүрсний үнэ 16.7%, түлшний мод 11.1%, хот хоорондын таксины үнэ 25%, дотоодын төмөр замын тариф 47%-иар өссөн байна. Орон сууцны түрээс 11.3%, бензиний үнэ 9-9.5%, боловсролын үйлчилгээний үнэ мөн 20.2%-иар өсч, хуучин, шинэ орон сууцны үнэ албан бус ажиглалтаар сарын дотор 20-30%-иар нэмэгдсэн байна.

Хэдийгээр 2007 оны 9-р сарын байдлаар нийт хэрэглээний сагсны үнийн түвшин өнгөрсөн оны мөн үеийнхээс 13.2%, өмнөх оны жилийн эцсийнхээс 12.2%-иар өссөн боловч түүний дотор хүнсний бараа, ялангуяа мах, махан бүтээгдэхүүний үнэ огцом өссөн нь, мөн ундаа, ус, хувцас, бөс бараа, гутал, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа, орон сууц, ус, цахилгаан, түлшний үнэ бас өссөн нь хэрэглэгчдэд хүнд цохилт болж байна.

1990-ээд оны сүүлээс макро эдийн засгийн тогтворжилтын бодлого амжилттай хэрэгжиж, эдийн засаг тогтворжсоны үр дүнд 1992 онд жилийн 325%-д хүрч байсан инфляци 2002 онд 1.4% болж буурсан боловч сүүлийн жилүүдэд Монголын эдийн засагт инфляцийн аюул дахин нүүрлэх болов. Үүний шалтгаан нь зохиомол хомсдол, юаны ханш, шатахууны нийлүүлэлт дэх “картель”, Засгийн газрын “бүтээн байгуулалт” уул уурхайн салбар дахь орлогын өсөлт, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт юм. Энэ нь манай эдийн засгийн бүтэц, суурь нь нилээд тогтворгүй, эрсдэлтэй, эдийн засгийн хувьд улам эмзэг болж байгааг харуулж байгаа юм.

²⁰ Үнийн өсөлтийг хязгаарлахын тулд Засгийн газар 2 жил дараалан махны нийлүүлэлтийг тогтворжуулах тусгай арга хэмжээ авсан.

²¹ Эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн биелэлтийн үнэлгээ, Сангийн яам

Хүснэгт 1.2. Хүнсний хэрэглээний хувь, хүнсний импортын хэмжээ

	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Өрхийн хэрэглээний мөнгөн зарлагад хүнсний хэрэглээний эзлэх хувь	47.4	49.5	47.9	42.9	41.6	41.7	42.5	40.8	32.0	31.0	30.6	30.4
Үр тарианы импортын хэмжээ, мян.тонн	-	-	17.3	46.5	18.2	92.2	29.2	139.3	61.5	114.9	97.5	102.2

Эх үүсвэр: УСГ, 2006

Үнийн түвшин 2007 оны 2-р хагасаас огцом өсөх болсон нь маш олон шалтгаантай. Нэг талаас 2006 оноос эхлэн шат дараалан төрийн албан хаагчдын цалинг өсгөх арга хэмжээ авсан нь манай эдийн засагт үнийн хөөрөгдлийг бий болгоход түлхэц өгч, макро эдийн засгийн тэнцвэрийг алдагдуулахад хүргээд байна. Үүгээр барахгүй 2008 онд цалинг өсгөх тухай шийдвэрийг олон нийтэд зарласан нь нийт үнийн түвшинг нэмэгдүүлэхэд хүргэлээ. Нөгөө талаас Монголын эдийн засаг сүүлийн жилүүдэд маш эрчимтэй өсч, ДНБ 2004 онд 10.6%, 2006 онд 8.6%, 2007 онд бараг 9%-ийн өсөлттэй гарах гэж байгаа нь бараа, үйлчилгээний эрэлтийг идэвхжүүлэв.

Эрчимтэй эдийн засгийн өсөлтөөс Монголын өнөөгийн зах зээлийн тогтолцоо, бөөний болон жижиглэнгийн худалдааны үр ашиггүй бүтэц, дэд бүтэц, тээвэр болон эрчим хүч, замын сүлжээний хөгжил ихээхэн хоцорч, оновчгүй бодлогын улмаас 2007 оны хавраас эхлэн эдийн засаг “хэт халах” буюу нийлүүлэлт нь эрэлтээ хангахаа больсон.

Хүмүүсийн гар дээрх мөнгөний хэмжээ өссөн байхад нийлүүлэлтийн хувьд Монголын зах зээл импортын бараанаас сүүлийн жилүүдэд хэт их хараат болсон. 1997 оноос хойш хүнсний импортын хэмжээ, хувь нь өсч, үр тарианы импорт 5 дахин, гурилын импорт сүүлийн жилд 75.2-105.6 мянган

тонн болж өслөө. Үүний зэрэгцээ 2003-2006 оны хооронд буудайн дотоодын үйлдвэрлэл 160.4-127.8 мянган тонн болж, үр тарианы үйлдвэрлэл 165-138.6 мянган тонн болж тус тус буурлаа. Тариалсан талбайн хэмжээ гурван жилийн дотор 225-162 мянган га хүртэл багасчээ²² /Хүснэгт 1.2/.

Монголын төмөр замын ачаалал, дэд бүтэц нь даацаасаа хэтэрч, зах зээлд барааг цаг хугацаанд нийлүүлэх чадваргүй боллоо. Хэдийгээр эрэлт ихэсч, нийлүүлэлт багассан үед үнийн түвшин зах зээлийг зохицуулж өсдөг боловч түүнээс гадна дээрх дурдсан хүчин зүйлстэй шууд холбоогүй атлаа түүнийг далимдуулан зах зээл дэх нийлүүлэлтийг зохиомлоор багасгасан, олон салбарт үнийн хөөрөгдөл, зохиомол өсөлт бий болгосон явдал ажиглагдлаа. Энэхүү үнийн зохиомол өсөлт, хөөрөгдлийг зах зээлд бий болгодог гол нөхцөл нь шударга бус өрсөлдөөн юм.

Дээрх байдлаас харахад импортын үнэ өсөөгүй, валютын ханш тогтвортой, нийлүүлэлт хэвийн байгаа тохиолдолд үнийн огцом өсөлтүүд ажиглагдаж байгаа бол эдгээр салбарууд шударга бус өрсөлдөөнд автагдсан гэж дүгнэж болно.

Мөн шударга бус өрсөлдөөн нь үнийн хөөрөгдөл, нийлүүлэлтийн хиймэл хязгаар-

²² Дотоодын нийлүүлэлт ийнхүү багассан тохиолдолд хүн амын хэрэгцээг хангах, үнийн өсөлтийг хязгаарлахын тулд импортыг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлага гарч байгаа.

лалтыг бий болгодог. Шударга бус өрсөлдөөнд зах зээлийн өрсөлдөөнгүй, хуваарилалтыг зах зээлийн жамаар хийдэггүй салбарууд илүү автамттай байна. Жишээлбэл, уул уурхайн салбар, газрын хуваарилалт, тендэрийн үйл ажиллагааг дурьдаж болно. Аль алинд нь шударга бус өрсөлдөөн бий болсноор улс их хэмжээгээр хохирч, орох ёстой орлого нь хувь хүмүүсийн авилгын орлого болон хувирч, нийгэмд маш их хэмжээний хохирол учирч байгаа юм. Тендэрийн үйл ажиллагааг жишээ

болговол, шударга бус өрсөлдөөнөөс болж, хамгийн хямд, чанартай бараа, бүтээгдэхүүн сонгогдохгүй, татвар төлөгч нарын мөнгө үрэн таран цацагдаж, хэрэглэгч нарт чанар муутай, өндөр үнэтэй бараа нийлүүлэгдэж байна. Тендэрт зориулагдаж байгаа төсвийн хөрөнгө, зээл тусламжийн хэмжээ өсөх тусмаа хохирлын хэмжээ ч өсч байна.

Ийнхүү шударга бус өрсөлдөөнтэй тууштай тэмцэх, шударга өрсөлдөөнийг хамгаалах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

БҮЛЭГ 2.

Зах зээлийн өрсөлдөөн ба зохицуулалт

2.1. ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ЗАСАГЛАЛ БА ӨРСӨЛДӨӨН

Өрсөлдөөн нь зах зээлийн эдийн засгийн тулгуур ойлголтын нэг бөгөөд эдийн засгийн эрх чөлөөтэй гүнзгий уялдаа холбоотой. Шударга өрсөлдөөн нь эдийн засгийг эрүүлжүүлж, хөгжил дэвшилд хүргэдэг бол шударга бус өрсөлдөөн нь хоцрогдол, ядуурал, сүйрэлд хүргэдэг. Өмнөх бүлэгт дурдсан эдийн засгийн эрх чөлөөний судалгаанаас харахад нэг талаас эдийн засгийн эрх чөлөө засгийн газрын хэт оролцоог үгүйсгэж байгаа мэт харагдаж байгаа боловч нөгөө талаас эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулахын тулд төрийн оновчтой оролцоо хэд хэдэн талаасаа зайлшгүй хэрэгтэй болдог. Өмчийн эрхийн халдашгүй байдлыг хамгаалах, гэрээ хэлцлийн биелэлтийн нөхцлийг бүрдүүлж өгөх, шударга бус өрсөлдөөнийг хязгаарлахад төрийн оролцоо маш чухал үүрэг гүйцэтгэдэг.²³

Зах зээлийн үйл ажиллагаа хэвийн явагдах, аж ахуй эрхлэгчид болон хэрэглэгчид, нийгэм өөрөө зах зээлийн эдийн засгаас

аль болох ихээр хожихын тулд зах зээлийн өрсөлдөөн шударга явагдах ёстой. Харин өрсөлдөөн шударга явагдахад төрийн эдийн засгийн зохицуулалт чухал үүрэгтэй. Иймээс шударга бус өрсөлдөөнтэй тэмцэхийн тулд эрх зүйн орчин нь боловсронгуй байх, түүнийг хэрэгжүүлэх төрийн чадавхи зайлшгүй чухал юм.

Нэгэнт зах зээлийн эдийн засаг тодорхой дүрмийн дагуу, тодорхой хууль эрх зүйн орчинд үйл ажиллагаагаа явуулдаг тул эдгээр дүрэм, хууль эрх зүйн орчны бүрдүүлэлт, биелэлт ба хөгжил нь төрийн үүрэг гарцаагүй мөн. Зах зээлийн үйл ажиллагааны үр өгөөж нь төрөөс шууд хамаарч байна. Үүнийг Нобелийн шагналт эдийн засагч Д. Норт: “Улс төр, институци²⁴ нь өмчийн эрхийг хамгаалж, гэрээ, хэлцлийн биелэлтийг хэрэгжүүлэх гол арга зам, нөөц, боломжийг олгож, зах зээлийн үр өгөөжийг тодорхойлдог”²⁵ гэж тайлбарлажээ. Жишээлбэл, компанийн өмчийн эрх хангалттай хамгаалагдаагүй, гэрээний биелэлт төвөгтэй байдаг тохиолдолд татвар төлдөг хэмжээнээсээ компаниудад гурав дахин илүү их зардал учирдаг гэсэн тооцоо байдаг бөгөөд уг

²³ Дээр дурдсан эдийн засгийн эрх чөлөөний үндсэн нөхцөл болох өмчийн эрх ба гэрээний биелэлтийн тухай Нээлттэй Нийгэм Форум, МУИС-ийн ЭЗС-ийн судлаачид 2006 оны эдийн засгийн эрх чөлөөний тойм судалгааны хүрээнд судалсан билээ.

²⁴ Институцийн тухай дэлгэрэнгүй ойлголтыг “Эдийн засгийн эрх чөлөөний тойм 2006”-гаас үзнэ үү.

²⁵ Institutions, Organizations And Market Competition*, Douglass C. North, Washington University, St. Louis

зардал нь нийт борлуулалтын 25%-тай тэнцэх хүртэл түвшинд хүрдэг²⁶. Тэгэхээр эдийн засгийг хөгжүүлэх, нийгмийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд төрөөс бизнесийн орчныг зохицуулах, бүрдүүлэх нь бизнесийн хөгжилд нэн чухал байдаг нь ойлгомжтой.

Фрейзер Институт болон Херитэж сангийн эдийн засгийн эрх чөлөөний индекст төрийн зохицуулалт, эрх зүйн үндсэн ойлголтууд маш чухал байр суурийг эзэлж, бүгд ямар нэгэн байдлаар тухайн салбарын зохицуулалтыг хэмждэг.

Тиймээс зах зээлийн өрсөлдөөнийг нийгмийн сайн сайхан байдалд нийцүүлэх зорилгоор өрсөлдөөнийг хянан зохицуулахад **шударга бус өрсөлдөөнөөс бусад үйлдвэрлэгчдийг хамгаалах, том үйлдвэрлэгчид зах зээл дээр давамгайл байрлах тогтоохоос сэргийлэх, мөн давамгайл байрлах урвуулан ашиглахыг хориглох, буруу зар сурталчилгаа явуулахыг хориглох, шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх зорилгоор нэгдэн нийлэх, хуйвалдахаас урьдчилан сэргийлэх** гэх зэрэг үйл явц маш чухал юм. Эдгээр зохистой бус үйл ажиллагааг зохицуулахын тулд монополийн эсрэг хууль үйлчилж байдаг. Үүнтэй уялдан улс орнуудын өрсөлдөөний асуудлыг хянан зохицуулах газрын эрх, үүрэг, хариуцлага шинэчлэгдсээр л байна. Өндөр хөгжсөн орнууд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг компанийн эрх ашгийг хамгаалахаас илүү эрхэмлэдэг бөгөөд тухайн улсын зохицуулалтын чанар, хүрээнээс шалтгаалж өөр өөр байдаг.

Хуулийн хэрэгжилт нь төр зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлж, шүүхийн тогтолцоо, хууль хэрэгжүүлэгч агентлаг, төрийн яам, байгууллагуудаар дамжуулан хувийн өмчийн

халдашгүй эрхийг хамгаалах үүргийг биелүүлдэг учраас засаглал сул, дорой, хуулиуд нь боловсронгуй бус, хэрэгжилт нь хангалтгүй байвал эдийн засгийн эрх чөлөөний байдал эрс дорддог.

Шударга бус өрсөлдөөн давамгайлдаг бол эдийн засгийн эрх чөлөө ихээхэн боогддог бөгөөд өрсөлдөөгүй нөхцөлд хэрэглэгчид хэт өндөр үнэ төлөх, компаниуд техникийн шинэчлэл хийхээ зогсоох, хөрөнгө оруулалтаа багасгах, шинийг санаачлахаа зогсоох зэрэг олон сөрөг үр дагавар гарч, улс орон өөрөө дэлхийн зах зээл дэх өрсөлдөх чадвараа хүртэл алддаг. Жишээлбэл, өрсөлдөж байгаа компаниудыг өрсөлдөөнтэй орчинд ажиллаагүй компаниудтай харьцуулахад инновацийг нэвтрүүлэх магадлал нь 50%-иар илүү өндөр байдаг.

Шударга бус өрсөлдөөний улмаас техникийн шинэчлэл, эдийн засгийн өсөлт удааширч, тэр хэмжээгээр шинэ ажлын байр бий болдоггүй. Хуйвалдааны аргаар зах зээлээ хуваасан компаниуд улсын төсвөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтыг ч ялгаагүй хуйвалдан хуваахын тулд улс төрд нөлөөлж, улс орон авилгад автагдах магадлал маш өндөр болдог.

Өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих бодлого явуулсан өндөр хөгжилтэй орнуудын судалгаанаас харахад эрх зүйн шинэчлэлийг бий болгож, өрсөлдөөнийг дэмжсэн арга хэмжээ авсан салбаруудын хувьд, жишээ нь АНУ-д ДНБ-ий 7%-тай тэнцэх жилийн ашиг бий болж, түүний 90%-ийг хэрэглэгчдэд дахин хуваарилсан гэсэн тооцоо байдаг байна.

Хөгжиж буй орнуудад хийгдэж буй өрсөлдөөнийг дэмжсэн шинэчлэл мөн ижил үр дүнд хүргэж байгаа тухай мэдээ байдаг. Бангладеш улс гэхэд л үүрэн холбооны салбараа чөлөөлсний үр дүнд шинэ үүрэн холбооны

²⁶ Investment report, 2005

компаниуд хөдөө орон нутагт өөрийн салбаруудаа олноор нээж, 2004 он гэхэд шинэ салбарууд 5000 тосгон, 12.5 сая хүнийг үүрэн утасны холбоотой болгосноос гадна олон ажлын байрыг шинээр бий болгожээ.

Монгол улсад үүрэн холбооны салбар чөлөөт өрсөлдөөнтэй болсноос хойш Скайтел, Жи Мобайл, Юнител зэрэг олон компаниуд бий болж, хэрэглээний үнэ тариф ихээхэн буурч, олон мянган шинэ ажлын байр бий болсон. Эдгээр жишээнээс харахад шударга өрсөлдөөн зөвхөн хэрэглэгчдэд хямд үнэ, илүү өргөн сонголтыг бий болгохоос гадна нийт эдийн засагт асар их эерэг нөлөөг үзүүлдэг нь ойлгомжтой байна.

2.2. ӨРСӨЛДӨӨНИЙ БҮТЭЦ БА ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨН

Зах зээлийн шударга, эрүүл өрсөлдөөнийг Адам Смитийн үеэс эхлээд өнөөг хүртэлх хугацаанд нийгмийн сайн сайхан байдал болон нийгмийн янз бүрийн зорилгуудад хүрэх гол арга хэрэгсэл гэж үзэж ирсэн. Худалдаж, худалдан авах үйл ажиллагаа хэрэгжиж буй газар бүхэнд зах зээл байдаг. Зах зээлд бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үнийн ба үнийн бус хүчин зүйлийн өрсөлдөөний үр дүнд хүмүүст сайн сайхан байдлыг бий болгож, тэдний эрх ашигт нийцэж байх зүй тогтолтой.

Зах зээлийг барааны төрөл болон өрсөлдөөнөөс шалтгаалан хоёр ангилдаг.

- Чанар, хийц, дизайны хувьд адил төстэй бараа нь ижил төрлийн барааны зах зээл / *homogeneous goods market*/ дээр худалдаалагдах бөгөөд зөвхөн аль нэг үзүүлэлтэд үндэслэн үнэ нь тогтоогддог. Жишээ нь, алтыг Монголд, эсвэл Америкт олборлосон нь чухал бус; бараа нь өөрөө алт учраас түүний

үнийг тогтооход алтны сорьц л чухал юм. Газрын тос, төмөр, нүүрс гэх мэт бараа бүтээгдэхүүн өөрийн гол үзүүлэлт болох илчлэг, коксжих болон энгийн гэсэн аль нэг үндсэн үзүүлэлтээрээ үнэлэгддэг. Ийм бараа борлуулдаг өрсөлдөгч компаниудын бүтээгдэхүүн зарчмын хувьд ижил болж байгаа учраас хэрэглэгчид зөвхөн аль хямд байгааг нь сонгодог тул *ижил төрлийн барааны зах зээл* гэж эдийн засгийн онолд тодорхойлдог. Ийм зах зээлд үнийн өрсөлдөөн давамгайлдаг онцлогтой.

- Пүүсийн нэр, дизайн, брэнд, чанар гэх мэт олон талаар ялгаатай барааны зах зээлд үнийн бус өрсөлдөөн давамгайлдаг бөгөөд эдгээр барааны хувьд аль нэг голлох үзүүлэлт гэхээсээ илүү тус барааны онцлогийг харгалзсан өрсөлдөөн явагдаж болно. Үүнийг *ялгаатай барааны зах зээл /differentiated goods market/* гэж нэрлэдэг. Энэ төрлийн зах зээл дээр бараг бүх төрлийн аж үйлдвэрийн болон брэндийн бараа худалдаалагддаг. Тухайлбал, Форд, Тоёота хоёулаа машин үйлдвэрлэдэг боловч хэрэглэгчид машин худалдан авахдаа зөвхөн үнэ бус, бусад хүчин зүйлийг үндэслэн сонголтоо хийдэг. Ливайс жинсэн өмд ердийн хятад жинс хоёр жинс гэдгээрээ адил боловч брэндийн нэрээр Ливайсын үнэ өрсөлдөгчийн үнээс 10-100 дахин өндөр ч байж болно.

Тэгэхээр өрсөлдөөнт зах зээлд олон нэр төрлийн хийгээд ялгаатай болон ижил төрлийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг үйлдвэрлэгчид зах зээлд боломжит үнээр нийлүүлж, хэрэглэгчид зөв мэдээллийн үндсэн дээр тэдгээр бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнээс зөв сонголт хийх боломжтой

болдог бөгөөд хамгийн чухал нь өрсөлдөөн шударга явагдах ёстой.

Өрсөлдөөнт зах зээлд үйлдвэрлэгчдийн тоо, хэмжээ харилцан адилгүй байж, үйлдвэрлэгчид зах зээлд нэвтрэх болон зах зээлээс гарах үйл явц чөлөөтэй, үнэ өөрөө хяналт зохицуулалтаас чөлөөтэй, мэдээлэл хангалттай, хүрэлцээтэй байхын сацуу зар сурталчилгаа хэрэглэгчдэд шинэ бараа бүтээгдэхүүний талаар зөв мэдээлэл өгч байх учиртай. Үнэн хэрэгтээ бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ зөвхөн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр зохицуулагдаж байх ёстой.

Аль нэгэн үйлдвэрлэгч зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн харьцаагаар зохицуулагдсан үнэд бие даан нөлөөлөх бололцоогүй, ямар нэгэн компанийн үйлдлээс болоод зах зээлийн үнэ өөрчлөгдөх боломжгүй өрсөлдөөнийг *төгс өрсөлдөөн* гэж нэрлэдэг.

Төгс өрсөлдөөний зах зээлд хэрэглэгчид мэдээллийг зөв эх үүсвэрээс хангалттай хэмжээгээр олж, харилцан зөв ашигласнаар зөв, сайн сонголт хийх нь мэдээж. Зөв, сайн сонголт хийхэд зах зээлийн тухай, зах зээлийн өрсөлдөөнд нийцтэй институциуд, нийгмийн сэтгэл зүй зөв бүрэлдэн тогтвор хувь хүн, айл өрх, аж ахуй эрхлэгчид, засгийн газар, ер нь зах зээлийн харилцаанд оролцож буй ямар ч талуудын үйл хөдлөл зөв гольдролдоо орж, машин механизмын эд ангиуд шиг аажмаар зугуухан хөдөлж эхлээд цаашдаа тасралтгүй ажиллах боломжтой болох бөгөөд энэ төрлийн зах зээл нийгэмд хамгийн их ашгийг авчрах болно.

Иймээс өрсөлдөөнийг дэмжих нь дараах маш чухал үүрэг, нийгэм-эдийн засгийн үр дагавартай:

- *Нийгмийн сайн сайхан байдлыг хангаж, аж ахуйн үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх, хэрэглэгчдийн*

эрх ашгийг хамгаалдаг. Хувь хүний сонголтын боломжийг өргөжүүлж, чадавхийг дээшлүүлэн эдийн засгийн чадавхийг сайжруулах нь зах зээлийн өрсөлдөөний гол зорилго юм. Зах зээлийн өрсөлдөөнийг хөгжүүлэхдээ нийгэм, эдийн засаг, улс төр, хууль эрх зүй, институцийн тааламжтай орчныг бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай юм.

- *Зах зээлийн шударга өрсөлдөөн нь хувь хүний сонголтыг өргөжүүлдэг.* Аж ахуйн бүх салбаруудад өрсөлдөгч компаниуд чөлөөтэй нэвтрэн орж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгон хүмүүсийн болон компаниудын сонголтыг өргөжүүлнэ.
- Өрсөлдөөний оновчтой хууль эрх зүйн орчныг бий болгосноор *зах зээлийн тогтолцоо нийгмийн үр ашигтай хуваарилалтыг* бий болгож чадна. Өрсөлдөөн нь зохицуулалтыг орлуулах биш, харин эдгээрийг хослуулж авч үзсэнээр шударга өрсөлдөөнийг хөгжүүлэх боломжтой.

Төгс бус өрсөлдөөн

Амьдралд *төгс өрсөлдөөн* тэр болгон хэрэгжих боломжгүй байдаг. Өрсөлдөөний явцад компаниудаас хамгийн үр өгөөжтэй, өрсөлдөх чадвартай цөөн компаниуд шалгарч, зах зээлд эзлэх хувь нь аажмаар томорч, зах зээлд ноёрхож эхэлдэг. Үүнийг эдийн засгийн ухаанд *төгс бус өрсөлдөөн* гэж үзэн хэлбэрээс нь хамааруулан *монополь, олигополь, монопольт өрсөлдөөний зах* зээл гэж ангилан судалдаг.²⁷

²⁷ Зах зээлийн өрсөлдөөнийг зах зээлийн үйл ажиллагаанд оролцож буй талуудын үйл хөдлөлтэй холбон тайлбарлах чөлөөт зах зээлийн өрсөлдөөний тухай эдийн засгийн сэтгэлгээ (А.Смит, 1776) бүрэлдэн тогтож, төгс өрсөлдөөний тухай онол, загварууд (Л.Вальрас, 1874; В.Парето 1906) ба төгс бус өрсөлдөөний тухай онолууд (Курно, 1838, Бертран, 1870, А.Маршалл, 1890; Э.Чемберлин, Ж.Робинсон, 1933) залгамжлан хөгжсөн.

- *Монополь зах зээлд* нэг л компани ноёрхдог ба уг зах зээл бий болох хоёр шалтгаан байдаг. Үүнд:
 - *Аргагүй монополь* салбар. Нэг салбарт нэг л том үйлдвэрлэгч ойрын нөхөн орлуулагчгүйгээр үйл ажиллагаа явуулах техникийн болон эдийн засгийн нөхцөл бүрэлдэхийг хэлнэ. Мөн энэ салбарт бусад компаниуд ороход хэцүү байдаг нь *аргагүй/зүй ёсны*²⁸ *монополийн* онцлог юм. Ийм *зүй ёсны монополийг* төрөөс шууд зохицуулах шаардлага гардаг.²⁹
 - *Цэвэр монополь* зах зээл. Энэ зах зээл дээр зах зээлийн өрсөлдөөнд үйл ажиллагаагаа бэхжүүлэн тогтвортой оршин тогтнож, ялгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэн, ялгаатай хэрэглэгчдэд ялгаатай үнээр борлуулдаг үйлдвэрлэгчид орно.
- Олигополийн өрсөлдөөнд хэд хэдэн компани өрсөлдөж, зах зээлийн үнийг тогтоодог. Олигопольт өрсөлдөөнд

цөөхөн компаниуд зах зээлийг бүрэн эзэлсэн тохиолдол ч байж болно. Мөн нэг, эсвэл цөөн компаниуд зах зээлийн дийлэнхийг мэдэлдээ авч, тэдэнтэй олон жижиг компаниуд өрсөлддөг боловч зах зээлийн үнийг томоохон компаниуд тогтоодог байж болно.

- Монопольт өрсөлдөөнд компани болгон барааны ялгаварлалын хүчээр зах зээлийг хуваан авч, зөвхөн өөрийн хэсэгтээ ноёрхлоо тогтоон өрсөлддөг. Зах зээлийн хэлбэр тус бүрд үйлдвэрлэгчдийн тоо, хэмжээ харилцан адилгүй, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ ялгаатай бүрэлдэн тогтдог. Зах зээлд нэвтрэх боломж өөр, үнийн хяналтын бодлого ч өөр өөр байсаар ирсэн, өөр байна, гэвч монополиуд өөрийн ноёрхлоо хадгалахын тулд бусад компаниудыг зах зээлдээ нэвтрүүлэхгүй байхыг хичээдэг тул ийм хандлага урт хугацаандаа ч байх магадлалтай. Монопольт өрсөлдөөнийг голдуу аж үйлдвэрийн бараатай холбож тайлбарладаг бөгөөд ийм өрсөлдөөнд орсон компани өөрийн монопольт зах зээлийг ялгаварлалын хүчин зүйлээр бий болгодог тул өрсөлдөөнд оршин тогтнохын тулд зах зээлд хүчтэй брэндүүд байх ёстой гэж үздэг.

Монголд өнөөгийн байдлаар гадаадын брэнд олноор орж ирсэн байгаа боловч дотоодын брэнд харьцангуй цөөн байна. Энэ нь нийт орлогын түвшин хараахан доогуур байгаа, хэрэглэгчид дотоодод үйлдвэрлэсэн барааг сонгохдоо үйлдвэрлэгчийг бус, аль хямд барааг сонгох сонирхолтой байгаатай холбоотой. Гэхдээ сүүлийн жилүүдэд хэд хэдэн хүчтэй брэндүүд гарч ирж (тухайлбал, Говь, СББ-ын брэндийн бүтээгдэхүүн, ГЕМ-ын бүтээгдэхүүн гэх мэт), зах зээлийн үнээс

²⁸ Монгол улсын “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хуулинд ийм шинжтэй монополийг зүй ёсны монополь гэж тодорхойлсон байдаг. Цаашид хуулийн хэллэгээр зүй ёсны монополь гэсэн нэр томъёог түлхүү хэрэглэх боловч эдийн засгийн онолд зүй ёсны монополийг аргагүй монополь гэж бас тодорхойлдог.

²⁹ Үүний тод жишээ гэвэл, цахилгааны үйлдвэрлэлд хэрэглэгчдэд хүрэх хүртлээ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах гэсэн дөрвөн шатыг дамжиж байгаа бөгөөд дамжуулан түгээх үйл ажиллагаа асар их хөрөнгө оруулалтыг шаарддаг цахилгаан эрчим хүчний сүлжээг байгуулах хэрэгтэй болдог. Тус зардал маш өндөр байдаг болохоор нэг оронд нэг л цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээ байх нь зохимжтой бөгөөд цахилгааны сүлжээнүүд хоорондоо өрсөлдөнө гэсэн ойлголт байдаггүй. Зүй ёсны монополийн шинж чанартай хүнд аж үйлдвэр, тээвэр, холбоо гм салбарууд хөгжих тусам уламжлалт зах зээлийн эдийн засгийн онолд өрсөлдөөн гол хүч болж, өрсөлдөөнийг дангаар нь голлон тайлбарлаж байсан чиглэл түүхэн явцдаа өөрчлөгдөж, өнөө үед эдийн засагч нар өрсөлдөөн ба зохицуулалт нь харилцан хослох, зайлшгүй хамттай байх ёстой гэж үздэг болсон. Нийтийн зорчигч тээвэр, тэр дотроос агаарын тээвэр, төмөр зам, автобус, троллейбусны үйлчилгээ нь зохицуулалттай салбар юм. Эдгээр салбарт үнэ бүрэлдэх механизм эрэлт, нийлүүлэлтийн харилцан үйлчлэлээр зах зээлийн өрсөлдөөний үндсэн дээр тогтохгүй, “зүй ёсны монополийн” шинж чанарыг заримдаа агуулсан байдаг ба үнийг нь төрөөс зохицуулдаг.

илүү өндөр үнээр борлогдож байгаатай холбоотой цаашид энэ төрлийн өрсөлдөөн манайд улам хөгжих нь гарцаагүй.

Шударга бус өрсөлдөөн

Төгс бус өрсөлдөөнт буюу зах зээлд цөөн тооны компаниуд давамгайлж, зах зээлийн үнэ, нийлүүлэлтэд нөлөөлөх, өрсөлдөгчөө шударга бусаар шахан дарамтлах бололцоотой болсноор *шударга бус өрсөлдөөн* бий болох нөхцлийг бүрдүүлдэг. Хэрэв аль нэг зах зээлд өрсөлдөөний цар хүрээ хязгаарлагдаж эхэлбэл зах зээлийн өрсөлдөөн шударга бус болон хувирч, нийгэмд ихээхэн хохирол учирна.

Аль 18-р зууны эхэнд зах зээлийн эдийн засгийн ухааныг үндэслэгч Адам Смит шударга бус өрсөлдөөний тухай тэмдэглэхдээ: “... *монополизм компаниуд барааны нийлүүлэлтийг байнга хязгаарлалттай байлгах аргаар эрэлтийг бүрэн хангахгүйгээр бодит үнээс илүү өндөр үнээр бараагаа борлуулж, өөрийн ашигаа хэт өндөр байлгадаг*”³⁰ гэжээ.

Зах зээлд ноёрхож байгаа компаниуд өөрийн давамгайл байдлаа ашиглан өндөр үнэ тогтоож, өрсөлдөөнийг хязгаарласнаар эдийн засгийн өсөлтийн сааралт, хэт өндөр монополизм ашиг, инновацийн зогсонги байдал зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог.

Өрсөлдөөнгүй зах зээлд давамгайл байдалтай компани бүтээгдэхүүний үнийг бууруулах, чанарыг дээшлүүлэх мотиваци байхгүй болдог тул барааны үнэ хэт өндөр болж, чанар муудаж, эцэстээ хэрэглэгчид хохирдог. Өрсөлдөгчгүй болсон компаниуд бүтээгдэхүүнээ шинэчлэх, шинэ бараа бий болгох сонирхолгүй болдог учраас

инновацийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, нийт хөрөнгө оруулалт багасч, тус салбарын өсөлт удааширдаг. Шинийг санаачлахгүй, өндөр үнээр хэт ашиг олох сонирхолтой болсон компаниуд зах зээлд шинээр компани нэвтрэн ороход нь төрөл бүрийн саад тотгор бий болгож, улмаар зах зээлийн нийлүүлэлтийг багасгаж, үнийг өндөр түвшинд хадгалахыг хичээдэг.

Шударга бус өрсөлдөөн олон хэлбэр, төрөлтэй боловч сөрөг нөлөө ихтэй, ихэнх орнуудад хуулиар хориглосон шударга бус өрсөлдөөний нийтлэг гурван хэлбэр байна. Үүнд:

1. *Үнэ тогтоох явдал* /price fixing/. Өрсөлдөгч компаниудын хоорондох үнийг өсгөх, тогтоох, эсвэл тодорхой түвшинд хадгалах талаар тохиролцдог. Тухайн тохиролцоо заавал бичгээр байх албагүй, мөн компаниудын тохиролцсон үнүүд 100% ижил байх шаардлагагүй, ямар нэгэн байдлаар үнээр өрсөлдөх явдлыг хязгаарласан, үнийг янз бүрийн түвшинд тогтоож, ялгаварласан байвал гэмт хэрэг гэж тооцогддог. /Зохицуулалтын хэсгээс дэлгэрэнгүйг үзнэ үү./
2. *Тендэрийн гажуудал* /bid rigging/. Төрийн байгууллага худалдан авах тендэрийг зориудаар будлиулж, эхнээс нь тендэрт ялагчийг тодорхойлж, өрсөлдөөн байхгүй болгох замаар үнийг өсгөх явдал юм. Тендэрийн гажуудал хэд хэдэн хэлбэртэй байж болно. Тухайлбал:
 - Аль нэг тохиролцсон компанийг ялуулахын тулд өрсөлдөгч компаниуд тендэрт оролцох саналаа татан авдаг. Эсвэл аль нэг компани тендэрт өрсөлдөх гэж байхад нь түүнийг оролцуулдаггүй.

³⁰ Адам Смит, Улс орны баялаг, 1776 “The monopolists, by keeping the market constantly under-stocked, by never fully supplying the effectual demand, sell their commodities much above the natural price, and raise their emoluments, whether they consist in wages or profit, greatly above their natural rate”.

- Хорших санал өгөх буюу эхнээсээ тендэрт ялах ямар ч бололцоогүй хэт өндөр үнэтэй саналыг өгч, тохиролцсон компанид тендэрийг ялах боломжийг олгож, өрсөлдсөн дүр харуулдаг.
- Тендэрт оролцож, ээлжлэн бие биендээ ялах боломжийг олгоно. Худалдан авах барааны хэмжээ, төрлөөс шалтгаалан тодорхой компанид хуваарилах явдал бас байж болно.
- Дэд гэрээний арга буюу бага үнэтэй өрсөлдөгч компани тендэрт оролцохгүй боловч эргээд түүний шанд тендэрт ялсан илүү өндөр үнэтэй компаниас захиалгыг тендэрийн дэд гэрээний байдлаар авч, ашгаа хуваана.

3. *Зах зээлийг хуваах явдал* /market division/. Компаниуд хоорондоо тохиролцсоны үндсэн дээр зах зээлийг газар зүйн байдлаар, барааны төрлөөр, эсвэл худалдан авагчийн төрлөөр хуваахыг хэлнэ. Жишээ нь, нэг компани зөвхөн нэг дүүрэгт бараа нийлүүлж, бусад дүүрэгт барааг худалдахгүй бөгөөд өрсөлдөгч нар нь ч өөр өөрийн дүүрэгтээ бараагаа худалдана. Тухайн компанид өөр дүүргээс тэдний бараа авах санал тавьсан ч хэт өндөр үнийг хэлж барааг борлуулахгүй байх жишээтэй байж болно.³¹

Үүнээс гадна шударга бус өрсөлдөөний өөр төрлийн хэлбэрүүд ч байж болох ба дээр дурдсан хэлбэрүүд түгээмэл бөгөөд хамгийн сөрөг нөлөөтэй.

Компаниуд өндөр ашиг олохын тулд өрсөлдөөнийг хязгаарлах олон төрлийн арга хэрэглэдэг. Өрсөлдөөнийг хязгаарлах дараах аргууд байна. Үүнд:

1. Компаниуд зах зээлд үгсэн хуйвалдаж, картель байгуулах замаар өрсөлдөөнийг хязгаарлаж, зах зээлийг газар зүйн байршил, барааны төрлөөр хуваан өндөр үнийг хадгалах арга. Картель нь хэд хэдэн компаниуд хамтарч, зах зээлийг хуваах гэрээ хэлцэл байгуулдаг учраас голдуу олигополь зах зээлийг үүсгэдэг. Картель үүсэхийн тулд олигополь зах зээл дээрх гишүүн компаниудын зах зээлийн нийт хувь харьцангуй өндөр байж, үнэ ба зах зээлийг бодитой хянадаг байх ёстой. Бусад тохиолдолд картелийн гишүүнд нэгдээгүй компаниуд картелийн үйл ажиллагаанд хүчтэй эсэргүүцэл үзүүлдэг. Мөн картельд нэгдсэнээр гишүүн компаниудын ашиг нэгдээгүй компаниудын ашгаас өндөр байх ёстой. Хэрэв аль нэг компани картелийн гишүүнчлэлээс татгалзан өрсөлдөгч нараас доогуур үнийг санал болгож, зах зээлийг өөртөө дангаар авах боломж гарвал тус компани картелиас гарах магадлал өндөр тул зах зээлийн нөхцөл өөрчлөгдөж, ийм бололцоонууд олноор бий болох тохиолдолд картелиуд тогтворгүй болж, амархан салан бутардаг. Мөн картелийн оршин тогтнох хугацаа, нөхцөл эдийн засгийн мөчлөгийн шат, нийт зах зээлийн байдлаас шалтгаалдаг. Тухайлбал, зах зээлийн борлуулалтын байдал сайн, эрэлт ихтэй, үгсэн хуйвалдахгүйгээр үнийг өндөр байлгах бололцоотой тохиолдолд картель үүсгэх шаардлага

³¹ “Price fixing, bid rigging and market allocation schemes: What they are and what to look for”, Citizen Complaint Center, Anti-trust Division, U.S. Dept. 950 Pennsylvania Ave. NW, Washington, DC 20530

гардаггүй. Эсрэгээр, зах зээлийн байдал муудах үед ашгаа хамгаалахын тулд картель байгуулах нь илүү үр дүнтэй байх тохиолдол байж болно. Гэвч зарим тохиолдолд хэт ашгийн хойноос хөөцөлдөж байгаа компаниуд зах зээлийн мөчлөгийн аль ч шатанд хуйвалдах сонирхолтой байдаг. Ихэнх тохиолдолд картелийг хууль бус гэж үздэг боловч ОПЕК зэргийн олон улсын албан ёсны картель бас байдгийг анхаарах хэрэгтэй. Гэхдээ ОПЕК-ийн тохиолдолд нэгдэж орсон талууд нь засгийн газрууд байдаг учраас ОПЕК-ийг энгийн картель гэж үзэж болохгүй. Картелийн хор уршгийг дараах жишээгээр харуулж болно. 1990 оны сүүлээр АНУ-ын Хууль зүйн яам витамин үйлдвэрлэгчдийн нууц картель байдгийг мэдсэн. Тус картель нийтдээ 5 тэрбум долларын витамин нийлүүлэлтийг хянаж байсан бөгөөд картелийн гишүүд компани болгоны үйлдвэрлэлийн хэмжээ (квот), бараа болгоны үнийг тохиролцож, худалдан авагчдыг хүртэл хувааж авсан байв. Үүнээс болж, витаминьг зах зээлийн үнээс илүү үнээр худалдаж авч байсан Женерал Миллс, Кока Кола, Тайсон Фудз болон Проктер энд Гэмбл зэрэг томоохон компаниуд хохирсон төдийгүй витамин орж байсан эдгээр компаниудын бүтээгдэхүүний үнэ бас өссөнтэй холбоотой энгийн хэрэглэгч нар ч мөн хохирсон. Тус картелийг судлахад АНУ, Герман, Швейцарь болон Японы компаниуд оролцсон бөгөөд хэрэг мөрдөлтийн эцэст дээд зэрэглэлийн хэд хэдэн менежерүүд шоронд орсон. Мөн Ф.Хоффман Ла Роше болон БАСФ

АГ компаниудад 500 сая болон 225 сая ам.долларын торгууль ногдуулж, нийтдээ картелийн гишүүдэд зөвхөн 1999 онд гэхэд л 850 сая ам.долларын торгууль ногдуулжээ.³²

2. Компаниуд өрсөлдөгч нарыг зах зээлээс шахан гаргах, нэвтрэн оруулахгүй, зориудаар саад учруулах замаар нийлүүлэлтийг хязгаарлан өндөр үнийг хадгалахыг эрмэлзэх арга. Энэ нь монополь болон олигополь зах зээлийн аль алинд ажиглагддаг. Жишээ нь, 2000 онд Японы томоохон улсын өмчтэй холбооны NTT East корпораци (Nippon Telegraph and Telephone East Corporation) утас, холбооны кабелийн дийлэнхийг эзэмшиж байсан бөгөөд тэдгээрээр дамжуулж өндөр хурдтай интернэтийн холболтыг түгээх гэсэн шинэ операторууд нэвтрэн ороход саад болж байгаа тухай Японы Шударга өрсөлдөөний комисс 2000 оны 12-р сард НТТ компанид сануулга өгсөн. Үүний үр дүнд НТТ компани тус үйл ажиллагаагаа зогсоосноор олон өрсөлдөгч компаниуд бий болж, эцэст нь АДСЛ-ын өндөр хурдтай интернэтийн зах зээл эрчимтэй хөгжиж, дэлхийд хамгийн өндөр хурдтай, холболтын болон интернэтийн хамгийн хямд тарифтай болжээ.³³

³² U.S. Department of Justice, Washington, D.C. 20530, Antitrust Enforcement and the Consumer

³³ Жишээ нь, 2007 оны 11-р сарын байдлаар Японд сарын 27 долларын төлбөрөөр секундэд 54 мегабитын хурдтай интернэтийн холболтыг захиалж болно. Харьцуулахад, Монголд хамгийн хямд үнэтэй байнгын холболттой интернэтийг хэд хэдэн компаниуд сарын ойролцоо 20 доллараар санал болгож байгаа бөгөөд түүний хурд нь секундэд 64 килобайт буюу дайл-ап модемийн холболттой бараг ижил хурдтай ба тэр нь бараг ижил үнээр Японд олдож байгаа 54 мбпс холболтоос 570 дахин удаан байна. Мэдээж, техникийн хувьд шууд харьцуулалтыг хийх нь буруу боловч, өрсөлдөөнийг хязгаарлаж байсан бол Японд ч гэсэн АДСЛ тийм хурдтай хөгжихгүй байх байсан.

3. Ноёрхож байгаа компани өрсөлдөгч нарын нийлүүлэгчийг худалдан авч, тэдний нийлүүлэлтийг зогсоох, эсвэл хэт өндөр үнэтэй болгох замаар өрсөлдөгчдөө хүнд байдалд оруулах арга. Үүнийг босоо интегралчлалын замаар өрсөлдөөнийг хязгаарлах гэж хэлдэг. Жишээ нь, Германы төмөр замын сүлжээний эзэмшигч болох Дойче Бан АГ (ДБ Нетц АГ), мөн тус төмөр замыг ашиглан өөрийн тээврийн үйлчилгээг DB Reise & Touristik, DB Regio AG, Railion нэрийн дор үзүүлдэг. 1994 оны тээврийн салбарын эрх зүйн шинэчлэлийн дагуу ДБ Нетц АГ-ын сүлжээг өөр тээврийн үйлчилгээний операторууд ашиглах эрхийг авсан хэдий ч төмөр замын эзэмшигч ДБ АГ өөрийн операторуудад хамгийн ашигтай тариф, түрээс, зам, сүлжээг олгож, өрсөлдөгчдөд далд аргаар илүү өндөр үнэтэй, ашиггүй нөхцлүүдийг санал болгож, засвар хийх нэрийн дор үйл ажиллагаанд нь саад учруулдаг гэж хувийн компаниуд үзжээ.³⁴
4. Холбоо, компьютер програмчлал, техникийн олон салбаруудад байдаг өөрийн өвөрмөц шударга бус өрсөлдөөний арга. Тухайлбал, DOS болон Windows үйлдлийн системийн үйлдвэрлэгч Майкрософт компани зах зээлд давамгайл байдалтай болсноо ашиглан өрсөлдөөний төрөл бүрийн бохир аргуудыг хэрэглэж байсан нь тогтоогджээ. 1990 оны эхээр Лотас компанийн 1-2-3 программ тооцооны хамгийн дэлгэрсэн программ байсан бөгөөд Майкрософтын бүтээгдэхүүн

болох эхсэлээс илүү өндөр зах зээлийн хувьтай байсан. Майкрософт компани өөрийн бүтээгдэхүүнээ дэлгэрүүлэхийн тулд DOS үйлдлийн системдээ олон удаа өөрчлөлтүүдийг оруулж, өөрчлөлт болгон нь Лотас компанийн 1-2-3 программыг ашиглах боломжгүй болгодог байсан. Хэдийгээр Лотас компани үйлдлийн систем болгоны өөрчлөлтийг даган программаа шинэчилдэг байсан боловч хэрэглэгчид үйлдлийн систем өөрчлөгдөх болгонд Лотас компанийн бүтээгдэхүүн ажиллахаа больж байснаас залхаж, эхсэл руу шилжиж эхэлсэн. Мөн Майкрософт компани 1990 оны дундуур хамгийн их эрэлттэй байсан интернэт браузер программ болох Нетскейптэй өрсөлдөхдөө өөрийн бүтээгдэхүүн болох Интернэт Эксплорерыг голлох компьютерын үйлдвэрлэгч компаниудад бүтээгдэхүүндээ суурилуулахыг хүчээр тулган, Нетскейпийн бүтээгдэхүүнийг ашиглахгүй байхын төлөө 150 сая ам доллар хүртэл төлж байсан. (Аппл компанийн Мак үйлдлийн системийн тохиролцооны гэрээнээс) 1998 онд Эксплорер хамгийн өндөр хувьтай програм болж, Нетскейп компанид дампуурах аюул тулгарч, АОЛ компанид худалдагдсан.

5. Өрсөлдөгч компаниуд хоорондоо нэгдэх замаар зах зээлийн хувиа өсгөх явдлыг хязгаарлах арга. Өндөр хөгжилтэй орнуудад нэгдэх процессийг маш сайтар хянаж, зах зээлд өндөр хувьтай байгаа хоёр компани нэгдсэнээр давамгайл байдалтай болно гэж үзэн зөвшөөрөл олгодоггүй. Жишээ нь, интернэтийн хайлтын компани Гугл 2007 онд

³⁴ Vertical Integration and Discrimination in the German Railway Sector: Results of a Questionnaire Survey, Martin Zauner, Abteilung für Mikroökonomik und Raumliche Ökonomik und Deutsches Zentrum für Luft- und Raumfahrt (DLR), Diskussionsbeitrag 2004/1

интернэтийн рекламн компани Даблклик-ийг худалдан авах гэсэн өргөдөл гаргасан ба хэрэв энэ хоёр нэгдвэл зах зээлийн хувь хэт өндөр болно гэж өрсөлдөгч компаниуд эсэргүүцэж, энэ асуудлыг холбогдох агентлагууд хэдэн сар судалж байна. Хэт өндөр хувьтай болсон тохиолдолд шинэ нэгдсэн компани зах зээлд давамгайл болж, өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тул ийнхүү болгоомжлох нь чухал байгаа юм.

Шударга бус өрсөлдөөний дээр дурдсан гажуудал, сөрөг нөлөөг бий болгохгүйн тулд маш нарийн зохицуулалт, боловсронгуй эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилт, хэрэгжилтийн механизмууд байх нь чухал.

2.3 ӨРСӨЛДӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ, ДЭЛХИЙН ТУРШЛАГА

Зах зээл хөгжих хэрээр шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах, шударга өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих нь эдийн засгийн зохицуулалт, бодлогын нэн тэргүүн асуудал болдог.

Шударга өрсөлдөөний зохицуулалт байхгүй нөхцөлд зах зээл нь зохистойгоор оршихгүй төдийгүй:

- нээлттэй зах зээлд байдаг үр өгөөжийг шударга өрсөлдөөнгүй зах зээлийн хэрэглэгч нар хүртэж чадахгүйд хүрдэг,
- аж ахуй эрхлэгчид бизнесийн эрүүл орчинд үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болдог, нөөцийг илүү үр ашиггүй хуваарилдаг,
- техник технологио сайжруулах, үйлдвэрлэлийг үр ашигтай явуулахад саад болдог,

- орлогын тэгш бус хуваарилалт бий болдог,
- үндэсний том корпорациуд засгийн газарт хууль бусаар нөлөөлөх, төрийн бодлого, хууль тогтоомж нь нийтийн сонирхолд бус, харин том үйлдвэрлэгчдийг хамгаалах, тэдний өсч дэвжихэд нь тусалдаг.

Зах зээлийн үйл ажиллагаанд харилцан өөр өөр сонирхолтой субъектүүд оролцдог бөгөөд тэдгээрийн ашиг сонирхол нь бизнесийн үйл ажиллагаанд оролцож буй зорилгоос хамаарч ялгаатай байдаг. Жишээлбэл, зарим нь ашиг хонжоо олохын төлөө, зарим нь нийгмийн сайн сайхны төлөө байдаг бол зарим нэг нь ашгийн төлөө биш боловч үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд зах зээлийн үйл ажиллагаанд оролцдог. Энэ нөхцөлд тэрхүү харилцаанд оролцож буй бүх субъектийн эрх ашгийг зохистойгоор хамгаалах, шударга ёсыг хангах үүднээс тэдгээрийн үйл ажиллагааг хуулиар зохицуулах шаардлагатай байдаг. Эрх зүйн зохицуулалт нь өөрөө тодорхой нийгмийн харилцааг зохицуулах, нийгмийн харилцааг дэг журамтай байхад чиглэсэн байдаг. Шударга өрсөлдөөнийг хуулиар зохицуулах нь дээрх зорилго буюу зах зээлийн харилцаанд оролцож буй бүх субъектийн эрхийг хангах, эрх ашгийг хамгаалахад илүү үр дүнтэй юм.

Шударга өрсөлдөөнийг хуулиар зохицуулах хандлага нь 200 гаруй жилийн өмнө үүссэн түүхтэй. Энэ нь анх АНУ, Герман зэрэг улс орнуудад хэрэглэж эхэлсэн бөгөөд гол төлөв тухайн үед монополийн үйл ажиллагааг хязгаарлах, аль нэг аж ахуйн нэгж зах зээлд дангаар ноёрхохыг зогсоох зорилгоор тусгай хууль баталж байсан. Баруун Европын зарим орнууд шударга өрсөлдөөний талаарх хуулийг

баталж, тэдгээрийг хэрэгжүүлэх, шударга өрсөлдөөний нөхцлийг бий болгох талаар олон жилийн туршлага хуримтлуулсан байна. Иймд Монгол улсын шударга өрсөлдөөний хууль тогтоомжийн онцлог, хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг судлахад зарим нэгэн өндөр хөгжилтэй орны эрх зүйн зохицуулалт, туршлага зэргийг танилцуулах нь зүйтэй.

Хэдийгээр ихэнх орнуудад, ялангуяа эрх зүйн өндөр хөгжилтэй орнуудад шударга өрсөлдөөний талаар хууль баталсан байдаг ч тэдгээр нь харилцан адилгүй байдаг. Гэсэн хэдий ч эдгээр орнуудад шударга өрсөлдөөний талаар дараах зохицуулалт хийж, шударга өрсөлдөөнд харш гурван төрлийн үйл ажиллагааг хориглосон.

- *Нэгдүгээрт*, хөндлөн болон босоо шугамын түвшинд үгсэж хуйвалдахын эсрэг буюу картелийн эсрэг үйл ажиллагааг, жишээлбэл, тодорхой бараа бүтээгдэхүүний үнийг тохиролцож тогтоох, зах зээлээ хуваах, шинэ өрсөлдөгч гарч ирэхэд саад учруулах, нийлүүлэгч болон борлуулагчийг үндэслэлгүйгээр ялгавартайгаар сонгох зэрэг үйлдлийг хориглосон байдаг.
- *Хоёрдугаарт*, давамгайл байдалтай аж ахуйн нэгж эрх мэдлээ урвуулан ашиглахын эсрэг эрх зүйн зохицуулалт хийж, давамгайл байдалтай аж ахуйн нэгж нь бусад өрсөлдөгч, мөн хэрэглэгчдэд сөрөг үр нөлөө авчирч болзошгүй байдаг тул хуулиар давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн зарим үйл ажиллагааг хориглосон байдаг.
- *Гуравдугаарт*, өрсөлдөгч нь өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулах байдлыг, жишээ нь бусад

өрсөлдөгчийн талаар буруу бөгөөд ташаа мэдээлэл тараах, бусад аж ахуйн нэгжийн шошго, барааны тэмдгийг хууль бусаар ашиглах зэрэг үйл ажиллагааг хориглосон байдаг. Ийм зохицуулалтыг ихэвчлэн шинээр буюу ардчиллыг сэргээн байгуулж байгаа, эсвэл хуучин социалист орнуудад хийсэн байдаг.

АНУ-ын эрх зүйн зохицуулалт

АНУ-д шударга бус өрсөлдөөний эсрэг эрх зүйн зохицуулалтыг Антитрастын эрх зүй гэж нэрлэдэг бөгөөд анх үүсэхдээ ганц нэг аж ахуйн нэгж зах зээлд ноёрхох байдлыг эсэргүүцэх, мөн худалдаанд саад болж буй өрсөлдөгчдийн үйл ажиллагааг зогсоох зорилготой байсан.³⁵ АНУ-ын шударга өрсөлдөөний эрх зүй нь дэлхийн анхны шударга өрсөлдөөний хуулиудын нэг гэдгээрээ төдийгүй, үр дүнтэй хэрэгждэгээрээ алдартай.

АНУ-ын шударга бус өрсөлдөөний эрх зүйн тогтолцоо нь холбооны хэмжээний ба муж улсын гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Муж улс нь өөрийн мужид антитрастын эсрэг хууль тогтоомжийг батлах эрхтэй байдаг ч холбооны хэмжээний хууль тогтоомжид нийцсэн байх ёстой. Үндсэндээ АНУ-ын холбооны хэмжээний шударга бус өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт нь Конгрессээс баталсан Шерманы Акт, Клэйтоны акт болон Холбооны Худалдааны Комиссийн Актад тулгуурладаг.

Шерманы Акт Конгрессээс 1890 онд батлагдсан. Зах зээлд монополь байдалтай аж ахуйн нэгжийн эсрэг чиглэсэн бөгөөд гол нь тэдний худалдаа, арилжаанд нөлөөлж буй

³⁵ АНУ-д анхны монополиуд трастын шинжтэй үүссэн бөгөөд Шерманы хууль уг монополиудтай тэмцэхийн тулд батлагдсан хууль байсан.

сөрөг үр нөлөөг зогсооход оршиж байсан.³⁶ Тус актад: “хэд хэдэн мужуудын хооронд, эсвэл гадаад улстай хийгдэж буй худалдаа, арилжааны бүх төрөлд саад болоход чиглэсэн аливаа гэрээ хэлцэл байгуулах, эсвэл траст болж нэгдэх нь хууль бус” гэж заасан байдаг.³⁷ Энэ акт нь нийтдээ долоон хэсгээс бүрддэг.

Эхний хэсэгт худалдаа, арилжаанд саад болоход чиглэсэн аливаа гэрээ, хэлэлцээр байгуулах, эсвэл траст болж нэгдэх нь хууль бус гэж тогтоогдсон бөгөөд аж ахуйн нэгжид 10 000 000 ам.доллар, хувь хүнд 350

000 ам.долларын торгууль, эсвэл гурван жил хүртэл хорих ял ногдуулна гэжээ.

Хоёрдугаар хэсэгт монополийн эсрэг чиглэсэн бөгөөд хэн нэг нь бусад мужтай, эсвэл гадаад улстай эрхлэх худалдаанд саад болохуйц монополь тогтоох нь мөн хууль бус гэж тогтоогдвол торгох, эсвэл хорих ялаар шийтгэнэ гэжээ.³⁸

Тухайн үед хуулиар аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулж, ялангуяа монополийг хуулиар хориглож, давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хориотой үйлдлийг зааж өгсөн явдал нь тухайн нэрлэгдсэн зах зээлд шинэ өрсөлдөгчийг бий болгох төдийгүй хэрэглэгчдэд таатай үр нөлөө үзүүлж, барааны чанар сайжран үнэ буурах зэрэг үр нөлөөг авчирсан гэж олон судлаачид дүгнэсэн байдаг.

Шерманы актад шударга өрсөлдөөнд харш хуйвалдаан ба монополь гэдгийг тодорхойлж өгөөгүй байсан нь энэ хуулийн эрх зүйн үр нөлөөг багасгасан гэж судлаачид үздэг. Гэвч АНУ нийтлэг /common/ эрх зүйн тогтолцооны орон учир эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд зан заншлын хэм хэмжээ ба шүүхийн шийдвэр чухал үүрэг гүйцэтгэдэг. Хуулиар аж ахуйн нэгж нь ямар нөхцөлд монополь байдалтай, ямар нөхцөлд давамгайл байдалтай байхыг тодорхойлж өгөөгүй ч энэхүү хийдлийг арилгахад, мөн хуулийг тайлбарлахад АНУ-ын шүүхүүд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн.

Клэйтоны акт Конгрессоос 1914 онд батлагдсан бөгөөд Шерманы актын адил монополийн эсрэг чиглэсэн байжээ. 12 дугаар хэсэгт худалдан авагчийг сонгох,

³⁶ 1870 онд АНУ-д байгуулагдсан Стандарт Ойл компани (өнөөгийн Эссо) дэлхийн анхны траст бөгөөд тухайн үедээ хамгийн том үндэстэн дамнасан компаниудын нэг байсан. Анх АНУ-ын Охайо мужид ах дүү Рокфеллер, Флаглер, Андриус болон Харкнесс гэдэг хүмүүс түншлэлийн хоршоо (partnership) байгуулан 1870 онд Стандарт Ойл гэдэг газрын тосны компанийг байгуулсан. Тус компани маш их шүүмжлэгдсэн бөгөөд хориотой аргуудыг ашиглан хоёр жилийн дотор орон нутгийн зах зээл дэх бүх өрсөлдөгч нараа дампууруулж чадсан бөгөөд аажмаар АНУ-ын хойд зүүн хэсгийн зах зээлийг бүхэлд нь хяналтанд оруулж, муж болгонд өөрийн салбараа байгуулсан. Тус компанийн төв оффис нь Кливлэнд хотод байрлаж, 1882 онд бүх салбар компаниудын удирдлагыг нэгдсэн удирлагын зөвлөлийн (single board of trustees) мэдэлд өгсөн. Үүнээс үүдэн компанийн зохион байгуулалтын тус хэлбэрийг траст гэж нэрлэдэг болсон. Стандарт Ойл зах зээлд анх өрсөлдөхдөө бусад компаниудаас илүү үр ашигтай ажиллаж, бусад компаниуд газрын тосны үлдэгдлээ хаядаг байхад Стандарт Ойл хаягдлаа зах зээлд бүтээгдэхүүн болгон борлуулж чадсан. Мөн газрын тосны үлдэгдлээс анх вазелин үйлдвэрлэсэн зэрэг түүхтэй. Ашиг ихтэй, хөрөнгийн боломжтой болонгуут Стандарт Ойл өрсөлдөгч компаниудыг шууд худалдан аваад, үйлдвэрүүдийг нь хааж, бусад салбарын компаниудтай гэрээ хийхдээ өөрийн зах зээл дэх давамгайл байдлыг ашиглан маш их хэмжээний хямдралыг өөртөө авч чаддаг болсон. 1868 онд Стандарт ойл болон Лейк Шор төмөр замын компани газрын тосны тээвэрлэлтийн гэрээ байгуулахдаа Стандарт ойл өдөрт 60 вагон газрын тос ачуулах үүргийг өөртөө авч, оронд нь тээврийн тарифын 71% -ийн хямдралтай гэрээг байгуулж чадсан. Жижиг компаниуд ийм их хэмжээний газрын тосыг үйлдвэрлэх чадваргүй тул энэ хямдралд хамрагдах боломжгүй болсон. Энэ нь эргээд Стандарт Ойлд маш их ашигтай болж, богино хугацаанд тус компанийн ашиг, хувьцааны хүү болон хөрөнгө асар их хэмжээгээр нэмэгдэн 1882-1906 оны хооронд тус компанийн цэвэр ашиг 838 сая ам долларт хүрсэн. 1890 онд Стандарт Ойл АНУ-ын нийт газрын тосны ажилтын 88%, өөрийн хяналтаа оруулан нийт үйлдвэрлэлийн 91%, эцсийн борлуулалтын 85%-ийг эзэлдэг болсон.

³⁷ Дөнгөж батлагдсан Шерманы хуулийг ашиглан АНУ-ын Хууль зүйн яам Стандарт Ойл компанийг шүүхэд өгч, 1911 онд тус компанийг хуулийн дагуу 34 бие даасан компани болгон задалж, компани болгоныг өөрийн удирдах зөвлөлтэй болгосон.

³⁸ 1890 онд хэд хэдэн тамхины үйлдвэрлэгчид нэгдэн American Tobacco Company гэдэг компанийг байгуулж, тамхины үйлдвэрлэлд ноёрхлоо тогтоож, 200 гаруй өрсөлдөгч компанийг залгисан. 1907 онд тус компанийг монополийн эсрэг хуулийн дагуу шүүхэд өгч, 1911 онд хэд хэдэн бие даасан нэгж болгон задалсан.

ялгаварлан гадуурхах, үнийг ялгавартайгаар тогтоохыг хориглосон байна. Энэ хуулиар монополь тогтооход чиглэсэн болон шударга өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагааг хориглосон байна.

Холбооны худалдааны комиссийн акт 1914 онд батлагдсан бөгөөд энэ актаар Холбооны Худалдааны Комиссийг байгуулсан. Уг Актын 5 дугаар бүлэгт зааснаар Комисс шударга бус өрсөлдөөн явуулж буй, эсвэл арилжаанд нөлөөлж буй хэн бүхний эсрэг захиргааны арга хэмжээ авах эрхтэй. Холбооны худалдааны комисс нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ шударга бус өрсөлдөөнийг тогтоох, хувь хүмүүс, аж ахуйн нэгжүүдийг шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх, холбогдох байгууллагаас мэдээлэл авах, шалгах эрхийг эдэлдэг.

Ерөнхийдөө дээрх гурван актаар шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх дараах дөрвөн төрлийн үйл ажиллагааг зохицуулсан байдаг. Үүнд монополь байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, худалдааг хууль бусаар хязгаарлах, компаниудын нэгдэл, холбоо бий болгох, үнийн хувьд ялгаварлан гадуурхах үйл ажиллагаа орно.

А. Монополь байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа: АНУ-ын хууль тогтоомжоор монополь байдлыг ерөнхийд нь хориглохыг зорьсон учир худалдаанд саад болж буй аливаа монополийг “хууль бус” гэж тогтоосон байдаг. Харин яг ямар аж ахуйн нэгжийг монополь байдалтай байх вэ гэдгийг хуулиар зааж өгөөгүй байсан бөгөөд монополь байдалтай аж ахуйн нэгжид хориглох үйл ажиллагааг зааж өгсөн. Жишээ нь, монополь байдалтай аж ахуйн нэгжид нэрлэгдсэн зах зээлд шударга өрсөлдөөнийг хязгаарлах,

тухайлбал, бусдыг тухайн зах зээлд нэвтрэн ороход саад болох, монополь байдлаа хууль бусаар ашиглах үйлдлийг хориглосон байдаг. Монополь байдалтай аж ахуйн нэгж нь энэхүү байдлаа хэрхэн урвуулан ашиглаж болохыг хэд хэдэн жишээнээс харж болох юм. Нэгдүгээрт, төрийн монополь татаас авдаг учир бүтээгдэхүүний үнээ бууруулсан ч алдагдалгүй. Харин бусад өрсөлдөгчдийн хувьд энэ нь шударга бус байдаг. Хоёрдугаарт, монополь байдалтай аж ахуйн нэгж өрсөлдөгчгүй тул өөрийн үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарт анхаарахгүй, орлуулах бүтээгдэхүүнгүй тул өндөр үнэ тогтоох үйлдэл хийж болно. Гуравдугаарт, монополь байдалтай аж ахуйн нэгж арай доогуур түвшинд байгаа сул өрсөлдөгчтэй хамтран ажиллахаас татгалзаж, бусад өрсөлдөгч тухайн салбарт, тухайн түвшинд гарч ирэхэд саад учруулах зэрэг үйлдэл байж болно.

Б. Худалдааг хууль бусаар хязгаарлахыг Шерманы актын 1 дүгээр хэсэг, Клэйтоны акт ба Холбооны худалдааны Комиссийн Актын 5 дугаар хэсэгт хориглосон байдаг. Энэхүү саад нь үнэ тогтоох байж болно. Худалдаанд тогтоож буй саад нь босоо ба хөндлөн шугамын байж болно. Хөндлөн шугамын нөхцөлд нэг шат, түвшинд байгаа өрсөлдөгч нар нэг нэгнийхээ үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт өрсөлдөхгүй байхыг тохирдог. Босоо шугамын нөхцөлд дээд шатны өрсөлдөгч доод шатны өрсөлдөөнийг хянах, тухайлбал, барааг худалдах үнэд хяналт тавьдаг байж болно. Энэ шатанд уях хэлэлцээр ба онцгойлон хамтран ажиллах аргыг хэрэглэсэн байж болно.

В. Клэйтоны актаар *компаниуд нэгдэн, нийлэх* эрхийг хязгаарлах талаар Шерманы актыг бодоход илүү нарийн зохицуулалт хийсэн. Клэйтоны актын 7 дугаар хэсэгт шударга бус өрсөлдөөнийг багасгах, монополь тогтоох үүднээс нэгдэхийг хориглосон байгаа. Жишээ нь, зарим төрлийн компани нэгдэхэд заавал урьдчилж төрөөс зөвшөөрөл авах шаардлагыг Клэйтоны актад оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тогтоосон.

Зарчмын хувьд нэгдэх нь хоёр үр дагавартай. Нэг талаас шударга өрсөлдөөнд саад болох, нөгөө талаас компанийн үйл ажиллагааг үр дүнтэй хийгээд менежменттэй болгох эерэг үр дагаврыг авчирдаг. Шударга бус өрсөлдөөний эсрэг хэм хэмжээ нь гурван төрлийн зорилготой компанийн нэгдлийг хориглосон байна:

- хөндлөн шугамын буюу нэг компани нь өөрийн нутаг дэвсгэрт, зах зээлд байгаа өөр нэгэн компанийг худалдан авах юм. Энэ нөхцөлд нэг компанийн гарт зах зээл нь төвлөрөх, бусад компани шинээр орж ирэхэд хүндрэлтэй байх үр дагавартай.
- босоо шугамын буюу компани уг нь өөр хүмүүс, компаниар хийлгэж болох зүйлийг өөрөө хийхийг хэлдэг. Жишээ нь, үйлдвэрлэгч өөрт нь бүтээгдэхүүн нийлүүлдэг компанийг худалдан авна.
- конгломерат байдлаар нэгдэх буюу дээр дурьдсан аргаас бусад бүх аргаар нэгдэхийг хэлдэг. Энэ нь ихэвчлэн томоохон корпорациуд нэгдэхийг хэлдэг бөгөөд нэг ёсондоо

шударга өрсөлдөөнд заналхийлнэ гэж тооцогддог.

Г. *Үнийг ялгаварлах* нөхцөлд нийлүүлэгч өөр нэгэн худалдан авагчдад тухайн барааг бусдад худалдсан үнээс дээгүүр, эсвэл доогуур үнээр нийлүүлэхийг хэлдэг. Клэйтоны актаар шударга өрсөлдөөнд харшлах учир үнийг ялгавартайгаар тогтоохыг хориглосон байдаг. 1936 оны Робинсон Патманы актаар энэ зүйлийг мөн хориглосон байсан. Энэ нөхцөлд аливаа аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд шударга өрсөлдөөнийг хязгаарлах, монополь болох зорилгоор нэг төрлийн болон ижил чанарын бараа, үйлчилгээг худалдахдаа ялгавартай үнэ тогтоохыг хориглосон. Үйлдвэрлэлийн зардал, худалдан авч буй барааны хэмжээнээс хамаарч, үнийг ялгавартай тогтоох нь дээрх заалтыг зөрчсөнд тооцогддоггүй.

АНУ-ын шударга бус өрсөлдөөний эсрэг хуулийг хэрэгжүүлэгч байгууллага

АНУ-д шударга бус өрсөлдөөний эсрэг хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн Хууль зүйн яам ба Холбооны худалдааны комисс гэсэн үндсэн хоёр байгууллага байдаг. АНУ-ын шударга өрсөлдөөний бодлого үр дүнтэй хэрэгжиж байгаа нь дээрх хоёр байгууллагын гүйцэтгэж буй үүрэг, тэдний эрх мэдэлтэй шууд холбоотой.

Энэ хоёр байгууллага шударга бус өрсөлдөөнийг практикт хэрэгжүүлж буй байгууллагын эсрэг хэрэг үүсгэх эрхтэй. Хууль зүйн яам нь холбооны шударга бус өрсөлдөөний эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн талаар эрүүгийн хэргийг үүсгэж, шүүхэд хүсэлт гаргах хүртэл эрхтэй. АНУ-ын шударга өрсөлдөөний хуулийн давуу тал

нь хууль зөрчигчдөд эрүүгийн хариуцлага ногдуулах эрхтэй байдагт оршдог.

АНУ-ын зохицуулалтын нэг онцлог нь зарим төрлийн монополийг шударга өрсөлдөөний эрх зүйн үйлчлэх хүрээнээс хассан байсан. Жишээ нь, үйлдвэрчний эвлэлийн байгууллага ба төрийн удирдлага, зохицуулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг энэхүү хуулиар зохицуулаагүй байдаг. Иймд төрөөс удирдаж буй эрчим хүчний компанид шударга бус өрсөлдөөний эсрэг хуулийн үйлчлэх хүрээнд багтахгүй юм.

Европын Холбооны эрх зүйн зохицуулалт

Европын Холбооны эрх зүйн зохицуулалт нь үр дүнтэй хэрэгждэг, оновчтой хийгээд олон талаасаа дэлхийд үлгэр жишээ болдгоороо алдартай. Анх Европын Холбоог байгуулж байхад хөрш зэргэлдээ болон улс төр, эдийн засгийн хөгжил, соёлтой орнуудын хоорондын худалдааг аль болохоор либералчилах, төрөөс тогтоож буй аливаа бэрхшээлийг арилгах, нийтлэг зах зээлийг бий болгох зорилтыг тавьж байсан.

Энэхүү зорилго нь эрх зүйн бүхий л салбарыг хамарч, улмаар шударга өрсөлдөөний институтыг ч тойроогүй билээ. Европын Холбооны шударга бус өрсөлдөөний эсрэг зохицуулалт 1957 онд батлагдсан Европын Холбоог байгуулах тухай Ромын гэрээнд тулгуурладаг. Уг гэрээ бараа, хөрөнгө, үйлчилгээг Европын Холбооны гишүүдийн нутаг дэвсгэрт чөлөөтэйгээр эргэлтэнд оруулах гээд худалдааны эрх чөлөөг баталгаажуулж, улмаар урьд өмнө гишүүн орнуудаас тогтоосон саадыг арилгахад чиглэсэн.

Уг гэрээ ёсоор Европын Холбооны гишүүн орон тус бүр нь Европын Холбооны гэрээ, хуулийг мөрдөхөөс гадна өөрийн хууль

тогтоомжоо тухайн гэрээ, холбооны хуульд нийцүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Энэхүү гэрээ шударга бус өрсөлдөөний эсрэг хуулийг хэрэгжүүлэх, мөн гишүүн орнууд энэ талаар хамтран ажиллах, өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим эрхээ гишүүн улсын байгууллагад шилжүүлэх гэсэн шинэлэг тогтолцоог Европын Холбооны хүрээнд бий болгосон.

Шударга бус өрсөлдөөнтэй холбоотой заалтыг дээрх Ромын гэрээний 1 дүгээр бүлгийн 3 дахь хэсгийн 81-89 дүгээр зүйлд заасан байдаг бөгөөд Европын Холбооны хүрээнд батлагдсан олон тооны журамд шударга бус өрсөлдөөнийг хориглох талаар зүйлүүд орсон байдаг. Жишээ нь, 1/2003 дугаартай “Өөрчлөн шинэчлэлийн тухай журам”-д Ромын гэрээний 81-82 дугаар зүйлийг хэрэгжүүлэх талаар, мөн 2790/99, 2658/2000, 2659/2000, 139/2004, 772/2004 дугаартай журамд шударга өрсөлдөөнтэй холбоотой заалтууд агуулагдсан байгаа. Европын Холбооны гишүүн орнууд ч өөрийн улсдаа шударга өрсөлдөөний талаар тусдаа хуулийг баталсан байдаг бөгөөд эдгээр нь үндсэндээ Холбооны гэрээ, хууль журамд нийцсэн байдаг.

Ромын гэрээ

Европын Холбооны шударга өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт нь 1957 оны Ромын гэрээний 81 болон 82 дугаар зүйлд тулгуурладаг учир энэ хоёр зүйлийн талаар товч танилцуулъя.

Ромын гэрээний 81 дүгээр зүйлд:

1. Гишүүн орнуудын худалдаанд саад болохуйц болон нийтийн зах зээл дэх өрсөлдөөнийг хязгаарлах буюу харшаар нөлөөлөх бүхий л үйл ажиллагаа явуулах, гэрээ, хэлцэл хийхийг хориглоно. Эдгээр үйл

ажиллагаа, гэрээ, хэлцэлд дараах үйл ажиллагааг ойлгосон байна. Үүнд:

- 1) Худалдах буюу худалдан авах үнэ, эсвэл худалдааны бүх нөхцлийг шууд буюу шууд бус аргаар тогтоох,
 - 2) Үйлдвэрлэл, зах зээл, техникийн хөгжил, хөрөнгө оруулалтыг хязгаарлах буюу хянах,
 - 3) Нийлүүлэлтийн зах зээл болон нөөцийг хуваах,
 - 4) Ижил төрлийн хэлэлцээрт худалдааны бусад оролцогчдод өөр нөхцөл бий болгож, улмаар тэднийг ялгаварлан гадуурхах, өрсөлдөх чадварыг нь бууруулах,
 - 5) Энгийн үед тухайн гэрээ, хэлэлцээрт нэмэлт үүрэг амлалт, нөхцлийг шаарддаггүй байхад нөгөө талдаа нэмэлт нөхцлийг биелүүлснээр гэрээ байгуулахыг шаардана.
2. Энэхүү заалтыг зөрчиж байгуулсан бүхий л гэрээ, шийдвэр нь хууль бус байна.
 3. Харин энэ зүйлийн 1 дэх хэсэгт барааны үйлдвэрлэл, түгээлтийг нэмэгдүүлэх, эсвэл техникийн болон эдийн засгийн хөгжил дэвшлийг хөхиүлэн дэмжих зорилтыг агуулсан бөгөөд хэрэглэгчдэд шударгаар үр дүн хүртэх боломж олгож байгаа үйлдэл буюу компаниудын хамтын шийдвэр гаргах үйл явц зэрэг заалт хамаарахгүй юм.

Мөн Гэрээний 82 дугаар зүйлд давамгайл байдлаа гишүүн орнуудын хоорондын худалдаанд саад болох зорилгоор урвуулан ашиглахыг хориглоно гэсэн бөгөөд урвуулан ашиглах үйлдэл гэдэгт:

- 1) Худалдах ба худалдан авах үнийг шударга бусаар шууд буюу шууд бусаар тогтоох болон бусад шударга бус худалдааны нөхцлийг тогтоох;

- 2) Үйлдвэрлэл, зах зээлийн болон техникийн хөгжлийг хязгаарлах;
- 3) Ижил төрлийн хэлэлцээрт худалдааны бусад оролцогчдод өөр нөхцөл бий болгож, тэднийг ялгаварлан гадуурхах, өрсөлдөх чадварыг нь бууруулах,
- 4) Энгийн үед тухайн гэрээ, хэлэлцээрт нэмэлт үүрэг амлалт, нөхцлийг шаарддаггүй байхад нөгөө талаа нэмэлт нөхцлийг биелүүлснээр гэрээ байгуулахыг шаардах гэж заасан байдаг.

Шударга өрсөлдөөнтэй холбоотой заалтууд, мөн тус Гэрээний 2, 3(g), 4, 5, 10, 12 дугаар зүйлүүдэд агуулагдсан байдаг. Тухайлбал, 2 дугаар зүйлд: *“...холбоо нь эдийн засгийн хувьд нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн үйл ажиллагааг зохистой хийгээд тогтвортой хөгжүүлэх, мөн шударга өрсөлдөөний дээд түвшинг хангах болно”* гэжээ.

Ерөнхийдөө Европын эрх зүйгээр шударга өрсөлдөөнд харш дараах төрлийн үйл ажиллагааг хориглосон. Үүнд: хөндлөн болон босоо шугамын түвшинд гэрээ, хэлцэл байгуулах, аж ахуйн нэгж нь давамгайл байдлаа хууль бусаар ашиглах юм. Мөн түүнчлэн шударга өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор аж ахуйн нэгжүүд нэгдэж, нийлэх харилцааг Европын Холбоо ба гишүүн орны хяналтанд байлгах болно гэсэн.

Хөндлөн шугамын түвшинд гэрээ, хэлцэл буюу картелийг шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх үүднээс хоёр үндсэн аргаар байгуулж болно. Нэгдүгээрт үнэ тогтоох, хоёрдугаарт үнэ тогтоох бус арга юм.

- *Үнэ тогтоох аргын* хувьд нэг түвшинд байгаа аж ахуйн нэгжүүд тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэд нөлөөлөх үүднээс тохиролцож,

үнэ тогтоох, зах зээлээ хуваах, нийлүүлэлтээ хязгаарлах замаар зах зээлийн үнэд нөлөөлөх зэргийг хэлж болно. Хэд хэдэн аж ахуйн нэгжүүд, жишээ нь, бензиний үнэ, үйлчилгээний үнийг аливаа бодит зардал, төлөвлөсөн орлого зэргийг харгалзахгүйгээр тогтоохыг хэлдэг. Ихэвчлэн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хязгаарлагдмал байх, өөр сонголт хийх боломжгүй, хэрэглэгч тухайн үнээр худалдаж авахаас өөр аргагүй байх нөхцөлд хэрэглэдэг бөгөөд нийлүүлэгч үнийг хэт өндөр тогтоох, эсвэл хэт доогуур үнээр тогтоодог бөгөөд эргээд хэрэглэгч, бусад өрсөлдөгч нарт харш нөлөө үзүүлдэг. Жишээ нь, хэрэглэгч хэтэрхий өндөр үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах болдог. Зах зээлээ хуваан авах гэдэгт цөөн хэдэн аж ахуйн нэгж тохиролцож бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг хуваасан байх жишээтэй. Тухайлбал, нэг хэсэг нь тухайн улсын нэг хэсэгт үйл ажиллагаагаа явуулах, нөгөө хэсэг нь өөр газарт үйл ажиллагаа явуулах, ингээд бусад өрсөлдөгч орж ирэхэд нь саад болох зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Хэдий энэ аргаар шууд үнэ тогтоодоггүй ч зах зээлээ хувааснаар шууд бус хэлбэрээр үнэд нөлөөлдөг. Жишээ нь, хэрэглэгч зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн л санал болгосон бараа, үйлчилгээг авах гэхэд өөр сонголт байдаггүй. Бүтээгдэхүүний нийлүүлэлтээ хязгаарлах нь шууд бус хэлбэрээр үнэ тогтоох арга гэж тооцогддог. Тухайн бүтээгдэхүүнийг орлуулах өөр бүтээгдэхүүн байхгүй байхад өөрийн нийлүүлж буй бүтээгдэхүүнээ ямар ч үндэслэлгүйгээр зах зээлээс татаж, хуурамчаар барааны

хомсдол бий болгож, үнийг өсгөх арга хэрэглэх тохиолдол байдаг.

- *Үнэ тогтоох бус арга.* Шударга өрсөлдөөнд зөвхөн үнэ тогтоох аргаар үгсэн хуйвалдах төдийгүй үнэ тогтоохгүйгээр бусад аргаар хуйвалдах тохиолдол ч байдаг бөгөөд үүнийг Европын эрх зүйгээр хориглосон байдаг. Үнэ тогтоох бус аргаар шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх гэдэгт тендэрийн хувьд хуйвалдах, тусгай нөхцөлтэйгээр гэрээ байгуулах, тухайлбал, зээл олгох, хөнгөлөлт үзүүлэхэд ялгаварлан гадуурхах гэх зэрэг үйлдлийг ойлгодог. Энэ нь өөрийн танил талын хүмүүст тодорхой үйл ажиллагаа явуулах эрх, лицензийг олгох, уг нь тусгай нөхцөл шаардагдахгүйгээр гэрээ байгуулж болох үед гэрээг байгуулахад нэмэлт нөхцөл шаардах зэрэг үйлдэл багтан ордог. Өөр нэг үнэ тогтоох бус аргын хувьд хөндлөн шугамын түвшинд гэрээ, хэлцэл байгуулахдаа ялгавартайгаар хандах, тухайлбал, үйлдвэрлэгч нь нийлүүлэгчтэй гэрээ байгуулахаас үндэслэлгүй татгалзах, эсвэл өөрөө нийлүүлэгчийн санал болгож буй бүтээгдэхүүний үйлдвэрлэж эхлэх зэрэг үйлдэл багтдаг бөгөөд энэ үйлдлийг нэг ёсондоо монополь байдал бий болгохоос урьдчилан сэргийлэх үүднээс хориглодог. Мэдээлэл солилцох, зар сурталчилгааны тухай хуулийг зөрчих нь мөн шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлдөг учир аж ахуй эрхлэгчид зарын цагийг өөр хоорондоо хуваах талаар гэрээ хэлцэл байгуулахыг хориглосон байдаг.

Давамгайл байдалтай, эсвэл олигополь байдалтай аж ахуйн нэгжид ч хөндлөн

болон босоо шугамын түвшинд гэрээ хэлцэл байгуулахыг хориглодог. Жишээ нь, тодорхой зах зээлд тодорхой төрлийн бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг заавал ганцаараа гэхгүйгээр цөөн хэдэн аж ахуйн нэгжтэй хамтарч хийж байгаа бөгөөд шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх үүднээс гэрээ хэлцэл байгуулахыг хориглодог.

Европын эрх зүйгээр ямар аж ахуйн нэгжийг давамгайл болон монополь байдалтай гэж ямар аж ахуйн нэгж гэж үзэхийг зааж өгөөгүй. Заримдаа давамгайл болон монополь байдал нь заримдаа давхардах тохиолдол байдаг. Иймд Европын Холбооны хэмжээнд давамгайл болон монополийн байдлыг тодорхойлох талаар тусгай аргачлал, журам зэргийг баталсан байдаг. Мөн Европын Холбооны шүүх болон үндэсний шүүхүүд ч өөрсдөө аливаа нэг аж ахуйн нэгж давамгайл буюу монополь байдалтай байна уу үгүй гэдгийг, мөн тэдний үйлдэл нь шударга өрсөлдөөний хуулиар зохицуулагдах эсэхийг өөрсдөө тодорхойлох практикийг тогтоосон байдаг. Жишээ нь, Европын шударга ёсны шүүх (United Brands vs Commission): *“...давамгайл байдлаа хууль бусаар буюу урвуулан ашиглах гэдэгт давамгайл байдалтай аж ахуйн нэгж нь бусад өрсөлдөгчөөс хамааралгүйгээр өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнийг тогтоох чадвартай, эсвэл тухайн бүтээгдэхүүний зах зээлийн нийлүүлэлтийн ихэнх хувийг эзэмшиж байгаа бол давамгайл байдалтай аж ахуйн нэгж байна”* гэсэн байдаг.

Европын Холбооны хэмжээнд давамгайл байдалтай байхыг эрх зүйгээр тодорхойлж өгөөгүй нь бас нэг өөр шалтгаантай. Давамгайл байдалтай байхыг хуулиар хориглоогүй бөгөөд гол нь хууль бусаар давамгайл байдлаа урвуулан хэрэглэгч болон бусад

өрсөлдөгчдөд сөргөөр нөлөөлж ашиглахыг хориглодогт оршдог.

Мөн босоо шугамын хэмжээнд шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх үүднээс гэрээ хэлцэл байгуулахыг хориглосон байдаг. Энэ нь үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалтын өөр өөр түвшинд байгаа аж ахуй эрхлэгч нар хэлэлцэн тохиролцохыг хэлдэг. Жишээ нь, А болон Б хоёр аж ахуйн нэгж нэг түвшинд байдаг, тэдний борлуулалтын хэмжээ ерөнхийдөө ойролцоо, харин С-гийн борлуулалтын хэмжээ арай доогуур. С нь борлуулалтаа нэмэгдүүлэх хүсэлтэй, мөн А болон Б-гийн түвшинд хүрэх хүсэлтэй. Д нь үйлдвэрлэгч. А болон Б хоёулаа Д –д бүтээгдэхүүн нийлүүлдэг. С мөн Д, эсвэл бусад үйлдвэрлэгчид нийлүүлэх хүсэлтэй байгаа. Гэвч А болон Б нь Д болон бусад үйлдвэрлэгчтэй С-гийн бүтээгдэхүүнийг авахгүй байх талаар гэрээ, хэлцэл хийсэн. Иймд С нь борлуулалтаа нэмэгдүүлэхэд хүндрэл гарч байна. Энэ нөхцөлд босоо шугамын түвшинд хуйвалдахыг хэлж байгаа. Энэ нь цөөн хэдэн аж ахуйн нэгж зах зээлд давамгайлж, бусад аж ахуйн нэгж гарч ирэхэд саад болж буй жишээ юм.

Хөндлөн шугамын хэлэлцээр нь шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлдөг гэдгийг босоо шугамын хэлэлцээрийг бодвол нотлоход арай хялбар байдаг. Харин яг тухайн босоо шугамын хэлэлцээр нь шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлж байна гэдгийг нотлоход хэцүү байдаг. Иймээс босоо шугамын хэлэлцээрийг тодорхойлох талаар Европын Холбооны хэмжээнд олон аргачлал баталсан байдаг.

Европын Холбооны шударга өрсөлдөөний эрх зүйг хэрэгжүүлэгч байгууллага

Ромын гэрээний 7 дугаар зүйлд зааснаар Европын Холбооны хууль тогтоомжийг

тайлбарлах, хэрэглэх болон хэрэгжүүлэх эрх нь энэ зорилгоор байгуулсан тусгай байгууллагын эрх мэдэлд байдаг.

Европын Холбоонд шударга өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлэх гурван үндсэн байгууллага байдаг бөгөөд эдгээр нь *Европын Комисс, Европын анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүх* юм. Түүнчлэн Европын Холбооны гишүүн орнуудын шударга өрсөлдөөний байгууллага болон үндэсний шүүхүүд ч шударга өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд уг байгууллагын эрх мэдэл, эрх хэмжээ маш чухал байдаг.

ЕХ-ны шударга өрсөлдөөний эрх зүйн хэрэгжилт харьцангуй дээгүүр түвшинд байдаг нь Европын Холбооны холбогдох байгууллагын эрх хэмжээнд оршдог гэж хэлж болно. Учир нь ЕХ-ны шударга өрсөлдөөний байгууллагууд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг шалгах, хууль бус үйлдлийг зогсоох, шударга өрсөлдөөний байгууллагын шаардлагыг белүүлэхгүй бол үйл ажиллагааг нь зогсоох, торгох зэрэгт захиргааны арга хэмжээ авах эрхтэй байдаг. Тухайлбал, Европын хэмжээнд шударга өрсөлдөөний хууль зөрчигчдөд 100 сая хүртэл еврогийн торгууль ногдуулах талаар заасан.

ЕХ-ны шударга өрсөлдөөний байгууллагын тогтолцоо нь ЕХ-ны нэгдсэн бодлого, түүний нэгдмэл байдал, холбооны хэмжээний болон гишүүн орнуудын хамтын ажиллагаанд тулгуурласан. Хэдийгээр Европын Холбооны шударга өрсөлдөөний байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг ч үндэсний байгууллагуудын энэ талаарх үүргийг нэмэгдүүлэхэд анхаарсан байдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Европын комисс Ромын гэрээний 85 дугаар зүйлд зааснаар Комисс нь 81, 82 дугаар зүйлд заасан зарчмын хэрэгжилтийг хангах үүрэгтэй.³⁹ Комисс нь дээр дурдсан заалтыг зөрчсөн хэргийг судлах эрхтэй бөгөөд зөрчсөн нь нотлогдвол тухайн хууль бус үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авах эрхтэй. Мөн гишүүн орнууд уг комисстой хамтран ажиллах үүрэг хүлээдэг.

Комисс хэд хэдэн хэлтэст хуваагддаг. Тэдгээр нь шударга бус өрсөлдөөний талаар тусгай хэрэг, жишээлбэл, нэг хэсэг нь хөндлөн шугамын түвшинд гэрээ, хэлцэл байгуулах, нөгөө хэсэг нь босоо шугамын төвшинд гэрээ, хэлцэл байгуулах, өөр нэг хэсэг нь компаниуд нэгдэн нийлэх үйл ажиллагааг хянадаг.

Удирдах зөвлөл (DG Comp) шударга өрсөлдөөний тухай хуулийн болон бодлогын асуудлыг хэрэгжүүлдэг бөгөөд аливаа байгууллагын талаар хамтран шийдвэр гаргадаг онцлогтой.

Европын анхан шатны шүүхийг (Court of first instance) 1989 онд байгуулсан бөгөөд олон төрлийн хэргийн зэрэгцээ Европын комиссоос шилжүүлсэн шударга бус өрсөлдөөнтэй холбоотой шийдвэрийг дахин авч хэлэлцэх эрхтэй байгууллага юм. (Гэрээний 230 дугаар зүйл)

Давж заалдах шатны шүүх (Court of Justice) Европын Холбооны шударга бус өрсөлдөөний эсрэг эрх зүйг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Европын Холбооны давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг дахин авч хэлэлцэх эрхийг эдэлдэг.

³⁹ Европын Комиссын үйл ажиллагааны талаар 1/2003 дугаартай журам байдаг. Энэ журмаар урьд нь шударга өрсөлдөөний талаарх хэргийг зөвхөн комиссын гарт төвлөрүүлэх байдлаас татгалзаж, шударга бус өрсөлдөөнтэй холбоотой хэргийг шийдвэрлэхэд орон нутгийн эрх бүхий байгууллага болон үндэсний шүүхэд эрх олгодог болсон.

Үндэсний шүүхүүд шударга бус өрсөлдөөнтэй холбоотой хэргийг авч хэлэлцэх эрхтэй байдаг. Хэргийг шийдвэрлэхдээ Ромын гэрээний 81 ба 82 дугаар зүйл, мөн өөрийн дотоодын хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэрэглэх боломжтой. Үндэсний шүүхүүд шударга өрсөлдөөнтэй холбоотой хэргийг шийдвэрлэхдээ Европын Холбооны шударга өрсөлдөөний байгууллага болон Европын Холбооны давж заалдах шүүхээс зөвлөгөө авах эрхтэй. Энэхүү ажиллагаа нь шударга өрсөлдөөнтэй холбоотой хэргийг үр дүнтэйгээр шийдвэрлэх, Европын Холбооны эрх бүхий байгууллагаас туршлага судлах, үндэсний шүүхийн чадварыг нэмэгдүүлэх зорилтыг агуулдаг.

ЕХ-ны шударга өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтын талаар бүрэн ойлгохын тулд гишүүн орны зохицуулалтыг авч үзэх нь зүйтэй. Хэдийгээр харилцан өөр өөр эрх зүйн тогтолцоотой боловч ЕХ-ны гишүүн болох хоёр улсын эрх зүйн тогтолцоог авч үзье.

Их Британи улсын эрх зүйн зохицуулалт

Их Британи улс нийтлэг эрх зүйн тогтолцоотой орон бөгөөдийн тогтолцоотой орнуудад нийгмийн харилцааг зохицуулах, хэрэг шийдвэрлэхэд хууль тогтоомжоос гадна шүүхийн прецедент, заншлын хэм хэмжээ чухал үүрэг гүйцэтгэдэг.

Их Британи улс 1998 онд “Шударга өрсөлдөөний тухай хууль (Competition Act)”-ийг баталснаар шударга өрсөлдөөний эрх зүйн хөгжилд шинэ үеийг авчирсан. Өмнө нь үйлчилж байсан шударга өрсөлдөөний эрх зүй нь хүнд нүсэр бөгөөд үр дүн багатай байсан гэж олон судлаачид тэмдэглэж байсан. Одоогийн Их Британийн шударга өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт Европын Холбооны эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтанд тулгуурлан хийгдсэн.

Их Британи 1998 оны өрсөлдөөний тухай хуулийг боловсруулахад Ромын гэрээний 81, 82 дугаар зүйлийг үлгэр жишээ болгосон бөгөөд хууль дөрвөн үндсэн хэсгээс бүрдсэн:

- Эхний хэсэгт шударга өрсөлдөөнд харшлах үйлдлүүд, тухайлбал, гэрээ, хэлцэл байгуулах, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах, мөн шударга бус өрсөлдөөний талаар хэргийг шалгах, хууль бус үйлдэлд ногдуулах хариуцлага зэргийг заасан.
- Хоёрдугаар хэсэгт Ромын гэрээний 85 болон 86 дугаар зүйлтэй холбоотой мөрдөн байцаах ажиллагаа явуулах талаар заасан.
- Гуравдугаар хэсэгт монополийн талаар заасан.
- Дөрөвдүгээр хэсэгт нэмэлт асуудлыг зохицуулсан.

Их Британид 2002 онд “Аж ахуйн нэгжийн тухай хууль” (Enterprise Act) батлагдсан бөгөөд шударга бус өрсөлдөөнтэй холбоотой компаниудын нэгдэх, нийлэх зэрэг асуудлыг зохицуулжээ. Энэ хоёр хууль нийлээд өнөөгийн Их Британи улсын шударга өрсөлдөөний эрх зүйн үндсэн эх сурвалж болдог.

1998 оны шударга өрсөлдөөний хууль болон 2002 оны аж ахуйн нэгжийн хуулиар *Шударга худалдааны газар*, *Шударга өрсөлдөөний комисс*, *Шударга өрсөлдөөний давж заалдах шатны шүүхийг* байгуулсан.

Шударга худалдааны газар (Fair trade office) нь зах зээлийн үйл ажиллагаанд оролцогч талуудад таатай нөхцлийг бүрдүүлэх, шударга өрсөлдөөнд оролцох эрхийг нь хангах талаарх ажлыг зохион байгуулах, үүний дотор бизнесийн байгууллагад худалдааны болон шударга өрсөлдөөний хуулийг хэрэглэх талаар зөвлөгөө өгөх эрхтэй байдаг. 2002 оны

“Аж ахуйн нэгжийн тухай хууль”-иар Шударга худалдааны газрын удирдлага нь Худалдаа үйлдвэрийн сайдын томилсон дарга, хоёр гүйцэтгэх болон гүйцэтгэх бус захирлаас бүрддэг. Шударга худалдааны газар нь 1998 оны болон 2002 оны хуулийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ компаниудын захирлыг албан тушаалаас нь чөлөөлүүлэх хүртэл арга хэмжээ авах эрх мэдэлтэй.

Шударга өрсөлдөөнд харш нөхцөл бий болсон гэж үзсэн нөхцөлд шударга худалдааны газар нь *Өрсөлдөөний комисст* (Competition commission) тухайн нөхцөл байдлыг шалгуулахаар хандаж болно. Өрсөлдөөний комисс нь компаниуд нэгдэх, тэдний дотоод дүрэм, журмыг шалгах, мөн холбогдох этгээдээс шударга өрсөлдөөний талаар асуух, түүний дараа өөрийн бие даасан дүгнэлтээ гаргаж болдог. Мөн ийм төрлийн шалгалт явуулахыг худалдаа үйлдвэрийн сайд “Өрсөлдөөний комисс”-т даалгаж болохыг заасан байдаг бол өрсөлдөөний комисс шалгалт хийхийг өөрөө санаачлах эрхгүй.

Давж заалдах шатны шүүх (Competition Appeal Tribunal) 1998 оны хуулиар байгуулагдсан ба талуудын маргаан хийгээд шударга худалдааны газраас гаргасан шийдвэрийг давж заалдах гомдлыг авч хэлэлцэх эрхтэй.

Итали улсын шударга өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт

Итали улс эх газрын эрх зүйн үүсэл хөгжлийн суурийг тавьсан орон гэж тооцогддог. Учир нь эх газрын эрх зүйг Ромын эрх зүйгээс үүсэлтэй гэж үздэг. Өнөөгийн байдлаар дэлхийн ихэнх улс эх газрын эрх зүйн тогтолцоотой, Монгол улс ч ийм эрх зүйн тогтолцоотой. Эх газрын эрх зүйн тогтолцоотой орны хувьд хууль тогтоомж нь нарийн кодчилогдсон, эрх зүй нь

салбаруудад хуваагдсан, нийгмийн харилцааг зохицуулах, хэрэг шийдвэрлэхэд хууль чухал үүрэг гүйцэтгэдэг онцлогтой.

Итали улс 1990 онд шударга өрсөлдөөний хуулийг баталсан бөгөөд ЕХ-ны шударга өрсөлдөөний эрх зүйн зохицуулалттай нийцсэн байдаг. ЕХ нь шударга өрсөлдөөний талаар нэгдсэн бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд Ромын гэрээний зохиогчид Европын Холбооны хэмжээнд нэгдсэн зах зээлийг бий болгох зорилт тавьсан ба гишүүн улсууд, түүний дотор Итали улс ч худалдаанд саад болох бүхий л хүчин зүйлийг арилгахыг чухалчилдаг.

Худалдаанд саад болох бүхий л хүчин зүйлийг арилгах нь бараа, үйлчилгээ, хөдөлмөр болон хөрөнгө Европын зах зээлд чөлөөтэй нэвтрэх, мөн чөлөөтэй гарах нөхцлийг бий болгох зорилготой. Гэвч тэдгээр нөхцлийг хангахад саад болж буй бэрхшээлийг арилгах нэг тохиолдол гэвэл зарим аж ахуйн нэгжүүд зах зээлээ хуваах, эсвэл нийлүүлэх, зах зээлээ гэрээгээр зохицуулж, худалдаанд саад болдог учир Итали улс ЕХ-ноос баталсан шударга өрсөлдөөний бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд дотоодын эрх зүйн орчинг бүрдүүлэхэд анхаарсан байдаг.

ЕХ-нд нэгдэн орсон улсууд Шударга өрсөлдөөний талаар хуулийг шинээр баталсан бөгөөд Европын Холбооны хэмжээний ерөнхий эрх зүйн зохицуулалтад нийцүүлж байна.⁴⁰

⁴⁰ Хэдийгээр дэлхий дахинаа шударга өрсөлдөөний талаар бодлого хэрэгжүүлэх ажиллагаа явуулж байгаа ч бүхий л улсад үр дүнтэйгээр үйлчлэх нийтлэг бодлого гэж байхгүй. Тариф Худалдааны Ерөнхий Хэлэлцээрээр худалдаанд саад болохуйц бэрхшээлийг арилгах зорилтыг тавьсан ч зөвхөн төрөөс тогтоосон саад бэрхшээлийг арилгаж чадсан бөгөөд хувийн хэвшилээс тогтоож буй бэрхшээлийг арилгаж чадаагүй. Мөн 1948 оны Хавайн Хартид хувийн хэвшилд зарим төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай заалт орсон байсан ч, уг баримтыг одоог хүртэл соёрхон батлаагүй.

Итали улсын шударга өрсөлдөөний хууль нийтдээ 34 зүйлээс бүрддэг бөгөөд зохицуулалт нь Европын Холбооны болон Их Британи улсынхтай төстэй. Тухайлбал, Италийн хуулиар, шударга өрсөлдөөнд харш аливаа гэрээ, хэлцэл байгуулах, давамгайл байдалтай аж ахуйн нэгж энэхүү байдлаа хууль бусаар, урвуулан ашиглахыг хориглох, компанийн нэгдэх болон нийлэх үйл ажиллагаанд хяналт тавих, төрийн өмчит монополь байдалтай болон тусгай зөвшөөрөгдсөн монополь байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулсан байдаг.

Итали улсын хуульд шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх, хязгаарлах гэрээ хэлцэл байгуулахыг хориглох тухай заалт хамаарахгүй байх нөхцлийг зааж, зах зээлийн нийлүүлэлтийн нөхцлийг сайжруулах⁴¹, хэрэглэгчдэд үр ашигтай байх талаар гэрээ байж болно гэж заасан.

Гэхдээ Итали улсын хуульд мөн давамгайл байдал болон монополь байдалтай аж ахуйн нэгж гэж ямар аж ахуйн нэгжийг хэлэх вэ гэдгийг тодорхойлоогүй, давамгайл байдалтай байхыг хуулиар хориглоогүй, зөвхөн шударга өрсөлдөөнд харшаар ашиглахыг хориглож байдаг.

Хуулиар компаниудын нэгдэх, нийлэх үйл ажиллагаанд хяналт тавихыг зорьж, шударга өрсөлдөөнд харшлах бол нэгдэн, нийлэх зөвшөөрөл олгохгүй. Мөн нэгдэн нийлэх гэдэгт ямар үйлдлийг ойлгох вэ гэдэг шалгуурыг зааж өгсөн онцлогтой. Компаниуд нэгдэн, нийлэх нь шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх тохиолдолд “Шударга өрсөлдөөний алба” нь нэгдэн, нийлэхийг хориглох эрхтэй.

⁴¹ Зах зээлийн нийлүүлэлтийг сайжруулах нөхцөл гэдэгт тухайн аж ахуйн нэгжийн олон улсын өрсөлдөх чадварыг сайжруулах, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх болон техник, технологийн дэвшлийг бий болгох зорилготой нөхцлийг хэлж байна.

Түүнчлэн энэ хуулиар төрийн өмчит болон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр монополь байдалтай компанийн үйл ажиллагааг зохицуулсан байдаг. (8 дугаар зүйл) Энэ зүйлд зааснаар хэрвээ хуульд өөрөөр заагаагүй л бол, тодруулбал тэдэнд төрөөс онцгой эрх олгоогүй бол уг хууль нь хувийн болон төрийн өмчит компанид адилаар хамаарна. Энэхүү зохицуулалт зарим аж ахуйн нэгжид хуулиар монополь байдалтай байхыг зөвшөөрсөн байдаг ч энэ байдлаа шударга өрсөлдөөнд харшаар, мөн хэрэглэгчдэд хохиролтойгоор ашиглаж болохгүй гэсэн үндэслэлээр хийгдсэн байдаг.

Италийн шударга өрсөлдөөний хуулиар “Шударга өрсөлдөөний алба”-ыг байгуулсан бөгөөд шударга өрсөлдөөнийг хангах талаар үүрэг хүлээлгэж, эрх хэмжээг тогтоож өгсөн нь уг алба хараат бус байгааг илэрхийлнэ.

Энэ байгууллага Ерөнхийлөгч ба 4 гишүүнээс бүрдэж, тэднийг Италийн депутат болон танхимын Ерөнхийлөгч томилдог. Эдгээр албан тушаалтан нь мэргэжлийн өндөр чадвартай төдийгүй хараат бус байх шинжийг агуулах ёстой. Зөвлөлийн гишүүд мэргэжлийн зөвлөгөө өгөх эрхгүй бөгөөд албан үүргээ гүйцэтгэх явцдаа төрийн болон хувийн байгууллагад удирдах үүрэг гүйцэтгэх, эсвэл олон нийтийн алба хаших эрхгүй. Алба нь ЕХ-ны шударга өрсөлдөөний талаар үйл ажиллагаа явуулж буй байгууллагатай хамтран ажиллах үүрэгтэй.

Италийн шударга өрсөлдөөний байгууллагын онцлог нь түүний эрх мэдлийг шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаанаас хамааруулан ангилж тогтоож өгсөнд байдаг. Жишээ нь, 2 дугаар бүлэгт шударга өрсөлдөөнд харш гэрээ, хэлцэл болон давамгайл байдлаа хууль бусаар ашиглаж байгаа талаар шударга өрсөлдөөний албаны эрх мэдлийг заасан байдаг бол 3 дугаар

бүлэгт компаниуд нэгдэн, нийлэх талаар албаны эрх мэдлийг заажээ.

Түүнчлэн шударга өрсөлдөөний алба нь шударга өрсөлдөөний нөхцлийг сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаарх зөвлөмжийг Ерөнхий сайд болон парламентад гаргах эрхтэй бөгөөд жил бүр үйл ажиллагааныхаа тайланг бэлтгэн гаргадаг.

Италийн шударга өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтын онцлог нь шударга өрсөлдөөнд харш тодорхой үйлдлийг хориглохыг зэрэгцээ уг хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих байгууллагын эрх хэмжээг тодорхой зааж өгөх, энэхүү эрх хэмжээг үр нөлөөтэй болон оновчтой болгоход чиглэсэн байдаг.

Энэ байгууллага өөрийн, эсвэл сонирхогч этгээдийн санаачилгаар шударга өрсөлдөөний талаарх нөхцөл байдлыг тодорхойлох, шалгах эрхтэй. Энэхүү шалгах эрх мэдэл, мөн холбогдох мэдээллийг шаардах эрх нь шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой. Учир нь Албанаас шаардсан мэдээллийг холбогдох аж ахуйн нэгж гаргаж өгөөгүй бол торгох эрхтэй байдаг. Алба шалгалтын үр дүнд холбогдох аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргаж, тухайн аж ахуйн нэгжид мэдээлэн, зөрчлөө арилгахыг шаардаж, тодорхой хугацаа тогтоож өгдөг. Энэ тогтоосон хугацаанд холбогдох аж ахуйн нэгж нь зөрчлөө арилгахгүй бол Алба тухайн компанийн өмнөх жилийн нийт эргэлтийн 10 хувь хүртэл хэмжээгээр торгох эрхтэй. Энэ нь шударга өрсөлдөөний хууль хэрэгжих чухал хөшүүрэг болж байдаг.

Түүнчлэн шударга өрсөлдөөний алба аж ахуйн нэгжийн шударга өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг зогсоохыг шаардах, нэгдэн

нийлэх нь шударга өрсөлдөөнд харш бол нэгдэж нийлэхийг хориглох эрхтэй.

Алба хамгийн дээд хэмжээний торгуулийг практикт хэрэглээгүй ч шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх үндэслэл болж чадсан. Харин Италийн хуульд шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаа явуулсны төлөө эрүүгийн хариуцлага ногдуулдаггүйгээрээ АНУ-ын холбогдох хуулиас ялгаатай юм.

Дээрх орнуудын шударга өрсөлдөөний тухай эрх зүйн зохицуулалт ерөнхийдөө төстэй байна гэж дүгнэж болно. Харин хууль тогтоомжинд тусгагдсан хэлбэр, байдал бага зэргийн ялгаатай байв. Тухайлбал, АНУ-д шударга өрсөлдөөний талаарх зохицуулалт хэд хэдэн тусдаа хуулиар зохицуулагдсан байсан бол Европын Холбооны хувьд ерөнхий нэг баримт бичгээр зохицуулагджээ.

Давамгайл буюу монополь байдалтай аж ахуйн нэгжийг тодорхойлж өгөөгүй нь эдгээр орнуудад нийтлэг байв. Шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллагын эрх хэмжээ болон хариуцлагын механизмын хувьд бага зэрэг ялгаатай зүйл ажиглагдсан. Жишээлбэл, АНУ-д шударга өрсөлдөөний байгууллагаас гадна Хууль зүйн яам шударга өрсөлдөөний хуулийн хэрэгжилтийг хянах үүрэг хүлээдэг бол Европын холбооны хэмжээний шударга өрсөлдөөний байгууллагаас гадна гишүүн улс орнуудын шударга өрсөлдөөний байгууллагууд мөн хянах үүрэг хүлээдэг.

Шударга өрсөлдөөний зохицуулалтын талаарх дэлхийн туршлагыг судлахад шударга өрсөлдөөний тухай хууль 19 дүгээр зууны сүүл болон 20 дугаар зууны эхэн үеэс эхэлж, анхлан хууль тогтоогчдын анхаарлын объект болжээ. АНУ-д 1890 онд Шерманы Хуулийг баталсан байдаг бол Герман улсад 1896 онд шударга бус өрсөлдөөний тухай хуулийг анх баталсан.

Шударга өрсөлдөөний тухай хуулийг батлахад олон улсын гэрээ, хэлэлцээрүүд ч чухал үүрэг гүйцэтгэсэн. Жишээ нь, 1883 оны “Үйлдвэрлэлийн өмчийг хамгаалах” тухай Парисын Конвенцийн 10 дугаар зүйлд шударга бус өрсөлдөөн гэж нэрлэгдэх үйлдлийг жагсаасан байдаг. Гэвч олон жилийн турш олон улсад шударга өрсөлдөөнийг иргэний эрх зүйгээр зохицуулж ирсэн түүхтэй. Дэлхийн олон орны туршлагаас харахад олон улсад шударга өрсөлдөөний ач холбогдлын талаар үзэл санаа төлөвшихөд нилээд хугацаа шаардагдсан.

Шударга өрсөлдөөний эрх зүйн нөхцлийг бүрдүүлэх ажиллагаа дэлхийд дараах хандлагатай хөгжиж ирсэн. Эхлээд монополийн үйл ажиллагааг хязгаарлах, давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг төрөөс зохицуулах явдал байв. Дараа нь шударга өрсөлдөөний хуулиар бусад аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулах, тухайлбал, компаниуд нэгдэх, бусад компанийн хувьцааг худалдан авахыг зохицуулах явдал байв. Цаашилбал, шударга өрсөлдөөний хуулиар хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, шударга өрсөлдөөнд оролцож буй аж ахуйн нэгжийн нэр төрийг хамгаалах, бусад хууль тогтоомжтой нягт уялдуулах явдал байсан. Түүнчлэн шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллагад илүү эрх мэдэл олгох байдлаар илэрхийлэгдэж байна.

Өнөөгийн байдлаар эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй ихэнх орнууд, мөн ардчиллыг шинээр байгуулж байгаа хуучин социалист орны ихэнх нь шударга өрсөлдөөний талаар хуулийг баталсан байна. Дэлхий нийтээр шударга өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтад ач холбогдол өгч байгаа нь шударга өрсөлдөөн эдийн засгийн хөгжилд ихээхэн үүрэг гүйцэтгэж, тухайн

нийгэмд шударга бус явдлыг устгах, эдийн засгийн харилцаанд оролцогчдод тэгш боломж олгох, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хүн амын амьдралын нөхцлийг сайжруулахад шууд нөлөөлдөг гэж хүлээн зөвшөөрч байгаатай холбоотой. Шударга өрсөлдөөнийг дэмжиж байгаа орнуудад шударга өрсөлдөөний байгууллагад ихээхэн эрх мэдэл олгож, тэдгээрийн байр суурийг бэхжүүлэх хандлага улам бүр нэмэгдсээр байна.

Энэхүү судалгааны тайланд Монгол улсаас бусад хуучин социалист орнуудын шударга өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтыг дурьдаагүй. Гэхдээ ЕХ-ны орнуудын шударга өрсөлдөөний тухай хуультай харьцуулахад хуучин социалист орнуудын шударга өрсөлдөөний тухай хуульд шударга өрсөлдөөнд харшлах гэрээ, хэлэлцээр байгуулах, давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулахаас гадна шударга бус өрсөлдөөн явуулснаас бусад өрсөлдөгч субъектэд учрах хохирлоос хамгаалах, мөн хэрэглэгчийн эрхийг нэмж зохицуулсан байдаг. Харин АНУ болон баруун Европын орнуудад шударга өрсөлдөөний эсрэг аж ахуйн үйл ажиллагааг нэг хуулиар, харин үүнтэй холбоотой бусад үйл ажиллагааг аж үйлдвэрийн өмч, патентын эрхийн тусдаа хуулиар зохицуулсан байдгаараа ялгаатай.

Хуучин социалист орнуудын шударга бус өрсөлдөөний эсрэг хуулийг батлахад ихэвчлэн эрх зүй хийгээд эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй орнуудын хууль, тогтоомжийг үлгэр жишээ болгож, мөн холбогдох мэргэжилтнүүдээс туршлага суралцаж баталж байсан түүхтэй. Нэг талаасаа энэ нь зөв, үнэхээр эдгээр эдийн засгийн төлөвлөгөөт бодлого хэрэгжүүлж байсан улс орнуудад шударга өрсөлдөөний нөхцлийг

хангах туршлага огт байгаагүй учир гадаадын хөгжилтэй орнуудын туршлагыг харгалзан үзэх хэрэгтэй. Гэвч нөгөө талаасаа АНУ зэрэг бусад эдийн засгийн хувьд хөгжилтэй орнуудад шударга өрсөлдөөний бодлогыг хэрэгжүүлж эхлээд багагүй хугацаа өнгөрч, асар их туршлага хуримталсан байгаа ч шууд тэрхүү туршлагыг өөрийн улсдаа хэрэглэнэ гэдэг огтхон ч боломжгүй зүйл. Учир нь улс орнуудын эдийн засгийн цар хүрээ, үүний дотор гадаад худалдаа, нөөц зэрэг нь хуучин социалист улсынхаас ялгаатай байдаг. Иймд өөрийн улсын онцлог, нийгмийн төлөвшил зэрэгт тохируулсан шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэх нь нэн чухал. Бид өөрийн орны хууль тогтоомжийг боловсруулахдаа шударга өрсөлдөөний эрх зүйн орчинг бүрдүүлсэн улс орны туршлагыг ихээхэн ашиглаж, тэдэнд тулгарч байсан бэрхшээл, хүндрэлийг судалж, тэдгээрийг харгалзан цаг хугацаа хожих боломжтой юм.

2.4 МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨРСӨЛДӨӨН, ЗОХИЦУУЛАЛТЫН ХӨГЖИЛ

Өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас харахад аль ч улсад шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах хуулиуд зах зээлийн эдийн засгийн тулгуур хуулиудын нэг байдаг ба тэдгээрийн хэрэгжилт эдийн засагт асар их ач холбогдолтой байдаг. Эдгээр улсын олон жилийн туршлагаас Монгол улсад суралцах, жишиг болгох зүйлүүд их байна.

Монгол улс жижиг нээлттэй эдийн засагтай бөгөөд өөрийн гэсэн өрсөлдөөний онцлог шинж чанаруудтай. Жишээ нь, жижиг эдийн засагт үйлдвэрлэлийн төвлөрөл өндөр байдаг, зах зээлд нэвтрэн ороход саад бэрхшээл их, үйлдвэрлэлийн түвшин үр ашигтай түвшнээс доогуур байдаг гэж Майкл

Гейл (2003) тэмдэглэжээ. Жижиг эдийн засагт зах зээлийн өрсөлдөөний боломжит, нийцтэй орчныг төлөвшүүлэхэд хүндрэлтэй, олон өвөрмөц асуудал бий. Тэр тусмаа зах зээл рүү шилжиж байгаа шилжилтийн эдийн засгийн өөрийн онцлогууд ч байна.

Социализмын үед Монголд бүх бараа, үйлчилгээний үнийг төрөөс хатуу хянаж, бүх салбарт улсын өмчийн монополиуд оршиж, өрсөлдөөн огт байгаагүй гэж хэлэхэд хилсдэхгүй. Гадаад худалдааны эрх чөлөөгүй нөхцөлд дотоодын зах зээлд цөөн тооны дотоодын үйлдвэрлэгчид ажиллаж, импортоор оруулсан бараанд тусгай коэффициентийн системийг ашигласан үнийг тогтоож, эдийн засгийг үндсэндээ дэлхийн зах зээлээс хаалттай байлгаж ирсэн бөгөөд өрсөлдөөн гэдэг ойлголт өөрөө социализмын үеийн төвлөрсөн төлөвлөгөөний биелэлтийн төлөөх өрсөлдөөнөөр хязгаарлагдаж байсан.

Монголын эдийн засгийг зах зээлийн горимд оруулах, зах зээлийн эдийн засгийн үндсэн элементүүд болох чөлөөт үнийн тогтолцоо, зах зээлийн өрсөлдөөнийг богино хугацаанд бий болгох шаардлага тавигдлаа. Энэ нөхцөлд бүхий л аж ахуйн нэгж болон аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй субъектэд тэгш эрх олгох, давамгайл, эсвэл монополь байдалтай аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах шаардлага зүй ёсоор тавигдсан билээ.

1986 онд эдийн засгийн шинэчлэлийн зарим арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлж, 1987 онд төрөөс зарим барааны үнийг чөлөөлж, 1988 онд хоршооны болон улсын үйлдвэрийн тухай хуулийг баталж, түүний дагуу улсын бөгөөд хоршооны үйлдвэрүүд илүүдэл бүтээгдэхүүнээ зах зээлд чөлөөтэй борлуулах эрхтэй болж, анхны хоршоонууд олноор үүссэн. 1989 оны хувьд

ээмших малын тоог өсгөж, хувийн аж ахуй дэмжсэн алхмууд хийгдсэн. Энэ үеэс эхлэн Монголын эдийн засагт урьд нь олон жил байгаагүй зах зээлийн өрсөлдөөн хөгжиж эхэлсэн. Иймд нээлттэй зах зээлийн эдийн засаг рүү шилжих үед шударга өрсөлдөөнийг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх, түүний хэрэгжилтийг хангах ажлыг Монгол улсад зохион байгуулах шаардлагатай болсон.

1990 оны 10-р сараас эхлэн Монголын эдийн засгийг зах зээлд шилжүүлэх эдийн засгийн бодлогын олон арга хэмжээнүүд хэрэгжиж, улсын үйлдвэрүүдийн хувьчлал, гадаад худалдааны либералчилал, үнийг чөлөөтэй болгох үйл явц, валютын ханшийг чөлөөлөх, үйлдвэрүүдийг компани болгон өөрчлөх, санхүү, мөнгөний хүрээнд томоохон өөрчлөлтүүд эхэлсэн. 1991 оны Хөдөлмөрийн хуулиар Засгийн газар цалингийн доод түвшинг (сарын 750 төгрөг) мөрдөж, үйлдвэрүүдийн цалинг төрөөс шууд тогтоохыг зогсоон, хөдөлмөрийн зах зээлийг чөлөөлөх арга хэмжээг авсан.

1991 оны 1-р сард Засгийн газрын 20-р тогтоолоор хүнсний барааны 50%, бусад барааны 70%-ийг чөлөөлж, засгийн газрын мэдэлд зөвхөн 35 төрлийн жижиглэнгийн болон 30 төрлийн бөөний худалдааны үнийг үлдээсэн. 1991 оны 10-р сард засгийн газраас үнийг хянадаг барааны нэр төрлийг 17 болгон цөөрүүлж, 1992 оноос хамгийн чухал бараа болох шатахуун болон зарим хүнсний бараанаас бусдын үнийг чөлөөлсөн. Үүний зэрэгцээ жижиг болон том улсын үйлдвэрүүдийн хувьчлал идэвхтэй явагдаж, хувийн хэвшил хөгжиж, зах зээлийн эдийн засгийн гол бүрэлдэхүүн хэсгүүд бий болж, зах зээлийн өрсөлдөөн идэвхжсэн. Бага хувьчлалын хүрээнд 2670 үйлдвэр аж ахуйн газар хувьчлагдахаас 1991 оны 12-р сарын 15-ны байдлаар 1673 цэг салбар худалдаанд

зарлагдаж, 1347 нь худалдагдсан байв. (Өмч хувьчлал – 10 жилд, хуудас 17, 2001)

Хэдийгээр зах зээлийн эдийн засгийн гол элементүүд бүрэлдэж эхэлсэн боловч зах зээлийн шинэ тогтолцоо хараахан хөгжөөгүй байхад улсын хангамж, худалдаа, хөрөнгө оруулалтын систем маш хүнд байдалд орж, барааны зах зээлд хомсдол бий болж, амьжиргааны түвшинг зохицуулах үүднээс картын системийг хэрэглэх шаардлага гарсан. Үүний гол шалтгаан гэвэл Монголын эдийн засагт ЗХУ болон бусад социалист орнуудын шилжих рублиэр тооцоо хийгдэж, социалист улсуудын худалдааны тогтолцооноос хэт хараат байсны зэрэгцээ тогтолцооны хямралд орсон явдал мөн. 1991 оноос шилжих рублийн тогтолцоо хүчингүй болж, бүх гадаад худалдаа доллараар хийгдэх болсон үед Монголын өргөн хэрэглээний бараа, шатахуун, эрчим хүч, тоног төхөөрөмж болон түүний эд ангиудыг бараг 100% хангадаг байсан Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн худалдааны систем татан буугдахад Монголын зах зээлд ихээхэн хүндрэл учирсан. Энэ хямралаас гарах гарц нь зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжих явдал байв.

Өмнөх жилүүдэд асар их худалдааны алдагдалтай байсан Монгол улс (1986 онд – гадаад худалдааны тэнцлийн алдагдал 330 сая ам доллар, 1986 онд 589 сая ам долларын алдагдалтай, төлбөрийн тэнцлийн алдагдал 1983 онд 824 сая ам доллар, 1986 онд 1063 сая ам долларын алдагдалтай) шилжих рублийн оронд доллараар худалдаа хийх шаардлагатай тулгаран валютын нөөц улсын нийт хэрэглээг хангах боломжгүй болсон. (1986 онд Монголын гадаад валютын нөөц 53.5 сая, 1990 оны эхэнд 122 сая ам доллар байсан) Иймээс гадаад худалдааг яаралтай либералчилах, валютын ханшийг чөлөөтэй

хөрвүүлэх, албан ханшаас татгалзах шаардлага тавигдсан.

Зах зээлийн хомсдол ихээхэн хүчтэй болсон энэ үед “ганзагын” наймааны үе эхэлж, урьд нь төвлөрсөн байдлаар гадаадаас хангадаг байсан барааг анхны наймаачид хувиараа гадаадаас авчран нийлүүлж эхэлсэн. Үүний зэрэгцээ тохиролцооны олон дэлгүүр нээгдэж, зах зээлийн өрсөлдөөн илрэх анхны үзэгдэл газар авч байв. Энэ үеэс эхлэн Монгол улсад хувийн сектор бүрэлдэн тогтож, бизнесийн янз бүрийн чиглэлүүд хөгжиж эхэлсэн. Үйлдвэрлэлийн салбараас худалдаа, үйлчилгээний газрууд илүү хурдацтай хөгжсөн ч хүнс ба хөнгөн үйлдвэрийн салбарт жижиг болон дунд үйлдвэр эрхлэгчдийн тоо нэмэгдэж, яваандаа үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, тэдгээрт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх асуудал чухал болсон.

Шилжилтийн эхний жилүүдэд аж ахуйн нэгжүүдийн тоо, ялангуяа хувийн хэвшлийн компанийн тоо огцом өсч, ерөнхийдөө зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчдийн дийлэнх жижиг бизнес эрхлэгчид болж, үнийн ялгаварлалгүй өрсөлдөөн явагдаж байсан. Зарим жижиг үйлдвэрлэгчид өдөр тутмын өргөн хэрэглээний барааг нэр төрлийн хувьд адил боловч “өөрийн” (сав баглаа боодол, барааны марк тэмдэг, компанийн нэр хүнд гэх мэт) гэж ялгагдахуйцаар үйлдвэрлэж байгаа ч “үнийн ялгаварлал” жинхэнэ утгаар оршихгүй байлаа.

Үнийг чөлөөлсөн ба өмч хувьчлалын үйл явц алхам алхмаар хийгдсэн. 1991 оноос хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр төрийн өмчийг хувьчлах үйл явц эхэлж, 1992 он гэхэд үндсэн фондын 13% хувьд шилжиж, үндсэн хөрөнгийн үнэлгээ 4-5 дахин өсөв. Үнэт цаасны зах зээл 1995 он

хүртэл хойшилж, нээгдсэн нь өсч увьчлалыг шударга явуулахад саад болжээ. Улсын алдагдалтай үйлдвэрүүдийг хувьчлах үйл ажиллагаа 1995-1998 онуудын хооронд үргэлжилж, 1995 оны 11-р сард УИХ-аас өмч хувьчлалын талаар баримтлах бодлогоо тодорхойлжээ. Өмчийг хувьчилснаар эдийн засагт үр ашигтай хуваарилалтыг бий болгох ба өрсөлдөөнийг дэмжсэн алхам боллоо. Зах зээлийн өрсөлдөөний үр дүнд ашигтай ажиллаж буй хувийн сектор, төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжүүд зэрэгцэн үйл ажиллагаа явуулж, өрсөлдөөний цар хүрээ, түвшин мэдэгдэхүйн өссөн. Хувийн секторт үйл ажиллагаагаа бэхжүүлсэн компаниуд томорч, зах зээл дээрх давамгайл байдлаа урвуулан ашиглах үйл явц, шударга бус өрсөлдөөний хэлбэрүүд илэрч, зах зээлд зар сурталчилгаа идэвхжиж, буруу ташаа мэдээлэл, зар сурталчилгаа нэмэгдэв. Зах зээлд бизнесийн шинэ шинэ чиглэл үүсч, шинэ шинэ компаниуд орж ирснээр зах зээлийн өрсөлдөөнд компаниудын эзлэх хувийн жин өөрчлөгдсөн. Ерөнхийдөө Монгол улсын эдийн засагт хувийн ба улсын сектор микро ба макро түвшинд хөгжих үндэс бий болж, зах зээлийн өрсөлдөөний хандлага өөрчлөгдөж эхлэв.

Зах зээлийн өрсөлдөөн зарим салбарт шинэчлэлт, өөрчлөлтийг дэмжсэн боловч зарим салбарт компаниуд төрийн санхүүгийн дэмжлэгтэйгээр ноёрхох, үгсэж хуйвалдах, тухайн зах зээлд борлуулах бүтээгдэхүүний үнийг тохиролцох явдал далд байдлаар бэхжиж эхэлсэн. Ийм нөхцөлд Монголын өрсөлдөөнийг оновчтойгоор зохицуулах, шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх хууль эрх зүйн болон зохион байгуулалтын үйл ажиллагаа улам ихээр шаардагдаж ирлээ.

Эрх зүйн шинэчлэлийн ажил 1992 онд Үндсэн хуулийг баталснаар эхэлсэн. Энэ нь

Монгол улсын эрх зүйн тогтолцоо төдийгүй улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны суурь болж, бүхий л хууль тогтоомж үндсэн хуульд нийцэх ёстой байв. 1993 онд “Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах тухай” хууль, “Дампуурлын тухай” хууль тус тус батлагдаж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн.

Монгол улсын Үндсэн хуулийн 5.1-д “Монгол улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасан. Мөн хуулийн 5.2 дугаар зүйлд “Монгол улсад өмчийн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрч, хуулиар хамгаална” гэж зааснаар шударга өрсөлдөөнийг хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх суурийг тавьсан. Тиймээс төрийн өмч илүү давамгайл байдалтай байх ойлголтоос татгалзаж, бүгд тэгш эрхтэй бөгөөд хуулиар нэгэн адил хамгаалагдах болно гэдгийг баталгаажуулжээ.

Үндсэн хуульд зааснаас гадна бусад эрх зүйн актад шударга өрсөлдөөний талаар зохицуулалт хийж эхэлсэн. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 7.12-т зааснаар Монгол улсын их хурлын дэргэдэх Эдийн засгийн байнгын хороо “шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого”-ыг хэрэгжүүлнэ, харин Засгийн газрын тухай хуулийн 8.4-т засгийн газар нь “...эдийн засгийн харилцааг аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж, шударга өрсөлдөөнийг дэмжин дангаар ноёрхлыг хязгаарлах, эдийн засгийн тэнцвэрийг сайжруулах арга хэмжээ авна” гэж заасан. Үүний дагуу Монгол улсын 1996, 2000, 2004 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах, дангаар ноёрхохыг хязгаарлах, монополийн эсрэг зэрэг эрх

зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох тухай тусгасаар ирсэн.

1998 оны “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн 15 дугаар заалтанд “аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа хэвийн явуулах, өрсөлдөх эрх зүйн орчинг бүрдүүлэх үүднээс шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, үндэсний эдийн засгийг хөгжүүлэх нэг хөшүүрэг болох гадаад, дотоод хөрөнгө оруулалтыг дэмжих, тэдгээрт төрөөс ижил нөхцөл бүрдүүлэх шаардлагыг иш үндэс болгон хөрөнгө оруулалтын тухай хуулийг боловсруулна” гэж заажээ.

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль

1993 онд анх удаа Монголын түүхэнд шударга өрсөлдөөний талаар бие даасан хуулийг баталсан.⁴² Уг хуульд 1995, 2000, 2005 онд нэмэлт өөрчлөлтүүд оруулж, 1995, 2000 онд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь ихэвчлэн давамгайл байдалтай аж ахуйн нэгжийг тодорхойлох шалгуур, шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааг нэмж зааж өгөх тухай байв. Харин 2005 оны нэмэлт өөрчлөлтөөр “Шударга өрсөлдөөний хянан зохицуулах газар”-ыг байгуулсан. Энэ нэмэлт өөрчлөлт нь шударга өрсөлдөөний хуулийг Монгол улсад хэрэгжүүлэх, шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэхэд цоо шинэ үеийг авчирсан гэж олон судлаач, мэргэжилтнүүд үздэг.

Монгол улсын шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах тухай хууль нь хэдий дутагдалтай гэж шүүмжлүүлдэг ч тэрхүү 1990-ээд оны

⁴² Монгол улсад шударга өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлэхэд нэн түрүүнд урьд өмнө хэрэгжиж байсан бүхий л салбар дахь төрийн ноёрхлыг багасгах зорилго чухал байв. Үүний тулд төрийн өмчийг хувьчлах, зах зээлийг чөлөөлөх ажлыг зохион байгуулсан. Өнөөгийн байдлаар Монгол улс нь үйлдвэр, үйлчилгээний ихэнхийг хувьчилсан бөгөөд аж ахуйн үйл ажиллагааг төрөөс удирдах гэхээс илүү зохицуулах аргыг хэрэглэж байна.

эхэн үеийн эрх зүйн шинэчлэлийн том ажлын явцад батлагдсан нь маш том амжилт гэж үздэг. Монгол улсын “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хууль 6 бүлэг, 18 зүйлээс бүрддэг.

Уг хуулиар: 1) давамгай байдлаа шударга өрсөлдөөнд харшаар ашиглах, давамгай байдалтай аж ахуйн нэгж өрсөлдөгч аж ахуйн нэгж өрсөлдөөнд саад учруулсан хэлцэл хийхийг хориглох, өрсөлдөгч аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалд ажиллахыг хориглох, өрсөлдөгчөө эрхшээлдээ авахыг хориглох, өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулахыг хориглох; 2) төрийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн шийдвэр гаргахыг хориглох; 3) шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллага; 4) зүй ёсны монополийг төрөөс зохицуулах талаар зохицуулсан байдаг.

Монгол улсын “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1-д “Уг хуулийн зорилго нь Монгол улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдэд зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагааг хориглон хязгаарлах, харш үйл ажиллагаанаас урьдчилсан сэргийлэх эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг тодорхойлж хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна” гэж заасан байдаг.

Хэдийгээр Монгол улсын шударга өрсөлдөөний тухай хуулийг бусад орны ижил төрлийн хуультай харьцуулахад олон төрлийн дутагдалтай хэдий ч нилээд олон давуу талыг агуулсан байдаг. Монгол улсын шударга өрсөлдөөний тухай хууль хуучин социалист орнууд болон эрх зүйн өндөр хөгжилтэй орнуудын шударга өрсөлдөөний зохицуулалтыг хослуулан хэрэглэсэн байдаг. Тухайлбал, Баруун Европын болон АНУ-ын шударга өрсөлдөөний тухай хуультай

харьцуулахад Монгол улсын хуульд давамгай байдалтай аж ахуйн нэгж болон монополь байдалтай аж ахуйн нэгж гэж ямар аж ахуйн нэгжийг үзэх шалгуурыг зааж өгсөн. Үүнд “зах зээлд тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын гуравны нэгээс дээш хувийг дагнан буюу бусад этгээдтэй хамтран хийж байвал давамгайлах байдалтай” гэж үзнэ. Ноёрхох гэдэгт давамгай байдлаа хууль бусаар ашиглах, өрсөлдөгчөө зах зээлд ороход саад учруулах, өрсөлдөөнийг болон хэрэглэгчийг хясан боогдуулахыг хэлдэг. Мөн уг хуулийн 5.3-т “тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэлт хийж байгаа нэг этгээд байхад л нийгмийн дундаж зардал, хамгийн бага байх зах зээлд дангаараа үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийг *зүй ёсны монополь* гэж үзнэ” гэжээ.

Манай улсын хуулиар давамгай байдалтай байхыг хориглоогүй, гол нь энэ байдлаа урвуулан ашиглахыг хориглох талаас нь зохицуулсан байдаг. Үүний үр дүнд давамгай байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг илүү үр дүнтэйгээр зохицуулж, улмаар шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах талаасаа ач холбогдолтой. Хууль бусаар ашиглах буюу урвуулан ашиглах (*abuse of dominant power*) гэдэгт шударга өрсөлдөөнд харшаар үйл ажиллагаа явуулахыг хэлдэг.

Монгол улсын шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд барааны тэмдэг, байгууллагын нэр хүнд, патентын хийгээд зохиогчийн эрхийн хуулийг зөрчих нь шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлнө гэж үзэн өрсөлдөгчийн болон түүний бараа бүтээгдэхүүний нэр хүндийг гутаах, эсвэл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараахыг хориглоно гэжээ. Тухайлбал, Монгол улсад цөөн хэдэн компани тамга үйлдвэрлэх эрхтэй байдаг. Гэтэл эдгээрийн нэг нь өөрийгөө төрийн тамга үйлдвэрлэх

цорын ганц байгууллага гэж гадуур сурталчилсан байв. Энэ нөхцөлд ихэнх захиалагч нар түүгээр тамга үйлдвэрлүүлж байсан. Энэ нь бусад тамга үйлдвэрлэгч нарт олон захиалагчдыг алдах, орлого олохгүй байх байдлыг бий болгосон. Иймд тухайн өөрийгөө цорын ганц төрийн тамга үйлдвэрлэгч гэж зарласан байгууллага нь буруу ташаа мэдээ тараах байдлаар шударга өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаа явуулсан. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллага нь тухайн байгууллагад захиргааны арга хэмжээ авсан байсан.

Давамгай байдалтай аж ахуйн нэгжийн тухай ойлголт

Давамгай байдалтай аж ахуйн нэгжүүд нь өөрийн давуу байдлаа, тухайлбал, борлуулалтын хэмжээ нь бусдаас давамгай байдаг, тэртээ тэргүй түүний бүтээгдэхүүнийг хэрэглэгчид нь сонгох болно, эсвэл түүний бүтээгдэхүүнийг орлох бүтээгдэхүүн байхгүй гэх утгаар өөрийн давуу байдлаа урвуулан ашиглаж болзошгүй байдаг. Энэ нь эргээд шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх, тухайлбал, үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, бусадтай хуйвалдаж үнийг нэмэх зэрэг байдлаар урвуулан ашиглахад хүргэдэг. Жишээ нь, бензиний үнийг хэт өндөр тогтоосноор ард түмний амьдралын түвшин доройтно. Иймд хуулиар давамгай байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хуулиар нарийн зохицуулах нь эдийн засгийн хөгжилд тустай гэж үздэг.

Монгол улсын шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулиар давамгай байдалтай аж ахуйн нэгжид шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх үүднээс босоо болон хөндлөн шугамын түвшинд гэрээ, хэлцэл байгуулахыг хориглосон байдаг. (ШБӨХХ-ийн 6, 7 дугаар зүйл)

Практикт тухайн хөндлөн шугамын гэрээ, хэлцэл нь шударга өрсөлдөөнд харш байна гэдгийг нотлоход хэцүү байдаг. Жишээ нь, “Шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах газар” нь шатахуун нийлүүлэгч хэд хэдэн давамгай байдалтай аж ахуйн нэгж 2006 онд хуйвалдаж, бензиний үнийг нэмсэн гэж тогтоосон боловч хангалттай нотлох баримт байгаагүй тул захиргааны арга хэмжээ авч чадаагүй.⁴³

Босоо шугамын түвшинд хуйвалдах явдал гэдэгт, тухайлбал, нийлүүлэгч үйлдвэрлэгч хоёр хуйвалдах, нийлүүлэгчийг ялгавартайгаар сонгох, худалдах үнийг ялгавартайгаар тогтоох, шинэ өрсөлдөгч гарч ирэхэд саад болохыг хориглосон.

Компаниуд нэгдэх үйл явцын зохицуулалт

“Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хуульд давамгай байдалтай аж ахуйн нэгжид:

- “...давамгай байдалтай аж ахуйн нэгжийн удирдлага өрсөлдөгч бусад аж ахуйн нэгжийн удирдлагын албан тушаалд хавсарч ажиллах”;
- “...ноёрхох зорилгоор өрсөлдөгчийн хувьцааг худалдан авах”-ыг хориглоно гэж заажээ.

Өрсөлдөгч аж ахуйн нэгжийнхээ хувьцааг худалдан авах нь төвлөрөл бий болгох үр дагаварт хүргэж болзошгүй. Менежмент, зохион байгуулалт, мөн илүү ашиг олох талаасаа компанид ашигтай гэж тооцогддог ч тухайн аж ахуйн нэгж нь зах зээлд давамгай байдалтай болж, зах зээлийн үнэ, нийлүүлэлт, чанар зэрэгт нөлөөлж үүнийгээ урвуулан ашиглаж, шударга өрсөлдөөнд саад учруулах магадлалтай байдаг. Иймд “Шударга бус

⁴³ Зарим орны туршлагыг харахад тухайн гэрээ хэлцэл картель мөн эсхийг тодорхойлох талаар тусгай аргачлал баталж, комиссоор хамтын шийдвэр гаргадаг байна.

өрсөлдөөнийг хориглох тухай” хуулийн 15 дугаар зүйлд зааснаар аж ахуйн нэгж нийлэх, өөрчлөгдөх, нэгдэх нь төрийн хяналтанд байна. Түүнчлэн давамгайл байдалтай аж ахуйн нэгж шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх үүднээс өрсөлдөгч аж ахуйн нэгжтэй нэгдэх, нийлэхийг хориглоно.

Өнөөгийн байдлаар нэгдэж, нийлэх гэж байгаа аж ахуйн нэгж бүртгүүлэхдээ заавал “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар”-аас дүгнэлт авах ёстой байдаг. Хянан зохицуулах газар нь холбогдох материалыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дүгнэлтийг бичгээр гаргана. Шаардлагатай гэж үзвэл хянан зохицуулах газар энэ хугацааг 14 хоног хүртэл сунгаж болно. Хянан зохицуулах газар нь *“...аж ахуйн нэгжүүдийг нэгдэх, нийлэх, хувьчлах замаар өөрчлөн байгуулснаар зах зээлд ноёрхох байр суурь эзлэн өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл бүрдэнэ”* гэж үзсэн тохиолдолд аж ахуйн нэгжүүдийг өөрчлөн байгуулахаас татгалзаж болно. Татгалзсан дүгнэлт нь “үг аж ахуйн нэгжийг улсын бүртгэлд бүртгэхгүй байх үндэслэл болно” гэж тус тус заасан байна. Өрнөдийн орнуудын хууль тогтоомжид аж ахуйн нэгж нийлэх, нэгдэх үйл явцыг маш нарийн зохицуулж, шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд эрх бүхий байгууллага тухайн аж ахуйн нэгжийг тараах хүртэл арга хэмжээ авах эрхтэй байдаг.

Монополийн зохицуулалт

Шударга бус өрсөлдөөний хуулийн дараагийн нэг зохицуулалт нь монополийн үйл ажиллагаанд чиглэдэг. (ШБӨХХ-ийн 5.2, 5.3, 16 дугаар зүйлүүд) Бусад оронтой харьцуулахад манай улсын монополийн эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Монополь тухайн салбарын онцлогоос

хамаарч бий болдог. Тухайлбал, зарим улсад шуудангийн үйлчилгээ төрийн эрх мэдэлд байж, улс монополь эрхээ тогтоосон байдаг. Монгол улсад нэг удаагийн зүү тариур үйлдвэрлэх үйл ажиллагааг ганц аж ахуйн нэгж эрхэлдэг. Мөн саяхныг хүртэл Монгол улсын иргэний агаарын тээвэр (МИАТ) нь дотоод гадаадын нислэг хийх эрх бүхий цорын ганц байгууллага байсан.

Төрөөс аль нэг салбарт монополь тогтоох нь нийтийн ашиг сонирхол, аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотой. Иргэний агаарын нислэг нь олон хүний амь нас, аюулгүй байдал, мөн хөрөнгө, баталгааны хувьд их хэмжээний өртөг шаарддаг учир төр энэ салбарт давуу эрх эдэлдэг. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар *зүй ёсны монопольд зах зээлд нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүний тоо хэмжээнээс хамааран зөвшөөрөл олгож, бодит байдлыг харгалзан тухайн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчид борлуулах үнийн өөрчлөлтийг хянан зөвшөөрөл олгон зүй ёсны монополийн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт буурсан тохиолдолд өрсөлдөөн бий болгох шаардлагыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлнэ. Зүй ёсны монополийн дараах үйл ажиллагааг хориглодог. Үүнд:*

- тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нийлүүлэхийг хязгаарлах,
- эсвэл нэг зах зээлээс нөгөөд борлуулахыг хязгаарлах,
- төрийн захиргааны байгууллага нь аж ахуйн нэгжтэй хуйвалдаж, өрсөлдөөнд харшаар нөлөөлөх, тухайлбал, бараа бүтээгдэхүүний үнийг бууруулах,
- зах зээлийг нутаг дэвсгэр, эсвэл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилах,

- аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд тухайн зах зээлд гарч ирэхийг хязгаарлах, эсвэл түүнийг зах зээлээс шахан зайлуулах,
- аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг бусад байгууллага, аж ахуйн нэгж, үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд зээлээр олгох гэх мэт үйл явцыг хориглосон байдаг.

Төрөөс зориудаар бий болгоогүй боловч тухайн зах зээлийн жамаар бий болсон монополь бас байж болох ба үүний жишээ бол нэг удаагийн зүү тариурын үйлдвэр юм. Зах зээлээ дагаад бий болсон монополь нь хэдийгээр төрөөс зөвхөн тодорхой нэг субъектэд энэ салбарт үйл ажиллагаа явуулахыг хязгаарлаагүй байхад зах зээлийн шалгуур - тодорхой стандарт, эд хөрөнгө, хяналт, ашиг, нийгмийн хэрэгцээ, шаардлага гэх зэргээс шалтгаалан өрсөлдөөнгүй нөхцөл байдал бий болдог.

Шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулахыг төрийн захиргааны байгууллагад хориглож, хуульд зааснаас бусад тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл буюу лиценз олгохыг зөвшөөрдөггүй.

Монополь байдалтай аж ахуйн нэгж өөрийн давамгайл байдлаа урвуулан ашиглах боломжтой. Жишээ нь, өөр үйлдвэрлэгч байхгүй нөхцөлд тухайн барааны нийлүүлэлтийг хязгаарлаж, хомсдол бий болгон үнийг өсгөх, эсвэл барааны чанарт анхаарахгүй байх гэх мэт. Онолын хувьд монополь байдал нь өрсөлдөх чадвар болон хэрэглэгчдэд сөрөг үр нөлөөтэй гэж үздэг. Дотоодын зах зээлд өрсөлдөгчгүй байсан аж ахуйн нэгж гадаад зах зээлд ч өрсөлдөх чадваргүй байдаг. Хэрэглэгчид өөр сонголт байхгүй шалтгаанаар өндөр үнэтэй ч бай, чанар муутай ч бай тухайн

бараа, бүтээгдэхүүнийг худалдан авахаас өөр аргагүйд хүрнэ. Монгол улсын үүрэн холбооны салбарт саяхныг хүртэл Мобиком давамгайлж, өрсөлдөгч гарч ирэх хүртэл үйлчилгээний тариф өндөр байсан.

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах алба /цаашид “Хянан зохицуулах алба” гэх/ нь шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, таслан зогсоох, өрсөлдөөнд оролцож, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагааг шалгаж дүгнэлт гаргах, аж ахуйн нэгжийн давамгайл болон зүй ёсны монополь байдалтай, түүнчлэн тэр байдлаа алдсаныг тогтоох болон шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэх санал боловсруулан холбогдох байгууллагад оруулах чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байна гэж заасан байдаг.

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар бүтцийн хувьд Зөвлөл, дөрвөн гишүүн, мөн байцаагч нараас бүрддэг. Энэ байгууллага нь шударга бус өрсөлдөөний хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс аж ахуйн нэгжийг шалгах, дүгнэлт гаргах, давамгайл байдалтай болон монополь байдалтай болсныг тогтоох, шударга бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хориглох, шударга өрсөлдөөний нөхцлийн талаар мэдээлэл өгөх, шударга өрсөлдөөний нөхцлийг сайжруулах талаарх зөвлөмжийг Засгийн газарт гаргах эрх эдэлж, гаргасан шийдвэрээ нийтэд мэдээлэх эрхтэй байдаг.

Мөн түүнчлэн уг газар нь компаниудын нэгдэх, нийлэх талаар хяналт тавьж, зүй ёсны монополь байдалтай аж ахуйн нэгж, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, үнийн

өөрчлөлтийн талаар зөвшөөрөл олгох эрхтэй байдаг.

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар нь шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль зөрчигчдөд захиргааны шийтгэл ногдуулах эрхтэй бөгөөд 250 000 хүртэл төгрөгөөр торгох, хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураах, зөрчлийг арилгах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ байж болно гэж заасан байна.

Монгол улсын шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулиар шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллага байгуулсан явдал шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэхэд маш урагштай алхам болсон гэж хүлээн зөвшөөрдөг. Гэвч манай улсын хуулиар шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллагын хараат бус байдал, эрх хэмжээг төдийлөн нарийн зааж өгөөгүй байна.

Монгол улсын шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулиар аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хэн бүхэн өмчийн хэлбэр, харъяалал зэргээс үл хамаарч шударга өрсөлдөөний тухай хуулийг дагаж мөрдөх ёстой.

Өрсөлдөөнийг зохицуулах бусад хууль

Шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэхэд шударга өрсөлдөөний тухай тусдаа хуультай байхаас гадна гадна бусад хуулийг ч түүнд нийцүүлэх шаардлагатай болдог. 1990-ээд оноос хойш Монгол улс эдийн засгийн салбарт өөрчлөн шинэчлэлт хийхдээ холбогдох хуулиудыг баталж, өнөөгийн байдлаар нээлттэй зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой ихэнх хуультай болсон. Тухайлбал, Компанийн

тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, татварын хуулиуд, банк болон банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хуулиуд, мөн гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиудыг нэрлэж болно.

Монгол улсын компанийн тухай хууль 2002 онд шинэчлэгдэж, нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн хэлбэр, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаас үл хамааран үйл ажиллагааг зохицуулах юм.

Компани үйл ажиллагаагаа “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хуулийн дагуу явуулах үүрэгтэй. Монгол улсын компанийн тухай хуульд зааснаар компани нийлэх, нэгдэх, тусгаарлах, хуваагдах байдлаар өөрчилж болно. (Компанийн хуулийн 18-23 дугаар зүйл). “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль”-ийн 15 дугаар зүйлд заасан төрөөс аж ахуйн нэгж нэгдэх, нийлэх үйл ажиллагаанд хяналт тавих талаар компанийн тухай хуульд заагаагүй байна. Компанийн тухай хуульд шударга бус өрсөлдөөнийг хориглосон тухай заалт бараг байхгүй, гэхдээ “Компанийн тухай хууль”-ийн 18.2-т зааснаар шүүх компанийг хуваах, тусгаарлах шийдвэр гаргаж болно.

Патентын тухай хууль 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан. Уг хуулийн зорилго нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн өмчлөх эрхийг баталгаажуулах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглахтай холбогдсон харилцааг хамгаалах зохицуулахад оршдог. Энэ хуулиар хэн ч патент болон гэрчилгээ эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглах эрхгүй гэж заасан. Монгол улсад шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар,

ашигтай загварын асуудлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар хариуцан гүйцэтгэдэг бөгөөд бусад асуудлын зэрэгцээ патентын тухай хууль зөрчигдсөн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх, патенттай холбоотой өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх эрхтэй.

Патенттай холбоотой маргааныг шийдвэрлэх тусгай комиссыг “Оюуны өмчийн газар”-ын дэргэд байгуулсан. Уг байгууллага гомдлыг хүлээн авснаас хойш 6 сарын дотор хянан шийдвэрлэж, хариуг бичгээр мэдэгдэх үүрэг хүлээдэг. Харин маргаанд оролцогч талууд комиссын шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхийн журмаар шийдвэрлүүлж болно. Патентын тухай хууль тогтоомж, зохиогч болон патентын эзэмшигчийн эрхийг зөрчигчдөд эрүүгийн, иргэний хийгээд захиргааны журмаар хариуцлага ноогдуулж болдог. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны хариуцлага хүлээлгэдэг бөгөөд шүүгч буюу улсын байцаагч нь иргэнд цалингийн доод хэмжээг хоёроос зургаа дахин, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гэм буруутай этгээдийг 7-14 хоногоор баривчлах, зөрчилтэй бараа бүтээгдэхүүн, эд зүйлсийг хураан авч, хууль бусаар олсон орлогыг улсын орлого болгон, тухайн барааг устгах, үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч болно. Патент эзэмшигчийн эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх асуудлыг Монгол улсын иргэний хуулийн дагуу шийдвэрлэж болдог.

2003 оны 12 дугаар сарын 23-ний өдөр батлагдсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хууль бараа бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг

зохицуулдаг. Аливаа нээлттэй зах зээлийн нийгэмд шударга өрсөлдөөнийг хангах нь үйлдвэрлэгч, нийлүүлэгч, борлуулагч, худалдан авагчийн зэрэгцээ хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэнэ.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нь нэг ёсондоо үндэсний аюулгүй байдал, хүн амын сайн сайхан, эрүүл орчинд амьдрахын нэг баталгаа болдог. Монополь эрхээ хууль бус хийгээд урвуулан ашиглах нь эцсийн дүндээ хэрэглэгчдэд сөрөг үр нөлөөтэй. Жишээ нь, Кока-Кола компанийн барааны тэмдгийн эзэмшигчийн зөвшөөрөлгүй, тэдний технологи, жорын дагуу ундаа үйлдвэрлэхгүйгээр Кока-Кола шошгын дагуу нийтэд борлуулж байгаа нөхцөлд хэрэглэгч ноцтой төөрөгдөлд орж, өөрийн төсөөлж байсан ундааг хэрэглэж чадахгүй, материаллаг хийгээд сэтгэл зүйн хохирол амсах болно. Энэ нөхцөлд бид шударга өрсөлдөөний хуулийг зөрчсөн, тухайлбал, барааны тэмдэг, шошгыг хууль бусаар ашигласан, худалдан авагчийг хууран мэхэлсэн, хэрэглэгчийг хохироосон зэрэг хууль бус үйлдлийг харж болно.

Хэрэглэгчид өөрсдийн аюулгүй байдал, чанар, стандартад нийцсэн бараа, үйлчилгээг худалдан авах, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар үнэн зөв мэдээллийг олж авах эрхтэй төдийгүй барааны доголдол, барааны талаар хуурмаг мэдээлэл авсан бол хохирлоо гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрхийг эдэлдэг. Монгол улсын зарим хуульд ч шударга өрсөлдөөнтэй холбоотой заалтууд агуулагдсан байдаг. Жишээлбэл, 2005 оны “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 1-7 дахь хэсэгт: “... газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд шударга өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай”

хуулийн 14.1.5-д заасны дагуу холбогдох байгууллага болон төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх, энэ талаар санал гаргах бүрэн эрхтэй” гэж заасан байна.

Монгол улсын өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтын үнэлгээ

Бусад орны хууль тогтоомжтой харьцуулахад Монгол улсын шударга өрсөлдөөний тухай хууль шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх үйл ажиллагааг ерөнхийд нь хуульчилсан. Бусад хуульд ч шударга өрсөлдөөнийг хэрэгжүүлэх талаар бодлогын шинжтэй заалтууд орсон. Италийн хуулиар зөвхөн картелийн үйл ажиллагаа, давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, монополийн үйл ажиллагааг зохицуулсан байхад Монгол улсын шударга бус өрсөлдөөний хуулиар эдгээр үйл ажиллагаа төдийгүй бусад шатны өрсөлдөөний талаар ч зохицуулалт хийгдсэн байдаг. Монголын хуулинд аж ахуйн үйл ажиллагаанд оролцож буй бүх субъект бусад өрсөлдөгчийг хүндэтгэх, тэдний талаар буруу ташаа, мэдээлэл тараахыг хориглоно гэж заасан байна. Мөн *давамгайл байдалтай аж ахуйн нэгж* болон *монополийг* тодорхойлох шалгуурыг заасан байхад Европын Холбооны улсуудад үүнийг заагаагүй байна.

Гэвч дутагдалтай талууд бас ажиглагдсан. Тухайлбал, манай улсын хуулиар давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулаад бусад аж ахуйн нэгж картелийн үйл ажиллагаа явуулахыг хориглох талаар зохицуулаагүй байна. Шударга бус өрсөлдөөний эсрэг байгууллага нэгдэн нийлэх үйл ажиллагаанд хяналт тавина гэсэн боловч яг ямар үйл ажиллагааг нэгдэн нийлэх гэх, яг ямар нөхцөлд энэхүү нэгдэн нийлэх нь шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх вэ гэдгийг тодорхой зааж өгөөгүй. Түүнчлэн зүй

ёсны монополийн үйл ажиллагаанд хяналт тавихдаа зөвхөн үнэ болон нийлүүлэлтийн өөрчлөлтөд анхаарснаас бус хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад анхаараагүй байна.

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллага татварын байгууллагатай адил байгууллагын баримт бичгийг шалгах, шаардлагатай нөхцөлд бизнесийн үйл ажиллагааг зогсоох эрхийг эдэлдэг учир тэдний хараат бус, санхүүгийн бие даасан байдал гэх зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Өнөөгийн байдлаар манай шударга бус өрсөлдөөний хянан зохицуулах газар шударга бус өрсөлдөөн явуулж байна гээд байгууллагыг шалгах, дүгнэлт гаргахад эсэргүүцэлтэй тулгарч байна.

Манай улсад шударга өрсөлдөөний хуулийг зөрчсөний төлөө эрүүгийн хариуцлага ногдуулахгүй, харин захиргааны хариуцлага ногдуулдаг. Монгол улсын иргэний хууль, эрүүгийн хууль, захиргааны хариуцлагын тухай хууль болон шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн дагуу хариуцлага ногдуулна. Монгол улсын эрүүгийн хуулийн 168 дугаар зүйлд зааснаар: “...барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашигласнаас бусад их хэмжээний хохирол учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зурган сар хүртэл хугацаагаар баривчлах, эсвэл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял ногдуулна” гэж заажээ. Захиргааны хариуцлага хүлээлгэхдээ үйл ажиллагааг зогсоож, торгууль ногдуулдаг. Торгуулийн хамгийн дээд хэмжээ 250 000 төгрөг байна. Гэвч их хэмжээний бизнесийн эргэлтийн хөрөнгөтэй байгууллагын хувьд энэ торгуулийн хэмжээ маш бага учраас хуулийг хэрэгжүүлэх сайн, үр дүнтэй арга болж чадахгүй байна.

Монгол улсын өнөөгийн шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль зарим шүүмжлэлүүдтэй тулгарч байгаа хэдий ч хуулийн үр дүн гарахад багагүй хугацаа шаардагддаг гэж эрх зүйн өндөр хөгжилтэй орны мэргэжилтнүүд үздэг. Өнөөдөр хууль батлагдаад маргааш нь шууд хэрэгжинэ гэж үзэж болохгүй. Ялангуяа эдийн засгийн харилцааг зохицуулж буй хуулийг хэрэгжүүлэхэд хугацаа их шаардагддаг. Мөн тухайн хуулийг хэрэгжүүлэхэд бусад хуультай нийцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай.

Өнөөдөр дэлхийн маш олон улсад шударга өрсөлдөөний хуулийн ач холбогдлыг дээдэлж, түүнийг эдийн засгийн өсөлт хөгжилтэй холбож, энэхүү хуулийг

хэрэгжүүлэх байгууллагыг ч хүндэтгэх төлөв харагдах боллоо. Иймээс Шударга өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлэх, Шударга бус өрсөлдөөний хянан зохицуулах байгууллагын үр нөлөөг нэмэгдүүлэх Монголчууд бидэнд амьдралаа дээшлүүлэх, эдийн засгаа хөгжүүлэх гээд олон талаасаа ач холбогдолтой гэдгийг өнөөдөр нэгэнт хүлээн зөвшөөрөх цаг болжээ.

Хэдийгээр “Шударга бус өрсөлдөөний хянан зохицуулах газар”-ын ач холбогдлын талаар харилцан адилгүй байр суурь байдаг ч олон аж ахуйн нэгжид шалгалт хийж, үйл ажиллагаанд нь дүгнэлт өгч, улмаар шударга өрсөлдөөний нөхцлийг Монгол улсад хангахад тууштайгаар тэмцэж байгааг дараах жишээнээс харж болно.

Жишээ 1.

Харилцан тохиролцож үнэ тогтоосон талаар:

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар нь 2006 оны 9 сард Монгол улсын зах зээлд автобензин, дизелийн түлш нийлүүлдэг хэд хэдэн аж ахуйн нэгж харилцан үнэ тогтоож, үнийг өсгөсөн талаарх мэдээллийг шалгаж байсан. Харин тухайн аж ахуйн нэгжүүд үүнийг үгүйсгэж байсан. Харилцан үнэ тогтоохыг “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хуулийн 7.1.1-ээр хориглосон байдаг. Аж ахуйн нэгжүүд харилцан үнийг тогтоосон гэдгийг практикт тодорхойлоход хэцүү байдаг учир зарим улсад энэ талаар тусгай журам баталсан байдаг.

Жишээ 2.

Хэрэглэгчдийн эрх ашгийг хохироосон талаар:

Мобиком компаниас хэрэглэгчдэдээ хандан үнийн багц үйлчилгээний санал гаргасныг хэрэглэгчдийн эрх ашгийг хохироосон хууль бус үйлдэл хэмээн шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар дүгнэлт гаргаж, хууль бус үйл ажиллагаагаа зогсоох шаардлага тавьж байсан.

Жишээ 3.

Бодит бус мэдээлэл тарааж, шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлсөн талаар:

“Тод тамга” УҮГ зах зээлд дангаар ноёрхохыг эрмэлзэн “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хуулийг зөрчиж, өрсөлдөгчийнхөө нэр хүндийг гутаах, борлуулалтыг хаах зэргээр тамга, тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий бусад аж ахуйн нэгжүүдийн эрхэнд халдаж байгааг таслан зогсоох тухай хүсэлт ирсний дагуу ШБӨХЗГ шалгалт хийжээ.

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 10.1.1-ийн “...өрсөлдөгчийн болон түүний бараа бүтээгдэхүүний нэр хүндийг гутаах, эсвэл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах”, 10.1.2-ын “...өөрийн болон өрсөлдөгчийн үйлдвэрийн газар, түүний байршил, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шинж чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсвэл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх” заалтуудыг зөрчсөн нь тогтоогдсон тул 150 000 төгрөгийн торгууль ногдуулж, зөрчлийг арилгуулсан.

БҮЛЭГ 3.

Салбаруудын өрсөлдөөний судалгаа

3.1 СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Өрсөлдөөнийг дэмжихийн тулд хувийн сектор төдийгүй нийгмийн секторт бодит тоо мэдээлэл, өгөгдөл зайлшгүй хэрэгцээтэй болж байна. 2005 онд “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар”-ыг байгуулснаар Монгол улсын зах зээлийн өрсөлдөөний байдлыг нийлмэл, цогц байдлаар судлах үйл ажиллагаа эхэлсэн гэж үзэж болно. Өмнө нь хувийн секторт үйл ажиллагаа явуулж буй компаниуд зах зээлийн эрэлтийн судалгаа, хэрэглэгч ба өрсөлдөгчдийн үйл хөдлөлийн судалгааг хийж, бодлого болон стратегиа тодорхойлдог байсан.

Монгол улсын зах зээлийн талаарх тоо, баримтын олдоц хангалтгүй, өрсөлдөөнийг тооцох арга, аргачлал төдийлөн хөгжөөгүй, өндөр хөгжилтэй орнуудын аргачлал, туршлагыг шууд хэрэглэх боломжгүй⁴⁴ байгаа өнөөгийн нөхцөлд тоон болон чанарын аргыг хослуулан хүн амын амьжиргаа, нийт эдийн

засагт голлох нөлөө бүхий⁴⁵ салбаруудыг сонгон өрсөлдөөний байдлыг тодорхойлж, цаашдын төлөв байдлыг харуулахыг зорилоо.

Судалгаагаар зах зээлийн өрсөлдөөний онцлог байдлыг гаргах үүднээс:

- зах зээл дээр *монополь* эрх мэдэл бүхий *цахилгаан, дулааны салбар*;
- төгс бус өрсөлдөөнтэй салбарууд болох *газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүн, үүрэн холбоо, мах, махан бүтээгдэхүүн, ноолуур, нийтийн тээврийн салбар*;
- төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээг худалдан авч байгаа процесс, *тендэрийн үйл ажиллагаа*;
- төрийн зохицуулалтаар лиценз, зөвшөөрөл олгогддог уул уурхай, газрын зах зээл гэсэн салбаруудыг сонголоо.

Салбарын онцлогоос гадна түүвэр судалгаанд цахилгаан, дулаан, мах, ноолуур, газрын тос, нийтийн тээврийн салбарыг сонгосон нь:

- Монголын эдийн засгийн өсөлтөд эдгээр салбаруудын эзлэх хувийн

⁴⁴ Компаниудын үндсэн мэдээлэл, тэр дотроос үндсэн хөрөнгийн мэдээлэл, хүчин зүйлсийн тоо хэмжээ ба үнийн тухай мэдээлэл гэх зэрэгт тулгуурлан бүтцийн бус аргаар зах зээлийн өрсөлдөөнийг хэмжиж, хэрэглэгчийн сайн сайхан байдалд нөлөөлөх нөлөөллийг тооцох боломж байгаа боловч тооны олдоцоос шалтгаалан энэ аргуудыг хэрэглэх боломж одоогийн байдлаар бүрэлдээгүй байна.

⁴⁵ 2006 оны байдлаар Монгол улсын ДНБ-д *цахилгаан, дулааны үйлдвэрлэл 2.5%, тээвэр холбоо 10.9%, хөдөө аж ахуй 18.8%* тус тус эзэлж, хэрэглэгчид өрхийн зарлагынхаа 30.4%-ийг хүнсний бараанд зарцуулж байна.

жин тийм их биш боловч хүмүүсийн амьжиргаанд үзүүлэх нөлөө ихтэй.

- Өргөн хэрэглээний бусад барааны зах зээлийг бодвол бараа, бүтээгдэхүүний үнэ зохиомлоор хэт өндөр байх, аль эсвэл нийгмийн эрх ашиг нэрийн дор хэт доогуур байх, үгсэн хуйвалдах нөхцөл байдал ажиглагдах болсон. Инфляци 2005 онд 12,7% байснаа 2006 онд 5,1% болж буурсан хэдий ч эдгээр салбаруудын үнийн түвшний өсөлт буураагүй, жишээлбэл, махны үнэ байнга өссөөр байгаа. Нөгөө талаар эдгээр салбарт олигополь зах зээлийн шинж хадгалагдсаар байгаа ба зах зээлд нэвтрэх боломж, барааны үнийн ялгаварлал, хэрэглэгчдийн сонголтын боломж, хэрэглэгчдийн сайн сайхан байдал гэх мэт зах зээлийн өрсөлдөөний үндсэн шинж чанар илрэхгүй байгаа.
- Эдгээр зах зээл “өөрийн онцлогтой” далд сүлжээ, хуйвалдаантай, гадаад зах зээлээс хамааралтай, дотооддоо албан ба албан бус зохицуулалтын дарамт ихтэй, зарим компани давамгай байдалтай байгаа зэрэг нь шударга худалдааны таатай орчинг бүрдүүлэхгүй байгаа ба энэ нөхцөл байдлыг харуулсан албан ёсны тоо баримт байхгүй.
- Эдгээр зах зээлийн өнөөгийн дүр төрхийг зах зээлийн өрсөлдөөний зохицуулалт, төвлөрөл болон хэрэглээний тэгш бус байдал зэрэг олон талаас нь судлах боломжтой.

Мөн судалгаанд сүүлийн үед ихээхэн анхаарал татах болсон уул уурхай болон газрын зах зээл, тендэрийн хуулийн хэрэгжилтийг тусгайлан судаллаа.

3.2. МОНОПОЛЬ САЛБАР ДАХЬ ӨРСӨЛДӨӨН: ЦАХИЛГААН, ДУЛААН

Цахилгаан, дулаан үйлдвэрлэл нь манай улсын хувьд төдийгүй аль ч улс орны хувьд суурь дэд бүтцийн хамгийн чухал салбар юм. 2006 онд тус салбар ДНБ-д 5.6% эзэлж, 3544 сая квт цахилгаан эрчим хүч, 7850.4 мянган Гкал дулаан үйлдвэрлэжээ. Тус салбарын үнэ, үйлдвэрлэл, ДНБ болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд эзлэх хувь Хүснэгт 3.1 байдалтай байна.

Манай улсад “Эрчим хүчний зохицуулах газар”-аас өгсөн тусгай зөвшөөрлийн дагуу цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг давхардсан тоогоор 60 аж ахуйн нэгж, байгууллага эрхлэн явуулж байна /Хүснэгт 3.2/.

Цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагууд нь цахилгаан дамжуулах сүлжээнээс цахилгаан эрчим хүч худалдан авч хэрэглэгчдэд түгээдэг. Цахилгаан, дулаан үйлдвэрлэлийн хувьд хэрэглэгчийн зүгээс цахилгаан, дулааны төвлөрсөн хэрэглээг харилцан орлох боломжтой бүтээгдэхүүн байхгүй, харин нийлүүлэгчийн зүгээс цахилгаан дамжуулах, түгээх төвлөрсөн үйл ажиллагааг өөр нэг үйл ажиллагаагаар орлуулах боломжгүй. Цахилгаан дамжуулах сүлжээ нь цахилгаан түгээх компаниудын хувьд монополь нийлүүлэгч, цахилгаан түгээх сүлжээ нь хэрэглэгчдийн хувьд зүй ёсны монополь нийлүүлэгч болж байна.

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газраас 18 аж ахуйн нэгжийг үйлчлэх хүрээний нутаг дэвсгэртээ зүй ёсны монополь, 2 аж ахуйн нэгжийг давамгай байдалтай болохыг тодорхойлж, зарласан. Зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуйн нэгжүүд нь зах зээл

Хүснэгт 3.1. Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, 2003-2006

	2003	2004	2005	2006
Цахилгаан эрчим хүч (сая.квт.цаг)	313.7	3,303.4	3,418.9	3,544.2
Дулаан эрчим хүч (мян.гкал)	7,133.3	7,746.6	7,805.6	7,850.4
Цахилгаан дулаан үйлдвэрлэл, оны үнээр (сая.төг)	141,187.7	141,141.2	167,619.5	176,515.6
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд эзлэх хувь (%)	16.0	11.1	11.4	8.1
ДНБ-д эзлэх хувь (%)	9.5	7.3	6.6	5.6
Цахилгаан дулаан үйлдвэрлэл, 2000 оны зэрэгцүүлэх үнээр (сая.төг)	98,372.7	102,642.2	107,719.1	110,326.8
Өсөлтийн хувь	-	4,3	4,9	2,4

Эх үүсвэр: УСГ, 2006

Хүснэгт 3.2. Цахилгаан эрчим хүчний салбарын аж ахуйн нэгжүүд

Олгосон тусгай зөвшөөрлүүд	Аж ахуйн нэгжийн тоо
Цахилгаан үйлдвэрлэх	7
Цахилгаан дамжуулах	2
Цахилгаан түгээх	16
Дулаан үйлдвэрлэх	10
Дулаан түгээх	25

Эх үүсвэр: Шударга бус өрсөлдөөнийг хянан зорицуулах газар, 2006

дээр монополь, эсвэл давамгайл болсноороо шударга өрсөлдөөнд харшилж байгаа хэрэг биш юм. Гагцхүү эдгээр аж ахуй нэгжийн үйл ажиллагаа нь өрсөлдөөнд харш, хэрэглэгчдийн эрх ашгийг хохирооход чиглэгдэж болохгүй.

Цахилгаан эрчим хүчний салбар дахь зарим аж ахуйн нэгж давамгайл болон зүй ёсны монополь байдлаа ашиглан хэрэглэгчдийг төлбөрөө төлөөгүй гэсэн шалтгаанаар эрчим хүчээр хязгаарлахад төлбөрөө төлсөн хэрэглэгчид хохирч байгаа сөрөг нөлөө гарч байгааг түүвэр судалгаанд хамрагдсан өрхүүд тэмдэглэлээ. Түүнчлэн цахилгааны хүч, хүчдэл, давтамж тогтворгүй; дулааны нийлүүлэлт цаг уурын орчноос эсрэг

байдаг зэрэг нь хэрэглэгчдийн эрх ашгийг ноцтой зөрчиж байна.

Цахилгаан дамжуулах, түгээх үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт ихээр шаарддаг, үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт хэрэглэгчид хязгаарлагдмал учир шинээр аж ахуйн нэгж орох боломжгүй, зөвхөн хэрэглэгчид шинээр гарч ирж буй тохиолдолд л цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл авах боломжтой зэрэг нь цахилгаан эрчим хүчний зах зээлд шинэ өрсөлдөгч бий болоход хүндрэл болдог.

Хэдийгээр цахилгаан, дулаан нийлүүлэгч компаниуд гэрээний зөрчлүүд гаргаж, хэрэглэгчдийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээж чадахгүй байх зэрэг хүндрэлүүд

гаргадаг ч өөр нийлүүлэгч байхгүй тул тухайн компанийн хэрэглэгч болохоос өөр аргагүйд хүрдэг. Түүвэр судалгаанд хамрагдсан өрхүүдийн 36% цахилгаан, дулаан нийлүүлэгч компани хэрэглэгчийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээж чадахгүй байна, 19% нь гэрээгээ биелүүлж чадахгүй байна гэжээ.

Цахилгаан дулаантай холбоотой хүндрэл бэрхшээлүүд аймгийн төвтэй харьцуулахад Улаанбаатар хотод элбэг тохиолддог. Тухайлбал, цахилгаан тасалддаг (57%), халуун, хүйтэн ус тасалддаг (18%), хүйтэн эсвэл халуун ус тасалддаг (20%, 14%), дулаан тасалддаг (14%) зэрэг бэрхшээлийг нэрлэж болно.

Цахилгаан эрчим хүчний салбарт шаардлагатай зохицуулалтын талаар тодруулахад хэрэглэгч өрхүүдийн 20% цахилгаан, дулааны үнийг нэмэхгүй байх, 15% сайн тоолуур, бойлерууртай болох, тус бүр 10% үйлчилгээг сайжруулах, цахилгааны шугам шинэчлэх, цахилгаан дулааны өөр эх үүсвэртэй болох, 4-7% цахилгаан дулаан тасалддаггүй болгох, бүх сумдыг цахилгаантай болгох, хариуцлагыг өндөржүүлэх хэрэгтэй гэсэн саналыг өглөө.

Цахилгаан дамжуулах, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний онцлог, шат дамжлага, байгууллага хоорондын уялдаа гэх зэргээс хамааран өрсөлдөөн нэвтрүүлж болох зарим хэсэгт зохицуулалт хийх зорилгоор төрийн өмчит хувьцаат компани болон орон нутгийн өмчит компани хэлбэрээр зохион байгуулсан нь үр өгөөжтэй болж, судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хувь 2001 оноос хойш зарим асуудлаа бие даан шийдэх боломжтой болжээ.

Төрийн ба орон нутгийн өмчит компаниудын ихэнх нь зургаа болон түүнээс дээш жилийн хугацаанд тухайн зах зээл

дээрээ оршин тогтнож байгаа болохоор үйл ажиллагаа нь тогтворжсон хэдий ч ойрын нөхөн орлуулагч байхгүй, зах зээлийн хүрээ хязгаарлагдмал, зах зээл рүү орох, зах зээлээс гарах үйл явц боломжгүй, үйл ажиллагааны шат дамжлагын зохицуулалт ихтэй байна. Өөрсдийн үйл ажиллагааны зах зээл дээр давамгайл байдалтай аж ахуйн нэгжүүд бөгөөд давамгайл байдал нь үйл ажиллагаанаас олох орлогод нөлөөлж чаддаггүй. Цахилгаан, дулааныг үйлдвэрлэх газруудыг бодвол түгээх, дамжуулах газрууд илүү давамгайл байдалтай байдаг. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу түүхий эд, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бэлтгэн нийлүүлэх байгууллагуудаа тендэр зарлан тодорхойлохын зэрэгцээ үйлдвэрлэх бүтээгдэхүүний зах зээлийн үнийг харъяа яам, зохицуулах агентлагууд тогтоодог.

Түүхий эд материалын том нийлүүлэгчдийн тоо цөөн, дийлэнхдээ ганц хоёр том нийлүүлэгчтэй байна. Ерөнхийдөө үйл ажиллагааны зах зээл нь том учраас компани гэж ярихаас илүү салбарыг төлөөлж, бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээгээрээ зах зээлийг бүхэлд нь эзэлдэг. Өрсөлдөөнгүйгээр зохицуулалт хэрэгжиж байна. Өрсөлдөөнгүй байгаа гол шалтгаан нь өндөр зардалтай, орлуулалт байхгүй, зах зээлийн хүрээ хязгаарлагдмал, үйлдвэрлэгчдийн тоо цөөн байгаа явдал юм.

Цахилгаан, дулаан дамжуулах, түгээх компаниуд нь төрийн өмчит үйлдвэрийн газар учраас өмчлөлийн 39%-ийг Төрийн өмчийн хороо, 41%-ийг Түлш, эрчим хүчний яам, 20%-ийг Санхүү, эдийн засгийн яам зохицуулж байна. Үйл ажиллагааг ТӨХ, ЭХЗГ, Диспетчерийн үндэсний алба, судалгаа хөгжлийн төв хянаж, “Эрчим хүчний тухай” хууль, “Эрчим хүчний харилцааны дүрэм”,

“Эрчим хүчний зохицуулах газрын дүрэм”-ээр зохицуулдаг. Зах зээлийн хүрээ хязгаар, бүтээгдэхүүний хэмжээ, зах зээлийн үнэ, нэгжийн дундаж зардал, салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг зэргийг зохицуулах газраас шийддэг.

Салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчдийн гомдол, санал их гардаг. Шийдвэрлэж болох хэмжээгээр асуудалд хандаж байгаа хэдий ч бодлогоор дамжуулан нөлөөлөх зүйлүүд бас гардаг. Энэ салбарт бизнес сэтгэлгээг төлөвшүүлэх явдал шаардлагатай байна. Салбарын гол бэрхшээл нь тоног төхөөрөмжийн моралийн элэгдэл юм. Ахиц, дэвшилттэй зүйлүүдэд хэрэглэгчдэд үйлчилдэг байгууллага гэдгээ ойлгосон тул сүлжээтэй, стандарттай, сахилга баттай байгууллага, хамт олон гэсэн сэтгэлгээ төлөвшиж байгаа, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн төслүүд хэрэгжиж, нэгдсэн сүлжээнд холбогдсон, засвар үйлчилгээгээ өөрсдөө хийх болсон, компанийн хэлбэрт шилжсэн гэх мэт нөхцөл байдлыг дурьдаж болно.

Монополь зах зээлд үйл ажиллагаа явуулж буй эдгээр үйлдвэрлэгчдийн ихэнх нь зах зээлийн өрсөлдөөний байдал эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн өөрчлөлттэй уялдаж чадахгүй байна гэж үзлээ. Шалтгааныг тодруулбал: эрх мэдэлтний шийдвэр, хээл хахууль, танил тал, далд сүлжээ, хэлэлцээр, түүнчлэн нефтийн салбараас хараат болохоор өрсөлдөөн бий болох боломжгүй, салбарт мастер төлөвлөгөө хэрэгжихгүй байгаа болохоор бодлого алдагдаж байгаа болон хэрэглэгчдийн хувьд төвлөрсөн хэрэглээ байхгүй, станцуудын хүчин чадал өөр өөр учраас үнэ, өртөг, тариф харилцан адилгүй байдаг, дотоодын мэргэжилтнүүдийн цалин доогуур байдаг тул идэвхжүүлэлт байхгүй гэсэн.

3.3. ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Монгол улсад газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нефть, шатах, тослох материалыг бөөнөөр болон жижиглэнгээр борлуулах, түлш эрчим хүчний үндсэн хэрэгцээг хангасаар ирсэн нефтийн салбар 1925 онд байгуулагджээ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед улсын өмчийн цорын ганц нефть хангамжийн НИК концерни байсан бол өнөөдөр зах зээлийн өрсөлдөөн, хэрэгцээг даган хөгжиж буй манай улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа салбарын нэг болсон.

Газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн гүйцэтгэж буй үндсэн үүргүүдэд нефтийн бүтээгдэхүүний импорт, Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан бөөний болон жижиглэнгийн борлуулалт, нефтийн агуулах болон үйлчилгээний станцууд, тос, тосолгооны материалын импорт, борлуулалт, шатах, тослох материалын түгээлт, хуваарилалт зэргийг нэрлэж болох юм.

Манай улс газрын тосны хэрэгцээгээ 100% импортоор хангадаг бөгөөд ОХУ (81%), Казакстан (12%), Хятад (7%) гэсэн хөрш орнуудаас импортолж байна. ОХУ-ын импортыг ЮКОС компани дангаараа 100% хангадаг /Хүснэгт 3.3/.

Манай улс 2005 оны байдлаар 563,6 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон бол 2006 онд 580 мянган тонн болж өссөн. Нийт газрын тосны бүтээгдэхүүний импортын 30% А-80, 15% АИ-92 автобензин, 48% дизель, 3% онгоцны түлш, үлдсэн 4% нь бусад төрлийн түлш байна.

Өнөөдрийн байдлаар Монгол улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүнийг хилийн 9 боомтоор импортолж, 98 агуулах,

Хүснэгт 3.3. Монгол улсын хэмжээнд импортлосон газрын тосны бүтээгдэхүүн, 2005

Бэлтгэн нийлүүлэгч	90-ээс доош октантай		90-ээс дээш октантай		Дизель түлш		Тос, тосолгооны материал, бусад		Нийт дүн	
	Тоо/ тн/	эзлэх хувь	Тоо/ тн/	эзлэх хувь	Тоо/ тн/	эзлэх хувь	Тоо/ тн/	эзлэх хувь	Тоо/ тн/	эзлэх хувь
ОХУ	119,068.2	70.7	74,512.6	88.9	231,756.5	85.8	30,875.1	74.7	456,212.4	80.9
Казакстан	24,342.0	14.5	9,280.6	11.1	29,993.4	11.1	2,778.6	6.7	66,394.7	11.8
БНСУ							2,843.6	6.9	2,843.6	0.5
БНХАУ	25,006.6	14.8			8,283.0	3.1	3,128.5	7.6	36,418.2	6.5
Япон	25.3	0.0					237.9	0.6	263.2	0.0
Узбекстан							1,089.7	2.6	1,089.7	0.2
Канад							37.5	0.1	37.5	0.01
Австрали							98.9	0.2	98.9	0.02
АНУ							217.2	0.5	217.2	0.04
Бусад							17.9	0.1	17.9	0.003
Нийт дүн	168,442.1	100.0	83,793.2	100.0	270,032.9	100.0	41,324.9	100.0	563,593.2	100.0

Эх сурвалж: Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар, 2006

1100 орчим ШТС /эдгээрээс 140 гаруй нь УБ хотод/ -аар дамжуулан хэрэглэгчдэд хүргэж байна. Энэ зах зээл дээр 20 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас жижиглэнгийн шатахууны хэрэгцээг үндсэн 6 компани болох НИК-Петровис (34%), Магнай Трейд (17%), Шунхлай (7%), Алтжин (5%), Сод Монгол (4%), Жаст (4%) хангаж байна. Газрын тосны бүтээгдэхүүний зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгжүүд аймаг, орон нутагт салбар нэгжүүдээрээ дамжуулан борлуулалт хийдэг нэгдсэн сүлжээтэй. Улсын хэмжээнд 2005 оны байдлаар нийт 1074 шатахуун түгээх станц /ШТС/ байгаагаас 141 нь Улаанбаатар хотод, 933 нь хөдөө орон нутагт байна. Улсын хэмжээнд нийт 98 нефть бүтээгдэхүүний агуулах байгаагаас Улаанбаатарт 25, хөдөө орон нутагт 73 байна /Хүснэгт 3.4/.

АМГТХЭГ-аас 2003 онд улсын хэмжээний шатахуун түгээх станц, нефтийн агуулахын

байдалд хийсэн судалгаанаас харахад улсын хэмжээний нийт агуулахын багтаамжийн 54,5% НИК-Петровис компаниудын агуулахад ноогдож байна. 2006 онд “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар” НИК-Петровис компаниуд хамтран зах зээлд давамгайл байдалтай байна гэж дүгнэжээ.⁴⁶

Манай улсын газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ жилээс жилд нэмэгдэж /2002 онд бензин, дизель түлш хэрэглэгч автомашин 103805 ширхэг, 2004 онд 120418 ширхэг, 2005 онд 131184 ширхэг, 2006 онд 140872 ширхэг⁴⁷/ байгаа нь зах зээлд шинээр аж ахуйн нэгж орж ирэх зах зээлийн багтаамж байна гэдгийг харуулж байна. Аж ахуйн нэгжийн түүвэр судалгаанд хамрагдсан компаниуд уг зах зээл дээр

⁴⁶ Газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн нэгжийг тогтоох талаар хийсэн судалгаа, түүний үр дүн, ШБӨХЗГ

⁴⁷ Гаалийн газрын статистик мэдээлэл, 2006

өрсөлдөөн бий болж байгааг тэмдэглэсэн. Тухайн салбарын үйл ажиллагааны зах зээлийг нийт судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 77% нь өрсөлдөөнтэй салбар гээд үнээр (79-82 %) өрсөлдөх явдал хамгийн түгээмэл байдаг гэжээ. Уг зах зээлд шинээр компани нэвтрэн ороход шинэ агуулах, шатахуун түгээх станцуудыг барьж байгуулах хөрөнгө санхүү болон дүрэм, журам зохицуулалтын асуудлууд хамгийн түгээмэл тохиолддог байна.

Энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд зах зээлийн өрсөлдөөнд үйлчилгээгээрээ ялгарах, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, үнийн бодлогоор өрсөлддөг ч тухайн зах зээл дээр шударга бусаар өрсөлдөх явдал гардаг. Энэ нь үнийн хуйвалдаан, эрх мэдэлтний шийдвэрээр илэрдэг. Зах зээлийн өрсөлдөөнд үнэ хамгийн чухал учраас газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэд нэгжийн дундаж зардал, өрсөлдөгчийн үнэ тогтоолт,

Хүснэгт 3.4. Монгол улсын хэмжээнд импортлосон газрын тосны бүтээгдэхүүн, 2005 /компаниар/

ГТБ импортлогч компанийн нэрс	90-ээс доош октантай		90-ээс дээш октантай		Дизель түлш		Тос, тосолгооны материал, бусад		Нийт дүн	
	Тоо/тн/	хувь	Тоо/тн/	хувь	Тоо/тн/	хувь	Тоо/тн/	хувь	Тоо/тн/	хувь
Петровис	15,957.02	9.5	31,099.03	37.1	46,772.80	17.3	1,943.83	4.7	95,768.68	17.0
НИК	47,531.96	28.2	6,660.89	7.9	38,514.59	14.3	2,104.22	5.1	94,811.66	16.8
Магнай трейд	37,328.09	22.2	13,647.50	16.3	28,093.45	10.4	1,239.09	3.0	80,308.13	14.2
УБТЗ ХЭГНХ	494.67	0.3		0.0	75,174.00	27.8	1,945.08	4.7	77,613.75	13.8
Шунхлай групп	8,933.27	5.3	6,999.40	8.4	11,398.89	4.2	14,413.07	34.9	41,762.63	7.4
Алтжин	8,450.47	5.0	8,491.91	10.1	8,844.02	3.3	0.00	0.0	25,786.40	4.6
Жаст	9,075.83	5.4	1,454.13	1.7	8,897.98	3.3	2,675.66	6.5	22,103.60	3.9
Сод Монгол	6,552.11	3.9	6,248.63	7.5	7,259.06	2.7	119.91	0.3	20,179.71	3.6
Юмтрейд	2,408.89	1.4	5,474.06	6.5	6,154.57	2.3	95.23	0.2	14,132.75	2.5
Тас Петролеум	3,182.32	1.9		0.0	3,993.75	1.5	0.00	0.0	7,176.07	1.3
Ойн бирж	2,395.68	1.4	1,894.79	2.3	2,606.31	1.0	0.00	0.0	6,896.78	1.2
Востокнефттегаз	0.00	0.0		0.0	6,031.72	2.2	59.82	0.1	6,091.54	1.1
Хөрс автосервис	5,141.94	3.1		0.0	78.44	0.0	200.59	0.5	5,420.97	1.0
УБҮ Эрдэнэт		0.0		0.0	4,273.72	1.6	870.65	2.1	5,144.37	0.9
Вектор интернэйшнл		0.0		0.0	3,314.90	1.2	1,483.47	3.6	4,798.37	0.9
А-жет Лимитэд		0.0		0.0		0.0	3,956.17	9.6	3,956.17	0.7
Жамп	669.04	0.4	236.19	0.3	2,619.64	1.0	0.00	0.0	3,524.87	0.6
Мон-Рад	1,858.43	1.1	22.53	0.0	631.37	0.2	18.39	0.1	2,530.72	0.4
Энтүм	2,140.44	1.3		0.0	286.46	0.1	0.00	0.0	2,426.90	0.4
Монголросцветмет	0.00	0.0		0.0	1,685.11	0.6	584.45	1.4	2,269.56	0.4
Бусад	4,330.43	2.6	1,564.13	1.9	13,402.18	5.0	9'601.31	23.2	40,889.59	7.3
Нийт дүн	168,442.1	100	83,793.19	100	270,032.9	100	41,324.9	100	563,593.2	100

Эх сурвалж: Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар, 2006

татвар их нөлөөлдөг. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь өрсөлдөгч компани бүтээгдэхүүнийхээ нэгжийн үнийг бууруулбал үнээ дагаж бууруулна гэжээ /Зураг 3.1/.


ҮСГ-ийн мэдээнээс гардаг А-76 бензиний үнийн өсөлтийг дээрх зургаар харууллаа. Бензиний үнэ тасралтгүй нэмэгдсээр байгаа ба 1 литр А-76 бензиний үнийг 1996 онд 144 төгрөг байсантай харьцуулбал 2000 онд 350 болж 2.4 дахин, 2006 онд 778 төгрөг болж, 5.4 дахин нэмэгдсэн байна. 2007 оны 1 сард 890 төг, 2-р сард 880 төг, 3-р сард 870 төг, 4-5 сард 850 төг, 6-7 сард 908 төг болж өссөн бөгөөд өнөөгийн байдлаар А92-ын үнэ 1140 төгрөг болсон /Зураг 3.2/.

Судалгааны явцад анхаарал татсан нэг асуудал бол газрын тос импортлогч аж ахуйн нэгжүүдийн бусад компанитай тохиролцоо хийж байгаа явдал байлаа. Тэд үнийн тохиролцоог илүү ихээр хийдэг. Зах зээл дээр борлуулж буй үнэ бараг ижил байгаа нь эдгээр компаниуд үнийн хуйвалдааныг хийж байгааг харуулах нэг үзүүлэлт бөгөөд үнийг хэлцэн тогтоодог явдал гардаг гэж аж ахуйн нэгжүүд тэмдэглэсэн.

Аж ахуйн нэгжүүд сүүлийн таван жилд тухайн зах зээл дээр гарсан томоохон өөрчлөлтийг өрсөлдөөн нэмэгдсэн явдал гэж үзэн өрсөлдөөний нэг үр дагавар болох үнэ буурах бус, эсрэгээрээ энэ салбарт үнэ нэмэгдсэн гэжээ. Энэ зах зээлд тодорхой хэмжээний өрсөлдөөн байна гэж хэлж болохоор байгаа боловч НИК-Петровис компаниуд хамтдаа давамгайл байдалтай үйл ажиллагаа явуулж, үнийг энэ хоёр компани тусдаа, эсвэл бусад компанитай хэлцэн тогтоодог байх магадлалтай.


Газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэгч компаниудыг нийт хэрэглэгчдийн 43% өрсөлдөөнтэй, үлдсэн 57% өрсөлдөөнгүй гэж үзэж, уг салбарыг өрсөлдөөнтэй гэж үзсэн хариулагчдын 34% өрсөлдөөн нэмэгдсэнээр ямар нэгэн эерэг үр дагавар гараагүй гэжээ. Гэхдээ үйлчилгээ сайжирч байна (32%), сонголтын хүрээ нэмэгдэж байна (30%), нэмэлт урамшуулал бий болж байна (15%), чанар сайжирч байна (8%) гэх зэрэг эерэг үр дагаврууд гарч байгааг тэмдэглэжээ. Хэрэглэгчид түлш шатахуун худалдан авахдаа үнэ (50%), үйлчилгээ (28%), байршил (23%), чанарыг (22%) харгалзан

Зураг 3.1. А-76 шатахууны үнэ болон ХҮИ-ийн түвшин, 1996-2006



Эх үүсвэр: ҮСГ, 2006

Зураг 3.2. А-76 шатахууны үнэ болон хэрэглээний сагсны үнийн өсөлтийн хувь, 1996-2006



Эх үүсвэр: УСГ, 2006

үздэг бөгөөд хэрэглэгч өрхүүдийн 79% түлшний үнэ өндөр байна гэжээ.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 53% АИ-92 түлш хэрэглэж байна. АИ-92-ийн хэрэглээ Улаанбаатар хотод аймгийн төвөөс өндөр байгаа бол аймгийн төвд А-80, А-76 түлшний хэрэглээ Улаанбаатар хотынхоос өндөр байна.

Хэрэглэгчид энэ зах зээлийг сайжруулахын тулд төрөөс зохицуулалт хийх (25%), үнийг тогтвортой болгох (18%), монголд газрын тосны үйлдвэртэй болох (13%), чанартай шатахуун нийлүүлэх (13%), үйлчилгээг сайжруулах (10%), өрсөлдөөнийг нэмэгдүүлэх (9%) шаардлагатай байна гэжээ.

Тус салбарын бүтээгдэхүүн нэгэн төрлийн (гомоген) барааны тоонд ордог болохоор зарчмын хувьд чанар ижил байгаа тохиолдолд хэрэглэгчид аль хямдхан барааг сонгодог зах зээл юм. Манайд нефть боловсруулах үйлдвэрүүд байдаггүй болохоор тус салбарт өрсөлдөөнийг хязгаарлах босоо тэнхлэгийн хэлцлүүд үүсэх боломж хязгаарлалттай боловч хэвтээ тэнхлэгийн картель төрлийн шударга

өрсөлдөөнийг хязгаарласан хэлцлүүд үүсэх магадлалтай⁴⁸ байна.

3.4 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Мах махан бүтээгдэхүүний зах зээл нь хөдөөгийн хүн ам, ялангуяа малчдын орлогыг бүрдүүлдэг, монгол хүний хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалдаг зах зээл юм. 1990 оноос өмнө буюу Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байхад мах, махан бүтээгдэхүүний худалдааг бүгд төрийн өмчит аж ахуйнууд эрхэлж байсан.

1992 онд “Хөдөө аж ахуйн бирж” байгуулж, улсын бүх хотууд, аймагт салбараа нээн сумдуудад агентуудаа томилон ажиллуулж, хөдөөгийн хүн амд хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, малчдаас малын түүхий эд, махыг дотоодын үйлдвэрлэгчдэд нийлүүлэх зорилготой байсан. Гэсэн хэдий ч энэхүү бирж үндсэндээ

48 Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газраас 2006 оны 9 сард Монгол улсын зах зээлд автобензин, дизелийн түлш нийлүүлдэг хэд хэдэн аж ахуйн нэгж харилцан үнэ тогтоож, үнийг өсгөсөн талаар мэдээллийг шалгасан.

өмнө нь ажиллаж байсан бөөний худалдаа, малын түүхий эд бэлтгэлийн бүтцийг дахин байгуулах оролдлого байснаас бус, жинхэнэ утгаараа ажиллах, түүхий эдийн бөөний худалдаачдад арилжааны үйлчилгээ үзүүлдэг бирж биш байсан. Тиймээс ч бирж 1996 онд татан буугдсан.

Монгол улс уламжлалт мал аж ахуйн орон учраас малын гаралтай түүхий эдээр баян юм. Монгол улсад жилд дунджаар 6 орчим сая мал нядалдаг ба 90 орчим хувь нь бог мал, үлдсэн 10 орчим хувь нь бод мал байна /Хүснэгт 3.5/.

Мах үйлдвэрлэлтийн хэмжээ 1990 онд 249 мянган тонн, 2000 онд 311 мянган тонн байсан бол 2006 онд 171 мянган тонн болж буурсан байна. Экспортлосон махны хэмжээ сүүлийн гурван жилд мөн буурч, 7-10 орчим мянган тонн болжээ /Хүснэгт 3.6/.

Өнөөгийн байдлаар мах, махан бүтээгдэхүүний худалдааны хувьд бараг

зохицуулалтгүй гэж хэлж болохоор байна. Мал сүргээр баян Монгол улс мах, махан бүтээгдэхүүний худалдааг хэрхэн явуулж байгааг сонирхон авч үзвэл “ченжүүд” малчдын хотоор очиж, эсвэл сум, аймгийн төв, хот суурин газар байрлан түүхий эдийг багаар худалдан авч бөөгнүүлэн цааш нь томоохон бөөний худалдаачдад борлуулдаг. Эдгээр жижиглэнгийн худалдаачид худалдан авсан мах, махан бүтээгдэхүүнээ чанарын үзүүлэлт, төрлөөр нь ангилж нөөцөлж байгаад хот, суурин газар байрлах бөөний худалдаачдад худалддаг. Ийнхүү малын түүхий эд бэлтгэл, худалдаа нь жижиг аж ахуйн нэгжүүд, хувь хүмүүсээр дамжин худалдааны төвүүд (зах), ялангуяа жижиглэнгийн худалдааны супермаркетуудаар явагдаж байна.

Түүвэр судалгаанд хамрагдсан өрхүүдийн ихэнх буюу 79% мах, махан бүтээгдэхүүний хэрэглээгээ захаас, 15% хүнсний дэлгүүрүүдээс, 14% өөрийн аж ахуйгаас, 10% сүлжээ дэлгүүрээс хангадаг, үлдсэн

Хүснэгт 3.5. Хүсэнд хэрэглэсэн малын тоо, малын төрлөөр, мян.тол, 1990-2006

Төрөл	1990	1995	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Бүгд	7630,4	6567,3	8743,9	8119,3	6763,4	6076,1	5 034,5	6 404,9	6 284,0	5 898,0
Тэмээ	47,5	31,6	31,9	47,1	45,4	31,8	20,7	33,3	33,4	29,3
Адуу	205,3	163,5	350,7	477,9	327,9	314,2	193,6	317,6	324,5	277,9
Үхэр	525,7	523,9	809,4	886,2	549,6	502,5	388,7	454,2	389,2	367,8
Хонь	5301,3	4627,1	4397	4306,2	3916,5	3739,6	3 104,4	3 204,3	2 918,2	2 896,1
Ямаа	1550,6	1221,2	3154	2401,5	1924,0	1488,0	1 327,1	2 395,5	2 618,8	2 326,9

Эх үүсвэр: УСГ, 2000, 2006

Хүснэгт 3.6. Мах үйлдвэрлэлт, экспортлосон мах, мян.тн, 1990-2006

Төрөл	1990	1995	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Мах үйлдвэрлэлт	248,9	211,7	289,0	310,6	226,4	204,4	147,9	195,2	183,9	170,7
Экспортлосон мах	24,3	2,2	15,0	16,7	16,0	23,3	15,1	8,4	7,8	11,7

Эх үүсвэр: УСГ, 2000, 2006

3.5% тогтсон газар байхгүй гэж хариулжээ. Энэ хариулт аймгийн төв, Улаанбаатар хотод нилээд ялгаатай: аймгийн төвийн өрхүүдийн дийлэнх буюу 90% захаас; Улаанбаатар хотын өрхүүдийн хувьд сонголт арай өөр буюу 64 % захаас; 27% хүнсний дэлгүүрүүдээс; 22% сүлжээ дэлгүүрүүдээс мах, махан бүтээгдэхүүний хэрэглээгээ хангадаг байна. Аймгийн төвийн өрхүүдийн өөрийн аж ахуйгаас махны хэрэгцээгээ хангадаг гэж хариулсан хувь Улаанбаатар хотын өрхүүдийнхээс өндөр байлаа.

Мах, махан бүтээгдэхүүний зах зээлийн нийлүүлэлт, борлуулалтаас гадна махны нөөцийн газрууд, мах, махан бүтээгдэхүүний боловсруулалт, үйлдвэрлэлийг авч үзэх хэрэгтэй. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 2005 оны байдлаас харахад

Дорноговь аймгийн “Дорнын Говь” компани адууны мах, үхрийн мах, хонины махны үйлдвэрлэл явуулж, нийт зах зээлийн 29%, мах болон хиамны үйлдвэрлэл явуулж буй Дарханы мах экспо, Улаанбаатарын Махимпекс компани зах зээлийн 13%, Орхон аймгийн “Эрдэнэт экспо” 7%, Улаанбаатарын “Хатан сүйх” компани 5%-ийг тус тус эзэлж байна /Хүснэгт 3.7/.

Хүснэгтээс харахад түүвэр судалгааг явуулсан Улаанбаатар хот, Дархан, Орхон аймгуудад махны үйлдвэрлэлийн дийлэнх хэсэг ажиллаж байгаа ба эдгээр аж ахуйн нэгжүүдээс авсан судалгааны үр дүнг товч танилцуулъя.

Судалгаанд хамрагдсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүд уг салбарыг дунд зэргийн өрсөлдөөнтэй салбар

Хүснэгт 3.7. Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2005 он

Аж ахуйн нэгжийн нэр	Үхрийн мах	Гахайн мах	Хонины мах	ямааны мах	Адууны мах	Дайвар бүтээгдэхүүн	Өлөн гэдэс	Хиамны зүйл	Махан консерв	Нийт дүн	Зах зээлд эзлэх хувь
Дорнын говь	295.0		16.0		1375.6					1686.6	29.0
Дархан мах экспо	522.9				220.6			11.8		755.3	13.0
Махимпекс	148.0		150.0	36.0	6.0	60.0		374.1		774.1	13.3
Эрдэнэт	27.5	2.4			20.1			53.2		103.2	1.8
Мах боловсруулах үйлдвэр	55.2		65.8		2.2	24.6				147.8	2.5
Хатан сүйх импэкс	0.5							83.1	178.9	262.5	4.5
Хатан сүйх Трейд								23.2		23.2	0.4
Ет транзит	240.0									240.0	4.1
Эрдэнэт прогресс	276.8		78.8	43.5	31.0					430.1	7.4
Ханбүргэд							137.7			137.7	2.4
Мон-Өлэкс							234.9			234.9	4.0
Цаст трейд								166.5		166.5	2.9
Бусад	5.8						239.7	582.5	21.9	849.9	14.6
Бүгд	1571.7	2.4	310.6	79.5	1655.5	84.6	612.3	1294.4	200.8	5811.8	100.0

гэж үзэж байна. Энэ салбарын зах зээл дээр сүүлийн таван жилд мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн тоо нэмэгдсэн, үнийн өөрчлөлт, хэрэглээ нэмэгдсэн өөрчлөлтүүд гарч, үнэ, борлуулалтын хэмжээ, чанараар өрсөлдөөн илрэх нь хамгийн нийтлэг байна. Мах, махан бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэн ороход хөрөнгө санхүү, үнийн өсөлт хамгийн гол бэрхшээл болдог.

Энэ зах зээл дээрх үйлдвэрлэгчид зах зээлийн өрсөлдөөнд бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, үйлчилгээгээрээ ялгарах, үнийн бодлогоор өрсөлдөж байгаа ч стандартын бус бүтээгдэхүүн, үйлчилгээгээр шударга бус өрсөлдөөн илэрдэг.


Мах, махан бүтээгдэхүүний зах зээлийн үнэд нэгжийн дундаж зардал, өрсөлдөгчийн үнэ тогтоолт, нефть, шатахууны үнэ болон бусад барааны үнэ голлон нөлөөлдөг. Мөн үнийн харилцан тохиролцоо энэ зах зээл дээр явагддаг. Хэрэглэгчдийн зүгээс борлуулж буй мах, махан бүтээгдэхүүний чанартай холбоотой

гомдол санал хамгийн их ирдэг. Махны үнийн өсөлт хэрэглэгч өрхүүдэд илүү мэдрэгдэж байна. Тэд мах, махан бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр, чанарын шаардлага ч хангаж чадахгүй байна гэжээ.

Сүүлийн таван жилд уг зах зээл дээр өөрчлөлт бараг гараагүй боловч үнэ байнга өссөөр байна. Мах, махан бүтээгдэхүүний үнийн динамикийг авч үзье. 1991 онд 1 кг нь 15 төгрөг байсан хонины мах 1993 онд 37 төгрөг, 1993 онд 165 төгрөг гэх мэтчилэн тасралтгүй огцом нэмэгдсээр 2000 он гэхэд 1135 төгрөг, 2005 онд 2124 төгрөг, 2006 онд 2273 төгрөг болсон байна /Зураг 3.3/.


Сүүлийн хоёр жил махны үнийг барихын тулд Засгийн газар тусгай арга хэмжээ авч байсан нь тухайн салбарт хэвийн өрсөлдөөн явагдахгүй байгаагийн нэг шалтгаан болсон гэж үзэж болно. Монгол улс харьцангуй бага зардлаар бэлчээрийн аргаар маш их хэмжээний махыг үйлдвэрлэдэг боловч махны дотоодын үнэ нь Шинэ Зеланд, Австрали зэрэг

Зураг 3.3. Махны үнэ болон ХҮИ, хүнсний барааны үнийн түвшин, 1991-2006



Эх үүсвэр: YCG, 2006

Зураг 3.4. Мах болон ХҮИ, хүнсний барааны өсөлтийн хувь, 1996-2006



Эх үүсвэр: УСГ, 2006

улсуудын үнэд дөхөж очиж байгаа нь эрүүл бус үзэгдэл гэж хэлж болно /Зураг 3.4/.

Мах махан бүтээгдэхүүний үнээс гадна чанарын шаардлага хангаж байгаа эсэх нь чухал юм. Судалгаанд хамрагдсан хэрэглэгч өрхүүдийн талаас илүү буюу 52% зах зээл дээр борлуулж буй мах, махан бүтээгдэхүүн чанарын шаардлага хангаж чадахгүй байна гэж хариулжээ. Тэдний 57% мах, махан бүтээгдэхүүний чанарын шаардлага хангахгүй тохиолдлыг хааяа, 12% байнга гардаг гэсэн бол үлдсэн 32% тийм тохиолдол гардаггүй гэжээ. Худалдан авсан мах, махан бүтээгдэхүүн чанарын шаардлага хангахгүй байгаад нөлөөлж буй гол шалтгаануудад борлуулагчдын зүй бус худалдаа (46%), сонголт хийх боломж муу (35%), махны чанарыг ялгахад хэцүү (35%), махыг төрөлжүүлж, ялгаварлал хийж зардаггүй (30%), ариун цэврийн шаардлага хангадаггүй, бохир орчин (21%) зэргийг нэрлэсэн байна /Зураг 3.5/.

Хэрэглэгчдийн мах, махан бүтээгдэхүүнийг худалдан авахдаа харгалзан үздэг сонголтнуудыг сонирхоход дийлэнх буюу 84% чанар, 39% үнэ, 20% орчин, 10% үйлчилгээг

харгалздаг гэсэн бол мах, махан бүтээгдэхүүн худалдан авахад гардаг хүндрэлүүдэд үнэ өндөр (81%), чанар муу (29%), сонголт муу (27%), үйлчилгээ муу (19%) гэсэн хариултууд зонхилж байна.

Мах, махан бүтээгдэхүүн борлуулагчид хэрэглэгчийнхээ өмнө хариуцлага хүлээж чадаж байна уу? гэсэн асуултанд хэрэглэгч өрхүүдийн 68% чадахгүй байна гэж хариулсан ба тэдний 58% өөр сонголт байхгүй, 28% өөр нийлүүлэгчийн талаар мэдээлэл байхгүй тул тухайн борлуулагчийн хэрэглэгч байхаас өөр сонголт байхгүй гэжээ. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 95% монголд махны үнэ бага байх боломж бий гэж үзэж байна.

Мах, махан бүтээгдэхүүний зах зээлийг сайжруулах талаарх саналыг тодруулахад хэрэглэгч өрхийн 70% махны үнийг өсгөхгүй тогтмол байлгах, 36% чанартай мах борлуулах, 27% үйлчилгээг сайжруулах, 14% ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах, 11% хяналтыг сайжруулах шаардлагатай гэж хариулсан нь хамгийн өндөр хувьтай хариултууд байлаа.

Монголчуудын хувьд мах, махан бүтээгдэхүүн бол энгийн нэг бараа, сольж орлуулах бололцоотой бүтээгдэхүүн биш, гол хүнсний бараа мөн гэдгийг санах хэрэгтэй. Орлого багатай, буурай хөгжилтэй манай улсад махны үнийг зайлшгүй төрийн хяналтад байлган, үнэ нь өсч байгаа байдлыг нэмж судалж, махны чанарын хяналтыг сайтар хэрэгжүүлэн, зах зээлийн хөгжилд саад болж байгаа хүчин зүйлсийг илрүүлэн тогтоож, тухайн салбарын өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих шаардлагатай болжээ.

3.5 НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛ


Ноолуур манай улсын стратегийн ач холбогдолтой барааны нэг юм. Монгол улс дэлхийн ноолуурын зах зээлд 20 орчим хувийг эзэлдэг бөгөөд тус салбарын зохицуулалт, удирдлага манай улсын гадаад худалдаа, хөнгөн аж үйлдвэрийн хөгжилд ихээхэн нөлөөтэй.

Одоогоос хорь, гучин жилийн өмнө ноолууран бүтээгдэхүүн чинээлэг хүмүүсийн тансаг хэрэглээ байсан бол

20-р зууны төгсгөлөөс дэлхийн ихэнх оронд ноолуур тансаг хэрэглээнээс гарч, өргөн хэрэглээний бараа болон хувирч байна. Дэлхийн ноолууран бүтээгдэхүүний хамгийн том зах зээл нь АНУ-ын зах зээл, дараа нь Япон, Европын орнуудын зах зээл ордог байна. Дээрх орнуудын ноолуурын эрэлт, хэрэгцээнээс хамааран самнасан ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ хэлбэлздэг.

Монгол улс ноолуурын дэлхийн зах зээлд өөрийн бүтээгдэхүүнийг гаргахын тулд Хятад, Иран, Австрали, Балба, Афганистан болон бусад орнуудтай өрсөлдөж байна. Зах зээл дээрх ноолуурын үнэ нь Хятадын үйлдвэрлэгчдийн нөлөөгөөр хэлбэлзэх хандлагатай байдаг боловч Монгол улс дэлхийн зах зээл дээр бэлтгэн нийлүүлэлт болон боловсруулсан ноолуурын хувьд нөлөө үзүүлэхүйц том үйлдвэрлэгч гэдэг нь тоо баримтаас харагддаг. Хятад, Монгол хоёр улс ноолуурын нөөцөөр баялаг орны тоонд улс зүй ёсоор ордог бөгөөд Монгол улс дангаараа дэлхийн ноолуурын үйлдвэрлэлийн 22 хувийг эзэлдэг. Монгол ноолуур нь атрия ихтэй, урт ширхэгтэй хийгээд гялалзсан өнгө

Зураг 3.5. Маж, махан бүтээгдэхүүн чанарын шаардлага хангаж чадахгүй байгаа шалтгаан



Эх үүсвэр: Аж ахуйн нэгжийн түүвэр судалгааны үр дүн

чанараараа Хятадын ноолуураас хэд хэдэн давуу талтай тул сайн чанарын ээрмэл утас, бөс даавуу үйлдвэрлэх боломжтой байдаг.

Ноолуурын экспорт манай улсын эдийн засаг, үйлдвэрлэл, малчдын амьдралд чухал байр суурийг эзэлдэг бөгөөд сүүлийн жилүүдэд ноолуурын үнэ өсч, малчдад ихээхэн ашигтай болсонтой уялдан ямаан сүргийн тоо жил бүр өсөх хандлагатай байна. Монгол улсын ямаан сүргийн тоо 2005 онд 2000 оноос 1,3 дахин өссөнөөр 13,3 сая толгой болж, ноолуур

үйлдвэрлэлт 1,1 дахин нэмэгдэж, 3450 орчим тонн болжээ /Хүснэгт 3.8/.

Экспортын бохир ноолуурын хэмжээ 1996 онд 431.4 тн, 1999 онд 799.5 тн, 2000 онд 717.2 тн байснаа 2001 онд 32 тн, 2004 онд 47 тн болж буураад эргээд өссөн байна. 2006 онд 1675.7 тн бохир ноолуур экспортлосон. Самнасан ноолуурын хэмжээ 1996 оноос 2005 оны хооронд 720-1200 тн орчимд хэлбэлзэж, 2006 онд өсөн 1427,5 тн болжээ. /Хүснэгт 3.9/

Хүснэгт 3.8 Ямаан сүргийн тоо ба бэлтгэсэн ноолуур, 1999-2005

	1999	2000	2001	2002	2003	2004	2005
Ямаан сүргийн тоо /сая/	11034	10231	9585	9056	10653	12215	13267
Бэлтгэсэн ноолуур тн/	3318	3090	2824	2856	2722	3153	3450

Эх үүсвэр: УСГ, 2005

Хүснэгт 3.9. Ноолууран бүтээгдэхүүний экспорт, 1996-2006

Ноолууран бүтээгдэхүүн	1996	1999	2000	2001	2002	2004	2005	2006
Бохир ноолуур								
Хэмжээ (тн)	431.4	799.5	717.2	32.0	79.0	47.4	381.3	1 675.7
Сая ам. доллар	9.3	14.4	21.9	0.6	1.0	0.7	13.4	63.1
Самнасан ноолуур								
Хэмжээ (тн)	720.9	1168	770.2	998.9	622.1	831.7	919.2	1427,5
Сая ам. доллар	51.8	45.9	54.5	54.9	30.1	44.1	52.8	81.7
Ноолууран топс								
Хэмжээ (тн)	28.3	41.5	7.1	24.3	15.4	12.7	13.9	13.0
Сая ам. доллар	2.2	2.2	0.6	2.0	0.9	1.0	1.1	1.0
Ноолуурын бүтээгдэхүүн								
Хэмжээ (тн)	215.8	314.5	428.5	364.7	438.4	1506.6	477.1	-
Сая ам. доллар	7.8	7.8	13.0	13.2	11.7	33.4	17.6	-
Ноолуурын нийт экспорт (сая ам. доллар)	71.2	70.3	90.1	70.7	43.8	79.2	84.9	-
Нийт экспорт (сая ам. доллар)	423.4	454.2	535.8	523.8	524.0	853.3	1064.9	1 542.8
Ноолуурын экспортын эзлэх хувь	16.8	15.5	16.8	13.5	8.3	9.3	8.0	-

Эх сурвалж: УСГ, 2000, 2006

Ноос ноолуурын зах зээлд Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ноос, ноолуурын чанарыг сайжруулах, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2000 оны 144, 2001 оны 26-р тогтоолоор “Ноолуур” хөтөлбөр, “Ноос” дэд хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байна. Ноос, ноолуур боловсруулах зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн зах зээлд эзлэх хувийг нийт борлуулалтад тухайн аж ахуйн нэгжийн эзлэх хувийн жингээр тооцож, “Шударга бүс өрсөлдөөнийг хориглох тухай” хуулийн 5.1-д заасны дагуу 2005 оны нийт борлуулалтад эзлэж буй хувь хэмжээг харгалзан ноос, ноолуур боловсруулах зах зээлд “Говь” ХК-ийг давамгайл⁴⁹ байдалтай аж ахуйн нэгж гэж үзэв.

Монголын ноолуурын боловсруулалт, гадаад худалдаанд тэргүүлэгч Говь хувьцаат компанийн хувьд гадаад, дотоод зах зээл дээр байр суурь нь нилээд бэхэжсэн буюу АНУ, Европ, Азийн зах зээлд сүүлийн 15-20 жилд хамтран ажиллаж байна. 2005 оны байдлаар 19,328 сая төгрөгийн борлуулалт хийсний дотор 13,795 сая төгрөгийн бүтээгдэхүүн экспортлож, 5,533 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг дотооддоо борлуулжээ. Говь хувьцаат компани бүтээгдэхүүнийхээ ихэнхийг экспортлодог.

Монгол улсын ноолууран бүтээгдэхүүний зах зээл дээр Говь хувьцаат компаниас гадна Буян, Монгол Амикал, Эвсэг компаниуд гадаадын хөрөнгө оруулалттайгаар туршилт, судалгааны ажлын үр дүнд зах зээлд өрсөлдөхүйц шинэ брэндүүдийг гаргаад байна.

Тус салбарт нэвтрэн орох, шинээр үйл ажиллагаа явуулах нь харьцангуй нээлттэй

байна. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулж, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд Төрийн зүгээс тус зах зээлд нэвтрэн ороход ямар нэгэн хязгаарлалт байхгүй. 1990 оны эхээр Монгол улсад ноолуурын улсын хоёр үйлдвэр (одоогийн Говь, Буян ХХК) байсан боловч зах зээлд шилжиж эхэлснээс хойш ноос, ноолуур боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг аж ауйн нэгжийн тоо эрчимтэй өссөн. Одоогийн байдлаар хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 36 үйлдвэр байгаа бөгөөд ноолуур боловсруулах талаар ямар нэг гэрээ хэлцэл байхгүй, бүх боловсруулагүй ноолуурын 80 хувийг ноолуурын ченжүүд айл өрхөөс шууд худалдан авч байна.

Хятад улс сүүлийн зургаан жилийн туршид боловсруулаагүй ноолуур экспортлохыг хориглосон бодлого явуулсны үр дүнд экспортын 70 орчим хувь нь бэлэн хувцас байхад Монгол улсынх 28% нь бэлэн хувцас, үлдсэн 72% нь түүхий болон самнасан ноолуур байна. Энэ нь Монгол улс 1996 онд ноолуурын экспортын хоригийг цуцалж, худалдааг чөлөөтэй болгосноор түүхий ноолуур экспортлох сонирхол нэмэгдэж, дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг бууруулахад хүргэсэн.

Сүүлийн жилүүдэд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хувьд дотоодын үйлдвэрлэлд бэлтгэж буй түүхий эдийн хэмжээ нэмэгдэж, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт нэмэгдэж байна. Түүхий эдээ шууд экспортлохын оронд түүнийгээ боловсруулан бэлэн бүтээгдэхүүн хийж, нэмэгдсэн өртгийг бий болгох нь ижил хэмжээний түүхий эдийг зах зээлд илүү үнээр борлуулах боломжийг олгоно. Хятад улс дотоодоос бэлтгэсэн

⁴⁹ Зах зээлийн төвлөрлийг зах зээлийн шинжилгээ судалгаанд хамгийн өргөн хэрэглэгддэг Херфиндал-Хершманы индекс (ХХИ)-ээр тодорхойлов
 $ХХИ_{2004 он} = 1550,3$; $ХХИ_{2005 он} = 1743,8$;
 ХХИ-ийн тооцоог үндэслэн 2004-2005 оны байдлаар ноос, ноолуур боловсруулах зах зээлийг дунд зэргийн төвлөрөлтэй, өрсөлдөөн хэвийн гэж үзэх үндэслэлтэй байна.

ноолуураа боловсруулахын зэрэгцээ жилд 3000 гаруй тонн ноолуурыг Монгол, Турк, Иран, Казакстанаас импортоор авдаг.

Ноолуурын үнийг бид өөрсдөө бус, урьд хөрш л тогтоож байна. Ихэнхдээ ченжийн гараар дамжиж, Эрээн хотод байгаа хэдэн компаниуд зохицуулдаг гэхэд хилсдэхээргүй байна. Хэрэв бид ноолуураа Эрээн хот руу гаргаад байвал ноолуурын үнэ өсөж, манайд ашигтай байх нь юу л бол. Бас нэг асуудал нь Хятад руу гаргаж буй ноолуурын тал хувь нь татваргүй гардаг гэсэн тооцоо ч хийсэн байна. Ядаж ноолуурын бүх экспортоос татвар хурааж чадвал Хятад руу гаргах ноолуурын хэмжээ буурах магадлалтай.

Ноолуурын үйлдвэрлэлийг Монголд эрхлэхэд түүхий эд гэж хамгийн том асуудал гараад байна. Бид малчидтайгаа тохирчихсон байж байтал ченжүүд ирээд үнийн өсгөөд аваад явчихдаг...


*Эрдэнэт хот,
Ноолуурын үйлдвэрийн эзэн*

2005 оны байдлаар манай улсад 6878 тн ноос, ноолуур угаах, 3888 тн ноос, ноолуур самнах хүчин чадал суурилагдаад байгаа нь үйлдвэрлэлийн хүчин чадал түүхий эдийн нөөцөөс 1,9-2,6 дахин их болохыг харуулж байна. Иймд үйлдвэрлэлийн хүчин чадал, технологийг сайжруулах, ноос, ноолуурын боловсруулалтыг боловсронгуй болгох, ноос, ноолууран бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлж, загварыг сайжруулан бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар аж ахуйн нэгжүүд зах зээлд өрсөлдөх боломж нээлттэй гэж үзэж байна /Хүснэгт 3.10/.

Түүвэр судалгаанд хамрагдсан ноолуурын үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүд ноолуурын зээлийг дунд зэргийн өрсөлдөөнтэй салбар гэж тодорхойлж байна.

Сүүлийн таван жилд ноолуурын зах зээл дээр өрсөлдөгчид/нийлүүлэгчдийн тоо нэмэгдэж, үнийн өөрчлөлт, техник, технологи нэвтэрч байгаа өөрчлөлтүүд гарчээ. Энэ зах зээл дээрх өрсөлдөөн зах зээлийн

Зураг 3.6. Ноолуурын үнийн динамик, 2000-2006



Эх үүсвэр: УСГ, 2006

Хүснэгт 3.10. Ноос, ноолуур угаах, самнах үйлдвэрлэлийн хүчин чадал, тн, 2000, 2005

Он	Үйлдвэрлэлийн төрөл	Түүхий эдийн нөөц /тн/	Суурилагдсан хүч чадал /тн/	Түүхий эдийн нөөц, хүч чадлын харьцаа
2000	Угаах	3200	5720	1.8 дахин их
	Самнах	2587	3321	1.3 дахин их
2005	Угаах	2675	6878	2.6 дахин их
	Самнах	2006	3888	1.9 дахин их

хүрээ, үнэ, борлуулалт, үйлдвэрлэлийн хүчин чадлаар илэрдэг бөгөөд технологийн шинэчлэл, мэргэжилтэн, ажилтныг урвуулах, бүтээмжийн өсөлт, үнийн бууралт зэрэг нь өрсөлдөгчөөс хүлээж болох хамгийн гол эрсдэл болдог.

Ноолуурын зах зээл дээр бүтээгдэхүүний чанар хамгийн чухал баримталдаг стратеги бөгөөд бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, нийлүүлэгчид/хэрэглэгчдээ татах стратеги мөн чухал байна. Энэ зах зээл дээр шударга бусаар өрсөлдөх явдал гардаг бөгөөд зах зээлийн өрсөлдөөн түүхий эдийн зах зээлийн үнийн хуйвалдаанаар илэрнэ. Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай ноолууран бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөөнийг сайжруулахын тулд юуны түрүүнд түүхий ноолуурын бэлтгэлийн системийг сайжруулах, хилээр гаргаж буй ноолуурт хяналт тавих, түүхий ноолуурын экспортыг бууруулах, хил гаалиар нууцаар гаргах явдлыг зогсоох хэрэгтэй байна. Учир нь түүхий, хагас боловсруулсан бүтээгдэхүүний үнэ эцсийн бүтээгдэхүүний үнээс доогуур байдаг, нөгөө талаас, ноолууран бүтээгдэхүүн нь тансаг хэрэглээнээс өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд шилжиж байгаа зүй тогтол ажиглагдаж байна. Цаашдаа ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай. Түүнчлэн компаниуд барааны чанар, өөрийн

ноолууран бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх нэр хүндэд анхаарах хэрэгтэй байна.

3.6. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Өргөн удам нутагтай, далайд гарцгүй манай улсын хувьд тээвэр асар чухал салбар мөн. Манай орны тээвэр нь авто, төмөр зам, агаар, усан замын тээвэр гэсэн дөрвөн үндсэн төрлөөс бүрдэж байна. Сүүлийн жилүүдэд тус салбар хөгжиж⁵⁰ байгаа хэдий ч 2007 онд төмөр зам өнөөгийн хөгжлийн хурдац, ачааллыг даахаа больж байгаа нь харагдаж ирсэн.

2006 онд Монгол улсад бүх төрлийн тээврээр 24.0 сая тн ачаа, давхардсан тоогоор 195.4 сая зорчигч тээвэрлэсэн нь 2005 оныхоос тээсэн ачаа 1.3 % буюу 300.9 мян. тн-оор, зорчигч тээвэрлэлт 1.4% буюу 2.6 сая хүнээр тус тус өссөн байна.

⁵⁰ Төмөр замаар тээсэн ачаа 2005 оныхоос 5.2% буюу 806.5 мян.тн-оор буурч, зорчигч тээвэрлэлт 2.3% буюу 95.7 мянган хүнээр өссөн байна. Дамжин өнгөрөх тээврийн хэмжээ 4.5 сая тн-д хүрч, 2005 оныхоос 17.2 хувь буюу 927.2 мян. тн-оор буурсан нь нийт тээсэн ачааны бууралтад нөлөөлжээ. Агаарын тээвэрт зорчигч тээвэрлэлт 2005 оныхоос 8.8 хувь буюу 29.5 мянган хүнээр, тээсэн ачаа 5.1 хувь буюу 101.9 тн-оор тус тус өсчээ. Агаарын тээврийн олон улсын зорчигч тээвэрлэлт 2005 оныхоос 14.0 хувь буюу 28.8 мянган хүн, дотоодын зорчигч тээвэрлэлт 0.6% буюу 0.7 мянган хүнээр тус тус өссөн байна. Авто тээврээр 2006 онд 9.2 сая тн ачаа, давхардсан тоогоор 190.7 сая тн зорчигч тээвэрлэсэн нь 2005 онтой харьцуулахад тээсэн ачаа 13.7% буюу 1.1 сая тн-оор, зорчигч тээвэрлэлт 1.3% буюу 2.5 сая хүнээр тус тус өсчээ. Авто техникийн үзлэг, тооллогын урьдчилсан дүнгээр 2006 онд 141.5 мянган авто машин тоологдсон нь 2005 оныхоос 7.8% буюу 10.3 мянгаар нэмэгджээ. Нийт авто машины 56.5% нь 10 хүртэлх жил, 43.5% нь 10-аас дээш жил ашиглагдсан байна. (ҮСГ, 2006 оны 12-р сарын мэдээ)

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж, хувийн өмч бий болж, түүн дээр суурилсан эдийн засгийн харилцаа бий болсноор авто тээврийн байгууллагууд хувьчлагдаж, өмчийн олон хэвшлийн аж ахуйн нэгжүүд үүсэн бий болсон. Хувийн тээврийн хэрэгсэл олширч, тээврийн үйлчилгээнд өргөн оролцох болсноор өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах харилцааг дахин зохицуулах шаардлага гарч, “Авто тээврийн” тухай хуулийг 1999 онд баталсан. Энэ хуулийн зорилго нь тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг зах зээлд адил тэгш эрхтэй, чөлөөтэй өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, тээвэрлэгч тээвэрлүүлэгчдийн хоорондын харилцаа, тэдний хүлээх үүрэг хариуцлага, тээврийн хэрэгслийн ашиглалтанд тавих хяналт, техникийн шаардлагыг баталгаажуулах байв. Энэ хууль батлагдан гарсан нь авто тээврийн салбарт зах зээлийн харилцааг төлөвшүүлэн хөгжүүлэх, хууль эрх зүйн орчин бүрдсэн.

Сүүлийн жилүүдэд хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдэж, Улаанбаатар хотын хүн ам эрс өссөн нь хотжилттой холбоотой олон чухал асуудлыг шийдвэрлэхэд хүргэж байна. Нийслэл хотын нийтийн зорчигч тээвэрт өмчийн харилцаа

шинэчлэгдэж, өнөөгийн байдлаар Автобус-1, Автобус-2, Автобус-3, Цахилгаан тээвэр хувьцаат компаниудаас бусад аж ахуйн нэгж хувийн хэвшил рүү шилжиж, авто тээврийн үйлчилгээ эрхэлдэг бизнесийн байгууллагын тоо хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг даган эрс нэмэгдэж байна. Нийслэлийн нийтийн тээврийн салбарт үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг “Нийслэлийн нийтийн тээврийг зохицуулах газар”-аас зохицуулж байна.

Улаанбаатар хотын нийтийн хэрэгцээний зорчигч тээврийн үйлчилгээнд 2005 оны байдлаар үндсэн шугамын 15, туслах шугамын 44, буухай үйлчилгээний 41, бүгд 100 орчим чиглэлд хотын болон хот орчмын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг тусгай зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр төрийн өмчийн 4 компани, хувийн хэвшлийн 81 аж ахуйн нэгж, байгууллага 2888 гаруй их багтаамжийн автобус, троллейбус, бага оврын автобусаар өдөр бүр тодорхой цагийн хуваариар гүйцэтгэж байна. Мөн Улаанбаатар хотод нийтийн таксины үйлчилгээний хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 2600 гаруй тээврийн хэрэгсэл ажиллаж байна / Хүснэгт 3.11/.

Хүснэгт 3.11. Улаанбаатар хотын нийтийн тээврийн салбар дахь аж ахуйн нэгж, тээврийн хэрэгслийн тоо, чиглэлээр, 2005

Үйлчилгээний төрөл, хэлбэр	Аж ахуйн нэгжийн тоо	Тээврийн хэрэгслийн тоо	Тайлбар
Автобусны үйлчилгээ			
Үндсэн чиглэл	15	668	Том оврын автобус
Туслах	44	1314	Бага оврын болон микроавтобус
Буухиа	41	906	Бага оврын болон микроавтобус
Таксины үйлчилгээ			
Такси	55	2616	Такси
Нийт	155	5504	

Эх үүсвэр: Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар, 2005

2006 оны эцсийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй 150-иад аж ахуйн нэгж Үндэсний статистикийн газарт бүртгэгдсэн байна. Энэ салбарт 3000 гаруй хүн ажил эрхэлж, 2006 онд 200 гаруй тэрбум төгрөгийн үйлчилгээ үзүүлжээ. Үндэсний статистикийн газрын ашигладаг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, нийтийн тээврийн үйлчилгээг тогтмол хуваарьтай /автобус/ үйлчилгээ болон тогтсон хуваарьгүй /такси/ үйлчилгээ гэж ангилдаг. Тогтмол хуваарьтай үйлчилгээ гэдэгт төмөр замын тээврээс бусад автобус, троллейбус зэргээр хот, дүүрэг, хот хооронд тогтсон цагаар хүн тээвэрлэх үйлчилгээ хамрагддаг бол тогтсон хуваарьгүй үйлчилгээнд такси, хувийн машинаар хүн тээвэрлэх үйлчилгээг авч үздэг байна. Эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн хувьд Хүснэгт 3.12 байдалтай байна.

Автобус, таксийг тусдаа зах зээл гэж үзэн өрсөлдөөний байдлыг Херфиндал-Хершманы индексээр тооцсон. Автобус буюу тогтсон хуваарьтай үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүдийн хувьд өрсөлдөөнгүй бөгөөд төвлөрлийн түвшин өндөр ажээ. Үйлчилгээ үзүүлж буй дөрвөн том аж ахуйн нэгж зах зээлийн нийт борлуулалтын 80 гаруй хувийг эзэлдэг нь үүний давхар баталгаа юм. Гэхдээ энэ зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй

аж ахуйн нэгжүүдийн тоо харьцангуй олон байгаа нь монопольт өрсөлдөөний зах зээлийн шинжтэй байна. Учир нь энэ зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь өөр өөрийн шугам, чиглэлтэй учраас бусад чиглэлийн дагуу үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгжүүдтэй өрсөлдөхгүй. Тиймээс зах зээлийн тодорхой хэсэг дээр монополь эрх мэдэлтэй байна /Хүснэгт 3.13/.

Таксины үйлчилгээний хувьд автобустай харьцуулахад илүү өрсөлдөөнтэй зах зээлийг бүрдүүлэх бөгөөд Херфиндал-Хершманы индекс 0.15 гэж гарсан. Энэ нь албан ёсны бүртгэлтэй аж ахуйн нэгжийн хооронд дунд зэргийн өрсөлдөөнтэй гэсэн үг. Гэхдээ энэ зах зээлийн чухал өрсөлдөгч бол албан ёсны статистикт бүртгэлгүй боловч хувийн машинаар такси үйлчилгээ үзүүлдэг хувь хүмүүс байна.

Нэгэн үе хуучин машиныг Солонгосоос голдуу оруулж ирэн такси үйлчилгээнд гарган түрээслэх бизнес ашигтай байсан билээ. Энэ хэрээр нийслэл хотод такси гэсэн жижиг машин хөлхөж, сүүлдээ 5-10 машинтай такси компаниуд ч олширсон. Харин сүүлийн үед такси илт цөөрсөн нь мэдрэгдэж, такси үйлчилгээ явуулдаг байсан компаниуд дампуурах нь дампуурч, гадагш гарах нь гарсан тухай мэдээлэл цацагдах болсон. Ийнхүү такси үйлчилгээ ховордсон нь хэд

Хүснэгт 3.12. Нийтийн тээврийн салбарын эдийн засгийн үзүүлэлт

Үйл ажиллагааны ангилал	Ажиллагсдын тоо	Борлуулалтын орлого /мян.төг/
Нийт:	3072	205,504,391
Үүнээс		
Автобусны үйлчилгээ	2191	112,324,165
Такси үйлчилгээ	881	93,180,226

Эх үүсвэр: УСГ, 2006

хэдэн шалтгаантай. Нэгдүгээрт, сүүлийн жилүүдэд бензиний үнэ хэд дахин нэмэгдсэн ч такси үйлчилгээний үнэ 250 төг/км хэвээр байна. Хоёрдугаарт, 2001 оноос хойш хувийн жижиг автомашинтай хүмүүсийг такси үйлчилгээнд явахыг зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалттай холбоотой. Энэ үеэс зах зээлийн өрсөлдөөн нэмэгдсэн. Гуравдугаарт, хувийн машинтай хүмүүс ихээр нэмэгдэн, нийслэл хотод замын түгжрэл үүсэх болсон.

Түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн нийтийн тээврийн хэрэглээнээс харахад микроавтобус (59%) болон такси (41%) хамгийн өргөн хэрэглэгддэг тээврийн хэрэгсэл гэдэг нь харагдлаа. Гэхдээ нийтийн тээврийн хэрэглээ аймгийн төв болон Улаанбаатар хотод нилээд ялгаатай байв. Аймгийн төвд микроавтобус, таксиг өргөн хэрэглэдэг бол Улаанбаатар хотод микроавтобус, автобус, такси, троллейбус гэсэн арай олон сонголттой байна.

Нийтийн тээврийн компаниуд норм норматив барьдаггүй, үйлчилгээ муу, тохилог бус, аюул эрсдэл ихтэй, шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэлтэй, тээврийн сүлжээний зохион байгуулалт муу зэргээр хэрэглэгчдийн эрх ашгийг зөрчдөг. Ихэнх тохиолдолд хэрэглэгчдийн гомдол, саналыг шийдвэрлэж өгдөггүй нь судалгаагаар харагдсан.

Аймгийн төвийн өрхүүдийн талаас илүү буюу 54 хувийнх нь өрхийн гишүүд

микроавтобусаар, 46% таксигаар, 0.7% автобусаар зорчдог гэсэн бол Улаанбаатар хотод микроавтобусны хэрэглээ хамгийн өндөр (64%), үүний дараа автобус (52%), такси (36%), троллейбус (23%)–ний хэрэглээ орж байна. Улаанбаатар хотын өрхүүдэд нийтийн тээврийн үнэ хямд (50%), шуурхай (50%) тул дээрх тээврийн хэрэгслээр зорчдог гэсэн хариулт хамгийн өндөр хувьтай байгаа бол аймгийн төвийн өрхүүд өөр сонголт байхгүй (49%), шуурхай (44%), үнэ хямд (28%) гэсэн хариулт өгсөн байна /Зураг 3.7/.


Судалгаанд хамрагдагсдын талаас илүү (54%) нь нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой хүндрэл бэрхшээл гардаг гэж хариулсан ба Улаанбаатар хотод нийтийн тээвэртэй холбоотой хүндрэл аймгийн төвийнхөөс илүү тохиолдож байна. Хүндрэл бэрхшээлүүдийг дурдвал: үйлчилгээ муутай (65%), шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэлтэй (48%), үнэ өндөр (20%) гэсэн хариултууд хамгийн өндөр хувьтай байна. Аймгийн төв болон Улаанбаатар хотод тохиолддог хүндрэл бэрхшээлүүдийн ялгаатай байдлыг дурдахад үйлчилгээ муутай, шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэлтэй гэсэн хариулт Улаанбаатар хотод аймгийн төвөөс өндөр байхад үнэ өндөр, норм барьдаггүй, тогтмол цагаар үйлчилдэггүй гэсэн хариултууд аймгийн төвд өндөр байна.

Хүснэгт 3.13. Автобус ба такси үйлчилгээний зах зээлийн төвлөрөл

Үйл ажиллагааны ангилал	Херфиндал-Хершманы индекс	Зах зээлийн төвлөрөл	Зах зээлийн өрсөлдөөн
Автобусны үйлчилгээ	0.23	өндөр	өрсөлдөөнгүй
Таксины үйлчилгээ	0.15	дунд зэрэг	өрсөлдөөн хязгаарлагдмал

Эх үүсвэр: УСГ, 2006

Зураг 3.7. Судалгаанд хамрагдсан өрх/өрхийн гишүүдийн ихэвчлэн зорчдог нийтийн тээврийн хэрэгсэл



Эх үүсвэр: Өрхийн түүвэр судалгааны үр дүн

Нийтийн тээврийн үнийн хувьд судалгаанд хамрагдагсдын талаас илүү нь одоогийн журмыг сонгосон. Түүнчлэн зорчсон буудлын тоогоор (31%) тогтоовол зүгээр гэсэн хариулт ч зохих хувийг эзэлж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах талаарх саналыг аймгийн төв, Улаанбаатар хотод ялгаатай авч үзвэл, соёлтой, шуурхай үйлчилгээ үзүүлэх (41%), тохилог тээврийн хэрэгсэлтэй болгох (19%), автобус, троллейбусыг нэмэгдүүлэх (18%), норм норматив барих, зохицуулалт, хяналтыг сайжруулах (тус бүр 13%), парк шинэчлэл хийх (11%) гэсэн саналууд Улаанбаатар хотод өндөр байхад зохицуулалт, хяналтыг сайжруулах (22%), соёлтой, шуурхай үйлчилгээ үзүүлэх (20%), автобус, троллейбусыг нэмэгдүүлэх (11%), норм норматив барих (10%) гэсэн саналууд аймгийн төвд зонхилох хувьтай байна.

3.7 ҮҮРЭН ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛ

Монголын үүрэн холбооны зах зээл сүүлийн үед хамгийн эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд өрсөлдөөний түвшин харьцангуй өндөртэй


салбаруудын нэг боллоо. Үүрэн холбоо буюу гар утасны хэрэглээ Монголд өндөр байгаа ба хэрэглэгчдийн ихэнх нь Мобикомын сүлжээг хэрэглэж байна. 1990 оны дундуур Монголд зөвхөн нэг компани буюу Монголын цахилгаан холбоо компани ажиллаж, суурин холбооноос өөр сонголт байгаагүй бол анх 1996 Мобиком компани (Японы хөрөнгө оруулалттай) орж ирсэн. 1999 онд Монголын Засгийн газар үүрэн холбооны салбарт тендэр зарлаж, Өмнөд Солонгосын хөрөнгө оруулалттай “Скайтел” компани үйл ажиллагаа явуулах эрх авсан.

2002 онд суурин утас хэрэглэгчдийн тоо 135,5 мянга, гар утас хэрэглэгчдийн тоо 256,8 мянга байсан бол 2005 онд суурин утас хэрэглэгчдийн тоо 160,5 мянга, гар утас хэрэглэгчдийн тоо 570,9 мянгад хүрчээ. (2007 онд 700 мянган хэрэглэгчтэй болсон). Мөн Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдэд холбооны үйлчилгээг өргөн хүргэх зорилгоор 1999 оноос утасгүй холбооны үйлчилгээ үзүүлж эхэлсэн бөгөөд энэ үйлчилгээг хэрэглэгчдийн тоо 2002 онд 14033 байсан бол 2005 онд 23003 болж өсчээ⁵¹.

⁵¹ Монгол улс зах зээлд, МУИС-ийн ЭЗС, 2007

Мобиком, Скайтел компаниуд эхнээсээ хоёр өөр стандартын холбооны технологийг ашиглаж ирсэн. Мобиком Европ болон Хятадад тархсан GSM стандартын технологийг оруулахад, Скайтел Америк, Солонгос болон Японд өргөнөөр ашиглагддаг CDMA төрлийн технологийг оруулсан. Тухайн үед GSM, CDMA аль аль нь өрсөлддөг байсан боловч сүүлийн үед дэлхийд GSM стандарт илүү тархаж байна. 2007 оны байдлаар Монголд GSM системийг Мобиком, Юнител, CDMA системийг Скайтел, Жи-Мобайл хэрэглэж, Монголын зах зээлд улсын хэмжээгээр өрсөлдөж байгаа бөгөөд зах зээлийн хувь дараах байдалтай байна. Жи Мобайл ороогүй болно.⁵²

Зураг 3.8. Үүрэн холбооны зах зээлийн хэрэглэгчид



Эх үүсвэр: Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар, 2007

Үүрэн холбооны салбарт өрсөлдөөн Монголын бусад салбаруудыг бодвол сүүлийн жилүүдэд харьцангуй идэвхтэй явагдаж байгаагийн гол шалтгаан гэвэл тус салбарт дангаар ноёрхож байсан Мобикомоос гадна гурван компани нэвтрэн орж, шат дараалан өрсөлдөөнийг идэвхжүүлж ирсэн.

Анх тус салбарт Мобиком дангаараа ноёрхож байхдаа 1997-1999 он хүртэл

үнийг бараг бууруулаагүй. Гэвч 1999 онд Скайтел компани нэвтрэн орох болсонтой холбогдуулан суурь хураамж, ярианы тариф аль алийг нь ихээхэн хямдруулжээ. Тэр үед Скайтел компанийн ярианы тариф нь нилээд хямд байсан нь ийнхүү Мобикомыг үнээ бууруулахад хүргэжээ. 2001 онд Мобиком тарифаа бууруулж, Скайтелийн түвшинд ойртуулахад Скайтел компани дахин тарифаа бууруулж, Мобикомоос тарифаа дахин хямдруулжээ /Зураг 3.9/.

1999-2005 он хүртэл хоёр компани ийнхүү өрсөлдөж ирсэн бөгөөд тарифын динамикийг харахад Скайтел компани илүү дайчнаар өрсөлдөж, ярианы тарифаа түрүүлж хямдруулж ирсэн байна. 2006 оны 6-р сараас эхлэн гурав дахь компани буюу Юнител ХХК тус зах зээлд орж ирсэнтэй холбогдуулан Скайтел, Мобиком аль аль нь дахин үнийн өрсөлдөөн рүү шилжиж, тариф болон суурь хураамжаа бууруулжээ.

Юнител компани энэ зах зээл дээр анх нэвтрэн орохдоо Скайтел компанийн стратегитай ижил стратеги буюу хямд үнэ, тарифын бодлогыг хэрэгжүүлж ирсэн. Одоо үүрэн холбооны зах зээл харьцангуй тогтворжиж эхэллээ. Үнэ, тарифын түвшин тогтвортой болонгуут компаниуд төрөл бүрийн нэмэлт үйлчилгээгээр өрсөлдөж эхэлсэн. Тухайлбал, Скайтел компани бизнесменүүдэд зориулсан ВИП үйлчилгээтэй байхад Мобиком олон улсын роуминг, ЖПС (дата мэдээллийн хангамж) зэргээр илүү байна.

Зах зээлд сүүлд орж ирсэн Юнител саяхан (2007 оны 9-р сараас) ТВ хөтөлбөр болон сумогийн сонирхолтой барилдааныг гар утсан дээрээ шууд “амьдаар нь” үзэх боломжийг хэрэглэгчдэдээ олгох, ярианы тарифаа хямд байлгах зэрэг арга хэрэглэсэн. Үүрэн холбооны салбарын нэг онцлог нь

⁵² Жи-Мобайл компанийн лиценз нь зөвхөн хөдөө орон нутгийн малчдад үйлчилгээ явуулахад зориулагдсан болно.

Зураг 3.9. Үүрэн холбооны зах зээлийн үнийн тариф, суурь хураамжийн динамик, 1996-2007



Эх үүсвэр: Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар, 2007

хэрэглэгчдийн тоо нэмэгдэх тусмаа дундаж зардал буурдаг тул өнгөрсөн хугацаанд тариф буурсан нь зөвхөн өрсөлдөөний үр дүн гэж хэлж болохгүй ч гэсэн өрсөлдөөн байгаагүй бол компаниуд үнээ бууруулдаггүйг нь Мобикомын 1997-1999 оны, Скайтелийн 1999-2001 оны жишээнээс харж болно.

Өрсөлдөөний үр дүнд тариф, хураамжийн түвшин тасралтгүй буурч, олон төрлийн үйлчилгээ бий болсон. Мэдээллээс харахад ярианы тариф 1997 оноос хойш Мобикомын хувьд 5 дахин, Скайтелийн хувьд 2 дахин буурсан гэсэн тооцоо гарч байна. Энэ нь хэрэглэгчдийн хожоо болсон бөгөөд компаниуд олон төрлийн нэмэлт үнэгүй үйлчилгээ бий болгосон.

Түүвэр судалгааны дүнгээс Монголд гар утасны хэрэглээ өндөр байгаа нь харагдсан ба судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн ихэнх буюу 75% мобикомын сүлжээг хэрэглэж байгаа дүн гарлаа. Мобикомын хэрэглээ аймгийн төвд Улаанбаатар

хотынхоос өндөр байгаа бол Скайтел, Юнителийн хувьд Улаанбаатар хотод аймгийн төвийнхөөс өндөр байна.

Үүрэн холбооны зах зээлийг өрсөлдөөнтэй салбар гэж хэрэглэгчид үзэж байгаа ба өрсөлдөөн нэмэгдсэнээр үнэ өсөхгүй, буурч байна; нэмэлт урамшуулал бий болж байна; үйлчилгээ сайжирч байна; сонголтын хүрээ тэлсэн зэрэг эерэг үр дагаврууд гарсан гэжээ.

Хэрэглэгчид харилцагчидтайгаа адил сүлжээнд байхын тулд (50%), анхнаасаа хэрэглэсэн (27%), сүлжээ сайн барьдаг (23%), ярианы тариф хямд (21%) гэдэг шалтгаанаар тухайн компанийн сүлжээг хэрэглэдэг. Ялангуяа аймгийн төвийн хариулагчдын дунд харилцагчидтайгаа адил сүлжээнд байхын тулд (53%), анхнаасаа хэрэглэсэн (31%) учир тухайн компанийн сүлжээг хэрэглэдэг гэж хариулсан хувь Улаанбаатар хотын хэрэглэгчдийнхээс өндөр байна.

Судалгаанд хамрагдагчдын 61% хэрэглэж

байгаа компанийнхаа үйлчилгээнд сэтгэл хангалуун байгаа бол үлдсэн 39% сэтгэл хангалуун биш байна гэжээ. Сэтгэл хангалуун биш байгаа шалтгаанд үнэ өндөр гэсэн хариулт өндөр хувийг эзэлж байна. Үнэ өндөр, сүлжээ тасардаг, үйлчилгээ муу гэсэн хариултууд аймгийн төвийн хэрэглэгчдэд Улаанбаатар хотын хэрэглэгчдийнхээс өндөр байна.

Судалгаагаар үүрэн холбооны зах зээл дээр хэрэглэгчдийн эрх ашиг зөрчигддөг байна. Улаанбаатар хотын хэрэглэгчдийн эрх ашиг их, бага хэмжээгээр зөрчигддөг гэсэн бол аймгийн төвийн хариулагчдын 61% тэдний эрх ашиг зөрчигддөг гэжээ.

Үүрэн телефон утасны зах зээлийг хэрэглэгчдийн 71% маш өрсөлдөөнтэй, 24% өрсөлдөөн дунд зэрэг, үлдсэн 5% өрсөлдөөнгүй, эсвэл мэдэхгүй гэжээ. Тухайн зах зээлийг өрсөлдөөнтэй гэж үзсэн хариулагчид өрсөлдөөн нэмэгдсэнээр үнэ өсөхгүй, буурч байна (63%), нэмэлт урамшуулал бий болж байна (42%), үйлчилгээ сайжирч байна (41%), сонголтын хүрээ тэлсэн (35%) зэрэг эерэг үр дагаврууд гарч байна гэлээ.

Цаашид үүрэн холбооны үйлчилгээг сайжруулахын тулд ярианы тарифыг бууруулах (27%), үйлчилгээг сайжруулах (14%), мобикомын монополийг багасгах (11%), суурь хураамжгүй болгох (10%), урамшуулал нэвтрүүлэх (8%), сүлжээ сайн барьдаг болгох, шинэ технологи нэвтрүүлэх (6-7%) хэрэгтэй гэсэн саналуудыг өгч байна.

Тус салбарын өрсөлдөөний байдлыг дүгнэхэд, өрсөлдөөний үр дүнд сонголт ихтэй болсон хэрэглэгчид сүлжээ сайн барьдаг, ярианы тариф хямд, үйлчилгээ түргэн шуурхай зэрэг үзүүлэлтээр хүссэн компанийг сонгох бололцоотой болж,

Монголын үүрэн ярианы үнэ нилээд их хэмжээгээр буурсан.

Гэхдээ энэ салбарт шударга бус өрсөлдөөнтэй холбоотой асуудал нилээд байна. Жишээ нь, өнгөрсөн жил хэрэглэгчид болон бусад өрсөлдөгчдийн зүгээс ШБӨХЗГ-т “Мобиком компанийн нэг минутын ярианы тарифын хямдралыг шалгаад өгөөч” гэсэн хүсэлт хүргүүлж, үнэн мөнийг тогтоолгож байсныг уншигчид тодхон санаж байгаа байх.

Мөн Мобиком, Скайтел, Юнител компаниуд саяхан “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар”-т Жи-Мобайл компанийн үйл ажиллагаатай холбоотой хүсэлт тавьжээ. Энэ нь тус компани Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгаас бусад газарт үйл ажиллагаа явуулах нөхцөлтэй тендэрт оролцож, эрх авсан атал энэ оны тавдугаар сард Цахилгаан холбооны зохицуулах хорооноос дээрх компанийг Улаанбаатарт үйл ажиллагаа эрхлүүлэх тухай тогтоол гаргасан байна. Жи-Мобайл компанийг нийслэлд үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөх тухай холбогдох төрийн байгууллагын эрх бүхий хүмүүсийн гарын үсэгтэй цаас цөөнгүй байна.⁵³

Тус салбарын өрсөлдөөнийг харахад анх уг салбар үүссэнээс хойш Мобиком компани гурав гаруй жил монополь эрхтэй үйл ажиллагаа явуулсан. Үүнийг Засгийн газар тусгай гэрээгээр баталгаажуулж өгсөн нь зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан явдал болсон. Мөн Мобиком компани төрөл бүрийн өрсөлдөөний аргуудыг хэрэглэн хэрэглэгчдийг зүй бусаар татахыг оролдож, Скайтел болон Мобикомын хооронд

⁵³ “Жи-Мобайл” компани орон нутагт зүүн, төв, хангай, баруун гэсэн бүсчиллээр сүлжээгээ нэвтрүүлнэ хэмээн ярьж байсан. Гэтэл холбогдох албаныхны өгүүлж буйгаар өнөөдрийн байдлаар 20 гаруй суманд сүлжээгээ хүргэсэн бололтой. Байх ёстой газраа ажиллахгүй төв суурин газрын зах зээлийг булаацалдах шаардлага бий гэж үү. Өнөөдөр /2007.07.20/

Хүснэгт 3.14. Монголын зарим зах зээлийн төвлөрөл ба өрсөлдөөн, үнийн байдал

Үйл ажиллагааны ангилал	Херфиндал-Хершманы индекс	Зах зээлийн төвлөрөл	Зах зээлийн өрсөлдөөн	Үнэ
Газрын тосны импорт	0.227	өндөр	Илт давамгай байдалтай аж ахуйн нэгжүүд ноёрхсон, картелийн шинж чанарыг агуулсан зах зээл. Нэвтрэн ороход хэцүү, нийлүүлэлт нь ганцхан импортын нэг эх үүсвэрээс хамааралтай. Өрсөлдөөнгүй гэж үзэж болно.	Сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөн
Утас хөдөлгөөнт холбоо	0.616	Мобиком илт давамгай	Өрсөлдөөнтэй, олигополийн үнийн (Бертрандын) өрсөлдөөний шинж чанарыг агуулсан. Шинэ компаниуд байнга орж ирдэг.	Сүүлийн жилүүдэд эрчимтэй буурсан
Мах, махан бүтээгдэхүүн	0.070	төвлөрлийн хувь нь доогуур боловч зах зээлийн үйл ажиллагаа нь шударга бус өрсөлдөөний шинж чанартай	Өрсөлдөөн хязгаарлагдмал, бөөний худалдааны биржүүд хөгжөөгүй учир үр ашиг муутай.	Сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөн
Ноос, ноолуур	0.115	дунд зэрэг	өрсөлдөөн хязгаарлагдмал, бөөний худалдааны биржүүд хөгжөөгүй учир үр ашиг муутай, дамалсан худалдааны шинжтэй	Төдийлөн өөрчлөгдөөгүй
Нийтийн тээвэр	Автобус- 0.230 Такси- 0.150	дунд зэрэг	Дунд зэргийн өрсөлдөөнтэй, зохицуулалт ихтэй	Өсч байгаа

Эх үүсвэр: YCG, 2006

мессэжийн үйлчилгээг явуулахгүй байсан нь шударга бусаар өрсөлдөж байсан гэж хэлж болно. Гэхдээ Мобиком компани тус зах зээлд одоог хүртэл илт давамгай байдалтай байгаа болохоор тус салбарын хяналт, зохицуулалт шаардлагатай хэвээр байна.

3.8 САЛБАРУУДЫН ТӨВЛӨРӨЛ

Төвлөрлийн харьцааг ихэнхдээ нийгмийн бодлого боловсруулахад өргөн ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, боломжит индексийг⁵⁴ ашиглан зах зээлийн бүтцийг тодорхойлсноор төвлөрлийн түвшин ба

хэлбэрийг тогтоож, тухайн зах зээл дээрх харьцангуй том ба жижиг үйлдвэрлэгчдийн нөлөөллийг харуулахын зэрэгцээ шинэ үйлдвэрлэгчийг зах зээлд нэвтрэх боломж байгаа эсэхийг харах юм.

Үндсэндээ өрсөлдөөний төвлөрлийн индекс нь тухайн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын хуримтлагдсан хувийг илэрхийлнэ. Энэ нь тухайн салбартаа томхон хувийг эзэлж байгаа компаниудын тоо хэмжээнд үндэслэсэн салбарын нийт хэмжээг координатын хавтгайн хэвтээ тэнхлэгт үзүүлээд босоо тэнхлэгийн дагуу төвлөрлийн хувийг харуулж байгаагаар дүрслэгддэг. Хэрвээ босоо тэнхлэгийн дагуу тухайн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй

⁵⁴ Хавсралтаас үзнэ үү.

компаниудын тоо ба эзлэх хувь нь тэнхлэгтээ илүү ойртон хотойж байвал тухайн зах зээл дээр төвлөрөл их байна, харин тухайн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй компаниудын тоо ба эзлэх хувь нь босоо тэнхлэгээс холдон хотойж байвал төвлөрөл бага байна гэж үзнэ.

Зах зээлийн төвлөрлийг тооцоход ноос, ноолуурын зах зээлийн хувьд дунд зэргийн төвлөрөлтэй, бүтцийн хандлагаар авч үзвэл зах зээлийн өрсөлдөөн хязгаарлагдмал байгаа бол мах, махан бүтээгдэхүүний салбар өрсөлдөөнтэй байна. Харин газрын тосны зах зээл хамгийн өндөр төвлөрөлтэй, өрсөлдөөнгүй салбар гэсэн дүн гарч байна.

Газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээл дээрх том таван аж ахуйн нэгж нь нийт борлуулалтын 90% байдаг бол мах, махан бүтээгдэхүүний салбарт 56.5%, ноос, ноолууран бүтээгдэхүүний зах зээлд 43% байна /Хүснэгт 3.14/.

3.9 ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

Түүвэр судалгаанд хамрагдсан өрхүүдийн шинж байдал

Судалгаанд нийт 720 хэрэглэгч өрх хамрагдсаны 41.7% Улаанбаатар хот, үлдсэн 58.3% аймгийн төвийн өрхүүд байлаа. Эдгээр өрхүүдийн тал орчим хувь 4-5 ам бүлтэй, гуравны нэг орчим хувь нь 1-3 ам бүлтэй өрхүүд, өрхийн ам бүлийн дундаж тоо 4.3 байна. Ам бүлийн тоо аймгийн төв, Улаанбаатар хотод бараг ялгаагүй байна.

Сууцны өмчийн хувьд дийлэнх (95%) нь хувийн сууцанд амьдардаг, талаас илүү буюу 55% төвлөрсөн халаалттай, 42% ердийн халаалттай, үлдсэн 3% төвлөрсөн бус халаалттай байна. Ердийн халаалттай буюу галлагаатай өрх аймгийн төвд Улаанбаатар

хоттой харьцуулахад өндөр байна. Усан хангамжийн хувьд нийт өрхийн 51% халуун, хүйтэн устай. Усан хангамжийн байдал аймгийн төв, Улаанбаатарт ялгаатай буюу Улаанбаатар хотын өрхүүдийн талаас илүү хувь төвлөрсөн халуун, хүйтэн устай байхад аймгийн төвийн өрхүүдийн худаг болон зөөврийн/гол, булгийн ус хэрэглэдэг хувь илүү байна.

Гар утасны хэрэглээ нилээд өндөр буюу нийт судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн 89% гар утас хэрэглэж байна. Гар утасны хэрэглээ Улаанбаатар хотод аймгийн төвөөс бага зэрэг өндөр байна.

Өрхийн сарын дундаж орлого, зарлагын хувьд сонирхолтой үр дүн харагдлаа. Нийт өрхийн хувьд сарын дундаж орлого 217'227 төгрөг байгаа бол зардал нь орлогоосоо өндөр буюу 228'000 төгрөг байна. Орлого, зарлагын хэмжээ Улаанбаатар хотод аймгийн төвөөс өндөр, гэхдээ аймгийн төвийн өрхүүдийн сарын дундаж орлого зарлагаасаа өндөр байхад, Улаанбаатар хотод эсрэгээрээ сарын дундаж зардал нь орлогоосоо өндөр байна. Энэ нь Улаанбаатар хотод хэрэглээний түвшин аймгийн төвийнхнөөс өндөр байгааг харуулж байна.

Өрхийн сарын орлого, зарлагыг бүлэглэсэн байдлаар авч үзье. Сарын дундаж орлогын хувьд нийт судалгаанд хамрагдсан өрхүүдийн дийлэнх (66 %) 50'001-250'000 төгрөгийн орлоготой. Сарын дундаж орлогын түвшинг 250'000 төгрөгөөс доош гэж хариулсан хувь аймгийн төвийн өрхүүдийн хувьд Улаанбаатар хотын өрхүүдээс өндөр байхад Улаанбаатар хотод 250'000 төгрөгөөс дээш орлоготой гэж хариулсан хувь аймгийн төвийнхнөөс өндөр байна.

Өрхийн сарын дундаж зарлагын хувьд 150'000 төгрөгнөөс дээш зардалтай өрхийн

хувь Улаанбаатар хотод аймгийн төвийнхөөс өндөр байна. Аймгийн төвийн өрхүүдийн дийлэнх (76%) 50'001-250'000 төгрөгийн зардалтай байна.

Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн шинж байдал

Аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох ажиллагсдын тоо, сарын дундаж цалин, жилийн дундаж борлуулалт, үндсэн хөрөнгийн хэмжээ зэрэг нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд аймгийн төвийн аж ахуйн нэгжүүдээс илүү байна.

Судалгаанд үүрэн холбоо, газрын тосны импорт, мах, махан бүтээгдэхүүн, ноолуур, нийтийн тээврийн⁵⁵ 112 аж ахуйн нэгж хамрагдсаны 57 нь аймгийн төв, 55 нь Улаанбаатар хотынх байлаа. Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүдийн дийлэнх (86%) хязгаарлагдмал хариуцлагатай компани байхад аймгийн төвүүдэд хувьцаат компани болон орон нутгийн өмчит үйлдвэрүүд олон байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ихэнх буюу 78% дотоодын хөрөнгө оруулалттай компани байсан бол зөвхөн 4.5% гадаадын хөрөнгө оруулалттай, үлдсэн 18% гадаад, дотоодын хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд байна. Түүнчлэн нийт судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 64% толгой/охин/салбар компанитайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Аж ахуйн нэгжүүдийн ажилласан жилийг авч үзвэл, Улаанбаатар хотын компаниуд аймгийн төвүүдэд үйл ажиллагаа явуулж буй

аж ахуйн нэгжүүдээс илүү олон жил ажиллаж байгаа дүр зураг ажиглагдлаа. Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүдийн 76% нь 6, түүнээс дээш жил ажиллаж байгаа бол энэ хувь аймгийн төвүүдийн аж ахуйн нэгжүүдэд 46% байна. Эсрэгээр 1-5 жил ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүд аймгийн төвүүдэд Улаанбаатараас өндөр хувьтай байна.

Ажиллагсдын сарын дундаж цалин байршлаар нилээд ялгаатай байна. Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүдийн ажиллагсдын сарын дундаж цалин 159'093 төгрөг байхад аймгийн төвд 123'074 буюу ойролцоогоор 36'000 төгрөгөөр зөрүүтэй байна. Аймгийн төвүүдийн аж ахуйн нэгжүүдийн талаас илүү (56%), Улаанбаатар аж ахуйн нэгжүүдийн гуравны нэгийн ажиллагсдын сарын дундаж цалин 50'000-100'000 төгрөг байна. Харин ажиллагсдын сарын дундаж цалин 100'000-аас дээш байгаа хувь Улаанбаатар хотод аймгийн төвөөс өндөр байна.

Аж ахуйн нэгжүүдийн жилийн дундаж борлуулалтын хэмжээг авч үзвэл, 48% нь 200 сая ба түүнээс дээш төгрөгийн борлуулалт хийж байгаа ба энэ хариултын хувь Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүдийн хувьд аймгийн төвийнхөөс даруй 2 дахин өндөр байна. Харин аймгийн төвийн аж ахуйн нэгжийн 61% 100 хүртэл сая төгрөгийн жилийн дундаж борлуулалттай байна. Аж ахуйн нэгжийн борлуулалтын хэмжээ ийнхүү байршлаар ялгаатай байгаа нь зах зээлийн багтаамжтай холбоотой байж болох юм.

Аж ахуйн нэгжүүдийн нийт борлуулалтад экспортын эзлэх хувь нилээд бага буюу аж ахуйн нэгжүүдийн 80% экспортын бүтээгдэхүүн гаргадаггүй гэжээ. Нийт борлуулалтад экспортын эзлэх хувийг аль ч ангиллаар авч үзсэн Улаанбаатар хотод аймгийн төвөөс өндөр байна.

⁵⁵ УБТЗ нь тээврийн тарифаа нэмсэн талаарх хэрэг. (2006 оны 2 сарын 28. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын тайлан) Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар нь уг аж ахуйн нэгж нь давамгайл байлаа ашиглаж, төмөр замын тээвэрлэлтийн тарифыг нэмсэн талаар холбогдох шалгалт хийж, дүгнэлт гаргаж, тээврийн тарифыг бууруулахыг шаардсан.

Аж ахуйн нэгжийн эдийн засгийн дараагийн үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь үндсэн хөрөнгийн хэмжээ юм. Улаанбаатар хотод 200 сая ба түүнээс дээш төгрөгийн үндсэн хөрөнгөтэй аж ахуйн нэгж 51% байгаа бол аймгийн төвд 2 дахин бага буюу 25% байна. Харин 100 сая хүртэл төгрөгийн үндсэн хөрөнгөтэй аж ахуйн нэгжийн эзлэх хувь аймгийн төвд өндөр байна.

Түүхий эд материал нийлүүлэгчдийн тоо болон том нийлүүлэгчдийн нийт нийлүүлэлтэд эзлэх хувийг тодруулахад ихэнх аж ахуйн нэгжүүд тендэрээр түүхий эд нийлүүлэгчдийг шалгаруулдаг гэсэн боловч тендэр шалгаруулалтад нилээд асуудал гардаг байна. Судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн 45% түүхий эд материал нийлүүлэгчдийн тоог 2-5, 31% зөвхөн 1, үлдсэн 23% 6-гаас дээш гэжээ. Энэ хариултын хувь аймгийн төв, хотод нилээд ялгаатай буюу аймгийн төвийн аж ахуй нэгжүүдийн 58% зөвхөн ганц нийлүүлэгчтэй гэсэн бол Улаанбаатар хотод зөвхөн 9% байна.

Судалгаанд сонгогдсон таван салбарын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөний байдлыг тодорхойлсон хариултаас үүрэн холбооны зах зээл дээр хамгийн их өрсөлдөөнтэй, үүний дараа газрын тосны импортын зах зээл, ноолуур, мах, махан бүтээгдэхүүний, хамгийн сүүлд нийтийн тээврийн зах зээл орж байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс үүрэн холбоо, газрын тосны импортын зах зээлийг том, харин мах, махан бүтээгдэхүүн, ноолуур, нийтийн тээврийн зах зээлийг дунд зэрэг гэж хариулсан хувь өндөр байна.

Тухайн салбарын үйл ажиллагааны зах зээлийг маш өрсөлдөөнтэй гэж хариулсан хувь үүрэн холбооны зах зээл дээр хамгийн өндөр

(95%), үүний дараа газрын тосны импортын зах зээл (77%), ноолуур (75%), мах (71%), нийтийн тээврийн зах зээл (55%) орж байна.

Сүүлийн таван жилд эдгээр салбарт өрсөлдөөн нэмэгдэж байна. Өрсөлдөөн үүрэн холбооны зах зээл дээр хамгийн ихээр (95%) нэмэгджээ. Өрсөлдөөн нэмэгдэхэд өрсөлдөгчид/нийлүүлэгчдийн тоо нэмэгдэж (63%), хэрэглэгчдийн шаардлага өсөхийн зэрэгцээ (21%) үнийн өөрчлөлт (11%) нөлөөлсөн. Газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүний импорт, махны зах зээл дээр өрсөлдөгчид/нийлүүлэгчдийн тоо нэмэгдсэн (64-71%), үнийн өөрчлөлт гарсан (20-29%), хэрэглээ нэмэгдсэн (12-18%) нь нөлөөлжээ. Ноолуурын зах зээл дээр өрсөлдөгчид/нийлүүлэгчдийн тоо нэмэгдсэн (60%) төдийгүй үнийн өөрчлөлт (20%) нөлөөтэй байгаагаас гадна техник, технологи нэвтэрч байгаа (10%) нь өөрчлөлтийн гол шалтгаан байсан бол нийтийн тээврийн зах зээл бусдаас арай өөр буюу өрсөлдөгчид/нийлүүлэгчдийн тоо нэмэгдэж (50%), хэрэглээ өсөхийн (29%) хамт, зохицуулалт муу (11%), хувьчлал (7%) хангалтгүй байгаа зэрэг шалтгаан нь тухайн зах зээлийн өөрчлөлтийг тайлбарлаж байна.

Өрсөлдөөний илрэл

Аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөн салбар тус бүрээр нилээд ялгаатай илэрч байна. Нийт аж ахуйн нэгжүүд өрсөлдөөн үнээр (57%), борлуулалтын хэмжээгээр (35%), зах зээлийн хүрээгээр (28%), чанараар (20%), үйлчилгээгээр (8%) илэрдэг гэсэн. Салбаруудаас үүрэн холбоо, газрын тосны импортын зах зээл дээр үнээр (79-82%) өрсөлдөх явдал түгээмэл байгаа бол мах, махан бүтээгдэхүүний зах зээл дээр үнэ, борлуулалтын хэмжээ, чанар; харин ноолуурын зах зээл дээр зах зээлийн хүрээ,

үнэ, борлуулалт, үйлдвэрлэлийн хүчин чадал гэх зэргээр өрсөлдөөн илэрч байна. Нийтийн тээврийн салбарт өрсөлдөөн илрэх хэлбэрт үнэ, борлуулалт, зах зээлийн хүрээ, патент, лиценз эзэмших эрх, хүчин чадал, чанар, үйлчилгээ зэргийг нэрлэж болохоор байна. Үйлчилгээгээр өрсөлдөөн илэрдэг гэсэн хувь үүрэн холбооны зах зээл дээр илүү өндөр байна.

Зах зээлд нэвтрэх боломж

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 52% тухайн зах зээлд анх нэвтрэн ороход ямар нэгэн бэрхшээл тохиолдсон гэжээ. Хамгийн гол бэрхшээлүүд нь хөрөнгө санхүү (64%), дүрэм, журам зохицуулалт (40%), ажиллах хүч (22%), бүртгэл (14%) байсан гэжээ. Салбараар авч үзвэл, үүрэн холбооны зах зээлд нэвтрэн ороход хөрөнгө санхүү (50%), дүрэм, журам зохицуулалт, орчин (33%), ажиллах хүч, бүртгэл (17%)-ийн асуудлууд талгарч байсан бол газрын тосны импортын зах зээл дээр мөн л хөрөнгө санхүү (62%), дүрэм, журам зохицуулалт (54%), бүртгэл (23%)-ийн асуудлууд тулгарсан байна. Мах, махан бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэн ороход хөрөнгө санхүү (71%), үнийн өсөлт (14%) гол бэрхшээл байсан бол ноолуурын зах зээлийн хувьд хөрөнгө санхүүгийн бэрхшээл судалгаанд хамрагдсан бүх компанид тулгарсан ба ажиллах хүч, бүртгэл, дүрэм, журмын зохицуулалтын бэрхшээл ч тулгарсан гэжээ. Харин нийтийн тээврийн зах зээлд нэвтрэхэд бусад компанитай адил хөрөнгө санхүү (44%), ажиллах хүч (25%)-ний асуудал тулгарч байсан ч дүрэм, журам зохицуулалт (69%) хамгийн том бэрхшээл байсан гэж хэлж болохоор байна.

Шинэ компани нэвтрэн ороход ямар нэгэн бэрхшээл бий эсэхийг тодруулахад

нийт аж ахуйн нэгжийн 66% бэрхшээл бий гээд зардал өндөр (55%), ажиллах хүч дутмаг (26%), бусад компанийн зүгээс үзүүлэх дарамт, зохицуулалт их (15%), зах зээлийн багтаамж бага, хэрэглэгчдийг татах хэцүү (10%) гэсэн бэрхшээлүүдийг дурьджээ.

Өрсөлдөөний аргууд

Нийт салбарт демпинг⁵⁶ (47%), технологийн шинэчлэл хийх (38%), далд сүлжээ (21%), хүчтэй зар сурталчилгаа явуулах (16%), бүтээмжийн өсөлт, үнэ бууруулах (14%), мэргэжилтэн, ажилтныг урвуулах (13%), урамшуулал, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх (6%) гэх зэргийг аж ахуйн нэгжүүд өрсөлдөгчөөсөө хүлээж болох эрсдэлүүд гэжээ. Харин өрсөлдөгчөөс хүлээж болох эрсдэлүүд салбар тус бүрээр ялгаатай байлаа /Хүснэгт 3.15/.

Зах зээл дээр оршин тогтнож, үйл ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлст өрсөлдөөн ихтэй (42%), зах зээлийн багтаамж муу (33%), хууль эрх зүйн орчин муу (17%), санхүүгийн чадавхи муу (14%), мэргэжилтэн хангалтгүй (13%) гэх зэрэг шалтгааныг нэрлэж байна.

Өрсөлдөөн ихтэй, зах зээлийн багтаамж муу гэсэн хариулт бүх салбарт нийтлэг байгаа хэдий ч үүрэн холбоо, газрын тосны импортын бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүний зах зээлд илүү өндөр хувьтай байна. Газрын тосны импортын бүтээгдэхүүний зах зээлд үнийг үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйл гэж дурьджээ. Ноолуурын зах зээлд зах зээлийн багтаамж муу, санхүүгийн чадавхи муу (тус бүр 58%), өрсөлдөөн ихтэй, мэргэжилтэн хангалтгүй (тус бүр 41%), мэргэжлийн ажилчид дутагдалтай (33%),

⁵⁶ Зах зээлийн үнээс хэт доогуур үнээр бүтээгдэхүүнээ борлуулж, өрсөлдөгч нарыг шахан зайлуулах, дампууруулах арга

техник технологийн хоцрогдолтой, бүтцийн өөрчлөлт хийх боломж муу (тус бүр 17%) гэсэн хариултын хувь өндөр байсан бол нийтийн тээврийн зах зээлд хууль эрх зүйн орчин муу (36%), зах зээлийн багтаамж муу (29%), өрсөлдөөн ихтэй (23%), санхүүгийн чадавхи муу (19%), техник технологийн хоцрогдолтой (16%), мэргэжилтэн хангалтгүй гэсэн хариулт өндөр хувьтай байна.

Зах зээлийн өрсөлдөөний үед тухайн зах зээл болон өрсөлдөгчийнхөө талаар судалгааг байнга хийж байх шаардлагатай байдаг. Судалгаанд хамрагдсан таван салбарын аж ахуйн нэгжүүд зах зээлийн онцлогоос хамаарч, судалгааг хэр тогтмол хийж байгаа нь нилээд ялгаатай байна. Мах, махан бүтээгдэхүүн, ноолуур, нийтийн тээврийн зах зээл дээр зах зээлийн судалгааг тогтмол хийдэггүй, эсвэл огт хийдэггүй гэсэн хариултыг хамгийн өндөр хувьтай өгсөн бол үүрэн холбоо, газрын тосны импортын бүтээгдэхүүний хувьд сар бүр зах зээлийн судалгааг явуулдаг гэсэн хариултыг илүү өгсөн байна.

Зах зээлийн өрсөлдөөний талаарх судалгаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн ихэнх (82-90%) нь зах зээлийн болон өрсөлдөгчийн талаарх судалгааныхаа үр дүнд хариу үйлдэл хийж, бодлогодоо тусгаж чаддаг гэжээ.

Өрсөлдөөний давуу талууд

Зах зээл дээр өрсөлдөөн нэмэгдсэнээр чанар сайжирна, үнэ буурна, бүтээгдэхүүний орлуулалт нэмэгдэнэ, компанийн нэр хүнд өснө, барааны стандарт сайжирна, үйлчилгээ сайжирна гэсэн эерэг үр дагаврууд гарна гэдгийг судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд тодорхойлж байна. Тоогоор илэрхийлбэл, 78% өрсөлдөөн нэмэгдсэнээр чанар сайжирна, 36% үнэ буурна, 22% бүтээгдэхүүний орлуулалт нэмэгдэнэ, өрсөлдөөний үр дүнд компанийн нэр хүнд өснө, 19% барааны стандарт сайжирна, 16% үйлчилгээ сайжирна гэсэн бол цөөн хувь (2-6%) технологийн дэвшил нэвтэрнэ, гэрээ хэлэлцээр тодорхой болно, борлуулалт нэмэгдэнэ, хэрэглэгчдийн соёл дээшилнэ гэжээ.

Өрсөлдөөний үр дүнд чанар сайжирна гэсэн хариулт аймаг, хотод ялгаагүй хамгийн өндөр хувьтай, харин аймгийн төвөөс судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд өрсөлдөөн бий болсноор үнэ буурна (44%) гэж хариулсан бол Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүд компанийн нэр хүнд өснө (29%) гэжээ. Энэ нь илүү их барааны сонголттой зах зээлд зөвхөн үнээр өрсөлдөх бус, чанар, хийц, үйлчилгээгээр өрсөлддөг хөгжсөн зах зээлийн шинжтэй нийцэж байна.

Хүснэгт 3.15. Өрсөлдөгчөөс хүлээж болох хамгийн гол гурван эрсдэл, салбараар

Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүтээгдэхүүн	Ноолуур	Нийтийн тээвэр
Демпинг	Демпинг	Демпинг	Технологийн шинэчлэл	Демпинг
Хүчтэй зар сурталчилгаа явуулах	Далд сүлжээ	Технологийн шинэчлэл	Мэргэжилтэн/ажилтныг урвуулах	Технологийн шинэчлэл
Технологийн шинэчлэл	Технологийн шинэчлэл	Бүтээмжийн өсөлт, үнийн бууралт	Бүтээмжийн өсөлт, үнийн бууралт	Далд сүлжээ

Эх үүсвэр: Аж ахуйн нэгжийн түүвэр судалгааны үр дүн

Мэдээлэл олж авдаг эх үүсвэрүүд

Улаанбаатар хотод судалгаагаар (53%), үйлчлүүлэгчдээс (44%), радио, телевиз, сонин хэвлэлээс (77%), зар сурталчилгаанаас (36%), ном эмхтгэл, гарын авлагаас (35%) өрсөлдөөний талаарх мэдээллийг олж авдаг гэж байхад аймгийн төвд радио, телевизээс мэдээллийг олж авдаг гэсэн хувь хамгийн өндөр буюу 46%, үүний дараа үйлчлүүлэгчдээс (32%), судалгаагаар (26%), сонин хэвлэл, зар сурталчилгаагаар гэсэн хариултууд орж байна.

Өрсөлдөөний талаарх хууль эрх зүйн акт, дүрэм журмын талаарх мэдлэгийн түвшин аймгийн төвд Улаанбаатар хотоос нилээд доогуур байна. Компанийн тухай хууль, ШБӨ-ийг хориглох тухай хууль, патентийн хууль, засгийн газрын тогтоолууд, дампуурлын тухай хууль, стандартын дүрмийг л мэддэг байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 59% өрсөлдөөний талаарх хууль эрх зүйн акт, дүрэм журмыг мэднэ гэж хариулсан ба мэдлэгийн түвшин аймгийн төвд (42%), Улаанбаатар хотоос (76%) нилээд доогуур байна. Өрсөлдөөний талаарх хууль эрх зүйн акт, дүрэм журмыг мэднэ гэж хариулсан аж ахуйн нэгжүүдээс ямар хууль эрх зүйн акт, дүрэм журам мэддэгийг тодруулахад компанийн тухай хууль (80%), ШБӨ-ийг хязгаарлах тухай хууль (65%), патентийн хууль, засгийн газрын тогтоолууд (42%), дампуурлын тухай хууль (36%), стандартын дүрэм (6%)-ийг нэрлэж байна.

Өрсөлдөөний стратеги

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн зах зээлийн өрсөлдөөнд баримталдаг стратеги салбараар нилээд ялгаатай байна. Үүрэн холбоо, газрын тосны импортын аж ахуйн нэгжүүд нилээд

төстэй буюу үйлчилгээгээрээ ялгарах (59-68%), бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх (47-50%), үнийн бодлого (26-36%) гэсэн хариултыг өндөр хувьтай өгсөн бол мах махан, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх (68%), үйлчилгээгээрээ ялгарах (32%), үнийн бодлого (21%) гэж хариулсан байна. Ноолуурын зах зээл бусдаас арай өөр буюу ихэнх нь (92%) бүтээгдэхүүний чанар хамгийн чухал баримталдаг стратеги гэжээ. Түүнчлэн энэ зах зээл дээр бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, нийлүүлэгчид/хэрэглэгчдээ татах (25%) стратеги чухал юм байна. Харин нийтийн тээврийн аж ахуйн нэгжүүд үйлчилгээгээр ялгарах (71%), нийлүүлэгчид/хэрэглэгчдээ татах (32%), чанарыг сайжруулах (29%), компани бие даан өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх (23%) стратегийг баримталдаг гэсэн нь хамгийн өндөр хувьтай байна.

Шударга бус өрсөлдөөн

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 66% зах зээл дээр шударга бусаар өрсөлдөх явдал гардаг гэжээ. Газрын тосны импорт, мах махан бүтээгдэхүүн, ноолуур, нийтийн тээврийн аж ахуйн нэгжүүдийн 64-75% тухайн зах зээл дээр шударга бусаар өрсөлдөх явдал гардаг гэсэн бол үүрэн холбооны зах зээл эдгээрээс арай бага буюу 47% нь ийм хариултыг өгсөн байна. Үүрэн холбооны зах зээлийн өрсөлдөөн зар сурталчилгаагаар (44%), зах зээлийн хил хязгаарын хуйвалдаан, хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүргэх (33%) замаар илэрдэг гэсэн бол газрын тосны импортын зах зээлийн өрсөлдөөн үнийн хуйвалдаан (64%), эрх мэдэлтний шийдвэрээр (43%) илэрдэг гэжээ. Харин мах, махан бүтээгдэхүүний зах зээл дээр стандартын бус бүтээгдэхүүн,

үйлчилгээгээр (55%) шударга бус өрсөлдөөн илэрдэг гэсэн хувь хамгийн өндөр байна. Энэхүү стандартын бус бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр өрсөлдөөн илэрдэг гэсэн хариулт нийтийн тээвэр (41%), ноолуур (22%), газрын тосны импортын (14%) зах зээл дээр ч тодорхой хувийг эзэлж байна. Ноолуурын зах зээлийн өрсөлдөөн хамгийн ихээр түүхий эдийн зах зээлийн үнийн хуйвалдаанаар (78%) илэрдэг гэсэн бол нийтийн тээврийн зах зээл дээр эрх мэдэлтний шийдвэр (64%) буюу нийтийн тээврийн зөвшөөрөл олгох явдлаар илэрдэг байна.

Бусад компанитай тохиролцоо хийдэг үү? гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн 44% “Тийм” гэж хариулжээ. Газрын тосны импорт болон ноолуурын зах зээл дээр тохиролцоо хийдэг гэж 50-иас дээш хувь нь хариулжээ. Бусад компанитай тохиролцоо хийдэг аж ахуйн нэгжүүд үнэ (69%), бүтээгдэхүүний чанар болон үйлчилгээ (тус бүр 25%), зах зээлийн хувь (14%), бараа бүтээгдэхүүний чанар (12%) зэрэгт тохиролцоонуудыг хийж байна. Ялангуяа газрын тосны импорт, мах, махан бүтээгдэхүүн, ноолуурын зах зээл дээрх аж ахуйн нэгжүүд үнийн (82-86%) тохиролцоо илүү хийдэг бол үүрэн холбоо, нийтийн тээврийн хувьд үйлчилгээгээрээ тохиролцоо нь элбэг байна.

Шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх нь

Компаниуд өөрсдөө ашигтай үед зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарласан тохиролцоонд ордог боловч түүнээсээ болж хохирсон тохиолдолд шударга бус өрсөлдөөнтэй тэмцдэг байна. Тухайн зах зээл дээр шударга бусаар өрсөлдөх явдал гардаг гэсэн аж ахуйн нэгжүүдийн тал орчим хувь нь шударга бус өрсөлдөөн гарсан тохиолдолд

салбарын зохицуулах газарт хандана гэсэн бол гуравны нэг орчим хэнд ч ханддаггүй/мэдэхгүй гэжээ. Мөн тодорхой хэсэг нь ШБӨХЗГ, шүүх цагдаад хандана гэсэн байна. Энэхүү хариултыг байршлаар авч үзвэл, аймгийн төвийн аж ахуйн нэгжүүдийн ихэнх (64%) салбарын зохицуулах газарт хандана гэсэн бол Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүдийн 34% дээрх хариултыг өгчээ. Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүд салбарын зохицуулах газраас гадна ШБӨХЗГ (27%), шүүх цагдаад (22%), хандана гэсэн нь аймгийн төвийнхнөөс өндөр хувьтай байна.

Шударга бус өрсөлдөөн бий болохоос сэргийлэхийн тулд хууль, эрх зүйн зохицуулалт сайн байх (50%), хуулийн хэрэгжилт сайн байх (37%), компани өөрөө бие даасан, чадвартай байх (36%), бодлогын зохицуулалттай байх (30%), төрийн оролцоогүй байх (14%), бизнес улс төрөөс ангид байх (12%) хэрэгтэй гэж хариулсан хувь хамгийн өндөр байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 59% хэрэглэгчдээс гомдол хааяа ирдэг, 11% байнга үлдсэн 30% гомдол ирдэггүй гэжээ. Хамгийн их гомдол хүлээн авдаг салбар нь үүрэн холбоо (89%), нийтийн тээврийн салбар (77%) байдаг бол үүний дараа мах, махан бүтээгдэхүүн (61%), газрын тосны импорт (59%), ноолуурын зах зээл (58%) орж байна.

Эдгээр салбарын хамгийн их хүлээн авдаг гомдол нь үйлчилгээтэй (63%) холбоотой. Энэ төрлийн гомдол үүрэн холбоо болон нийтийн тээврийн салбарт (82-100%) хамгийн их ирдэг. Үүний дараа чанартай холбоотой (46%) гомдлууд орж байна. Ялангуяа ноолуур, мах, махан бүтээгдэхүүний зах зээл дээр (82-100%) чанартай холбоотой гомдол их ирдэг байна. Харин бараа бүтээгдэхүүний үнэтэй холбоотой гомдол

(17-35%) (ноолуураас бусад салбарт) ирдэг ч үйлчилгээ, чанараас арай бага хувьтай байна.

Хэрэглэгчдээс ирсэн гомдлыг ихэнх тохиолдолд (63%) гомдлыг барагдуулж шийдвэрлэж өгдөг байна. Түүнчлэн хариуцлага тооцдог (37%), дотоод журмаар шийддэг (19) байна. Энэхүү хариулт салбараар ялгаа багатай байгаа хэдий ч зарим нэг онцлогыг дурьдахад газрын тосны импортын бүтээгдэхүүний зах зээлийн хувьд шатахууны чанарыг шалгах (31%), үүрэн холбооны зах зээлийн хувьд үйл ажиллагаа, үйлчилгээний (12%) хяналтыг сайжруулдаг гэжээ.

Бараа бүтээгдэхүүний стандартууд

Аж ахуйн нэгжүүдийн үндэсний стандартыг дагаж мөрдөж буй байдал олон улсын стандартыг дагаж мөрдөж байгаагаас арай илүү, гэхдээ аль аль стандартыг дагаж мөрдөж байгаа хувь хангалттай түвшинд байхгүй байна. Салбараар тийм ч их ялгаа байхгүй хэдий ч үүрэн холбооны зах зээлийн олон улсын болон үндэсний бараа бүтээгдэхүүний стандартыг дагаж мөрдөж байгаа хувь хамгийн өндөр, харин нийтийн тээврийн салбарынх хамгийн бага байна.

Олон улсын болон үндэсний стандартыг хэрхэн дагаж мөрддөг талаарх асуултанд нийт судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 42% олон улсын (ISO 9001) стандартыг сайн, 30% маш сайн, 17% дунд зэрэг үлдсэн 12% муу/маш муу дагаж мөрддөг гэж хариулсан. Харин үндэсний стандартыг нийт аж ахуйн нэгжүүдийн 44% маш сайн, 42% сайн, 17% дунд, зөвхөн 3% муу дагаж мөрддөг гэжээ. Эндээс аж ахуйн нэгжүүдийн үндэсний стандартыг дагаж мөрдөж буй хувь олон улсын стандартыг дагаж мөрдөж байгаагаас арай илүү, гэхдээ аль аль стандартыг дагаж мөрдөж байгаа хувь хангалттай түвшинд байхгүй байна гэж хэлэхээр байна.

Зардал ба үнэ

Судалгаанд сонгогдсон таван салбарын аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийнхээ нэгжийн үнийг тогтоохдоо үндэслэдэг зүйлсийг тодруулахад нийт судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 65% нэгжийн дундаж зардал, 37% өрсөлдөгчийн үнэ тогтоолт, 25% хэрэглэгчийн худалдан авах чадвар, 19% засгийн газрын зохицуулалт, 14% нефть, шатахууны үнийг үйлдвэрлэлийн нэгжийн зардлыг тогтооход нөлөөлдөг хүчин зүйлс гэж хариулсан нь өндөр хувьтай байна.

Үүрэн холбооны зах зээл дээр нэгжийн дундаж зардал (53%), засгийн газрын зохицуулалт, өрсөлдөгчийн үнэ тогтоолт (тус бүр 37%), хэрэглэгчдийн худалдан авах чадвар (26%) гэх зэргийг үйлдвэрлэлийн нэгжийн үнэ тогтооход нөлөөлдөг гол хүчин зүйлс гэсэн бол газрын тосны импортын зах зээл дээр нэгжийн дундаж зардал (82%), өрсөлдөгчийн үнэ тогтоолт (32%), татвар (18%) зэргийг гол хүчин зүйлс гэж нэрлэж байна. Татвар үнэд нөлөөлдөг хүчин зүйл гэдгийг газрын тосны импортын бүтээгдэхүүнээс өөр салбарт нэрлээгүй байна. Мах, махан бүтээгдэхүүн, ноолуурын зах зээлд нэгжийн дундаж зардал (67-79%), өрсөлдөгчийн үнэ тогтоолт (39-58%) голлон нөлөөлдөг гэж хариулсан байхад мах, махан бүтээгдэхүүний зах зээл дээр дээрх хоёр хүчин зүйлээс гадна нефть, шатахууны үнэ, бусад барааны үнэ бас нөлөөлдөг гэжээ. Нийтийн тээврийн салбар бусдаас нилээд ялгаатай буюу нэгжийн дундаж зардлаас (48%) гадна хэрэглэгчдийн худалдан авах чадвар (36%), засгийн газрын зохицуулалт (32%), хууль эрх зүйн акт болон өрсөлдөгчийн үнэ тогтоолт (тус бүр 29%), нефть, шатахууны үнэ (26%) чухал хүчин зүйлс гэжээ.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тал орчим буюу 48% нь өрсөлдөгч компани бүтээгдэхүүнийхээ нэгжийн үнийг

бууруулбал үнээ дагаж бууруулна гэжээ. Үлдсэн 38% нь үнээ өөрчлөхгүй, 4% нь тухайн нөхцөл байдлаас болно гэсэн бол үлдсэн 2% зөвшилцөнө, 8% хэлж мэдэхгүй байна гэжээ. Үнээ дагаж бууруулна гэдгийг газрын тос импортлогч аж ахуйн нэгжүүд хамгийн өндөр буюу 77% хариулсан бол үнээ өөрчлөхгүй гэдгийг ноолуур (75%) болон нийтийн тээврийн (52%) салбарын аж ахуйн нэгжүүд илүүтэйгээр хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс сүүлийн таван жилд тухайн зах зээл дээр гарсан томоохон өөрчлөлтүүд, эдгээр өөрчлөлт үнэд нөлөөлсөн эсэхийг тодруулсан. Хамгийн их өөрчлөлт бол өрсөлдөөн нэмэгдсэн (42-79%) явдал гэжээ. Ялангуяа үүрэн холбоо, газрын тосны импорт (59%), ноолуурын (58%) зах зээл дээр нийт судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн талаас илүү хувь нь өрсөлдөөн нэмэгдсэн гэсэн хариултыг өгсөн. Үүний дараа зах зээл дээр том компани орж ирсэн (25%), орлуулах бүтээгдэхүүн нэмэгдсэн (13%) гэсэн хариултууд орж байна. Сүүлийн таван жилд гарсан өөрчлөлтүүдийг дурьдсан дээрх хариултуудаас зах зээл дээр өрсөлдөөн ямар нэгэн хэмжээгээр нэмэгдэж, өөрчлөлтүүд гарч байна гэсэн үр дүн харагдаж байна. Харин сүүлийн таван жилд зах зээл дээр өөрчлөлт гараагүй гэсэн хариултыг мах, махан бүтээгдэхүүн (25%) үйлдвэрлэгчид бусдаас өндөр хувьтай хариуллаа.

Өрсөлдөөний төлөв

Өрсөлдөөний өөр үр дагавар бол чанар ба үнэд гарах өөрчлөлт юм. Сүүлийн таван жилийн хугацаанд өрсөлдөөний улмаас бий болсон үнийн өөрчлөлтийг сонирхоход 42% үнэ өөрчлөгдөөгүй, 31% үнэ өссөн гэсэн бол зөвхөн 27% нь үнэ буурсан гэжээ. Ялангуяа ноолуур, нийтийн тээврийн салбарт (69-

82%) үнэ өөрчлөгдөөгүй гэсэн хариулт өндөр хувьтай байна. Харин үнэ буурсан гэсэн хариулт (74%) үүрэн холбооны зах зээл дээр илүү ажиглагдлаа. Эсрэгээрээ, газрын тосны импорт, мах махан бүтээгдэхүүний зах зээл дээр үнэ өссөн (52-56%) байна.

Тухайн зах зээл дээр сүүлийн таван жилд өрсөлдөөн нэмэгдсэн гэсэн хариултыг судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд өгснийг өмнө дурьдсан. Гэтэл ойрын таван жилд тэдний талаас илүү хувь (62%) нь өрсөлдөөн нэмэгдэхгүй, харин цөөн хэдэн компани давамгайлна гэжээ. Нийтийн тээвэр (81%), үүрэн холбооны (74%) зах зээл дээр цөөн хэдэн компани давамгайлна гэсэн хариулт хамгийн өндөр хувьтай байна. Харин ноолуурын зах зээл дээр өрсөлдөөн нэмэгдэнэ (83%) гэжээ. Газрын тосны импорт болон мах, махан бүтээгдэхүүний зах зээл дээр нэг хэсэг нь (55-57%) цөөн хэдэн компани давамгайлна гэж үзэж байхад нөгөө хэсэг нь (41-43%) өрсөлдөгчид олноор нэмэгдэнэ гэж санал хуваагдсан байдалтай байна.

Ойрын таван жилд өөрсдийн үйл ажиллагааны зах зээл дээр өрсөлдөөн нэмэгдэхгүй цөөн хэдэн компани давамгайлна гэж үзэж буй шалтгааныг тодруулахад талаас илүү хувь нь (59%) зах зээлийн багтаамж муу гэсэн хариултыг өгсөн байна. Зах зээлийн багтаамж муу гэсэн энэхүү хариулт үүрэн холбоо (86%), нийтийн тээврийн (69%) зах зээлийн аж ахуйн нэгжүүдийн хувьд хамгийн өндөр харин мах, махан бүтээгдэхүүний зах зээл дээр (19%) хамгийн бага байна.

Өрсөлдөөн ба институцийн орчин

Монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдал эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн өөрчлөлттэй уялдаж чадаж байна уу? гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ихэнх буюу

68% чадахгүй байна гэжээ. Нийтийн тээвэр, мах, махан бүтээгдэхүүн, үүрэн холбооны зах зээлийн аж ахуйн нэгжүүдийн хувьд энэ хариулт (68-91%) өндөр байна.

Хуулийн зүйл ангиудын уялдаа холбоо муу (63%) байгаа нь монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдал эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн өөрчлөлттэй холбоотой гэж үзэж байна. Түүнчлэн тогтсон ёс заншил зах зээлийн өөрчлөлтийг даган өөрчлөгдөж чадахгүй байгаа, дүрэм журам зохицуулалт муу байгаа зэрэг нь бас нэг гол шалтгаан гэж хэлж болохоор байна.

Монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдлыг сайжруулахын тулд хуулийг сайн

хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах, хуулиа засаж сайжруулах, хуулиа дээдлэх, ухамсар, хариуцлагыг өндөржүүлэх, бизнес улс төрөөс ангид байх хэрэгтэй гэж судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд үзэж байна.

Судалгаанд хамрагсад үйлчилгээ ба чанар сайн, нийлүүлэгч олон, үнэ хямд/уян хатан, хууль эрх зүйн зохицуулалт сайн, шударга, төрийн оролцоо оновчтой байвал зах зээлийг өрсөлдөөнтэй гэж ойлгож байна. Тоогоор илэрхийлбэл, аж ахуйн нэгжийн 33% үйлчилгээ сайн, 23% нийлүүлэгч олон, 18% үнэ хямд/уян хатан, 13% хууль эрх зүйн зохицуулалт сайн, шударга, 11% чанар сайн, 9% төрийн оролцоо оновчтой байвал зах зээлийг өрсөлдөөнтэй гэж үзэж байна.

БҮЛЭГ 4.

Тендэр, газар, уул уурхайн салбарын өрсөлдөөн

Сүүлийн үед уул уурхай, газар болон үл хөдлөх хөрөнгийн зах ихээхэн анхаарал татаж байгаа бөгөөд эдгээр салбарт шийдвэрлэх маш олон асуудал тулгараад байна. Иймээс судалгааны баг газрын зах зээл, уул уурхайн салбарын өрсөлдөөний байдал болон тендэрийн хуулийн хэрэгжилтийг тусгайлан судаллаа.

4.1 ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛ

Эдийн засгийн бодлого (зах зээлийн үйл ажиллагаа), хууль (өмчийн эрхийн хамгаалагдсан байдал, эрх зүйн хэм хэмжээг тогтоох), газрын удирдлага (өмчийн эрхийг захирах) гэсэн гурван үндсэн салбар шинжлэх ухааныг хамтатган судалж, газрын эрхийг арилжааны хэлбэртэй хөрөнгө болгодог.

Газар эдийн засгийн хүчин хамгийн чухал зүйлсийн нэг боловч түүний зах зээлийн хөгжил олон орнуудын дунд тэгш бус байна. Дэлхийн зөвхөн 40 оронд л тодорхой шалгууруудад үндэслэсэн үр ашигтай хэлбэртэй, ойлгомжтой, үндэсний газрын зах зээлтэй байна гэж судлаачид үздэг. Газрын зах зээлийг судлахад Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн нийгэмлэгийн (OECD)

гучин улс орон газрын зах зээлийн талаарх дэлхийн тэргүүний туршлагыг илүү харуулж байна. Газрын зах зээл амжилттай хөгжихийн тулд түүнд зохицсон эрх зүйн орчин, бүртгэл, өмчлөлийн стандартууд хөгжсөн байх ёстой бөгөөд тийм орчин бүрэлдээгүй тохиолдолд түүнийг орлосон албан бус газрын наймаа хөгждөг. Албан бус газрын зах зээлийн үйл ажиллагаа ихээхэн хүндрэлтэй, чирэгдэлтэй, зардал ихтэй. Өөрөөр хэлбэл, газрын зах зээлийн дэд бүтэц бий болоогүй болохоор олон дүрэм журам сайтар боловсруулагдаагүй, албан бус зах зээлүүдэд өрсөлдөөний түвшин сул, хөрөнгө оруулалтын таатай орчныг дэмжихгүй байна. Албан бус зах зээлүүд нь өвлөх болон худалдаалах үйл явцыг нарийн төвөгтэй болгож буй гол шалтгаан болж байна.

Газрын зах зээлийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд, юуны өмнө эрх зүйн болон захиргааны тогтолцоонууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эрх зүйн тогтолцоо өмчийн эрхийг худалдаалах барааны хэлбэрт оруулахад газрын эрхийг тодорхойлох, маргааныг шийдэх, зөрчилтэй эрхүүдээс давуу эрхийг тогтоох, газрыг ашиглах ялгаатай боломжуудыг тогтооход чухал байдаг.

Газрын алба нь газрын зах зээлийн боломжит арилжааны тогтолцоог бий

болгоход чухал үүрэгтэй. Газрын зах зээлийн менежмент амжилттай хэрэгжихэд хуулийн хүрээнд бүх газар болон түүнтэй холбоотой нөөцийг зөвхөн арилжааны хэлбэрт оруулах биш, ямар төрлийн бараа болгохыг ойлгомжтойгоор тодорхойлох явдал чухал. Тиймээс газрын алба нь газар болон олон нийтийн эзэмшлийн хөрөнгийг кадастр болон газрын нарийвчилсан зургийг оролцуулан худалдаалах үйл явцад оролцохгүй газрыг ч гэсэн багтаан зөв удирдах нөхцлийг хангана.

Газрын зах зээл бүрэлдэн бий болохдоо бэлтгэлийн ба зах зээлийн гэсэн хоёр шатыг дамждаг байна. Бэлтгэл үе шатанд **газар (1)**, **газрын эрх (2)** бий болох ба газар эзэмших хугацаа, хувийн эзэмшлийн газартай болсноор нөөцийн анхны хуваарилалт хийгдэж эхэлнэ. Зах зээлийн үе шатанд **газар арилжаалах (3)** үйл явц эхэлж, **газрын зах зээл (4)** ажиллах бөгөөд баялаг бий болох гүйцэд боловсорсон өмчийн зах зээл (5) ажиллах болно. Иймд динамик шинжтэй, нийлмэл зах зээл ажилласнаар баялгийн хуримтлалыг хурдасгах юм.

Улс орнуудад газрын зах зээл бүрэлдэхэд бодлого боловсруулагчид газар өмчлөн, эзэмшиж, ашиглах эрх бүхий үүргийг олон нийтэд таниулж, газрын хуваарилалтыг тогтвортой болгон газрын эздэд капитал хуримтлуулах нөхцлийг бий болгох ёстой. Зах зээлгүйгээр газрын эрх байж болох ч газрын эрхгүйгээр зах зээл оршихгүй. Арилжаалах газрын эрх нь өмчийн институцийн гол үр дагавар юм.

Ихэнх улс орон газрын зах зээлийн үе шатуудыг дамжиж, улмаар илүү нарийн нийлмэл үе шат руу хүрэх нь газрын арилжааны тогтвортой тогтолцоог бий болгох чадавхиас хамаарч байна. Үүний зэрэгцээ барьцаалах үл хөдлөх хөрөнгийн

хоёрдогч зах зээл, өмчийн итгэл үнэмшил ч бас чухал. Өмчийн эрх нь газрын зах зээлийн гол хөдөлгүүр учраас газрын зах зээл дээрх бараа, тухайлбал, түрээс, үл хөдлөх хөрөнгийн барьцаа, зээл гэх зэрэг нь өмчийн өөр төрлийг эзэмших боломжийг олгоно. Хэрвээ засгийн газрын институцүүдийн үйл ажиллагаа хэвийн бөгөөд газрын алба болон газрын эрхийг баталгаажуулсан бол хууль эрх зүйн орчныг сайжруулснаар газрын зах зээлийн илүү нийлмэл бүтээгдэхүүнийг, тодруулбал, газрын эрх; барьцаалах хөрөнгийн хоёрдогч зах зээл; газрын гэрээг бий болгож, эзэмшүүлж, шилжүүлэх; итгэлцлийг хөгжүүлэх, өмчийн эрхийн итгэлцлийг бий болгох гээд газрын зах зээлийн олон төрлийн барааг бий болгох юм. Эдгээрийн зарим нь газрын зах зээлийн энгийн бараа болон тэдгээрийн үйл ажиллагаатай нягт холбоотой. Зарим нь хувийн өмчийн эрхийг өргөжүүлэх хуулийн болон захиргааны чухал өөрчлөлт, мөн түүнчлэн өмчийн бүртгэлийн өөрчлөлттэй холбоотой. Газрын зах зээлд шинэ бүтээгдэхүүнийг бий болгоход газрын ашиглалт, үүсгэл санаачилга, хүрээлэн буй орчны асуудал нэн чухал байна.

Монгол улсын газрын зах зээл сүүлийн жилүүдэд албан ба албан бус хэлбэртэй үүсч байна. Монгол улсын Үндсэн хуулийн заалтаас гадна Газрын тухай хууль (2002), Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003), Газрын төлбөрийн тухай хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2003), Газар зохион байгуулалт хийх журам (2003), Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журам (2003) гээд газрын зах зээлийн үйл ажиллагааг зохицуулах олон хууль, дүрэм журмууд батлагдсан.

Одоогийн хууль эрх зүйн хүрээнд Монгол улсын иргэд гэр бүлийн хэрэгцээний ба аж ахуйн зориулалтаар газрыг өмчилнө гэж заасан байдаг⁵⁷. Одоогийн байдлаар Монголд газрын зах зээл жинхэнэ утгаар төлөвшөөгүй байгаа бөгөөд ихэвчлэн үл хөдлөх хөрөнгө, газар дээр баригдсан байшин барилгын худалдаатай холбож үздэг.

Өнөөгийн нөхцөлд Монголд газрын зах зээл гол төлөв хот суурин газар, ялангуяа Улаанбаатарт хөгжиж байна. Улаанбаатарын газрын нийлүүлэлт хотын нийт талбайн 470 мянган га нутаг дэвсгэрээр хязгаарлагдана.⁵⁸ Улаанбаатарын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2001 онд баталсан бөгөөд зохион байгуулалт, менежментийн бодлогыг тодорхойлохдоо УИХ-аас гаргасан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Засгийн газраас баталсан “Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр”, нийслэлийн нийгэм-эдийн засгийн зорилттой уялдуулсан байдаг.

Хот суурин газрын нийлүүлэлт тогтмол байгаа ч эрэлт нь хүн амын өсөлт, эдийн засгийн хөгжилтэй хамт мэдэгдэхүйц ихэсч байна.

Газрын эрэлтийг хоёр хэсэгт хувааж болно. Нэг хэсэг нь аж ахуйн зориулалттай газрын эрэлт - үйлдвэр, дэлгүүр хоршоо, оффисын зориулалттай газрын эрэлт ордог. Ийм газрын эрэлт хотжилт, шилжих хөдөлгөөнийг дагаад илүү их өсч байна. Сүүлийн үед социализмын үеийн хот байгуулалтаас өөрчлөгдсөн зүйл гэвэл, нийслэлийн оршин суугчид хотын

төвийн гудамж, хөл хөдөлгөөн ихтэй газраас зайдуу амьдрах сонирхол ихтэй болж, өндөр хөгжилтэй орнуудад тохиолдож байсан үйл явдалтай төстэй процесс явагдаж байна. 1960-аад онуудад автомашины тоо нэмэгдэж, өндөр төдийгүй хурдны замууд олноор байгуулагдан өндөр хөгжилтэй орнуудын хотын хүн ам хотын зах руу шилжиж, хотын төвүүд бизнес, худалдааны төв болон хувирсан түүхтэй. Энэ бол ялангуяа АНУ-д их ажиглагдсан бөгөөд баян чинээлэг хотын захууд (suburbs) хотын төвийг (downtown) хүрээлэн хөгжиж эхэлсэн. Хотын төвд бизнесийн зориулттай байшингууд, засаг захиргаа, номын сан, театр зэрэг барилгууд үлдэж, хүн ам боллоцоогоороо хотын зах руу нүүдэг болжээ. Манайд нийслэл болон бусад суурин газрууд, хотын төвд илүү өндөр орлоготой, амьжиргааны сайн нөхцөлтэй хүмүүс амьдарч, хотын захад гэр хорооллууд байрлан уламжлалт хотжилтын (хүрээний) загвар дэлгэрсэн. Нөгөө талаас уламжлалт гэр хорооллуудад барилгажилт идэвхтэй явагдаж, аажмаар гэр хорооллоос хувийн орон сууцны хорооллууд болж өөрчлөгдөж байгаа нь Япон, Солонгос зэрэг орнуудын хөгжилтэй төстэй болж байгаа юм. Цаашид хуучин гэр хорооллуудад эрчим хүч, бохир, цэвэр усны сүлжээ, интернэт болон холбооны кабелиудтай болж, замын сүлжээг өргөжүүлж аажмаар тохилог орон сууцны хорооллууд болгох нь маш чухал. Улаанбаатарын төвд одоо АНУ-ын хотжилттой төстэй үйл явц өрнөж, яваандаа сонгодог хэлбэрийн хотын төв (downtown) үүсч байгааг хотын төвийн оффисын зориулттай барилгажилтаас харж болно.

Нөгөө хэсэг газрын эрэлт бол хувь хүмүүсийн орон сууцны эрэлт юм. Монгол улсын хүн амын 37,8% нийслэлд оршин сууж, сүүлийн таван жилийн статистик мэдээгээр 193085 хүн хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирснээр хотын нэг га газарт 40 орчим хүн суурьшиж байгаа

⁵⁷ Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх вйл ажиллагаа 2003 оны 05 дугаар сарын 01-нээс явагдаж, энэ хугацааг 2008 оны 5-р сарын нэгэн хүртэл сунгасан. Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газар нь түүний байршил, зориулалтаас хамааран: нийслэлд 0.07 хүртэл га, аймгийн төвд 0.35 хүртэл га, сумын төв, тосгонд 0.5 хүртэл га байна.

⁵⁸ Б.Төмөрхуяг, “Нийслэл дэх газрын харилцаа ба газрын зах зээл”, “Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг” олон улсын бага хурал, Улаанбаатар, 2007

нь улсын дунджаас 40 дахин их болжээ.⁵⁹ Одоогийн байдлаар газрын эрэлтийн гол илрэл нь орон сууцны эрэлт болж байгаа бөгөөд үүнийг шууд газрын эрэлт гэж тодорхойлох нь бас хэцүү. Гадаадын компанийн тооцоогоор, Улаанбаатар хотод жилд 9000 шинэ орон сууцны эрэлт байхад нийлүүлэлт нь жилд 3700 байгаа тул эрэлт нийлүүлэлт хоёр тэнцүү болох хандлага 2016 оноос наашгүй гэж тооцсон байгаа. Зах зээл тэнцвэрт орохын тулд жилд 17-18000 мянган орон сууцыг ашиглалтад оруулах шаардлагатай юм.

Газрын хувьчлал эхэлснээс хойш 2005 оны байдлаар нийслэлийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 50240 иргэн ашиглаж, эзэмшиж байгаа хашааныхаа 2513 га газрыг, 1260 иргэн 88,2 га газрыг шинээр тус тус өмчилж авчээ. Харин аймгуудын хэмжээнд гэр бүлийн зориулалтаар 44363 иргэн одоо ашиглаж, эзэмшиж байгаа хашааныхаа 6035,7 га газрыг, 17670 иргэн 3813,9 га газрыг шинээр, 51 иргэн аж ахуйн зориулалтаар 17,6 га газрыг тус тус өмчлөн аваад байна. Улсын хэмжээнд хоёр жилийн хугацаанд нийт 113584 иргэн газар өмчлөн авчээ.⁶⁰ 2007 оны 9 дүгээр сарын 21-ний байдлаар нийслэлийн хэмжээнд Налайх болон Багануур дүүргийг оролцуулан нийтдээ есөн дүүргийн 63960 өрх 3224,91 га газрыг өмчилж байгаа бөгөөд нийт өмчлүүлсэн газрын мөнгөн дүн нь 425688 сая төгрөг болж байна.⁶¹

Газрын хэмжээ, зориулалтаас хамааран дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулах аргыг хэрэглэн газрын эрхийг шилжүүлж байна. 2003-2006 онуудад

Улаанбаатар хотод 109 байршлын 921760 кв.м буюу 92,2 га газрыг дуудлага худалдаагаар олгожээ. 2006 онд газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг 36 удаа зохион байгуулахад 14 төсөлд санал ирээгүй, нэг төсөл хүчингүй болсон, долоон төслийн төлбөр хийгдээгүй, дөрвөн төслийн хугацаа тодорхойгүй шалтгаанаар хойшилжээ. Нийтдээ арван байршлын 521700 кв.м талбай бүхий 486011 мянган төгрөгийн анхны үнэтэй бизнесийн зориулалттай газар дуудлага худалдааны явцад 1636788 мянган төгрөгт хүрсэн байна. 2007 онд газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг 19 удаа зохион байгуулахад таван төсөлд санал ирээгүй, хоёр төсөл хүчингүй болсон, дөрвөн төсөл өрсөлдөгчгүйгээр шилжжээ. Нийтдээ найман байршлын 180000 кв.м талбай бүхий 163806 мянган төгрөгийн анхны үнэтэй бизнесийн зориулалттай газар 512540 мянган төгрөгт хүрсэн байна.⁶² Харин төсөл сонгон шалгаруулах зарчмаар олгож буй газрын мэдээлэл байхгүй байна.

Газрыг аж ахуйн эргэлтэд оруулахын тулд нилээд их бэлтгэл ажлууд хэрэгтэй байна. Юуны өмнө үндэсний хэмжээний орон зайн болон газрын мэдээллийн систем байгуулах шаардлага тулгарч байна. Энэ ажлын хүрээнд улсын хэмжээгээр кадастрын зураглалыг нэг солбицлын системд зурагжуулж, геодезийн цэг, тэмдэгтийн сүлжээг хиймэл дагуулын технологиор баруун таван аймаг болон газар зүйн бүсүүдэд нийт 446 цэгтэйгээр байгуулсны нэгэн адил говийн болон хангайн бүсийг хамарсан долоон аймгийн нутаг дэвсгэрт 330 цэгтэй геодезийн сүлжээг байгуулахаар болж байна.⁶³

Арилжааны банкууд газар ашиглах, эсвэл

⁵⁹ Б.Төмөрхуяг, “Нийслэл дэх газрын харилцаа ба газрын зах зээл”, “Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг” олон улсын бага хурал, Улаанбаатар, 2007

⁶⁰ Ш.Батсүх, “Монгол улсын газрын харилцааны шинэтгэлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”, 2007

⁶¹ Нийслэлийн газрын албаны “Газар өмчлөлийн хэлтэс”, 2007

⁶² Нийслэлийн газрын алба, Газар зохион байгуулалтын хэлтэс, 2007

⁶³ “Газар өмчлөлийн тайлан”, 2005, http://www.pmis.gov.mn/al-agac/admin/doc_medee/G-U-Tailan.DOC

эзэмших гэрчилгээтэй тохиолдолд тухайн газар дээр баригдсан үл хөдлөх хөрөнгийг газрын хамт барьцаалж зээл олгож байгаа бөгөөд газрыг дүүргийн Газрын албанд, харин үл хөдлөх хөрөнгийг “Эд хөрөнгийн улсын бүртгэлийн алба”-нд бүртгүүлснээр зээлийн барьцаа баталгаажиж байна. Жишээлбэл, ХААН банк 2002 оноос хойш бизнесийн зориулалттай зээлийг үл хөдлөх хөрөнгө барьцаалан олгож, нийтдээ 1723 зээлдэгчид газар барьцаалан зээл авчээ.⁶⁴

Газар ашиглах болон эзэмших эрх нь худалдан борлуулах боломжгүй учраас эдийн засгийн эргэлтэнд дангаараа орох боломжгүй. Хосолсон барьцааны үед газрыг ашиглах, эзэмших гэрчилгээний хугацаа богино болохоор урт хугацааны зээл олгох боломжгүй.

Барьцааны эрхийн бүртгэл тус тусдаа байгаа учраас, өөрөөр хэлбэл, газар эзэмших, ашиглах эрхийг газрын алба, харин өмчлөх эрх эд хөрөнгийн улсын бүртгэлийн албанд бүртгэгддэг ба байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд зээл хүсэх үеийн трансакцийн зардал өндөр байна.

Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор нийслэл хотын нэг га газрын эдийн засгийн суурь үнийг 440 сая төгрөгөөр тогтоосон боловч газрын зах зээлийн бодит үнэ болж чадахгүй байна.⁶⁵ Газрын татвар, төлбөр тооцож байгаа суурь үнэлгээ болон зах зээлийн үнэлгээ, үнийн хооронд уялдаа холбоо муу байгаа бөгөөд улмаар барьцаалан зээл олгоход хүндрэл учруулдаг. Газрын байршлын ялгааг тэр бүр тодорхойлоогүй байгаа нь газрын ялгаварт

үнэ тогтооход нөлөөлж чаддаггүй. Тиймээс газрын үнэлгээний системд үнэлгээний стандартчиллыг тогтоож, бүсчиллийн асуудлыг нарийвчлан гаргавал газрын зориулалт, ангиллыг илүү тодорхой болгоно. Газрын зах зээлийн үнийг зориулалтаар нь ялгаварлан тогтоох асуудал практикт их хүндрэлтэй. Тэр тусмаа газар тариалан эрхэлж байгаа нутаг дэвсгэр дээр ялгаварт рентэд тулгуурласан үнийг тогтоох нь хүндрэлтэй юм.

Газар ашиглалт, эдийн засгийн эргэлтэнд оруулах үйл явц аж ахуйн нэгжүүд төдийгүй хувь хүмүүсийн хувьд эрс өсөх хандлагатай байгаа ч судалгааны явцад уул уурхайн хувьд: байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсэн, нөхөн сэргээлт огт хийгдээгүй байгаа, хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах боломж олгохгүй байгаа, алтны уурхайнууд хаягдалгүй технологи ашиглаагүй зэрэг сөрөг үр дагаврууд гарсан нь ажиглагдсан бол хотын газар ашиглалтын хувьд: зуслангийн газрын хэмжээ янз бүр, зохион байгуулалтын хувьд зохисгүй байдал үүссэн, эзэмших эрхийн заалтыг зөрчсөн, газрын зөвшөөрөл олгоход хот байгуулалтын мэргэжилтнүүд хээл хахуульд илүү өртөмтгий, захирамж шийдвэр гаргуулахад, түүнчлэн техникийн нөхцөл гаргуулахад хүндрэлтэй байдаг гэсэн зохисгүй үр дагаврууд гарсан байна.⁶⁶

Хот, дүүрэг, тосгоны удирдлагын ажлын хариуцлага, хүмүүсийн ажлын зохион байгуулалт, хүн амын доторх газар өмчлөлийн талаарх ойлголт сул байгаа нь нилээд хэдэн судалгаанаас ажиглагдлаа.⁶⁷ Үүний нэг жишээ нь тусгай хамгаалалттай газар нутгийг төлөөлүүлэн дархан цаазат Богд хан уул,

⁶⁴ Я.Түвдэндорж, “Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах нь”, “Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг” олон улсын бага хурал, Улаанбаатар, 2007

⁶⁵ Б.Төмөрхуяг, “Нийслэл дэх газрын харилцаа ба газрын зах зээл”, “Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг” олон улсын бага хурал, Улаанбаатар, 2007

⁶⁶ ННФ, “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн нэгдсэн тайлан, USAID, USDA, CHF International, “Гэр санаачилга”: 2005 оны хашаа, байшингийн үнийн судалгаа

⁶⁷ ННФ, “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн нэгдсэн тайлан, USAID, USDA, CHF International, “Гэр санаачилга”: 2005 оны хашаа, байшингийн үнийн судалгаа

Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт хийгдсэн судалгаанаас: өндөр албан тушаалын хүмүүс, тэдний хамаатан садангууд газрыг их хэмжээгээр (54%) авч байна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагад тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33.2 заалтыг зөрчин газар олгосон, газар ашиглах зөвшөөрөлгүй газрыг ашиглаж байгаа (26%), газрын даац ачаалал хэтэрсэн байхад хамгаалалтын захиргаа хуулиа зөрчиж, эрхээ хэтрүүлэн үйл ажиллагаа явуулан газар олгодог (17%) зэргийг нэрлэж болно.

Цаашилбал, Ашигт малтмалын тухай хууль (лицензийн асуудал), ТХГН-ийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Үндсэн хууль зэрэг олон хуулийн заалт хоорондоо зөрчилдөж байгаа учраас газар нутгийн маргаан их гарч байна. Энэ бүхнээс үзэхэд газрын эдийн засгийн харилцаа эрүүл бус байна. Хотын газар ашиглалтын гол алдаа дутагдал нь удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгаа явдал гэж дүгнэжээ.⁶⁸

Газрыг эдийн засгийн харилцаанд оруулахын тулд газраа өмчилж авсан иргэдэд, тухайлбал, тариаланчид, фермерүүдэд туслалцаа үзүүлэх шаардлага гарч байна. Тариаланчдад зориулсан техникийн тусламж, газраа өмчилж авсан хувь хүмүүст үзүүлэх зээлийн үйлчилгээ, гамшиг тохиолдсон үед туслах арга хэмжээ, томоохон аж ахуйн нэгжтэй өрсөлдөх чадавхи, нөхцлийг нь дээшлүүлэх иж бүрэн хөтөлбөр хэрэгжиж болох юм. Мөн түүнчлэн хотын гэр хороололд амьдардаг иргэдийг зээлийн бүртгэлд оруулж, ипотекийн зээлийг хөгжүүлэх зайлшгүй асуудал тулгарч байна.

Газрын зах зээл дээр өмчлөлийн асуудал маш чухал учраас газар өмчлөлийн хэлбэрүүд ч чухал үүрэгтэй юм. Өөрийн орны уламжлалт ахуйн онцлогийг харгалзан үзвэл газар өмчлөлийн хувьд төрийн, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын, хувь хүний, хамт олны⁶⁹ гэсэн хэлбэрээс илүү нутаг орон, төрж өссөн газар гэсэн албан бус институци манайд хүчтэй байгаа билээ. Газар өмчлөх субъект, өмчлүүлэх газрын зориулалт, хэмжээ тодорхой болохоор газрын байршлыг тодорхойлох, тодруулбал, хот, сууринд олгох орон сууцны газар, аж ахуйн газар, газар тариалангийн талбайг зөв тодорхойлох хэрэгтэй бөгөөд энд байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа, нэгдсэн сүлжээ зайлшгүй чухал байх болно.

2007 оны 6-р сарын 20-ны өдрийн байдлаар Барилгын бирж, Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын Осмо ХХК, Хауснэт, Инфохаус, Зар мэдээ сонин, Шуурхай зар сонин, Өнөөдөр сонин, Тунамал зоос, Тэнхлэг зууч ХХК зэрэг мэдээллийн эх сурвалжуудаас газрын биржтэй холбоотой үнийн мэдээллийг цуглуулахад 1328 мэдээлэл байснаас 1171 зарах, 106 түрээслэх, гурван барьцаалах, есөн хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллах, 34 худалдаж авах мэдээлэл бүртгэгджээ. Эдгээр компаниудын үйл ажиллагаа газрын зах зээл дээрх стандарт үйл ажиллагаа биш, харин үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааны эхлэлийг харуулж байна. Тиймээс газрын бирж ажиллуулж, газар өмчлөх эрхийг улам баталгаажуулах газрын худалдах, худалдан авах үйл ажиллагааг бодит утгаар нь хэрэгжүүлэх асуудал тулгарч байна. Газрын зах зээлийн хөгжлийн талаарх зөв мэдээлэл олон нийтэд зөв арга замаар хүрч чадвал

⁶⁸ ННФ, “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн нэгдсэн тайлан, 2004

⁶⁹ О.Амархүү, В.Батхүү, Б.Баяр “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай Монгол улсын хуульд хийсэн дүн шинжилгээ”, 2003

газрын бирж ажиллах нөхцөл бүрэлдэнэ. Өнөөгийн байдлаар нийслэл, аймгийн засаг даргын тамгын газруудын “Газрын алба”-дуудын эрх мэдэл буюу төрийн институци газрын зах зээлийн харилцаанд давамгайлж байгаа тул газрын бирж логик агуулга, хэлбэрээрээ бүрэлдээгүй байна.

Газрын зах зээл нээгдэхгүй байгаа учраас мэдээллийн хүртээмж тэгш бус, харилцан адилгүй байна. Нөгөө талаар газар үл хөдлөх хөрөнгө болсноор хөрөнгө оруулалтын үндэс болж чадахгүй байна. Газрыг үнэ төлбөргүй өмчилснөөрөө ямар үнэ цэнэтэй хөрөнгийг эзэмшиж байгаа талаарх иргэдийн ухамсар төлөвшиж тогтоогүй. Газрын зах зээл нь бараа бүтээгдэхүүний зах зээлийг бодвол их онцлог зах зээл. Газрын харилцааны институци хөгжлийнхөө эхэн үед байгаа болохоор хязгаарлагдмал нийлүүлэлттэй газрын хязгааргүй эрэлт, хэрэгцээ цаашдаа өсөх хандлагатай байна.

Газар эзэмшил, өмчлөл, ашиглалттай холбоотой гарч буй гол маргаантай асуудлууд нь дараах байдалтай байна. Үүнд:

1. Шилжин ирэгсдийн дийлэнх хотын захын хороололд суурьшиж, зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй хашаа барьж байгаа тул хот гэдэг институци гаднаасаа дотогшилж хөгжих стратеги алга байна. Хот дотроосоо гадагшаа тэлж хөгжих үү, аль эсвэл гаднаасаа дотогшилж хөгжих үү гэсэн хотын газрын талаарх бодлого тодорхойгүй. Түүнчлэн газрын дэд бүтцийн бодлого нийслэлийн хувьд оновчгүй байгаа юм.
2. Орон сууцны зориулалтаар өмчилж буй газарт үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байшин барих юм уу, аль эсвэл айлын хашааны газрыг худалдан авч орон сууц барих уу гэх зэрэг өмчлүүлсэн газрын эргэлтийн хууль эрх зүйн зохицуулалт дутагдаж байгаагаас гэрээг албадан биелүүлэх институци хөгжөөгүй.
3. Кадастр, газрын зохион байгуулалт, газрын зөвшөөрөл, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн уялдаа холбоо муу байгаагаас зориулалтын бус аргаар газрыг ашиглан нийгмийн сайн сайхан байдалд сөрөг үр дагаврыг бий болгож байна.
4. Газрын бирж ажиллаж эхлээгүй байгаа тул газрыг худалдах, худалдан авах, түрээслүүлэх, зээлийн барьцаа болгох талаарх үнэн зөв, гүйцэд мэдээлэл хүн амд хүрч чадахгүй байна. Мэдээлэл хүрч чадахгүй байгаа нэг жишээ бол төсөл сонгон шалгаруулах замаар олгож буй газрын тухай мэдээлэл ил тод биш байна.
5. Газар өмчлөлийн ажил нь аймаг орон нутагт харилцан адилгүй далайцтай байгаа учраас газар эзэмших хугацаа, хувийн эзэмшлийн газартай болох тухай ойлголт, газар, газрын эрхийн асуудалд хандах хандлага эрс тэс ялгаатай гэж хэлж болно.
6. Газрын алба ба газрын үнэлгээний албаны үүрэг функц тодорхой биш, удирдлага зохион байгуулалт сул, газрын үнэлгээгээр мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай, газрын зах зээлийн мэдээлэлд цогц дүн шинжилгээ хийгээгүй байна. Одоогийн газрын үнийг жинхэнэ утгаараа байгаа газрын зах зээлийн үнэ биш хэлж болно.
7. Газрын зах зээлд танил тал, хээл хахууль их байна. Өндөр албан тушаалын хүмүүс, тэдний хамаатан садангууд газрыг их хэмжээгээр авч байна.

8. Үл хөдлөх хөрөнгийн татварын тогтолцоо сайн хөгжөөгүй байна.

Тиймээс одоогийн байдлаар Монгол улсын хэмжээнд газрын зах зээлийн үйл ажиллагааны эхлэл орон нутгийг бодвол нийслэл хотод илүү далайцтай явагдаж, газрын зах зээлийн бэлтгэл шат хангагдаж байна. Газрын үнэ эрэлт, нийлүүлэлтийн үндсэн дээр биш, харин гажуудалтай хуулийн үндсэн дээр тогтож байгаа. Газрын зах зээлийн үйл ажиллагаанд нөлөөлөх сөрөг дам нөлөө их. Газрын харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчин илүү боловсронгуй болох шаардлагатай.

4.2. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨРСӨЛДӨӨН

Манай улс төрөл бүрийн ашигт малтмалын арвин баялаг нөөцтэй бөгөөд эрдэс баялаг, уул уурхайн салбар нь эдийн засагт эзэлж байгаа хувь хэмжээгээрээ тэргүүлэх салбарын түвшинд хүрээд байна /Зураг 4.1/.


Уул уурхайн салбар нь манай орны эдийн засгийн хөгжлийг тодорхойлж байгаа

томоохон салбар хийгээд ДНБ-д эзлэх хувь жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь дээрх зургаас тодорхой харагдаж байна. Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг Хүснэгт 4.1-д харуулав.

Тус салбар 2006 онд 950 тэрбум гаруй төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь дотоодын нийт бүтээгдэхүүний 30%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70%, экспортын бүтээгдэхүүний 76%-ийг тус тус эзэлжээ. Ийнхүү тус салбарын манай улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд оруулж буй хувь нэмэр сүүлийн жилүүдэд өссөөр байгаа бөгөөд аж үйлдвэр, экспортын тэргүүлэх салбарын түвшинд хүрчээ. Цаашдаа ч энэ хандлага хадгалагдах төлөвтэй. Учир нь ирэх жилүүдэд манай эдийн засагт асар хүчтэй нөлөөлөх томоохон төслүүд хэрэгжин, Оюутолгой, Тавантолгой орд газрууд ашиглалтад орох гэж байна.

Энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн хувьд уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр дангаараа зэс, молибдений баяжмал; нэг аж ахуйн нэгж катодын зэс; 127 нэгж алт; 44 аж ахуйн нэгж жонш; 28 аж

Зураг 4.1. Уул уурхай, олборлох үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувь, 2003-2006



Хүснэгт 4.1. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн үйлдвэрлэл, 2000-2006

Бүтээгдэхүүн	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Зэсийн баяжмал (мян.тн)				372.2	371.4	361.6	370.5
Молибдений баяжмал (тн)				3836.6	2428.0	2528.0	2987.0
Алт (тн)	11.5	12.1	10.9	11.1	19.4	24.1	22.6
Жоншны баяжмал (мян.тн)				198.4	148.2	134.1	137.6
Хайлуур жонш (мян.тн)				488.2	468.2	507.9	521.9
Нүүрс (мян.тн)	5185.0	5141.0	5544.4	5666.1	6865.0	7517.1	8074.1
Газрын тос (мян.баррель)	65.5	82.8	139.2	183.0	215.7	200.7	366.8

Эх үүсвэр: УСГ, 2006

ахуйн нэгж нүүрс; 2 аж ахуй газрын тос тус тус олборлож байна.

Хамгийн өрсөлдөөнтэй зах зээл нь алт. Алтны зах зээлд 1999 онд алт олборлож буй компанийн тоо 28 байсан бол 2004 оны байдлаар 127 аж ахуйн нэгж байна.⁷⁰ Эдгээр компаниуд 1999 онд 6141,1 га талбайд алтны олборлолт явуулж, 5458,07 кг бүтээгдэхүүн гаргаж авсны зэрэгцээ 163,9 га-д нөхөн сэргээлт хийхдээ 175,9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулжээ. Харин 2003 оны байдлаар 5552,04 га талбайд олборлолт хийж, 5090,64 кг бүтээгдэхүүн гаргаж авсны зэрэгцээ 238,38 га-д нөхөн сэргээлт хийхдээ 538,83 сая төгрөгийн хөрөнгө зарцуулжээ. 2005 оны 2 дугаар сарын 15-ны байдлаар 62,63 сая га талбайг хамарсан 4447 хайгуулын, 160,68 мян. га уулын эдэлбэр бүхий 842 ашиглалтын нийт 5290 хүчин төгөлдөр лицензээр 62,79 сая га талбай олгосон нь нийт нутаг дэвсгэрийн 40,15% болж байна. Нэг талаас алт олборлох зөвшөөрлийн эрэлт их өндөр, нөгөө талаас алтны уурхайн нөхөн сэргээлтийн стандарт 2000 онд батлагдсанаас хойш нилээд хугацаа өнгөрсөн, аж ахуйн нэгж төдийгүй хувь хүмүүс хууль бусаар алт олборлох нь ихэссэн зэргээс үүдэн газар ашиглалт, нөхөн сэргээлт

илүү тулгамдсан асуудал болж байна. Иймээс төрийн болон орон нутгийн зүгээс тавих хяналт, шаардлагыг сайжруулах, ачаалал нэгэнт ихтэй болсон болон нөхөн сэргээлт огт хийхгүй байгаа аж ахуйн нэгжүүдэд дахин лиценз олгохгүй байх хэрэгтэй.

Алт олборлолтын зах зээлд 30-100 гаруй мянган хүн байнгын болон улирлын чанартай ажиллаж байгаа бөгөөд түүний өсөлт болон зах зээлээс гадуурх борлуулалт Монголын эдийн засагт чухал нөлөөтэй байна. Гар аргаар олборлолт явуулах үйл ажиллагаа их хэмжээний хөдөлмөр шаардсан, технологийн хувьд хялбар, бага зардалтай учраас олон хүний хувьд амин чухал шийдэл болж байгаа юм. Хүн амын ядуу бүлгийн амьжиргааг хангаж байгаа ч эрх зүйн зохицуулалтын хүрээнээс гадуур, эрсдэл бүхий үйл ажиллагаа байгаль орчныг сүйтгэж, ажлын аюултай нөхцөл болон химийн хортой бодистой харьцаж байгаа зэрэг нь асуудал болсоор байна. Хууль бусаар алт олборлогчид болон ашиглалтын лиценз эзэмшигч нарын хооронд маргаан зөрчилдөөн ч гарсаар байна.⁷¹

⁷⁰ УСГ, 2007

⁷¹ 2001 онд Засгийн газраас энэхүү албан бус үйл ажиллагааг зохицуулах түр хугацааны журам боловсруулан ашигт малтмалыг гар аргаар олборлох үйл ажиллагааг зохицуулах оролдлого хийсэн. Гэхдээ энэ журам нь үр дүнгүй, амьдралд хэрэгжих боломжгүй болох нь батлагдаж, жилийн дараа хүчингүй болж дахин шинэчлэгдээгүй.

Уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “...эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх замаар экспортын чиг хандлагатай уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэнэ” хэмээн тусгагджээ. Өнөөдөр 2007 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд хайгуул, ашиглалтын 48.3 сая га талбайг хамарсан 5000 орчим тусгай зөвшөөрөл байгаа бөгөөд үүнээс 387.6 мянган га талбайд 1081 ширхэг ашиглалтын лицензээр уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байна.

Гэсэн хэдий ч өнөөдөр энэ салбарт тулгамдсан, шударга бус өрсөлдөөнтэй холбоотой асуудал нилээд бий. Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд 2006 оны байдлаар 80 гаруй төрлийн ашигт малтмалын 1170 орд бүртгэлтэй байдаг хэдий ч алт, зэс, молибден, хайлуур жонш гянтболд, нүүрснээс бусад нь аж ахуйн эргэлтэд ороогүй байна.

Ашигт малтмалын тухай хуулиар Монгол улсын бүх ашигт малтмал, байгалийн эрдэс баялгийг улсын баялаг гэж үздэг. Олборлох, эсвэл хайгуулын лиценз авсан тохиолдолд анх авсан компани түүнийг өөр компанид худалдаж болдог. Энэ үйл ажиллагааг 1997 онд баталсан “Ашигт малтмалын тухай” хуулиар зохицуулдаг.

1997 оны ашигт малтмалын тухай хууль нь салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг урамшуулахад анхаарсан хэдий ч хяналтыг хэт сул тавьж, итгэл хүлээх чадваргүй, эрсдэлтэй орчин бий болжээ.

Тус зах зээлийн эрэлт, нийлүүлэлт нь үнээр зохицуулагдах бус, хайгуулын лицензийг олгохдоо “хамгийн түрүүнд” лиценз эзэмших зөвшөөрлийн материалыг бүрдүүлж ирсэн аж ахуйн нэгж, хувь хүнд олгох зарчмаар явагдсан нь хөрөнгө, мэргэжил, технологийн бэлтгэлгүй этгээдүүдийн гарт энэ зах зээлийг өгсөн. Уул уурхайн салбарт анхнаасаа шударга өрсөлдөөний аргаар бус, захиргааны аргаар хуваарилах зарчим зонхилж, газартай ижил гажуудалтай зах зээл үүсч, дамлан худалдах явдал, авилга, лицензийн хууль бус наймаа газар авсан. Лицензийн худалдаа жинхэнэ зах зээлийн үнээр зарагдахгүй байгаа учраас улс тэр орлогыг алдаж, улмаар улс ихээхэн хэмжээгээр хохирч байна.

Монгол улсын газар нутгийн ихээхэн хэсэг нь хайгуулын лиценз хэлбэрээр гадаадын компаниудын мэдэлд байдаг тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярих болсон. Ихэнх лиценз эзэмшигчид орд газрыг бие даан аж ахуйн эргэлтэд оруулах

Хүснэгт 4.2. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт ба шинээр олгогдсон лицензийн тоо, 1997-2004

	1997-2000	2001	2002	2003	2004
Хайгуулалтын ажилд зарцуулсан хөрөнгө (сая.ам.дол)	23.3	4.8	20.6	35.3	-
Уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө (сая.ам.дол)	39.7	41.6	33.2	33.0	38.4
Газрын тосны хайгуул, олборлолтын ажилд оруулсан хөрөнгө (сая.ам.дол)	72.3	8.5	11.6	13.0	10.6 ¹
Шинээр олгосон лицензийн тоо	2180	1152	1283	1433	2325
Талбайн хэмжээ (сая.га)	29.7	8.7	23.7	17.3	31.5

Эх үүсвэр: Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газар, 2004

хөрөнгө санхүү, техник, мэргэжилтний чадавхигүйгээс лицензийг зөвхөн арилжааны үйл ажиллагаанд ашиглах, тухайлбал дамжуулан худалдах, зээлийн баталгааны хэрэгсэл хэлбэрээр ашиглахыг эрмэлзэх болсон. Хайгуулын лицензтэй холбоотой зах зээл нь ихээхэн нууц, хууль бус үйл ажиллагааг агуулсаар байна. Үүнээс гарах арга зам нь лицензийн дуудлагын худалдаа юм. Тус салбарт дуудлагын худалдаа сүүлийн жилүүдэд маш цөөхөн явагдсан байна /Хүснэгт 4.2/.

4.3. «ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ» ХУУЛИЙН ТУХАЙ

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш олон улсын байгууллагууд манай Засгийн газарт зах зээлийн нөхцөлд бараа үйлчилгээ худалдан авах процесс хэрхэн явагдах ёстой талаар нилээд их зөвлөлгөө өгч тусалсан.

Нэгэнт татвар төлөгчдийн мөнгөөр маш их хэмжээний ажил, бараа авч байгаа болохоор 1-рт, төсвийн буюу татвар төлөгчдийн мөнгийг хэмнэх, 2-рт, төсвийн байгууллага, төрийн үйлчилгээнд хамгийн чанартай болон хямд үнээр бараа үйлчилгээг авах хэрэгтэй тул олон улсын практикт аль болохоор олон компаниудаас санал авах, тендэрийн үйл ажиллагааг нээлттэй, шуурхай болгох, нийлүүлэгч нарын дунд өрсөлдөөнийг бий болгох зорилгоор тендэрийн электрон холбооны системүүдийг хүртэл суурилуулсан байдаг.

Энэ бол зөвхөн засгийн газрууд бус, аливаа барааг авахдаа хамгийн оновчтой сайн нийлүүлэгчийг олохын тулд томоохон корпорациуд хүртэл хэрэглэж байгаа B2B (business to business) системүүд юм.

Тендэрийн гол санаа нь барааг худалдан авах зах зээл буюу засгийн газрын зах зээлд өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжихэд оршиж байгаа бөгөөд тендэрийг электрон маягаар хийвэл ажлыг улам үр өгөөжтэй болгодог.

Монгол улсын Засгийн газрын худалдан авах ажиллагаа *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”* хуулийг үндэслэн хийгдэх ёстой. Уг хуулийн гол зорилт нь *“төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад”* оршдог.

Зарчмын хувьд худалдан авах үйл ажиллагаа төвлөрсөн бус хэлбэртэй байгаа бөгөөд Засгийн газрын байгууллагуудын хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээг төвлөрүүлэн худалдан авч өгдөг тусгай байгууллага, алба ажиллахгүй гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл, төрийн болон орон нутгийн хөрөнгийг захиран зарцуулж, ашиглаж буй захиалагч байгууллагууд холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагаагаа өөрсдөө хэрэгжүүлж, зохион байгуулах үүрэгтэй бөгөөд худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэгч нь аль ч тохиолдолд захиалагч байгууллага байх юм.

Тендэрийн объектууд одоо 5000 орчим байгууллага байгаа бөгөөд төрийн болон орон нутгийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулинд зааснаар захиалагч нь бүх шатны төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, төсөвт байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан үйлдвэрийн

газрууд байгаа юм. Тендэрийн хэмжээ, цар хүрээнээс шалтгаалан Засгийн газар, яам, агентлагууд, аймгийн болон сумын захиргаа, төсвийн байгууллагууд өөрсдөө тендэрийг хэрэгжүүлнэ гэсэн үг. Энэ бол асар их хэмжээний мөнгө, хөрөнгийн асуудал учраас үүнийг хуулиар зохицуулах шаардлага зах зээлд шилжиж эхэлсэн үеэс мэдрэгдсэн.

Тендэрийн хууль ба түүний хэрэгжилт

Монголд анхны тендэрийн хуулийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль” гэсэн нэртэйгээр боловсруулсан бөгөөд тус ажилд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк тусламж үзүүлж, Улсын Их Хурал 2000 оны 4-р сард баталсан билээ. Анхнаасаа тус ажлыг Азийн хөгжлийн банк хариуцаж, хоёр ч удаа санхүүжилт гаргасан. 2002 онд тендэрийн үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй болгохын тулд олон улсын байгууллагууд тендэрийн үйл ажиллагааны вэб хуудас, программыг суурилуулахад техникийн туслалцаа үзүүлжээ.

Тус хуулинд тендэрийн хэрэгжилт, баримт бичгийн бүрдүүлэлтийн стандартууд, экспертүүдийн сонголтын шалгуур зэрэг олон зүйлийг багтааж, төрөөс барааг худалдан авах явцыг нилээд цэгцэлсэн. Хуулиар тендэрийн шалгаруулалтын эрх мэдлийг салбаруудын яамдад биш, Сангийн яаманд төвлөрүүлсэн.

Тендэр шалгаруулах ажлыг зохион байгуулахын тулд 2000 оны 6-р сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдааны 30 дугаар тэмдэглэлд заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалт хариуцсан нэгжийг Сангийн яамны үндсэн бүтцэд багтаан байгуулж, “худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд шууд оролцохгүй, харин хэрэгжүүлэгч засгийн

газрын байгууллагуудыг мэргэжлийн арга зүй, шаардлагатай журам заавраар хангаж, тэдгээрийн гэрээ байгуулах үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, журам зааварт нийцэж байгаа эсэхэд хяналт тавих” үүргийг өгсөн. Хэдийгээр тус нэгж тендэрийн үйл ажиллагаанд шууд орохгүй гэж заасан байсан боловч практик дээр тендэрийн үйл ажиллагаа тус нэгжид төвлөрсөн. Тус нэгжийг Сангийн яамны бүтцэд оруулах тухай олон улсын байгууллагууд санал болгож байсан нь тендэрийн агентлагын бие даасан, хараат бус байдлыг анхнаасаа үгүйсгэсэн.

2001 онд тус нэгжийг Сангийн яамны хэлтэс болгосон бөгөөд 2004 онд түүний статусыг дахин өөрчилж, Сангийн яамны “Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газар” болгож, сайд болон яамны төрийн нарийн бичгийн даргын мэдэлд шилжүүлж, завсрын шат дамжлагыг багасгасан.

Тендэрийн үйл ажиллагааны гол чиглэлийг тус газрын хувьд дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

- Засгийн газрын худалдан авах ажиллагааны урт болон дунд хугацааны бодлогыг тодорхойлох;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоог бий болгон бэхжүүлэх;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоог бий болгож, худалдан авах ажиллагааны бодлого, үндсэн зарчмыг олон улсын хөгжлийн чиг хандлага, өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан сайжруулах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил түүнтэй холбогдон гарсан тогтоол, бичиг баримтыг боловсронгуй болгох, санал боловсруулах;

- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгоход мөрдөх олон улсын жишигт нийцсэн бичиг баримтуудыг бий болгох;
- Монгол улсад шинээр нэвтрүүлж буй Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор олон улсын банк, санхүүгийн байгууллага, бусад орнуудын ижил төстэй нэгжүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Бодлогын хэрэгжилтийг зохицуулах буюу худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хууль болон түүнийг дагалдаж гарсан бусад эрх зүйн баримт бичиг, заавар журам, тендэрийн жишиг бичиг баримтыг улсын хэмжээнд нэгдсэн журмаар мөрдүүлж хяналт тавих.

Түүнчлэн худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллага, ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; сурталчилгааг зохион байгуулах, боловсон хүчин бэлтгэх зэрэг үүрэг, чигийг заасан. Тэгэхээр тус нэгж маш их хэмжээний ажлыг гүйцэтгэх ёстой болсон нь тодорхой байгаа юм.

Сүүлийн жилүүдэд Монгол төрийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувь маш эрчимтэй өсч эхэллээ. 2005 онд Монгол улсын төсвийн нийт хэмжээ 800 тэрбум төгрөг байсан бол 2008 онд төлөвлөж байгаа хэмжээ 2.4 триллион төгрөг болж, 3 жилийн дотор төсвийн орлого гурав дахин нэмэгдэж байгаа нь олон талын эерэг болон сөрөг үзэгдлүүдийг бий болгох аюултай байна.

Монголын төр маш их хэмжээгээр бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч байна. 2006 онд Монгол улсын төсвийн зарлага 1 триллион 228 сая төгрөгт хүрч, өмнөх жилээс 60%-иар буюу 484 тэрбум төгрөгөөр өсчээ. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүнд бараа, үйлчилгээний зардал 56.2%, үүний дотор цалин 15.9%, бараа, үйлчилгээний бусад зардал 40.3%, зээлийн үйлчилгээний төлбөр 1.5%, татаас, шилжүүлэг 22%-ийг тус тус эзэлж байна⁷² /Зураг 4.2/.

1991 онд зах зээлийн шилжилт эхлэхээс өмнө төсвийн зарлага/ДНБ-ий харьцаа 60%-тай тэнцэж байсныг 45% хүртэл бууруулж, зах зээлийн шилжилтийн 15 жилийн дотор энэ харьцаа дунджаар 36.9% болсон.


Үүнийг нарийвчлан авч үзвэл, 1992-1996 онуудад төсвийн зарлага/ДНБ-ий харьцаа дунджаар 27%, харин 2000-2003 онуудад 40 гаруй хувь байсан боловч 2004, 2005 онуудад харьцангуй багассан. Төсвийн зарлага/ДНБ-ий харьцаа эргээд 2006, 2007 онуудад 38% орчим болж өссөн бөгөөд 2008 оны байдлаар социализмын үетэй ойролцоо буюу 45%-д хүрэхээр төлөвлөгдөж байна.

ННФ-ын хийсэн судалгааны ажилд “2005 онд Монгол улсын нийт төсвийн орлогыг 708.2 тэрбум төгрөгөөр, төсвөөс зарцуулах зарлагын доод хэмжээг 775.1 тэрбум төгрөгөөр тооцон баталжээ. Түүний багагүй хэсэг нь төрийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд зарцуулагдсан байна”, “нийт төсвийн 28 гаруй хувийг эзлэх хөрөнгө мөнгөний их урсгал арав гаруй жилийн турш ямар нэгэн зохицуулалтгүй шахам явж ирсэн”⁷³ гэж тэмдэглэжээ.

⁷² УСГ, 2006 оны 12-р сарын мэдээ

⁷³ Тендэр “түйтгэр” болон хувирах нь, О.Мөнхбат Доктор (Ph.D) МУИС. Нийгмийн Судалгааны Хүрээлэн, ННФ-ын нийтлэл, 2006

Зураг 4.2. ДНБ, төсвийн зарлага, төсвийн зарлага ДНБ-ий харьцаа, 1991-2008



Эх үүсвэр: УСГ, 2007

Хэдийгээр тендэрийн хууль батлагдан гарсан ч Монголд тендэрийн үйл ажиллагаа хуулийн дагуу бүрэн явагдаж чадаагүй. 2002 онд Дэлхийн банкнаас тендэрийн журмаар хэрэгжсэн хоёр төсөлд шалгалт хийж, төслийн хүрээнд байгуулсан найман гэрээний ихэнх нь тендэрийн хуулийн дагуу хийгдээгүй, зөрчилтэй байсныг тогтоожээ. Мөн 2003 онд 2001-2003 оны хооронд төрийн хөрөнгөөр бараа, үйлчилгээг худалдан авахаар байгуулсан дотоодын 1300 ажлын гэрээний 40% хуулийн дагуу хийгдээгүй нь тогтоогдсон. Сангийн яамны тендэрийн нэгжээс хийсэн шалгалтын явцад засгийн газрын үйлчилгээ, цагдаа, байгаль орчны салбарт өрсөлдөөнгүй буюу шууд захиалгаар хийгдсэн гэрээний хувь хамгийн өндөр байжээ.

2004 онд Үндэсний Аудитын газраас хийсэн шалгалтаар тендэрийн үйл ажиллагаанд маш олон зөрчил илэрчээ. Үүнд:

- “Аудитад хамрагдсан 19 байгууллагын 94,7% буюу 18 байгууллага тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээний жагсаалтыг гаргаж, нийтэд мэдээлээгүй, нийт худалдан авалтын 40,8% буюу 27,8 тэрбум төгрөгийг шууд гэрээ байгуулах болон гүйцэтгэгч байгууллагын нэхэмжлэхээр тус тус худалдан авсан.
- Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 16 дугаар тушаалаар тус яамны ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор орон сууц худалдан авахад зориулж, Баянгол дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан орон сууцны дөрвөн давхар барилгыг “Солонго бил” ХХК-аар 285.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсан.

- ХХААЯ 2,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шүлхийн вакцин, оношлуур нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендэрийг 2003 оны 1 дүгээр сард зарлаж, 2 дугаар сарын 20-нд гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч хугацаа бага гэсэн үндэслэлээр тусгайлсан тендэрээр шалгаруулахаар тендэрийн хороо шийдвэрлэсэн байна.
- Мөн ургамал хамгааллын бараа нийлүүлэх 244,8 сая төгрөгийн тендэр шалгаруулалтыг хугацааны өмнө нийлүүлэх шаардлагыг харгалзах гэсэн үндэслэлээр хязгаарлагдмал хэлбэрээр зарласан.
- ГЕГ-аас нээлттэй зарласан 33 тендэрийн урилга, бусад материалд тулгуурлан шалгаж үзэхэд шалгалтад хамрагдсан тендэрийн материалын 56.8% буюу 25 тендэрийн урилгад тендэр хүлээж авах эцсийн хугацааг хуульд заасан хэмжээнээс 4 – 25 хоногоор дутуу зарласан.
- Шуудан, цахилгаан холбооны газар нийт 14 бараа, ажил үйлчилгээнд нээлттэй тендэр зарласнаас 6 тендэрийн хороог урилгаа тараасны дараа байгуулсан, тендэр хүлээн авах хугацааг хуулийн дагуу зарлаагүй.
- Шуудан, цахилгаан холбооны газраас зарласан Говь-Алтай, Завханы чиглэлийн агаарын шилэн кабелийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Баянтуул амралтанд очиж, үнэлгээ хийхэд 310,0 мянган төгрөг зарцуулсан.
- Багануур ХК-д САТ-777D өөрөө буулгагч автомашинд зориулж, “Вагнер – Ази ТТ” ХХК-аас нийлүүлсэн хөдөлгүүрийн зарим эд анги удаа дараалан эвдэрч,

үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулснаас тус компанид 446.1 сая төгрөгийн хохирол учруулсан, тус компанид “Азотын бордоо нийлүүлэх” тендэрт шалгарсан “Эрчим-концерн” ХХК захиалагчтай байгуулсан гэрээний үүргээ 100% биелүүлээгүй байхад гүйцэтгэгчтэй ямар нэг хариуцлага тооцоогүй байна” гэсэн зөрчлийн тухай тэмдэглэсэн.

“Зууны мэдээ”, “Өдрийн сонин” болон “Өнөөдөр” зэрэг өдөр тутмын сонинд сард дунджаар 30 орчим янз бүрийн тендэрийн зар нийтлэгдсэн байна. Энэ баримтыг жилийн турш улсын хэмжээнд нийт 100.000 гаруй худалдан авах үйл ажиллагаа хийгддэг гэсэн тоотой харьцуулах юм бол тун ч бага дүр зураг гарна. УИХ-ын Тамгын газраас аваад Засгийн газар, яам, тэдгээрийн харьяа агентлаг, газруудын 33 вэб хуудсуудыг судалж үзэхэд 90-ээд хувьд нь төрийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авахтай холбоотой ганц ч зарыг олж үзсэнгүй” гэж ННФ-ын хэлэлцүүлгийн үеэр судлаачид тэмдэглэсэн байсан. Мөн “Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар гэсэн худалдан авагч томоохон субъектүүдийн вэб хуудсанд тендэрийн сураг ч алга. Бас тендэр зарласан ч бэлтгэх хугацаа өгөлгүй цаг хугацаагаар боох тул пүүс компани, хувь хүмүүс тендэрийн материалаа бэлтгэж чадалгүй хоцроход хүрдэг аж.”⁷⁴

Аливаа тендэрийг шударга явуулах анхдагч нөхцөл бол сонирхогч талуудыг үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээллээр жигд хангаж, ил тод нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх явдал юм. Гэтэл тендэрийг зохион байгуулах эрх үүрэг бүхий эрх мэдэлтнүүд төрийн хөрөнгөөр худалдаж авах бараа ажил,

⁷⁴ Тендэр “түйтгэр” болон хувирах нь, О.Мөнхбат Доктор (Ph.D) МУИС. Нийгмийн Судалгааны Хүрээлэн, ННФ-ын нийтлэл, 2006

үйлчилгээ болон үүнтэй холбогдуулан явуулж буй тендэрийн талаарх зар мэдээг нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод зарлахын оронд нуун дарагдуулах юм уу тендэрийн дуусах хугацааг тулгаж байж зарладаг нь гэм биш зан болов.

Тендэрийн шалгаруулалтад бас доголдолтой зүйлүүд харагдаж байна. Энэ их мөнгөний урсгалыг одоогийн байдлаар Сангийн яамны “Худалдан авах ажиллагааны бодлого зохицуулалтын газар” гэсэн тав хүрэхгүй ажилтантай, эрх мэдэл хязгаарлагдмал, гүйцэтгэх засаглалын шууд хяналтад байгаа ганц нэгж хянаж, зохицуулахыг оролдож байна.⁷⁵ Тендэрт шударга бусаар өрсөлдөж, улсын захиалгыг олон зуун сая, тэрбум төгрөгөөр авч буй байдалтай шударга бус өрсөлдөөний хориглох тухай хуулийн дагуу тэмцэх зайлшгүй шаардлагатай байгаа нь сүүлийн үед олон яамдын тендэрийн журам, явц хангалтгүй, хуулийг зөрчин явагдаж байгаагаас харагдаж байна.

Монголд 2006 онд тендэрийн хуулинд өөрчлөлт оруулж, 1 сая ам доллар байсныг 10 сая доллараас доош өртөгтэй тендэрт⁷⁶ гадаадын компаниудыг оролцохыг хориглож, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.6-д “Улсын төсвийн хөрөнгөөр барьж байгуулах авто зам, эрчим хүчний төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа

эрхэлдэг дотоодын нийт аж ахуйн нэгжүүдийн хүчин чадалтай тэнцүү буюу түүнээс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар жишиг үнийг үндэслэн гүйцэтгэгчдийг шууд сонгох шаардлагатай” гэж үзсэн бол “шууд гэрээ байгуулж болох тухай” заалтыг нэмж оруулсан.⁷⁷

Мөн аливаа байгууллага жилд зургаан удаа тендэрт оролцоод гуравт нь ялсан бол энэ хугацаанд дахин оролцох эрхгүй болох зохицуулалтыг хүчингүй болгосон байна. Энэ нь тухайн байгууллагын тендэрт оролцох эрхийг нээж, хамрах хүрээг нь өргөжүүлж буй явдал ажээ.

Тендэртэй холбоотой сүүлийн саруудад хэвлэлд нийтлэгдсэн зарим мэдээллийг дурдъя.

- Зууны мэдээ сонинд ”2006 оны 5 дугаар сарын 26-ны өдөр тендэрийг нээж, үнийн саналыг дуудаж байхад С.Отгонбаяр сайд аман шийдвэр өгч, тендэрийг зогсоосон. Тухайн үед тендэр шалгаруулалтыг хүчингүй болгох, зогсоох үндэслэлгүй болохыг Сангийн яамнаас албан бичгээр сануулсаар байхад хүчингүй болгосон. Энэ нь түрүүчийн тендэрт орсон

⁷⁵ Тендэр “гүйтгэр” болон хувирах нь, О.Мөнхбат Доктор (Ph.D) МУИС. Нийгмийн Судалгааны Хүрээлэн, ННФ-ын нийтлэл, 2006

⁷⁶ **Хуучин мөрдөж байсан заалт**
9.2. Захиалагч нь 1,000,000,001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий тендэр шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно.
Одоо мөрдөж буй заалт
9.2. Захиалагч нь 10,000,000,001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 100,000,001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендэр шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно.

⁷⁷ 14 дүгээр зүйл. Ерөнхий нөхцлийг магадлах

Хүчингүй болгосон заалт

14.2. Өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр тухайн жилд зарлагдсан тендэр шалгаруулалтад хуулийн этгээд зургаагаас дээшгүй удаа оролцож болох бөгөөд үүнээс гурван удаад тендэр нь шалгарсан бол тухайн жилд дахин тендэр шалгаруулалтад оролцохыг хориглоно.

/Төслийн анхны хувилбараар хуулийн этгээд тухайн жилд 10-аас дээшгүй удаа тендэр шалгаруулалтад оролцож, зургаад нь ялсан бол хэмээн өөрчлөхөөр ярьж байсан юм/

34 дүгээр зүйл. Гэрээ шууд байгуулах арга

Нэмсэн заалт

34.1.6. Улсын төсвийн хөрөнгөөр барьж байгуулах авто зам, эрчим хүчний төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын нийт аж ахуйн нэгжүүдийн хүчин чадалтай тэнцүү буюу түүнээс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар жишиг үнийг үндэслэн гүйцэтгэгчдийг шууд сонгох шаардлагатай гэж үзсэн бол.

34.4. Энэ хуулийн 34.1.6-д заасан гүйцэтгэгчдийг шууд сонгох төслийн жагсаалтыг Засгийн газар батална.

компаниудын үнийн саналыг ил болгох, дахин оролцох бололцоог хааж, өөрт орлого оруулдаг компаниудаа шалгаруулах нөхцлийг бүрдүүлсэн. 2006 онд зарласан тендэрийн 5 дугаар багцад гал сөнөөгчийн хорт утаанаас хамгаалах баг, дагалдах хэрэгслийн хамт нийлүүлэхээр 6 аж ахуйн нэгж оролцсоноос хамгийн үнэтэй буюу 149,5 сая төгрөгийн санал ирүүлсэн "Эйч энд Эйч" компанийг шалгаруулсан.⁷⁸

- “Холбооны техник, хэрэгсэл бэлтгэх тендэр зарлахад өмнө нь энэ чиглэлээр ажиллаж байсан туршлагатай дөрвөн аж ахуйн нэгж материалаа ирүүлжээ. Зарлагдсан хугацаанд дээрх аж ахуйн нэгжүүдийн материалыг сайд С.Отгонбаярын томилуулсан Г.Сугарбат хууль зөрчин задалж, тухайн вед хамгийн бага үнийн саналтай байсан "Их бүрэн" ХХК-ийн материалыг судалж, дахин тендэр зарлахдаа хэзээ байгуулагдсан нь тодорхойгүй, өмнө нь ийм төрлийн тендэрт оролцож байгаагүй "GTL"ХХК-ийг шалгаруулсан бөгөөд уг компанитай холбооны хэрэгсэл нийлүүлэх гэрээ байгуулахдаа анхны үнийн саналаа 10 сая төгрөгөөр өсгөж, "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг ноцтой зөрчсөн байна”.⁷⁹
- Замын салбарт 2007 онд гадаад, дотоодын 100 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийнэ. Үүний 32 тэрбум төгрөгийн барилгын ажлыг замын компаниудтай шууд гэрээ байгуулж ажиллана гээд Засгийн газраас замын, болон түлш, эрчим

хүчний салбарт шууд гэрээ байгуулах объектуудын жагсаалтыг баталсан.⁸⁰

- Түлш, эрчим хүчний яам 68 тэрбумын төгрөгийн 59 объектын барилгын ажлыг эрчим хүчний компаниудтай шууд гэрээ байгуулан ажиллах болсон,⁸¹
- 2007 оны дөрөвдүгээр сарын 18-нд Түлш, эрчим хүчний яамнаас зарласан тендэрт 8900 нарны зай нийлүүлэх тендэрт тус компани оролцжээ. Тендэрт оролцсон 13 компаниас “Бодь электроникс” хамгийн бага үнээр буюу нэг нарны цахилгаан үүсгүүрийг 308 ам.доллараар нийлүүлэх санал тавьсан аж,⁸² Гэтэл ТЭХЯ-наас тендэрийн шийдвэрийн хугацааг хойшлуулж, “Бодь электроникс”-ийн гэрээ байгуулсан үйлдвэрт яамнаас хүн томилон техник үзүүлэлтийн шалгалт хийхээр болжээ. ТЭХЯ болон уг тендэрт 340 ам.долларын үнийн санал тавьсан “Баян констракшн” ХХК-ийн төлөөлөгчид дээрх үйлдвэрт очоод ирсний дараа “Бодь электроникс” компанид яамнаас “Танайх техник үзүүлэлтээр тендэрт тэнцсэнгүй” гэсэн хариуг өгчээ. “Баян констракшн”-ийг судалж үзэхэд найман хүний бүрэлдэхүүнтэй, Монголд нэг ч байшин босгоогүй атлаа ТЭХЯ-ны 20 орчим тэрбум төгрөгийн тендэрийг авсан байна. Хууль зөрчин шударга бус болсон уг тендэрийн талаар “Бодь электроникс” компани Нийслэлийн захиргааны шүүхэд хандаад байгаа бөгөөд 8900 нарны зайн тендэрийн шийдвэрийг цуцлуулах зорилготой аж. Хэвлэлийн хурлын үеэр “Бодь

⁷⁸ Зууны мэдээ Огноо: 2007-08-14

⁷⁹ Зууны мэдээ Огноо: 2007-08-14

⁸⁰ Өнөөдөр, Тендэр буюу яамдын хүнд суртал, Д.Бэхээ (2007-03-23)

⁸¹ Өнөөдөр, Тендэр буюу яамдын хүнд суртал, Д.Бэхээ (2007-03-23)

⁸² Өнөөдөр, “Тендэрийг хэдхэн компани хувааж авдаг”, Б.Наран (2007-08-09)

электроникс”-ийн удирдлага мэдэгдэхдээ: “Ер нь зөвхөн энэ салбар ч биш. Засгийн газраас зарласан бүх тендэрийг нэр бүхий хэдхэн компани хувааж авдаг” гэсэн юм.

Энэ бүх дээр дурьдсан үйл ажиллагаа хуулинд заасан “худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх

зарчмыг баримтална” гэсэн заалтыг хамгийн ичгүүргүй, бүдүүлэг байдлаар илт зөрчиж, олон улсын байгууллагуудаас өгсөн олон сая доллараар бий болгосон төрийн худалдан авалтын системийг бүрмөсөн утгыг нь алдагдуулж, төсвийн хөрөнгийг дураар нь хувааж идэх бололцоог одоогийн төр баригчдад олгосон явдал болж байгаа юм.

БҮЛЭГ 5.

Дүгнэлт, зөвлөмж

1990 оноос хойш Монгол улсад зах зээлийн өрсөлдөөний орчин бий болж эхэллээ. Зах зээлийн эдийн засагт шилжээд 17 жил болж байгаа өнөө үед Монголын зах зээлийн соёлжсон өрсөлдөөний өөрийн орчинг төлөвшүүлэх хурц шаардлагатай тулгарлаа. Энэ нь манай улсын нийгэм эдийн засгийн нөхцөлд тохирсон, нөгөө талаас зах зээлийн зохицуулалтын дэлхийн тэргүүний туршлага, дадлагыг агуулсан зах зээлийн тогтолцоотой байх шаардлагатай болсныг харуулж байгаа юм.

1990 оноос хойш 2000 он хүртэл эдийн засгийн бодлогын гол анхаарал нь зах зээлийн шилжилтийг амжилттай эхлүүлэх, шилжилтийн хямралыг даван туулах, зах зээлийн механизм, орчинг бүрэлдүүлэх, ОУВС болон Дэлхийн банкны зааврын дагуу макроэдийн засгийн тогтворжуулалтыг бий болгох, инфляцийг бууруулах, улсын өмчийг хувьчлахад чиглэгдэж ирсэн. Энэ нь тухайн үеийн яах аргагүй хамгийн тулгамдсан асуудлууд байсан.

2000 оноос хойш гадаад зах зээлийн нөхцөл байдлын нөлөөгөөр эдийн засгийн байдал аажмаар сайжирч, зах зээлийн эдийн засгийн гол бүрэлдэхүүн хэсгүүд бий болсноос хойш эдийн засгийн

өсөлтийг ханган, ядуурлыг бууруулах⁸³ асуудал тавигдсан. Энэ үеэс эхлэн төсөв, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох, төрийн өмчийн байгууллагууд, үйлдвэрүүдийн менежмент, хяналтын системийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх асуудлууд тавигдах болсон. Иймээс нийгмийн бодлого, ядуурлыг бууруулах асуудал, ажилгүйдлийг бууруулах болон эдийн засгийн өсөлтөөр дамжуулан нийгмийн асуудлуудыг хэрхэн шийдэх тал руу бодлого боловсруулагчид, хандивлагчдад, олон улсын байгууллагуудын болон олон нийт, нийгмийн анхаарал илүү чиглэгдсэн.

Зах зээлийн эдийн засгийн орчин бүрэлдэж, зах зээл өөрөө эрчимтэй хөгжин, эдийн засаг өндөр хурдацтай өсч байгаа өнөө үед зах зээлийн үйл ажиллагааг хэвийн болгох, зардал чирэгдэл багатайгаар хөгжүүлэхийн тулд одоогийн нөхцөл байдлыг бодлого боловсруулагчдын анхаарлын төвд оруулах шаардлагатай болж байна,⁸⁴ Гол асуудал нь зах зээлийн эдийн

⁸³ Монгол улсын эдийн засгийн өсөлтийг бий болгох, ядуурлыг бууруулах бодлогын баримт бичиг, 2003

⁸⁴ Сүүлийн үед олон улсын байгууллагууд үүнд анхаарлаа хандуулж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдийн хамгийн нөлөөтэй судалгааны нэг, Дэлхийн банкаас гаргадаг бизнесийн орчны хөгжлийн Doing Business судалгаа нь эдийн

засгийн хамгийн суурь ойлголт болох чөлөөт өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих явдал юм.

Зах зээлийн эдийн засагт шийдвэрээ зөв гаргахын тулд зөв мэдээ, мэдээлэл асар ач холбогдолтой болж, мэдээлэл нь зах зээлийн хэвийн үйл ажиллагааны голлох нөхцлүүдийн нэг болж байна. Зөвхөн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зах зээлийн тухай биш, хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөн, хөрөнгийн зах зээл, тэр дотроос үнэт цаас, газар ба үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн өрсөлдөөн, улмаар олон улсын ийм төрлийн зах зээлүүдийн талаарх мэдлэг, чадвар, туршлагыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ бий боллоо.

Шударга бус өрсөлдөөн нь эдийн засгийг ялзрал руу хөтөлж байна. Үүний шалтгаан нь:

- Эрх зүйн орчин болхи;
- Хууль дүрэм биелүүлэх хариуцлага сул;
- Зах зээлийн дэд бүтэц бүдүүлэг;
- Бизнес-төрийн сүлбээ хавтгайрсан;
- “Ченж” хэмээх панзчид зах зээлийг эзэлсэн;
- Иргэний нийгмийн нөлөө сул;
- Зүй ёсны монополиудыг хянах механизм үгүй;
- Төрийн бодлогын алдаа нь монолиудыг дэвэргэж байна;
- Дотоодын монополиуд гадаад монополиос хараат байна.

5.1. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Монголын эдийн засгийн эрх чөлөөний өнөөгийн байдал, зах зээлийн өрсөлдөөн болон түүний зохицуулалтын хөгжил, сонгосон салбаруудын өрсөлдөөний өнөөгийн байдлыг судалж, дараах дүгнэлтүүдийг гаргаж байна. Үүнд:

Эдийн засгийн эрх чөлөөний хүрээнд:

- Монголын эдийн засгийн эрх чөлөөний байдал, бизнесийн орчны хөгжлийг 2005-2006 оны Фрейзерийн эдийн засгийн эрх чөлөөний индекс болон бусад судалгаанаас харахад нийт дүнгээр төдийлөн дорвитой өөрчлөлтгүй байна. Бизнесийн салбарт манай улсын зарим үзүүлэлтүүд нь дэлхийн болон Ази Номхойн далайн бүс нутгийн хэмжээнд нилээд дээгүүр үнэлэгдсэний зэрэгцээ 2007 оны 1-р сараас татварын багц хуулинд томоохон өөрчлөлт хийж, татварын дарамтыг ихээхэн бууруулсан зэрэг нааштай өөрчлөлтүүд хийгдэж байна.
- Манай улсад бизнесийн орчин, засаглалыг сайжруулах, ил тод болгох талаар зарим нэг алхмууд хийгдэж, ирэх онуудын бизнесийн орчны олон улсын үнэлгээ сайжрах найдвар байгаа боловч засаглалын хүрээнд манай улсын үнэлгээ буурсаар байгаа нь түгшүүртэй мэдээ юм.
- Манай улс авилгаас цэвэр байх байдлын түвшингээр хамгийн доогуур оноотой байна. Монгол улс “Авилгатай тэмцэх газар” болон “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар”-ыг байгуулж, авилга, шударга бус өрсөлдөөнтэй тууштай тэмцэж

эхэлсэн нь зөв алхам бөгөөд энэ хүрээнд дорвитой өөрчлөлт, үр дүн хүлээгдэж байгаа юм. Энэ нь манай нийгэм-эдийн засгийн хөгжлийн ирээдүйн гол төлвийг шийдвэрлэх алхмууд болж байна.

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

- Хуульд, тэр дундаа зах зээлийн шударга өрсөлдөөний хуульд өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт оруулахдаа нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийг харгалзан үзэж, хууль ба эдийн засгийг хослуулж хэрэглэх нь зайлшгүй болж байна. Шударга өрсөлдөөний зохицуулалтын эрх зүйн суурь тавигдсан ч эдийн засгийн талаасаа болон бодит хэрэгжилт хангалтгүй байна. Нийгмийн харилцаанд өмнө нь ажиглагдаж байгаагүй шинэ шинэ харилцааны хэлбэр илэрч байгаа болохоор хүмүүсийн харилцааны онцлог асуудлыг хууль эрх зүйн хүрээнд шинэчлэн тогтоож, хүмүүсийн харилцааны ёс зүй, ёс суртахууныг зохицуулах арга механизм чухал болж байна.
- Албан ба албан бус институцийн орчныг сайжруулж, зах зээлийн өрсөлдөөнийг дэмжихэд албан хүч, албадлага зарим талаар шаардлагатай. Хувь хүний сонирхол зах зээлийн өрсөлдөөний тулгуур боловч нийгмийн харилцаанд оролцож байгаа болохоор тухайн хүн амьдралынхаа хэв маягийг зах зээлийн өрсөлдөөнт орчинд нийцүүлэх шаардлагатай болж байна. Тиймээс хүмүүсийн харилцааг зохицуулахад зайлшгүй дагаж мөрдөх харилцааны ёс зүйн норм, хэм хэмжээ байдаг бөгөөд тэдгээрийг тулган хүлээлгэхэд албан хүч, албадлага хэрэгтэй байна. Иргэний хуульд байх

зарим заалтыг эс тооцвол хариуцлага, гэм хор, гэрээ, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна. Магадгүй эдгээр асуудлуудыг зохицуулах бие даасан хууль ч батлагдах хэрэгтэй болов уу.

- Зах зээлийн шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах хууль бодит утгаараа бий болох шаардлага тулгарч байна.

Сонгогдсон салбаруудын зах зээлийн өрсөлдөөний тухайд:

- Зах зээлийн өрсөлдөөн үнэ, борлуулалтын хэмжээ, зах зээлийн хүрээ, чанар, үйлчилгээ зэрэг үзүүлэлтүүдээр илрэх нь хамгийн нийтлэг байна.
- Зах зээл дээр шинэ компани нэвтрэн ороход зардал өндөр, ажиллах хүч дутмаг, бусад компанийн зүгээс үзүүлэх дарамт, зохицуулалт их, зах зээлийн багтаамж бага, хэрэглэгчдийн татах хэцүү гэсэн бэрхшээлүүд голлон гарч байна.
- Демпинг, технологийн шинэчлэл, далд сүлжээ, хүчтэй зар сурталчилгаа явуулах, бүтээмжийн өсөлт, үнэ бууруулах, мэргэжилтэн, ажилтныг урвуулах, урамшуулал, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх зэрэг эрсдэлүүд нь өрсөлдөгчөөс хүлээж болох гол эрсдэлүүд болж байна. Мөн шударга бус өрсөлдөөн ихтэй, зах зээлийн багтаамж муу, хууль эрх зүйн орчин муу, санхүүгийн чадавхи муу, мэргэжилтэн хангалтгүй зэрэг нь зах зээл дээр оршин тогтнож, үйл ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс болж байна.
- Зах зээл дээр өрсөлдөөн нэмэгдсэнээр чанар сайжирна, үнэ буурна, бүтээгдэхүүний орлуулалт нэмэгдэнэ,

компанийн нэр хүнд өснө, барааны стандарт сайжирна, үйлчилгээ сайжирна гэсэн эерэг үр дагаврууд гарч байна.

- Зах зээлийн салбарууд үйлчилгээгээрээ ялгарах, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, үнийн бодлогоор голлон өрсөлдөж байна.
- Монгол улсын зах зээл дээр шударга бусаар өрсөлдөх явдал гарч байна. Шударга бус өрсөлдөөн нь зар сурталчилгаа, зах зээлийн хил хязгаарын хуйвалдаан, хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүргэх, эрх мэдэлтний шийдвэр зэргээр илэрдэг. Түүнчлэн зах зээл дээрх аж ахуйн нэгжүүдийн дунд үгсэн хуйвалдах явдал багагүй гарч байна.
- Шударга бус өрсөлдөөн бий болохоос сэргийлэхийн тулд хууль, эрх зүйн зохицуулалт сайн байх, хуулийн хэрэгжилт сайн байх, компани өөрөө бие даасан, чадвартай байх, бодлогын зохицуулалттай байх, төрийн оролцоогүй байх, бизнес улс төрөөс ангид байх хэрэгтэй.
- Нэгжийн дундаж зардал, өрсөлдөгчийн үнэ тогтоолт, хэрэглэгчийн худалдан авах чадвар, засгийн газрын зохицуулалт, нефть, шатахууны үнэ зэрэг нь үйлдвэрлэлийн нэгжийн зардлыг тогтооход нөлөөлдөг хүчин зүйлс болж байна.
- Хуулийн зүйл ангиудын уялдаа холбоо муу байгаа нь монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдал эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн өөрчлөлттэй уялдаж чадахгүй байгаагийн гол шалтгаан ажээ. Түүнчлэн тогтсон ёс заншил зах зээлийн өөрчлөлтийг

даган өөрчлөгдөж чадахгүй байгаа, дүрэм журам зохицуулалт муу байгаа зэрэг нь бас нэг гол шалтгаан гэж хэлж болохоор байна. Монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдлыг сайжруулахын тулд хуулийг сайн хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах, хуулиа засаж сайжруулах, хуулиа дээдлэх, ухамсар, хариуцлагыг өндөржүүлэх, бизнес улс төрөөс ангид байх нь зүйтэй.

Тендэр, уул уурхай, газрын зах зээлийн өрсөлдөөний тухайд:

- Нийгмийн бухимдлыг бий болгосон өөр томоохон асуудлууд бол уул уурхай, газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлүүд юм. Өнөө үед Монголын төр улсын хамгийн том худалдан авагч болсонтой холбогдуулан төрийн худалдан авалт манайх шиг жижиг зах зээлд олон талын сөрөг нөлөө үзүүлж байгаа юм.
- Газар, уул уурхайн салбарын зах зээлийн эрэлт, нийлүүлэлт нь үнээр зохицуулагдах бус, “хамгийн түрүүнд” лиценз хүсэж материал бүрдүүлсэнд олгох зарчмаар явагдсан нь шударга өрсөлдөөн явагдаагүй ирлээ гэж дүгнэхэд хүргэж байна. Газар, уул уурхайн салбарт анхнаасаа шударга өрсөлдөөний аргаар бус, захиргааны аргаар хуваариалах зарчим зонхилж, гажуу зах зээл үүсч, дамлан худалдах явдал, авилга, лицензийн хууль бус наймаа газар авчээ. Энэ нь эргээд Монгол улсад ихээхэн хохирол учруулж байна.

5.2. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Шударга өрсөлдөөнийг хөгжүүлэх нь Монголын өнөөгийн эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах, төрийн оролцоог оновчтой болгоход нэн чухал болж байна. Шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх нь төрийн эдийн засгийн бодлогын үндсэн зорилтуудын нэг бөгөөд тус үйл ажиллагааг эрчимжүүлэхийн тулд:

- *Шударга бус өрсөлдөөнтэй шийдэмтгий тэмцэх улс төрийн хүсэл, зориг.* Сүүлийн жилүүдэд Монголын улс төр, бизнес хоёрын хооронд эрүүл бус сүлжээ үүсч, зарим тохиолдолд бизнесийн бүлэглэлүүд улс төрд шууд оролцдог боллоо. Энэ нь эргээд төрийн үйл ажиллагаа, бодлогыг ихээхэн гажуудуулж байна. Тухайлбал, тендэрийн хуулинд хийгдсэн өөрчлөлтүүд эрчим хүч, барилгын салбарт шударга өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжихээс илүү төсвийн мөнгийг тодорхой бизнесийн бүлэглэлүүдэд ямар ч өрсөлдөөнгүй хуваарилах механизм болж, тендэрүүд явагдаж байгаа салбаруудад будлианууд байнга гардаг боллоо. Энэ нь шударга өрсөлдөөнийг төрөөс хангалтгүй дэмжиж байгааг, зарим нөхцөлд шударга бус өрсөлдөөнийг зориудаар бий болгож байгаагийн илрэл. Тиймээс төр засаг энэ явдалтай тууштай тэмцэж, түүнийг бодитой алхам, шийдэмгий арга хэмжээгээр олон нийтэд харуулах ёстой. Шударга өрсөлдөөнтэй нийгэмд нийгмийн сайн сайхан байдал хамгийн дээд цэгт байдаг. Үүний тулд нэгдсэн бодлоготой, дэс дараалалтай алхмууд шаардлагатай: засаг захиргааны соёлжсон, орчин үеийн нөхцөл, шаардлагад нийцсэн бүтцийг бий болгох, төр засгийн үйл ажиллагаанд тавих нийгмийн, олон нийтийн хяналтыг сайжруулах, монополиудын үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, хариуцлагыг нь тодорхой болгох, нийлүүлэлтийг зохиомлоор багасгаж дамлан худалдаалах буюу “ченж”-ийн үйл ажиллагааг хязгаарлахын тулд зах зээлийн механизмыг тууштай хөгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийн тулд зах зээлд нэвтрэн орох аливаа хиймэл саад тотгорыг арилгах, тусгай арга хэмжээ авах, зохицуулалтыг хийх, төрийн эрх мэдэлтнүүдийг бизнест оролцохыг хориглох, төрийн өмчийн үйлдвэрүүдэд улс төрийн нөлөөг байхгүй болгож, шударга өрсөлдөөний үндсэн дээр хамгийн сайн мэргэжлийн менежментийн багуудаар удирдуулах нь Монголын эдийн засаг дахь шударга өрсөлдөөнийг хөгжүүлэх болно.
- *Улс төр, бизнесийн холбоосыг зөв гальдралд оруулах.* Хэдийгээр дотоодын бизнесүүд өөрийн эрх ашгаа хамгаалан улс төрийн лоббиг явуулж байгаа нь бусад оронд байдаг үзэгдэл боловч олон улсын практикт: нэгдүгээрт, тус лобби нилээд замбараатай бөгөөд хяналттай байдаг, хоёрдугаарт, улсын, төрийн бодлого зөвхөн бизнесийн төлөө бус, нийт нийгмийн эрх ашгийг хүндэлсэн байх ёстой бөгөөд төрийн бодлого зайлшгүй ямар нэгэн байдлаар бизнесийн эрх ашгийг хөндөж, нийгмийн төлөө үйл ажиллагааг явуулахад шахалт үзүүлэх ёстой. Гэвч өнөөгийн манай эдийн засгийн бодлого бизнесээ энэ чиглэл рүү чиглүүлж чадахгүй байгаа юм. Уул уурхайн салбарт байгаль

орчныг хамгаалах, олборлолтын дараах нөхөн сэргээлтийн ажиллагаа туйлын хангалтгүй явагддаг, барилга, хот байгууламжийн хүрээнд хотын ерөнхий төлөвлөгөөний биелэлт замбараагүй болж, үүнээс маш их хохирол, зардал үүсч байгаа, маш олон салбарт зохицуулалт сул байгаа. Энэ бол өрсөлдөөнийг дэмжих хүрээнд ч ажиглагдаж байна. Бодлогын зохицуулалт төрийн шууд хийх ёстой үүрэгт ажил мөн бөгөөд үүний тууштай, оновчтой байдал нийгмийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх явцад ямар ч бизнесийн лобби байсан нийгмийн эрх ашиг нь хэзээд эцсийн зорилго байх ёстой.

Эрх зүйн зохицуулалт

1. Хуулийн агуулгын тухайд

Нэн түрүүнд өрсөлдөөний тухай **хуулийн нэрийг** өөрчилж, **агуулгыг** сайжруулснаар хуулийн зорилт, цаашилбал хуулийн хэрэгжилтийг үр дүнтэй болгох боломжтой.

2. Харилцан нийцэх, уялдаатай байх тухайд

Шударга өрсөлдөөний талаар хууль тогтоомжийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд шударга өрсөлдөөний тухай хуульд бусад хуулийг нийцүүлж, тэдгээрийн хоорондын уялдааг хангах, институцийн хувьд зохион байгуулалттай байх нөхцлийг хангах хэрэгтэй. Иймд компанийн тухай хууль, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, татварын тухай хуулиуд, тендэртэй холбоотой хуулиуд, зар сурталчилгааны тухай хууль, стандартчилалын тухай хуулийг шударга өрсөлдөөний хуультай нийцүүлэх шаардлагатай.

3. Шударга өрсөлдөөний ач холбогдлыг олон нийтэд таниулах, ойлгуулах тухайд

Шударга өрсөлдөөний нөхцлийг өөрийн улсад бүрдүүлэхэд аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй этгээд, төрийн байгууллагууд, олон нийтэд шударга өрсөлдөөний тухай хуулийг сурталчилж, өрсөлдөөний талаарх мэдлэг, ухамсрыг нь дээшлүүлэх хэрэгтэй.

4. Шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллагын эрх хэмжээг нарийн зааж өгөх, тэдэнд илүү эрх мэдэл олгох тухайд

Монгол улсын “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар”-ын үйл ажиллагааг нарийн зохицуулснаар түүний хараат бус байдлыг хангах төдийгүй үйл ажиллагаагаа үр дүнтэйгээр хэрэгжүүлэх баталгаа болно. Шударга өрсөлдөөний байгууллагын үйл ажиллагаа, мөн шийдвэрийг үр дүнтэй хийгээд бодит болгоход түүний шийдвэр гаргах журмыг ч анхаарах ёстой. Жишээ нь, аливаа нэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа шударга өрсөлдөөнд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргахад шийдвэрийг хамтарч гаргах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, зөвлөл, эсвэл хороо хамтарч шийдвэр гаргах бөгөөд тухайн хороонд хуульч, эдийн засагчид ажиллах нь илүү үр дүнтэй.

Шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах газар нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, Шударга бус өрсөлдөөний хянан зохицуулах газрын шийдвэрийг биелүүлэхийг шаардах, түүнийг биелүүлэх үүднээс хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах нь зүйтэй. Шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэхэд холбогдох хуулиасаа илүү тухайн зохицуулалтад нь нийцүүлж шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах үүргийг тодорхойлох хэрэгтэй.

5. Хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох тухайд

Монгол улсын хуулиар шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаа явуулснаар эрүүгийн хариуцлага ногдуулахааргүй бол захиргааны хариуцлага ногдуулна гэсэн. Баруун Европын орнуудад шударга өрсөлдөөний тухай хуулиас гадна шударга бус өрсөлдөөн явуулсны төлөө иргэний хуулиар хариуцлага ногдуулах талаар заасан. Мөн зарим улсад, хамгийн тод жишээ нь АНУ-д эрүүгийн хариуцлага ногдуулахыг заасан бөгөөд энэ нь гурван жилийн хугацаагаар хорих хүртэл ял байж болно гэсэн байдаг.

Манай улсын хувьд ихэнхдээ захиргааны шийтгэл ногдуулж, зарим тохиолдолд иргэний хэрэг үүсгэх гэхэд хуулиар шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын эрх мэдэл хязгаарлагдмал байх, нэхэмжлэгчийн эрхээс хамаардаг байна. Түүнчлэн захиргааны шийтгэлийн хэмжээ бага байна.

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллагын шалгах, мөрдөн байцаах эрхийг хэрэгжүүлэх үүднээс саад болж буй, эсвэл худал мэдээлэл өгч байгаа этгээдийг шийтгэх талаар шударга бус өрсөлдөөний эсрэг хуульд тусгах хэрэгтэй.

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, биелүүлэх тогтолцоог боловсронгуй болгох нь өнөө үед тулгамдаад байгаа асуудлын нэг юм. Иймд энэхүү ажлыг түргэн шуурхай, зохион байгуулалттайгаар, мөн бодитойгоор хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.

6. Хуулинд оруулах өөрчлөлтийн тухайд

Судалгааны явцад “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар”-ын удирдлага, ажилтнуудтай олон удаа уулзаж, санал бодлоо солилцсон бөгөөд удахгүй

өргөн барих Монгол улсын “Өрсөлдөөнийг хамгаалах тухай” хуулийн төсөлд судалгааны үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд:

1. Давамгайл байдалтай аж ахуйн нэгж гэж ямар аж ахуйн нэгжийг хэлэх вэ гэсэн шалгуурыг илүү дэлгэрэнгүй зааж өгөх;
2. Зүй ёсны монополь гэж ямар монополийг хэлэх вэ, төрийн өмчит байгаа нөхцөлд ямар байх вэ, мөн төрөөс олгосон тусгай зөвшөөрлийн монополь гэж ямар монополийг хэлэх вэ, эдгээрийн шалгуурыг зааж өгөх;
3. Монгол улсын одоогийн үйлчилж буй “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хууль шударга өрсөлдөөний талаарх зохицуулалтын эхний бүлэгт “Шударга өрсөлдөөнд харш гэрээ, хэлцэл байгуулахыг хориглох” гэсэн заалт оруулж, дараах үйлдлийг хориглох:
 - худалдах ба авах үнийг шударга бусаар шууд буюу шууд бусаар тогтоох болон бусад шударга бус худалдааны нөхцлийг тогтоох;
 - үйлдвэрлэл, зах зээлийн болон техникийн хөгжлийг хязгаарлах;
 - ижил төрлийн хэлэлцээрт худалдааны бусад оролцогчдод өөр нөхцөл бий болгож, тэднийг ялгаварлан гадуурхах, өрсөлдөх чадварыг нь бууруулах;
 - энгийн үед тухайн гэрээ, хэлэлцээрт нэмэлт үүрэг амлалт, нөхцлийг шаарддаггүй байхад нэмэлт нөхцлийг биелүүлснээр гэрээ байгуулахыг шаардах”.
4. Энэ бүлэгт “давамгайл байдлаа урвуулан ашиглах” гэсэн зохицуулалтыг оруулах:
 - худалдах ба худалдан авах үнийг шударга бусаар шууд буюу шууд

бусаар тогтоох болон бусад шударга бус худалдааны нөхцлийг тогтоох;

- *үйлдвэрлэл, зах зээлийн болон техникийн хөгжлийг хязгаарлах;*
- *ижил төрлийн хэлэлцээрт худалдааны бусад оролцогчдод өөр нөхцөл бий болгож, тэднийг ялгаварлан гадуурхах, өрсөлдөх чадварыг нь бууруулах;*
- *энгийн үед тухайн гэрээ, хэлэлцээрт нэмэлт үүрэг амлалт, нөхцлийг шаарддаггүй байхад нэмэлт нөхцлийг биелүүлснээр гэрээ байгуулахыг шаардах”.*

Энэ хэсэгт шударга өрсөлдөөнд харш гэрээ хэлцэл байгуулахгүй байх заалт хамаарахгүй байх нөхцлийг заах: “Шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах газар нь тодорхой хугацаанд энэхүү гэрээг байгуулахыг хориглох тухай заалтыг аль нэг аж ахуйн нэгжид хамааруулахгүй байхыг шийдэж болох бөгөөд үйлдвэрлэлийг сайжруулах, гадаадад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, барааны чанарыг сайжруулах, техник, технологийн хөгжлийг хангах” зорилготой байж болно.

5. Компанийн нэгдэх, нийлэх талаар. Монгол улсын өнөөгийн үйлчилж буй хуулиар компанийн нэгдэн, нийлэх талаар их бага заалт орсон байдаг. Иймд шинээр дараах үйлдлийг компаниуд нэгдэх, нийлэх гэж ойлгох :

- Нэг буюу хоёр компани нэгдэх;
- Аль нэг компанийн хяналтын багцыг эзэмшиж нэг буюу хоёр этгээд нь өөр нэг компанийн хяналтын багцыг худалдан авах, олж авах;

- Нэг буюу хоёр компани хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, шинээр компани байгуулах.

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар дээрх байдлыг судалж, зөвшөөрөл олгох журмыг тогтоох. Нэгдэн, нийлэх зөвшөөрөл олгохгүй байх үндэслэл нь *шударга өрсөлдөөнд харшаар нөлөөлөх гэсэн шалгуур байх ёстой. Энэхүү шалгуур нь нийлүүлэгч борлуулагчийн боломж, зах зээлд нэвтрэн орох боломж, тухайн шинээр бий болж буй аж ахуйн нэгжийн байр суурь, тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог* зэрэг байж болно.

6. Зүй ёсны монополийн үйл ажиллагааг зохицуулахдаа дараах үйл ажиллагааг төрөөс нэмж зохицуулах шаардлагатай:

- Нийлүүлж буй бараа, үйлчилгээний үнийн өсөлт;
- Гаргаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар;
- Энэ байдлаа алдах нөхцөл;
- Шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллагаас зүйл ёсны монополь байдалтай аж ахуйн нэгжид хийх шалгалт, түүний хувьд шийдвэр гаргах журам.

7. “Шударга бус өрсөлдөөний зохицуулалт” гэсэн 14-р зүйлийг “Шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааны зохицуулалт” гэж өөрчлөх.

8. Шударга өрсөлдөөний хянан зохицуулах газрын хувьд :

- Шударга өрсөлдөөний хянан зохицуулах газрын хараат бус байдлыг хуульчлах;
- Зөвлөлийн шударга бус өрсөлдөөний талаар шийдвэр гаргах журмыг батлах;

- Шударга өрсөлдөөний хянан зохицуулах газрын эрх мэдлийг: 1) компаниудын гэрээ, хэлцэл байгуулах болон давамгайл байдлаар урвуулан ашиглах талаар авах арга хэмжээ, 2) компаниуд нэгдэх талаар авах арга хэмжээ гэж хоёр хэсэгт хувааж, хянан зохицуулах газар нь хэрхэн шалгах, ямар шаардлага тавих зэргийг нь нарийн зааж өгөх;
 - Хянан зохицуулах газрын шалгах эрхийг зааж өгөх; (ямар үндэслэлээр, жишээ нь өөрийн санаачилгаар, өрсөлдөгчийн гомдлын үндсэн дээр гэх зэргээр зааж өгөх)
 - Шийдвэр гаргах журмыг нарийвчлах;
 - Хянан зохицуулах газрын шалгах эрхэд саад болоход ямар арга хэмжээ авч болох талаар зааж өгөх, (торгох байж болно)
9. Шударга өрсөлдөөний хуулийг зөрчигчдөд дараах төрлийн захиргааны хариуцлага ногдуулахаар зааж болно.
- Үйл ажиллагааг нь зогсоох;
 - Тусгай зөвшөөрлийг нь хураах;
 - Торгууль ногдуулах;
 - Тараах;
 - Торгуулийн хэмжээ нь одоогийн хуулиар аж ахуйн нэгжийн хувьд 250,000 мянга байдаг, иймээс тухайн аж ахуйн нэгжийн өмнөх жилийн нийт эргэлтийн 10 % хүртэл хувиар торгох гэж заах.
10. Шударга өрсөлдөөний хянан зохицуулах газрын үйл ажиллагаагаар тайлагнах журмын талаар нэмж дэлгэрэнгүй оруулах.
11. Шударга өрсөлдөөний хянан зохицуулах газрын шийдвэрийг давж заалдах журмыг зааж өгөх.
- ### Салбаруудын өрсөлдөөн
- Газар болон уур уурхайн салбарт: лиценз, зөвшөөрлийн олголт аль болохоор шударга өрсөлдөөний зарчимд тулгуурласан байдлаар зохион байгуулагдаж, эрэлтээс үүсч байгаа ашиг төрийн болон орон нутгийн төсвийн эх үүсвэр болох талд анхаарах хэрэгтэй. Иймээс газрын болон уул уурхайн лицензийн олголтыг нээлттэй, уралдаант байдлаар зохион байгуулах, газар олголтыг дүүргүүдийн мэдлээс гарган нэгдсэн газрын худалдаа, биржийг зохион байгуулах нь зүйтэй. Уул уурхайн салбарт лиценз олголтыг замбараатай, шалгууртай болгож, хүссэн хүн болгонд олгох бус, хөрөнгө оруулалт хийх, олборлолт явуулах чадвартай компанид өрсөлдөөнт замаар олгох үндсэн дээр лицензийн дамлан худалдах явдлыг зогсоох, лицензийн ченжүүдийн үйл ажиллагаанд саад тавих шаардлагатай.
 - Газрын тос, мах, ноос, сүүний салбарт биржүүдийг байгуулах зах зээлийн үйл ажиллагааг сонгодог хэлбэрт оруулах, үр өгөөжтэй зах зээлийг бий болгох шаардлагатай. Энэ салбарт цөөн тооны давамгайл байдалтай компаниуд, ченжүүдийн үйл ажиллагааг хязгаарлахын тулд тус салбарт бусад компаниуд, аж нэгжүүд чөлөөтэй нэвтрэн орох боломжийг бүрдүүлж өгөх шаардлагатай.
 - Нийтийн тээврийн салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зорчигчдын эрх ашгийг

хамгаалах бодлого чухал байна. Өрсөлдөөнийг хөгжүүлэхийн тулд тус салбарт шинэ операторуудыг оруулах, үйлчилгээний нийлүүлэлтийг өсгөх хэрэгтэй.

- Цахилгаан, дулаан үйлдвэрлэл, эцсийн үйлчилгээг үзүүлэх шатанд компани чөлөөтэй орох, хоорондоо өрсөлдөх, эцэст нь илүү чанартай бөгөөд хямд бүтээгдэхүүн бий болгохыг эрмэлзэх ёстой. Иймд дэд бүтцийн шинэтгэл хийх хэрэгтэй.

Тендэрийн үйл ажиллагаа

- 2006 онд тендэрийн хуулинд оруулсан нэмэлт заалтууд болох “...шууд гэрээний зөвшөөрөл”, “нэг компанид олон удаа

тендэрт оролцож, ялах боломж” зэрэг шударга өрсөлдөөнийг хязгаарласан заалтуудыг хориглох,

- Тендэрийг зохион байгуулж буй газрыг аль болохоор бие даасан байдалтай болгож, Сангийн яамны харьяаллаас гаргаж, статусыг нь өндөржүүлэх, түүний чадавхи, чадварыг сайжруулах,
- Тендэрийн үр дүн, тайланг олон нийтэд байнга зарлах,
- Аливаа тендэрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах,
- Тендэрийн комисст иргэний нийгэм, татвар төлөгчид, олон улсын байгууллагуудын төлөөлөгч нарыг оролцуулж байх ёстой.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Эрх зүйн баримт бичиг

Монгол улсын Үндсэн хууль, 1992 он

Төв банк, Монгол банкны тухай хууль, 1996 он

Банкны тухай хууль, 1996 он

Гадаад хөрөнгө оруулалтын тухай хууль, 1993 он

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001 он

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2003 он

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, 2000 он

Хоршооны тухай хууль, 1998 он

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, 2002 он

Валютын зохицуулалтын тухай хууль, 1994 он

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль,

Патентийн тухай хууль

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 2003

Газрын тухай хууль, 2003

Газрын төлбөрийн тухай хууль, 2003

Ном зүй

Adib Kanafani and Katsuhiko Kuroda, 2005, Global Competition in Transportation Markets: Analysis and Policy Making

Annual Report of the Japan Fair Trade Commission for FY2002. October 7, 2003, Japan Fair Trade Commission

ANTITRUST ENFORCEMENT IN THE MEAT PACKING INDUSTRY, U.S. Department of Justice, 2006

Bid Rigging. An Analysis of Corruption in Auctions, GESY, Yvan Lengwiler, Elmar Wolfstetter, 2005

Competition and policy in EU and UK, Mather M. Dabbah, Cambridge University Press, 2004

Economic Freedom of the World: Annual Report, The Fraser Institute, 2006, 2007

Economic Freedom: Prosperity and Social Progress, Jagdish Bhagwati, Keynote Speech delivered to the Conference on Economic Freedom and Development in Tokyo, June 17-18 1999.

Esfandiar Maasoumi, Stephen D. Prowse, Daniel J. Slottje, (2002). *Measuring market power in the steel industry*

Frank Bealey, 2001, Power in Business and the State: An Historical Analysis of its Concentration, Routledge Frontiers of Political Economy, 36

Gasoline Empirical Analysis, Competition Bureau, March 2005, Government of Canada

Global Competition in transportation markets, Adib Kamafani, Kathuhiko Kuroda, Elsevier, 2005

- Haimanti Bhattacharaya and Robert Innes. (2006). *Does market concentration promote or reduce new product introductions? Evidence from US food industry*
- J.A.Bikker and K. Haaf, (2000). *Measures competition and concentration in the banking industry: a review of the literature*
- J.A.Bikker and K. Haaf. (2000) *Competition, concentration and their relationship: An empirical analysis of the banking industry*
- Joaquin Maudos and Amparo Nagore. *Explaining market power differences in banking: a cross-country study*
- Korea Fair Trade Commission. (2005), *Annual Report on Competition Policy Development in Korea*
- Maher M. Dabbah, 2004, EC and UK Competition Law: Commentary, Cases and Materials
- Market Studies: A Review by the Competition Bureau, October 6, 2005, Government of Canada
- Masatoshi Kato and Yuji Honjo. *The stability of market leadership positions in Japanese manufacturing industries*
- Massimo Motta, 2004, Competition Policy: Theory and Practice
- Matthew D.Shapiro, (1987). *Measuring market power in US. industry*
- Merger Review Performance Report, The Competition Bureau, Government of Canada 2005
- Michael A. Crew and Menahem Spiegel, 2005, Obtaining the best from Regulation and Competition, Topics in Regulatory Economics and Policy
- Michael Beeman, 2002, Public Policy and Economic Competition: Change and Continuity in Antimonopoly Policy, 1973-1995, Nissan Institute Routledge Japanese Studies Series
- Michal S. Gal, 2003, Competition Policy for Small Market Economies
- Mongolia Country Procurement Assessment Report, 2003, World Bank,
- Mongolia Investment Climate Statement, 2007, USAID
- Options for Amending the Competition Act: Fostering a Competitive Marketplace, June 2003, Government of Canada
- Paul Geroski, 1990, Barriers to Entry and Strategic Competition (Fundamentals of Pure and Applied Economics)
- PRICE FIXING, BID RIGGING, AND MARKET ALLOCATION SCHEMES:WHAT THEY ARE AND WHAT TO LOOK FOR, U.S. Dept. of Justice
- Public policy and Economic competition in Japan. 1973-1995 Michael L.Beeman
- Randal Watson. (2004). *Prodauct Variety and Competition in the retail market for eyeglasses*
- Rating Agency Finds Mongolia's Economy Powering Ahead, UB Post, B.Bulgamaa, Thursday, September 27, 2007.
- REGULATORY IMPACT ANALYSIS STATEMENT, COMPETITION BUREAU, Government of Canada, 2003
- Sanctions on Western Cartels Threaten Japan: Punishing bid riggers is just the beginning; Naive and credulous Japanese firms targeted in Europe, U.S., Nikkei business, 2007.4.23
- Steven Berry and Peter Reiss, (2006). *Empirical models of entry and market structure*
- The Economics of Ticket Scalping, James J. Atkinson, University of Notre Dame, May 2004
- The Effects of Recent Volatility in International Petroleum Markets on Canadian Wholesale and Retail Gasoline Prices, Competition Bureau, Government of Canada 2005

Thorsten Fischer and David R.Kamerschen, (2003). *Measuring competition in the US airline industry using the Rosse-Panzar test and cross-sectional regression analyses*

2008 оны төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэл, Монголбанк, 2007

Адам Смит, (1776). *Улс Орнуудын Баялаг*

О.Амархүү, В.Батхүү, Б.Баяр “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай Монгол улсын хуульд хийсэн дүн шинжилгээ”, 2003

Ш.Батсүх, 2007, “Монгол улсын газрын харилцааны шинэтгэлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”

“Газар өмчлөлийн тайлан”, 2005, http://www.pmis.gov.mn/alagac/admin/doc_medee/G-U-Tailan.DOC

“Газар өмчлөлийн тайлан”, 2005, http://www.pmis.gov.mn/alagac/admin/doc_medee/G-U-Tailan.DOC

Я.Түвдэндорж, “Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах нь”, “Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг” олон улсын бага хурал, Улаанбаатар, 2007

Монгол улсын Гаалийн Ерөнхий Газар, (2004-2006). *Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл*

Монгол улсын худалдаа болон ноолуурын бодлого. Дэлхийн банк 2001 он

Монгол улсын эдийн засаг-нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн тухай, Засгийн Газар, Сангийн Яам, 2007

Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм, (2006). Институцийн хөгжил-эдийн засгийн өсөлтийг түргэтгэх шинэтгэлийн дараагийн үе шат, ННФ, МУИС-ЭЗС

Ноолуур хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан. Монгол улсын засгийн газар 2005 он.

ННФ, “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн нэгдсэн тайлан, 2004

ННФ, “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн нэгдсэн тайлан, USAID, USDA, CHF International, “Гэр санаачилга”: 2005 оны хашаа, байшингийн үнийн судалгаа

О.Мөнхбат, (2006), Төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог боловсронгуй болгох нь

Б.Төмөрхуяг, 2007, “Нийслэл дэх газрын харилцаа ба газрын зах зээл”, “Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг” олон улсын бага хурал, Улаанбаатар

Үндэсний Статистикийн Газар (ҮСГ), (1995-2006). Монгол улсын статистикийн эмхэтгэл

Үнийн өсөлтийг хязгаарлахын тулд Засгийн газар 2 жил дараалан махны нийлүүлэлтийг тогтворжуулах тусгай арга хэмжээ авсан.

Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар, 2005-2006 оны тайлан,

Шударга бус өрсөлдөөнийг хянан зорицуулах газар, 2006, Газрын тосны гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн нэгжийг тогтоох талаар хийсэн судалгаа, түүний үр дүн

Эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн биелэлтийн үнэлгээ, Сангийн Яам

Тендэрийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн аудит, Монгол улсын Үндэсний Аудитын газар, 2004

Өдөр тутмын сонинууд:

Зууны Мэдээ

Өдрийн Сонин

Өнөөдөр

Ашигласан сайтууд:

<http://www.freetheworld.com>

<http://www.olloo.mn/>

<http://www.forum.mn/>

<http://www.ursulduun.mn>

<http://www.ulaanbaatar.mn/>

<http://www.legalinfo.mn/>

<http://www.mongolbank.mn/>

Хавсралтууд

Хавсралт 1. Зах зээлийн төвлөрөл ба бүтцийн зохицуулалтын индексүүд

Зах зээлийн өрсөлдөөн ба зохицуулалтын асуудлыг зөвөөр шийдэхийн тулд зах зээлийн өрсөлдөөн болон төвлөрлийг (өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлдэг зах зээлийн ноёрхлын үзүүлэлт) хэмжих нь төрийн бодлого боловсруулахад чухал байдаг. Учир нь шударга бус өрсөлдөөний нөхцөл голдуу цөөн тооны (эсвэл ганцхан) компаний мэдэлд зах зээлийн томоохон хувь нь мэдэлд орсон тохиолдолд бүрддэг. Цөөн тооны компаниуд зах зээлийн ноёрхсон тохиолдолд тэд зах зээлээ хувааж, өрсөлдөөнийг хязгаарлах, үнийг хянах, тохирох боломж бүрддэг гэж үздэг. Иймээс зах зээл дэх шударга бус өрсөлдөөнийг хэмжихэд нэн тэргүүнд зах зээл цөөн тооны компаниудын гарт төвлөрсөн эсэхийг шалгадаг.

Зах зээлийн өрсөлдөөний хэмжүүрүүд нь *бүтцийн* болон *бүтцийн* бус гэж хуваагддаг.

- Бүтцийн хандлага нь зах зээлийн бүтцийг тодорхойлоход чиглэгдэх бөгөөд зах зээлийн төвлөрөлтэй шууд холбоотой.
- Зах зээлийн өрсөлдөөний хэмжүүрийн бүтцийн бус хандлага нь зах зээлийн төвлөрлөөс хамаардаггүй.

Зах зээлийн төвлөрлийн харьцааг хэмжих олон аргачлал байна. Ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгдсөн хандлага нь тухайн зах зээл дээрх аж ахуй нэгжийн тоо болон аж ахуй нэгжийн хэмжээний хуваарилалт (тэгш бус байдал) хоёр дээр үндэслэдэг. Тиймээс төвлөрлийн индексийн (CI) ерөнхий хэлбэр нь дараах байдалтай байна.

$$CI = \sum_{i=1}^n s_i w_i$$

Энд s_i - i -р аж ахуй нэгжийн зах зээлийн хувь,

w_i - зах зээлийн хувьд харгалзах жин,

n - зах зээл дээрх пүүсийн тоо.

Төвлөрлийн индекс буюу харьцааг тогтоохдоо бүтцийн хандлагын дагуу дараах индексүүдийг ашиглаж байна. (J.A.Bikker and K.Naaf, 2000) Үүнд:

1. Төвлөрлийн харьцаа (TX_k)
2. Херфиндал-Хериманы индекс (ХХИ)
3. Холл-Тайдмэний индекс (ХТИ)
4. Розенблатын индекс (РИ)
5. Компрехенсив аж үйлдвэрийн төвлөрлийн индекс (КТИ)
6. Ханнай ба Кэйгийн индекс (ХКИ)
7. U индекс (U)
8. Мультипликатив Хауз индекс (H_m)

9. *Аддитив Хауз индекс (H_a)*

10. *Энтропи хэмжүүр (E)*

Эдгээр индексүүд төвлөрлийн хэмжээг илүү илэрхийлэх бөгөөд төвлөрлийн харьцаа нь зах зээлийн бүтцийг, тэр дотроос олигополь шинжийг илүү харуулна. Түүнчлэн компаниуд зах зээлээс шахагдах, шинэ пүүс орж ирэх, хоорондоо нэгдэх зэрэг нь зах зээлийн төвлөрлийн харьцааг өөрчилж байдаг.

Төвлөрлийн харьцааг ихэнхдээ нийгмийн бодлого боловсруулахад өргөн ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, боломжит индексийг ашиглан зах зээлийн бүтцийг тодорхойлсноор төвлөрлийн түвшин ба хэлбэрийг тогтоож, тухайн зах зээл дээрх харьцангуй том ба жижиг үйлдвэрлэгчдийн нөлөөллийг харуулахын зэрэгцээ шинэ үйлдвэрлэгчийг зах зээлд нэвтрэх боломж байгаа эсэхийг харах юм.

Үндсэндээ өрсөлдөөний төвлөрлийн индекс нь тухайн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын хуримтлагдсан хувийг илэрхийлнэ. Энэ нь тухайн салбартаа их хувийг эзэлж байгаа компаниудын тоо хэмжээнд үндэслэсэн салбарын нийт хэмжээг координатын хавтгайн хэвтээ тэнхлэгт үзүүлээд босоо тэнхлэгийн дагуу төвлөрлийн хувийг харуулж байгаагаар дүрслэгддэг. Хэрвээ босоо тэнхлэгийн дагуу тухайн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй компаниудын тоо ба эзлэх хувь нь тэнхлэгтээ илүү ойртон хотойж байвал тухайн зах зээл дээр төвлөрөл их байна, харин тухайн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй компаниудын тоо ба эзлэх хувь нь босоо тэнхлэгээс холдон хотойж байвал төвлөрөл бага байна гэж үзнэ.

Зах зээлийн төвлөрлийн харьцааг индексээр үзүүлж, графикт дүрслэхээс гадна нэг талаас, зах зээлд үйл ажиллагаа явуулж

буй компаниудыг эзлэх хувиар нь эрэмбэлээд хувиар илэрхийлэн; нөгөө талаас тэдгээрийн зах зээлд нийлүүлж байгаа бүтээгдэхүүний хэмжээг мөн эрэмбэлж, хувиар илэрхийлээд Лоренцийн муруйг дүрсэлж болно. Лоренцийн муруй нь зах зээлийн төвлөрлөөс илүү тэгш бус байдлыг хэмждэг. Тодруулбал, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын нийт хөрөнгийн хэмжээ чухал бөгөөд компаниудын хэдэн хувь нь уг зах зээл дээрх нийт хөрөнгийн хэдэн хувийг эзэлж байгааг харуулснаараа тэгш бус байдлыг илэрхийлэх юм.

Лоренцийн муруй ба төвлөрлийн муруй хоёрын гол ялгаа нь: нэгдүгээрт, Лоренцийн муруйд зах зээл дээрх компаниудын хуримтлагдсан хувийг илэрхийлдэг бол төвлөрлийн муруйд зөвхөн хэвтээ тэнхлэгт тухайн салбарын хуримтлагдсан хэмжээ дүрслэгдэнэ. Хоёрдугаарт, Лоренцийн муруйд зах зээл дээрх компаниудыг жижгээс нь эхлэн эрэмбэлж байхад төвлөрлийн муруйд компаниудыг томоос нь эхлэн эрэмбэлнэ. Эдгээр хоёр муруй аль аль нь зах зээлийн хувь хэмжээнээс хамаарч байдаг. Тиймээс нийгмийн бодлогын шинжилгээнд чухал ач холбогдолтой.

Цаашилбал, зах зээлийн өрсөлдөөн ба зохицуулалтын хоорондын хамаарлын өөрчлөлтийг харуулахын зэрэгцээ өрсөлдөөний үр дүнд бий болох дам нөлөө ба үр дагавруудыг онолын болон олон улсын туршлага талаас нэгтгэн үзүүлье.

Ер нь зах зээлийн үнийг цааш нь нарийвчлан авч үзвэл, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зах зээл үү, аль эсвэл эдгээрийг бүтээхэд оролцож буй хүчин зүйлсийн зах зээл үү, үгүй бол хөрөнгийн буюу үнэт цаасны зах зээл үү гэдгээс хамааран үнэ янз бүрийн аргаар бүрэлддэг. Хэрэглэгчийн сайн сайхан байдлыг илүүд

үзэж байгаа бол бид өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ зах зээл дээр хэрхэн бий болж, хэрэглэгчид сонголт хийх боломж өгч байна уу, эсвэл дарамт учруулж байна уу, ерөнхийдөө хэрэглэгчийн илүүдлийг зах зээл дээр хэрхэн сайн сайхан байдал руу чиглүүлэх вэ гэсэн багц асуудлыг шийдэхэд хүрнэ.

Зах зээлийн тогтолцоонд өрсөлдөөний талаар гүнзгийрүүлэн судлаад үзвэл бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний орлуулалт, хослуулалт нь нэг талаас хүмүүст зөв сонголт хийж, өөрсдийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд, нөгөө талаас үйлдвэрлэгчдэд өрсөлдөөнд шахагдахгүйгээр боломжит ашиг, орлого олоход чухал нөлөөтэй.

Төвлөрлийн харьцаа (ТИ_k)

Энэ индекс маш энгийн бөгөөд тоо мэдээлэл дутуу үед өргөн хэрэглэгддэг, тухайн зах зээл дээрх хамгийн том k ширхэг аж ахуйн нэгжийн нийт зах зээл дээр эзлэх хувиар илэрхийлэгддэг.

$$CR_k = \sum_{i=1}^k s_i$$

Зах зээл дээр манлайлдаг k пүүсийг авч үзээд үлдсэн жижиг пүүсүүдийн мэдээллийг авч үздэггүйгээрээ онцлогтой. Түүнчлэн энэ индексийн бас нэгэн дутагдалтай тал нь k -н утга хэд байхыг тодорхойлсон дүрэм байдаггүй.

Херфиндал-Хершманы индекс (ХХИ)

Хамгийн өргөн хэрэглэгддэг энэхүү индекс нь тухайн зах зээл дээрх аж ахуй нэгжүүдийн зах зээлд эзлэх хувийн квадратуудын нийлбэрээр тодорхойлогддог. Зах зээлийн бүх мэдээллийг авч үздэг энэхүү индекс нь дараах томъёогоор тодорхойлогддог.

$$HHI = \sum_{i=1}^n s_i^2$$

Томъёоноос харахад том аж ахуй нэгжүүдийн хувьд илүү их жин өгдөг нь харагдаж байна. Энэхүү индексийн утга $1/n$ ба 1-ийн хооронд байдаг. Ерөнхийдээ энэхүү индексийн утга 0.18-аас дээш утгатай бол тухайн зах зээл дээр өрсөлдөөн хязгаарлагдмал гэж үздэг.

Холл-Тайдмэны индекс (ХТИ) ба Розенблатын индекс (РИ)

Эдгээр индексийг Холл ба Тайдмэн (1967), Розенблат Niehans (1961) нар хөгжүүлсэн бөгөөд хэлбэр болон онцлогийн хувьд нэг нэгэндээ шилждэг. Холл, Тайдмэн нар Херфиндал-Хершманы индексийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд төвлөрлийг хэмжихэд түүний шинж чанар хадгалагдаж, аж ахуй нэгжийн тоог төвлөрлийн индекст тусгах ёстой гэж үзсэн. Индекс дараах хэлбэртэй:

$$HTI = 1 / \left(2 \sum_{i=1}^n is_i - 1 \right)$$

Энд аж ахуй нэгж тус бүрийн зах зээлд эзлэх хувь нь тэдгээрийн эрэмбээр жинлэгдэж байна. Хамгийн том нь $i = 1$ гэсэн жин авна. Энэхүү индексийн утга тэгээс нэгийн хооронд хэлбэлзэнэ.

Розенблатын индекс нь төвлөрлийн муруйтай холбоотой бөгөөд дараах хэлбэртэй.

$$RI = 1 / (2C). \text{ Энд } C = \sum_{i=1}^n is_i - 1 / 2$$

Эдгээр индексийн ялгаа нь аж ахуй нэгжүүдийн эрэмбэтэй холбоотой.

Комплексив аж үйлдвэрийн төвлөрлийн индекс (КТИ)

Энэ индекс янз бүрийн салбар дахь пүүсүүдийн тархалт болон төвлөрөлтэй холбоотой маргаанаас үүсэлтэй. Маргаан нь давамгайл байдлтай цөөн хэдэн аж ахуй нэгжүүд зах зээлийн үйл хөдлөлийг тодорхойлдогийг уламжлалт индексүүд авч үзээгүй гэдгээс үүссэн. Энэ индекс Херфиндал-Хершманы индексийн онцлогийг агуулсан бөгөөд дараах хэлбэрээр томъёологддог.

$$CCI = s_1 + \sum_{i=2}^n s_i^2 (1 + (1 - s_i))$$

Ханнай ба Кэйгийн индекс (ХКИ)

Ханнай ба Кэй (1977) нар төвлөрлийн индексийн дараах хэлбэрийг үзүүлсэн.

$$HKI = \left(\sum_{i=1}^n s_i^\alpha \right)^{1/(1-\alpha)} \quad \alpha > 0, \quad \alpha \neq 1$$

Энд α нь мэдрэмжийн параметр бөгөөд тухайн зах зээлд шинэ пүүс орж ирэх, эсвэл шахагдсанаас болж төвлөрөл хэрхэн өөрчлөгдөхийг тусгадаг.

U индекс (U)

Энэ индексийг Дэвис (1979) тодорхойлсон бөгөөд төвлөрлийн индекс нь тухайн салбар дахь аж ахуй нэгжийн тоо болон тэгш бус байдлын үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ гэж үзсэн. Томъёо нь:

$$U = I^\alpha n^{-1}$$

Энд $\alpha \geq 0$ ба I нь тэгш бус байдлын хэмжүүр.

Хауз индексүүд

Олигополь зах зээлийн Курногийн загварын янз бүрийн тайлбарууд дээр үндэслэн Хауз (1977) зах зээлийн төвлөрлийн онолын хэмжүүр хангаж байх зургаан шалгуурыг тодорхойлсон. Өмнөх хэмжүүрүүдийн аль нь ч энэ шалгуурыг хангаагүй гэж үзсэн. Тиймээс тэрээр эдгээр шалгуурыг хангасан хоёр төвлөрлийн хэмжүүрийг тодорхойлсон. Хоёр хэмжүүр нь хоёулаа олигополь загвар дахь хуйвалдааны нөлөөг тусгадаг α параметрээс хамаардаг. Сайжруулсан Курногийн мультипликатив хэмжүүр нь дараах хэлбэртэй.

$$H_m(\alpha, \{s_i\}) = \sum_{i=1}^n s_i^{2 - (\alpha \text{ХХИ} - s_i^2)^\alpha}$$

Энд ХХИ нь Херфиндал-Хершманы индекс ба α нь хуйвалдааны зэргийг илэрхийлэх параметр.

Хауз аддитив зохицуулсан төвлөрлийн Курногийн хэмжүүрийг илэрхийлсэн бөгөөд дараах хэлбэртэй.

$$H_a(\beta, \{s_i\}) = \sum_{i=1}^n (s_i^2 + (s_i(\text{ХХИ} - s_i^2))^\beta)$$

Энд $\beta > 1$.

Энтропи хэмжүүр (E)

Энтропи хэмжүүрийн онолын үндэслэл нь мэдээллийн онолоос үүсэлтэй бөгөөд дараах хэлбэрээр томъёологдох юм.

$$E = - \sum_{i=1}^n s_i \log_2 s_i$$

Энэхүү индексийн утга хамгийн багадаа 0, хамгийн ихдээ $\log_2 n$ байна.

ХАВСРАЛТ 2: ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХҮСНЭГТҮҮД

Аж ахуйн нэгжийн судалгааны үр дүн

Хүснэгт 2.1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн үндсэн шннж байдал

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Аж ахуйн нэгжийн төрөл			
Хоршоо	1.8	1.8	1.8
Хувьцаат компани	12.3	3.6	8.0
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	63.2	85.5	74.1
Төрийн өмчит үйлдвэр	8.8	7.3	8.0
Орон нутгийн өмчит үйлдвэр	14.0	1.8	8.0
Хөрөнгө оруулалтын төрөл			
Дотоодын	78.9	76.4	77.7
Гадаадын	5.3	3.6	4.5
Гадаад, дотоодын хамтарсан	15.8	20.0	17.9
Толгой, охин, салбартай эсэх			
Тийм	38.6	32.7	35.7
Үгүй	61.4	67.3	64.3
Компанийн ажилласан жил			
1-2 жил	29.8	12.7	21.4
3-5 жил	24.6	10.9	17.9
6-10 жил	35.1	49.1	42.0
10-с дээш жил	10.5	27.3	18.8
Компанийн ажиллагсдын тоо			
25, түүнээс бага	63.2	23.6	43.8
26-50	15.8	20.0	17.9
51-75	7.0	14.5	10.7
76-100	7.0	10.9	8.9
101-125	1.8	3.6	2.7
126-с дээш	5.3	27.3	16.1
Ажиллагсдын сарын дундаж цалин (төг)			
50 000-100 000	56.1	29.1	42.9
100 001-150 000	24.6	29.1	26.8
150 001-200 000	12.3	25.5	18.8
200 001, түүнээс дээш	7.0	16.4	11.6
Дундаж цалин	123'074	159'093	140'762
Тоо	57	55	112
Бүгд	100	100	100

Хүснэгт 2.2. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Жилийн дундаж борлуулалтын хэмжээ (сая төгрөгөөр)			
50-с доош	22.8	10.9	17.0
50-100 хүртэл	38.6	10.9	25.0
100-150 хүртэл	3.5	7.3	5.4
150-200 хүртэл	3.5	5.5	4.5
200, түүнээс дээш	31.6	65.5	48.2
Нийт борлуулалтад экспортын эзлэх хувь			
50 хүртэл	5.3	12.8	9.0
50-99	3.6	9.1	6.1
100	.0	9.1	4.5
Экспортод гаргадаггүй	91.2	69.0	80.4
Үндсэн хөрөнгийн нийт хэмжээ (сая төгрөгөөр)			
50-с доош	22.8	9.1	16.1
50-100 хүртэл	40.4	27.3	33.9
100-150 хүртэл	8.8	7.3	8.0
150-200 хүртэл	3.5	5.5	4.5
200, түүнээс дээш	24.6	50.9	37.5
Түүхий эд, материалыг нийлүүлэгчдийн тоо			
1	58.1	9.4	31.3
2-5	32.6	54.7	44.8
6-10	4.7	15.1	10.4
11, түүнээс дээш	4.7	20.8	13.5
Түүхий эд материалын том нийлүүлэгчдийн нийт нийлүүлэгчдийн дүнд хэдэн хувь			
15% хүртэл	29.8	23.6	26.8
15-30% хүртэл	5.3	14.5	9.8
30-50% хүртэл	3.5	16.4	9.8
50% түүнээс дээш	61.4	45.5	53.6
Тоо	57	55	112
Бүгд	100	100	100

Хүснэгт 2.4. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани) өөрсдийн үйл ажиллагааны зах зээл дээрх өрсөлдөөнд гарч буй өөрчлөлтийн шалтгааныг* тодорхойлсон байдал

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Өрсөлдөгчид/нийлүүлэгчид нэмэгдсэн	63.2	70.6	64.0	60.0	50.0	60.6
Хэрэглээ нэмэгдсэн	0.0	17.6	12.0	.0	28.6	14.1
Үнийн өөрчлөлт	10.5	29.4	20.0	20.0	0.0	14.1
Техник, технологи нэвтэрч байна	0.0	5.9	4.0	10.0	0.0	3.0
Хэрэглэгчдийн шаардлага нэмэгдсэн	21.1	0.0	4.0	0.0	0.0	5.1
Чанар сайжирсан	5.3	5.9	0.0	0.0	0.0	2.0
Хувьчлал	0.0	0.0	0.0	0.0	7.1	2.0
Зохицуулалт муу	5.3	0.0	4.0	0.0	10.7	5.1
Тоо	19	17	25	10	28	99

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.5. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн үйл ажиллагааны зах зээл дээрх өрсөлдөөний илрэх хэлбэр

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Борлуулалтын хэмжээгээр	21.1	40.9	32.1	50.0	35.5	34.8
Үнээр	78.9	81.8	46.4	50.0	38.7	57.1
Зах зээлийн хүрээгээр	36.8	31.8	3.6	66.7	25.8	27.7
Үйлдвэрлэлийн хүчин чадлаар	10.5	9.1	14.3	50.0	12.9	16.1
Патент, лицензийг давуу эзэмших эрхээр	0.0	0.0	0.0	0.0	19.4	5.4
Чанараар	5.3	31.8	28.6	8.3	16.1	19.6
Технологийн шинэчлэлээр	0.0	0.0	0.0	8.3	0.0	.9
Үйлчилгээгээр	31.6	4.5	0.0	0.0	6.5	8.0
Тоо	19	22	28	12	31	112

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.7. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн (компани) зах зээлд нэвтрэн орох талаар

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Танай компани энэ зах зээлд нэвтрэн ороход ямар нэгэн бэрхшээл тохиолдсон уу?						
Тийм	31.6	59.1	50.0	75.0	51.6	51.8
Үгүй	68.4	40.9	50.0	25.0	48.4	48.2
Тийм бол, ямар бэрхшээлүүд тохиолдсон бэ?*						
Хөрөнгө санхүү	50.0	61.5	71.4	100.0	43.8	63.8
Ажиллах хүч	16.7	7.7	7.1	66.7	25.0	22.4
Бүртгэл	16.7	23.1	7.1	22.2	6.3	13.8
Дүрэм, журам зохицуулалт	33.3	53.8	7.1	22.2	68.8	39.7
Лиценз, зөвшөөрөл	0.0	7.7	0.0	0.0	0.0	1.7
Орчин	33.3	0.0	0.0	0.0	12.5	6.9
Үнийн өсөлт	0.0	0.0	14.3	0.0	0.0	3.4
Тоо	6	13	14	9	16	58
Танай компанийн эрхэлж буй үйл ажиллагааны зах зээл дээр шинэ компани нэвтрэн ороход ямар нэгэн бэрхшээл бий юу?						
Тийм	52.6	77.3	57.1	83.3	67.7	66.1
Үгүй	47.4	22.7	42.9	16.7	32.3	33.9
Тийм бол, ямар бэрхшээлүүд тохиолдсон бэ?*						
Мэдээлэл хомс	0.0	5.9	18.8	20.0	9.5	10.8
Зардал өндөр	40.0	82.4	56.3	50.0	42.9	55.4
Ажиллах хүч дутмаг	20.0	5.9	31.3	50.0	28.6	25.7
Бусад компанийн зүгээс дарамт	0.0	23.5	12.5	30.0	9.5	14.9
Зохицуулалт их	30.0	5.9	0.0	10.0	28.6	14.9
Зах зээлийн багтаамж бага	10.0	17.6	0.0	0.0	14.3	9.5
Хэрэглэгчдийг татах	30.0	5.9	6.3	10.0	4.8	9.5
Тоо	10	17	16	10	21	74

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.8. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани) өөрийн үйл ажиллагааны зах зээл дээр өрсөлдөгчөөсөө хүлээж болох эрсдэлүүд болон зах зээл дээр оршин тогтнож, үйл ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлсон байдал

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Өрсөлдөгчөөс хүлээж болох эрсдэлүүд						
Демпинг	52.6	50.0	57.1	33.3	38.7	47.3
Технологийн шинэчлэл хийх	21.1	27.3	42.9	75.0	38.7	38.4
Бүтээмжийн өсөлт, үнийн бууралт	15.8	18.2	14.3	41.7	0.0	14.3
Хүчтэй зах сурталчилгаа явуулах	31.6	18.2	3.6	25.0	12.9	16.1
Далд сүлжээ	15.8	27.3	14.3	8.3	25.8	20.5
Мэргэжилтэн/ажилтныг урвуулах	15.8	4.5	10.7	50.0	3.2	12.5
Урамшуулал, шинэ үйлчилгээ	15.8	9.1	3.6	0.0	3.2	6.3
Хэрэглэгчдийг татах	5.3	0.0	3.6	0.0	3.2	2.7
Бодлогоор	0.0	0.0	0.0	0.0	6.5	1.8
Зах зээлийн багтаамж	0.0	0.0	0.0	8.3	9.7	3.6
Эрсдэл байхгүй	0.0	4.5	3.6	0.0	12.9	5.4
Зах зээл дээр оршин тогтнож, үйл ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс						
Өрсөлдөөн ихтэй	57.9	59.1	39.3	41.7	22.6	42.0
Зах зээлийн багтаамж муу	36.8	36.4	21.4	58.3	29.0	33.0
Санхүүгийн чадавхи муу	0.0	13.6	0.0	58.3	19.4	14.3
Мэргэжилтэн хангалтгүй	5.3	4.5	7.1	41.7	12.9	11.6
Мэргэжлийн ажилчид дутагдалтай	5.3	4.5	7.1	33.3	9.7	9.8
Техник технологийн хоцрогдолтой	0.0	9.1	7.1	16.7	16.1	9.8
Бүтцийн өөрчлөлт хийх боломж муу	5.3	4.5	0.0	16.7	6.5	5.4
Хууль эрх зүйн орчин муу	15.8	4.5	10.7	8.3	35.5	17.0
Төрийн оролцоо	5.3	0.0	10.7	8.3	6.5	6.3
Өрсөлдөгч монополь шинжээ хадгалах	10.5	0.0	0.0	0.0	0.0	1.8
Байршил	0.0	9.1	3.6	.0	3.2	3.6
Үнэ	0.0	18.2	7.1	8.3	3.2	7.1
Сөргөөр нөлөөлөх хүчин зүйл байхгүй	15.8	4.5	7.1	0.0	0.0	5.4
Тоо	19	22	28	12	31	112

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.9. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн өрсөлдөөн бий болсноор гарах давуу талууд болон өрсөлдөөний талаарх мэдээллийг олж авдаг эх үүсвэр

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Өрсөлдөөн бий болсноор гарах давуу талууд*			
Чанар сайжирна	77.2	78.2	77.7
Барааны стандарт сайжирна	17.5	20.0	18.8
Компанийн нэр хүнд өснө	15.8	29.1	22.3
Гэрээ хэлэлцээр тодорхой болно	1.8	7.3	4.5
Үнэ буурна	43.9	27.3	35.7
Бүтээгдэхүүний орлуулалт нэмэгдэнэ	22.8	21.8	22.3
Үйлчилгээ сайжирна	22.8	9.1	16.1
Технологийн дэвшил нэвтэрнэ	10.5	1.8	6.3
Хэрэглэгчдийн соёл дээшилнэ	3.5	0.0	1.8
Борлуулалт нэмэгдэнэ	3.5	0.0	1.8
Давуу тал байхгүй	3.5	7.3	5.4
Мэдэхгүй	1.8	3.6	2.7
Тоо	57	55	112

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.10. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани) –ийн зах зээлийн өрсөлдөөнд баримталдаг стратеги

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					Бүгд
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	
Үйлчилгээгээрээ ялгарах	68.4	59.1	32.1	16.7	71.0	52.7
Бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх	10.5	9.1	17.9	25.0	12.9	14.3
Үнийн бодлого	26.3	36.4	21.4	8.3	19.4	23.2
Компани бие даан өрсөлдөх чадвар	5.3	9.1	10.7	8.3	22.6	12.5
Нийлүүлэгчид/хэрэглэгчдийг татах	5.3	13.6	3.6	25.0	32.3	16.1
Бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх	47.4	50.0	67.9	91.7	29.0	52.7
Бүтцийн өөрчлөлт, шинэчлэлт	0.0	0.0	3.6	0.0	9.7	3.6
Хууль дүрмээ сахих	0.0	4.5	0.0	0.0	6.5	2.7
Тоо	19	22	28	12	31	112

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.11. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн өрсөлдөөний талаарх хууль эрх зүйн дүрэм журмын мэдлэг

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Өрсөлдөөний талаарх хууль эрх зүйн акт, дүрэм журмыг мэддэг эсэх			
Тийм	42.1	76.4	58.9
Үгүй	57.9	23.6	41.1
Тоо	57	55	112
Тийм бол, ямар хууль эрх зүйн акт дүрэм журмыг мэдэх вэ?*			
Компанийн тухай хууль	70.8	85.7	80.3
Патентийн хууль	29.2	50.0	42.4
ШБӨХориглох тухай хууль	70.8	61.9	65.2
Дампуурлын тухай хууль	25.0	42.9	36.4
Засгийн газрын тогтоолууд	37.5	45.2	42.4
Стандарт	8.3	4.8	6.1
Мэдэхгүй	8.3	2.4	4.5
Тоо	24	42	66

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.12. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани) –ийн эрхэлж буй зах зээл дээр шударга бус өрсөлдөөн гардаг эсэх энэ нь ямар хэлбэрээр илэрдэг талаар

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Зах зээл дээр шударга бус өрсөлдөөн гардаг эсэх						
Тийм	47.4	63.6	71.4	75.0	71.0	66.1
Үгүй	52.6	36.4	28.6	25.0	29.0	33.9
Тоо	19	22	28	12	31	112
Тийм бол, ямар хэлбэрээр илэрдэг*						
Эрх мэдэлтний шийдвэрээр	22.2	42.9	15.0	11.1	63.6	35.1
Үнийн хуйвалдаанаар	22.2	64.3	15.0	77.8	27.3	36.5
Бүтээгдэхүүний хуйвалдаанаар	0.0	7.1	0.0	11.1	13.6	6.8
Зах зээлийн хил хязгаарын хуйвалдаанаар	33.3	14.3	5.0	0.0	4.5	9.5
Зар сурталчилгаагаар	44.4	21.4	.0	11.1	4.5	12.2
Лиценз эзэмших эрхээр	11.1	7.1	10.0	11.1	22.7	13.5
Стандартын бус бүтээгдэхүүн, үйлчилгээгээр	0.0	14.3	55.0	22.2	40.9	32.4
Чанараар	0.0	7.1	5.0	0.0	0.0	2.7
Буруу мэдээлэл	33.3	7.1	15.0	0.0	4.5	10.8
Тоо	9	14	20	9	22	74

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.13. Шударга бус өрсөлдөөн гарсан тохиолдолд хандах газар, хандсан эсэх, асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Шударга бус өрсөлдөөн гарсан тохиолдолд хандах газар			
ШБӨХЗГ	6.5	26.5	18.8
Татварын ерөнхий газар	6.5	2.0	3.8
Шүүх цагдаа	12.9	22.4	18.8
Засгийн газар	0.0	4.1	2.5
Салбарын зохицуулах газар	61.3	38.8	47.5
Хэнд ч ханддаггүй/мэдэхгүй	19.4	34.7	28.8
Тоо	31	49	80
Шударга бус өрсөлдөөн гарсан тохиолдолд хэн нэгэнд хандсан эсэх			
Тийм	40.0	46.9	43.9
Үгүй	60.0	53.1	56.1
Тоо	31	49	80
Асуудлыг шийдвэрлэсэн байдал			
Хариуцлага тооцсон	10.0	11.8	11.1
Салбарын дүрэм, журмаар шийдвэрлэсэн	20.0	11.8	14.8
Шийдвэрлэж өгөөгүй	60.0	58.8	59.3
Тоо	12	23	35

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.14. Шударга бус өрсөлдөөн бий болохоос сэргийлэх аргууд

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Шударга бус өрсөлдөөн бий болохоос сэргийлэх аргууд*			
Хууль, эрх зүйн зохицуулалт сайн байх	40.4	60.0	50.0
Хуулийн хэрэгжилт сайн байх	31.6	41.8	36.6
Бодлогын зохицуулалттай байх	19.3	40.0	29.5
Компаний бие даасан, чадвартай байх	40.4	30.9	35.7
Бизнес улс төрөөс ангид байх	14.0	9.1	11.6
Төрийн оролцоогүй байх	12.3	16.4	14.3
Мэдээллээр хангах	3.5	1.8	2.7
Хуулийн мэдлэгтэй байх	5.3	3.6	4.5
Мэдээлэл сайтай байх	1.8	3.6	2.7
Бусдын нөлөөг багасгах	1.8	3.6	2.7
Ил тод байх	0.0	3.6	1.8
Сэргийлж чадахгүй	1.8	3.6	2.7
Мэдэхгүй	5.3	0.0	2.7
Тоо	57	55	112

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.15. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани) –ийн зах зээл дээр олон улсын (ISO 9001) болон үндэсний стандартыг дагаж мөрддөг байдал

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Олон улсын (ISO 9001) стандартыг дагаж мөрдөж байгаа байдал						
Маш сайн	36.8	27.3	35.7	33.3	19.3	29.5
Сайн	42.1	36.4	46.4	33.3	45.2	42.0
Дунд	10.5	31.8	10.7	16.7	16.1	17.0
Муу	10.5	4.5	3.6	8.3	12.9	8.0
Маш муу	0.0	0.0	3.6	8.3	6.5	3.5
Үндэсний стандартыг дагаж мөрдөж байгаа байдал						
Маш сайн	36.8	59.1	50.0	41.7	32.3	43.8
Сайн	47.4	31.8	39.3	33.3	51.6	42.0
Дунд	10.5	4.5	10.7	25.0	12.9	11.6
Муу	5.3	4.5	0.0	0.0	3.2	2.7
Тоо	19	22	28	12	31	112

Хүснэгт 2.16. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани) –ийн үйлдвэрлэлийнхээ нэгжийн үнийг тогтоохдоо үндэслэдэг зүйлс*

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Нэгжийн дундаж зардал	52.6	81.8	78.6	66.7	48.4	65.2
Бүтээгдэхүүний тоо хэмжээ	5.3	4.5	3.6	8.3	3.2	4.5
Засгийн газрын зохицуулалт	36.8	13.6	0.0	8.3	32.3	18.8
Хууль эрх зүйн акт	0.0	4.5	0.0	0.0	29.0	8.9
Бусад бүтээгдэхүүний үнэ	5.3	4.5	10.7	0.0	9.7	7.1
Хэрэглэгчийн худалдан авах чадвар	26.3	13.6	7.1	8.3	35.5	25.0
Өрсөлдөгчийн үнэ тогтоолт	36.8	31.8	39.3	58.3	29.0	36.6
Нефть, шатахууны үнэ	5.3	13.6	14.3	0.0	25.8	14.3
Татвар	0.0	18.2	0.0	0.0	0.0	3.6
Ашиг	0.0	13.6	0.0	0.0	3.2	3.6
Мэдэхгүй	10.5	4.5	7.1	8.3	0.0	5.4
Тоо	19	22	28	12	31	112

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.17. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн өрсөлдөгч компани бүтээгдэхүүнийхээ нэгжийн үнийг бууруулбал хийх хариу үйлдэл, бусад компанитай тохиролцоо хийдэг эсэх, хийдэг бол ямар тохиролцоо хийдэг талаар

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Өрсөлдөгч компани бүтээгдэхүүнийхээ нэгжийн үнийг бууруулбал хийх хариу үйлдэл						
Үнээ дагаж бууруулна	52.6	77.3	57.1	25.0	25.8	48.2
Үнээ өөрчлөхгүй	26.3	9.1	39.3	75.0	51.6	38.4
Зөвшилцөнө	5.3	4.5	0.0	0.0	0.0	1.8
Тухайн нөхцөл байдлаас болно	0.0	4.5	3.6	0.0	6.5	3.6
Хэлж мэдэхгүй байна	15.8	4.5	0.0	0.0	16.1	8.0
Бусад компанитай тохиролцоо хийдэг эсэх						
Тийм	31.6	50.0	39.3	58.3	45.2	43.8
Үгүй	68.4	50.0	60.7	41.7	54.8	56.3
Тоо	19	22	28	12	31	112
Тийм бол, ямар тохиролцоо хийдэг*						
Үнэ	33.3	81.8	81.8	85.7	57.1	69.4
Бүтээгдэхүүний чанар	33.3	27.3	36.4	14.3	14.3	24.5
Зах зээлийн хувь	0.0	0.0	9.1	42.9	21.4	14.3
Чанар	16.7	0.0	9.1	0.0	28.6	12.2
Үйлчилгээ	66.7	0.0	9.1	0.0	50.0	24.5
Тоо	6	11	11	7	14	49

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.18. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн бараа бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой гомдлын талаар

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой гомдол хэр тогтмол ирдэг талаар						
Байнга	26.3	4.5	3.6	0.0	16.1	10.7
Хааяа	63.2	54.5	57.1	58.3	61.3	58.9
Гомдол ирдэггүй	10.5	40.9	39.3	41.7	22.6	30.4
Тоо	19	22	28	12	31	112
Гомдлын төрөл*						
Чанар	17.6	53.8	82.4	100.0	20.8	46.2
Үнэ	23.5	23.1	35.3	0.0	16.7	21.8
Үйлчилгээ	82.4	61.5	17.6	0.0	100.0	62.8
Гомдлыг хэрхэн шийдвэрлэдэг*						
Гомдлыг барагдуулна	64.7	53.8	76.5	57.1	58.3	62.8
Хариуцлага тооцно	29.4	30.8	41.2	28.6	45.8	37.2
Тайлбарлаж өгнө	0.0	7.7	5.9	0.0	4.2	3.8
Хяналтыг сайжруулна	11.8	0.0	5.9	0.0	4.2	5.1
Чанарыг шалгана	0.0	30.8	0.0	0.0	0.0	5.1
Дотоод журмаар шийднэ	29.4	7.7	11.8	14.3	25.0	19.2
Тоо	17	13	17	7	24	78

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.19. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн үйл ажиллагааны зах зээл дээр сүүлийн таван жилд гарсан томоохон өөрчлөлтүүд

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Тухайн салбарт гарсан сүүлийн таван жилд гарсан өөрчлөлтүүд*						
Том компани зах зээлээс гарсан	0.0	9.1	0.0	8.3	9.7	7.1
Том компани орж ирсэн	31.6	40.9	21.4	16.7	16.1	25.0
Орлуулах бүтээгдэхүүн нэмэгдсэн	15.8	0.0	17.9	25.0	12.9	13.4
Өрсөлдөөн нэмэгдсэн	78.9	59.1	42.9	58.3	41.9	53.6
Хууль эрх зүйн орчин өөрчлөгдсөн	0.0	9.1	7.1	8.3	25.8	11.6
Технологийн шинэчлэл	0.0	13.6	14.3	8.3	22.6	13.4
Түүхий эдийн үнэ өссөн	0.0	4.5	7.1	8.3	0.0	3.6
Хэрэглээ нэмэгдсэн	5.3	4.	7.1	0.0	0.0	3.6
Өөрчлөлт гараагүй	10.5	13.6	25.0	0.0	12.9	14.3
Тоо	19	22	28	12	31	112

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.20. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн үйл ажиллагааны зах зээл дээр сүүлийн таван жилд гарсан томоохон өөрчлөлтүүд үнэд нөлөөсөн эсэх

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Үнэ өссөн	10.5	52.4	56.0	18.2	11.5	31.4
Үнэ буурсан	73.7	9.5	24.0	0.0	19.2	26.5
Үнэ өөрчлөгдөөгүй	15.8	38.1	20.0	81.8	69.2	42.2
Тоо	19	21	25	11	26	102

Хүснэгт 2. 21. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани) өөрсдийн эрхэлж буй үйл ажиллагааны зах зээлийн өрсөлдөөнийг ойрын таван жилд төсөөлж буй байдал

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Өөрийн компанийн эрхэлж буй үйл ажиллагааны зах зээлийг ойрын таван жилд хэрхэн төсөөлж байна вэ?						
Цөөн хэдэн компани давамгайлна	73.7	54.5	57.1	16.7	80.6	61.6
Өрсөлдөгчид олноор нэмэгдэнэ	21.1	40.9	42.9	83.3	16.1	35.7
Хэлж мэдэхгүй байна	5.3	4.5	0.0	0.0	3.2	2.7
Тоо	19	22	28	12	31	112

Хүснэгт 2.22. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани) өөрсдийн эрхэлж буй үйл ажиллагааны зах зээлийн өрсөлдөөнд ойрын таван жилд өрсөлдөөн нэмэгдэхгүй цөөн хэдэн компани давамгайлна гэж үзэж буй шалтгаан

Шалтгаан*	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Зах зээлийн багтаамж муу	85.7	58.3	18.8	50.0	69.2	58.6
Хэрэглэгчдийн тоо бага	7.1	8.3	0.0	0.0	3.8	4.3
Зохицуулалт ихтэй	0.0	.0	6.3	0.0	11.5	5.7
Хууль/хяналт/зөвшөөрөл	0.0	8.3	0.0	0.0	3.8	2.9
Жижгүүд шахагдана	14.3	8.3	0.0	0.0	7.7	7.1
Шаардлага өндөрсөнө	0.0	0.0	18.8	0.0	7.7	7.1
Тоо	14	12	16	2	26	70

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.23. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдал эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн өөрчлөлттэй уялдаж чадаж байгаа эсэхийг тодорхойлсон байдал

Сонгосон үзүүлэлтүүд	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах, махан бүт	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдал эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн өөрчлөлттэй уялдаж чадаж байгаа эсэх						
Чадаж байгаа	26.3	45.5	25.0	50.0	19.4	30.4
Чадахгүй байна	68.4	50.0	75.0	50.0	80.6	67.9
Мэдэхгүй	5.3	4.5	0.0	0.0	0.0	1.8
Тоо	19	22	28	12	31	112

Хүснэгт 2.24. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд (компани)-ийн монголын зах зээл дээрх өрсөлдөөний байдал эдийн засгийн бодлого, хууль эрх зүйн орчин, институцийн өөрчлөлттэй уялдаж чадахгүй байгаа шалтгааныг тодорхойлсон байдал

Шалтгаан*	Салбар					
	Үүрэн холбоо	Газрын тосны импорт	Мах	Ноолуур	Нийтийн тээвэр	Бүгд
Хуулийн зүйл ангиудын уялдаа холбоо муу	61.5	72.7	52.4	100.0	60.0	63.2
Тогтсон ёс заншил зах зээлийн өөрчлөлтийг даган өөрчлөгдөж чадахгүй байна	30.8	18.2	9.5	33.3	32.0	23.7
Дүрэм журам зохицуулалт муу	23.1	18.2	23.8	16.7	28.0	23.7
Хуулийн хэрэгжилт муу	15.4	0.0	4.8	0.0	8.0	6.6
Засгийн газрын оролцоо	7.7	9.1	4.8	0.0	4.0	5.3
Авилгал	7.7	0.0	4.8	0.0	8.0	5.3
Дэмжлэг байхгүй	0.0	0.0	4.8	0.0	0.0	1.3
Хяналт муу	0.0	0.0	4.8	16.7	12.0	6.6
Стандарт байхгүй	0.0	9.1	0.0	0.0	4.0	2.6
Мэдэхгүй	7.7	0.0	0.0	0.0	8.0	3.9
Тоо	13	11	21	6	25	76

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.25. Монголын зэх зээл дээрх өрсөлдөөний байдлыг сайжруулах талаарх санал*

Санал	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Хуулиа дээдлэх	7.0	14.5	10.7
Хуулиа засаж сайжруулах	5.3	21.8	13.4
Хуулийг сайн хэрэгжүүлэх	24.6	41.8	33.0
Ухамсар, хариуцлагыг өндөржүүлэх	15.8	1.8	8.9
Засгийн газар ажлаа сайн хийх	7.0	9.1	8.0
Стандарт тогтоох, дүрэм журам гаргах	7.0	0.0	3.6
ЖДҮ дэмжих	5.3	7.3	6.3
Хяналтыг сайжруулах	19.3	14.	17.0
Бизнес улс төрөөс ангид байх	7.0	9.1	8.0
Санал байхгүй	3.5	7.3	5.4
Мэдэхгүй	10.5	14.5	12.5
Тоо	57	55	112

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.26. Зах зээлийн өрсөлдөөний талаарх ойлголт*

Санал	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Үнэ хямд/уян хатан байвал	21.1	14.5	17.9
Чанар сайн байвал	7.0	14.5	10.7
Үйлчилгээ сайн байвал	31.6	34.5	33.0
Хууль эрх зүйн зохицуулалт сайн байвал	17.5	9.1	13.4
Шударга байвал	8.8	18.2	13.4
Төрийн оролцоо бага байвал	7.0	10.0	8.9
Нийлүүлэгч олон байвал	15.8	30.9	23.2
Мэдэхгүй	5.3	7.3	6.3
Тоо	57	55	112

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.27. Хэрэглэгч өрхүүдийн шинж байдал, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Ам бүлийн тоо			
1-3	33.6	33.7	33.6
4-5	47.6	45.3	46.7
6, түүнээс дээш	18.8	21.0	19.7
Ам бүлийн дундаж тоо	4.23	4.28	4.25
Сууцны өмчийн хэлбэр			
Улсын	3.1	1.3	2.4
Хувийн	95.7	94.7	95.1
Байгууллагын	1.2	4.0	2.4
Өрхийн шинж байдал			
Гэр хороолол	41.7	46.7	43.8
Байшин хороолол	58.3	53.3	56.3
Халаалт			
Төвлөрсөн	53.1	57.7	55.0
Төвлөрсөн бус	1.7	5.3	3.2
Ердийн	45.2	37.0	41.8
Усан хангамж			
Төвлөрсөн: Халуун хүйтэн устай	46.4	56.7	50.7
Зөвхөн хүйтэн устай	5.0	3.0	4.2
Худаг	36.2	31.3	34.1
Зөөврийн/гол булаг	12.4	9.0	11.0
Гар утастай эсэх			
Тийм	87.1	91.3	88.9
Үгүй	12.9	8.7	11.1
Өрхийн сарын дундаж орлого			
50 000 хүртэл	7.9	2.0	5.4
50 001-150 000	44.5	33.3	39.9
150 001-250 000	26.0	27.3	26.5
250 001-350 000	11.7	18.3	14.4
350 001, түүнээс дээш	10.0	19.0	13.8
Өрхийн сарын дундаж орлого (төгрөг)	188'083	246'371	217'227
Өрхийн сарын дундаж зардал			
50 000 хүртэл	6.2	0.3	3.8
50 001-150 000	46.2	18.7	34.7
150 001-250 000	29.8	34.3	31.7
250 001-350 000	11.0	20.7	15.0
350 001, түүнээс дээш	6.9	26.0	14.9
Өрхийн сарын дундаж зардал (төгрөг)	176'517	279'483	228'000
Тоо	420	300	720
Бүгд	100.0	100.0	100.0

Хүснэгт 2.28. Цахилгаан дулаантай холбоотой тулгардаг хүндрэл бэрхшээлүүд, цахилгаан эрчим хүчний салбарт шаардлагатай зохцуулалтын талаарх санал

Сонгосон үзүүлэлтүүд	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Цахилгаан, дулаантай холбоотой тулгардаг хүндрэл, бэрхшээлүүд*			
Цахилгаан тасалддаг	38.0	57.2	46.0
Дулаан тасалддаг	14.4	13.8	14.1
Халуун ус тасалддаг	17.5	14.4	16.2
Хүйтэн ус тасалддаг	9.3	19.8	13.7
Халуун, хүйтэн ус тасалддаг	3.6	17.8	9.5
Цахилгаан эрчим хүч хэлбэлзэлтэй	8.4	1.7	5.6
Цахилгаан, дулаан буруу бичдэг	1.9	0.3	1.3
Үйлчилгээ муу, хүнд сурталтай, соёлгүй	0.5	0.3	0.4
Шугам, саниехникийн гэмтэл	1.9	0.7	1.4
Хүндрэл бэрхшээл тулгардаггүй	48.8	0.7	28.8
Цахилгаан, эрчим хүчний салбарт шаардлагатай зохицуулалт*			
Цахилгаан, дулааны үнийг нэмэхгүй байх	14.8	27.9	20.3
Цахилгаан, дулаан тасалддаггүй болгох	3.6	12.4	7.3
Үйлчилгээ сайжруулах	10.3	11.1	10.6
Цахилгааны шугам шинэчлэх	8.4	14.1	10.8
Хариуцлагыг өндөржүүлэх	3.3	3.7	3.5
Цахилгаан, дулааны өөр эх үүсвэртэй болох	11.0	9.1	10.2
Сайн тоолуур, бойлертэй болгох	16.3	13.1	14.9
Бүх сумдыг цахилгаантай болгох	4.8	5.4	5.0
Санал байхгүй	18.2	13.8	16.3
Мэдэхгүй	16.7	4.4	11.6
Тоо	418	298	716

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.29. Судалгаанд хамрагдсан хэрэглэгч өрхүүдийн мах махан бүтээгдэхүүний хэрэглээгээ хангадаг газар

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Махны хэрэглээгээ ихэвчлэн хаанаас хангадаг вэ?*			
Өөрийн аж ахуйгаас	16.7	9.4	13.6
Захаас	90.2	64.3	79.4
Сүлжээ дэлгүүрүүдээс	1.2	22.3	10.0
Хүнсний дэлгүүрүүдээс	5.7	27.0	14.6
Тогтсон газар байхгүй	1.2	6.7	3.5
Тоо	420	300	720

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.30. Судалгаанд хамрагдсан хэрэглэгч өрхүүд мах махан бүтээгдэхүүний үнэ, чанарын талаар хариулсан байдал

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Зах дээр борлуулж буй мах махан бүтээгдэхүүний үнэ			
Хэт өндөр	60.0	57.0	58.8
Өндөр	37.6	39.6	38.4
Боломжийн	2.4	3.4	2.8
Мах махан бүтээгдэхүүний үнийн өсөлт зөв эсэх			
Зөв	9.2	6.3	8.0
Буруу	90.8	93.8	92.0
Мах махан бүтээгдэхүүн чанарын шаардлага хангадаг эсэх			
Тийм	51.4	52.0	51.7
Үгүй	48.6	48.0	48.3
Мах махан бүтээгдэхүүн чанарын шаардлага хангахгүй тохиолдол хэр тогтмол гардаг вэ?			
Байнга	16.7	6.0	12.3
Хааяа	48.6	65.8	55.7
Тийм тохиолдол гардаггүй	34.8	28.2	32.0
Total	420	300	720
Бүгд	100	100	100

Хүснэгт 2.31. Судалгаанд хамрагдсан хэрэглэгч өрхүүдийн мах, махан бүтээгдэхүүний худалдан авахдаа харгалзан үздэг зүйлс, мах, махан бүтээгдэхүүн худалдан авахад гардаг хүндрэл, бэрхшээлүүд

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Мах, махан бүтээгдэхүүн худалдан авахдаа харгалзан үздэг зүйлс*			
Үнэ	42.7	33.9	39.1
Чанар	81.7	86.2	83.6
Үйлчилгээ	14.5	5.0	10.6
Орчин	32.4	3.4	20.3
Эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэх	6.2	3.7	5.2
Махны төрөлжилт	1.4	0.3	1.0
Байршил	0.2	1.7	0.8
Мах махан бүтээгдэхүүн худалдан авалттай холбоотой гардаг хүндрэл бэрхшээлүүд*			
Чанар муу	26.7	33.2	29.4
Үнэ өндөр	77.1	85.6	80.6
Сонголт муу	22.9	32.2	26.7
Үйлчилгээ муу	18.6	19.1	18.8
Махны стандарт байхгүй	1.7	1.0	1.4
Махыг буруу жигнэж өгдөг	3.1	2.0	2.6
Ариун цэвэр муу	4.3	3.0	3.8
Махын төрөлжилт, үнийн ялгаварлал байхгүй	1.0	2.0	1.4
Бэрхшээл байхгүй	3.8	1.7	2.9
Хэлж мэдэхгүй байна	1.0	1.3	1.1
Тоо	420	300	720

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.32. Судалгаанд хамрагдсан хэрэглэгч өрхүүд мах махан бүтээгдэхүүний үнэ, чанарын талаар хариулсан байдал

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Мах махан бүтээгдэхүүн борлуулагчид хэрэглэгчийнхээ өмнө хариуцлага хүлээж чадаж байна уу?			
Тийм	38.6	23.8	32.5
Үгүй	61.4	76.2	67.5
Хэрэв борлуулагчид хэрэглэгчийнхээ өмнө үүрэг хүлээж чадахгүй байгаа бол яагаад тухайн борлуулагчийн хэрэглэгч байсаар байна вэ?*			
Өөр сонголт байхгүй	59.1	54.8	57.1
Өөр нийлүүлэгчийн талаар мэдээлэл байхгүй	28.6	28.1	28.3
Хэрэглэж дадсан	6.6	6.1	6.4
Байршил	1.9	9.2	5.3
Зах хямд	1.2	0.4	0.8
Хэрэгцээ байгаа болохоор	2.7	1.3	2.1
Монголд махны үнэ бага байх боломжтой эсэх			
Тийм	94.5	95.3	94.8
Үгүй	5.5	4.7	5.2
Мах махан бүтээгдэхүүний зах зээлийг сайжруулахтай холбоотой санал*			
Үнэ өсгөхгүй тогтмол байлгах	66.7	73.8	69.6
Чанартай мах борлуулах	33.3	39.3	35.8
Үйлчилгээ сайжруулах	23.6	31.9	27.0
Махыг төрөлжүүлэх	1.9	2.0	1.9
Зохицуулалт, хяналтыг сайжруулах	11.2	9.7	10.6
Ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангах	14.0	12.8	13.5
Нөөцийн махтай байх	1.7	0.3	1.1
Байхгүй	1.2	0.0	0.7
Тоо	420	300	720

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.33. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн тухайн тээврийн хэрэгслээр зорчдог шалтгаан

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Тухайн тээврийн хэрэгслээр зорчдог шалтгаан*			
Үнэ хямд	27.7	50.2	37.7
Шуурхай	44.0	49.8	46.6
Аюул багатай	3.2	9.7	6.1
Тохитой	10.2	10.1	10.2
Найдвартай	0.9	0.7	0.8
Хөнгөлөлт үзүүлдэг	0.0	2.5	1.1
Боломжийн	0.6	0.7	0.6
Дуртай газар зогсож үйлчилдэг	2.0	2.2	2.1
Өөр сонголт байхгүй	49.3	26.4	39.0
Тоо	342	273	615

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.34. Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой гардаг, хүндрэлүүд

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой хүндрэл гардаг уу?			
Тийм	45.8	64.7	54.2
Үгүй	54.2	35.3	45.8
Тоо	342	273	615
Нийтийн тээврийн компанийн зүгээс учруулдаг хүндрэл бэрхшээлүүд*			
Шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэлтэй	42.4	53.6	48.3
Үйлчилгээ муутай	58.3	71.2	65.1
Үнэ өндөртэй	26.2	13.7	19.7
Тогтмол цагаар үйлчилж чаддаггүй	12.5	7.1	9.7
Аюул ихтэй, дүрэм зөрчдөг	3.6	4.3	4.0
Норм барьдаггүй	14.3	5.4	9.7
Тогтсон буудал байдаггүй	2.4	2.7	2.6
Хөнгөлөлт үзүүлдэггүй	2.4	0.0	1.1
Мэдэхгүй	0.6	0.0	0.3
Тоо	168	184	352

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.35. Нийтийн тээврийн компаниуд хэрэглэгчдийн эрх ашгийг хангаж чадаж байгаа эсэх, хэрэглэгчдийн зөрчигдөж буй эрх ашиг, түүнийг шийдвэрлэж буй байдал

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Нийтийн тээврийн компаниуд хэрэглэгчдийн эрх ашгийг хангаж чадаж байна уу?			
Тийм	46.5	23.2	36.2
Үгүй	53.5	76.8	63.8
Тоо	342	273	615
Нийтийн тээврийн компаниуд хэрэглэгчдийн ямар эрх ашгийг зөрчиж байна вэ?*			
Тохилог бус тээврийн хэрэгсэл	48.1	46.3	47.1
Норм норматив барьдаггүй	66.8	68.2	67.6
Тээврийн сүлжээний зохион байгуулалт муу	19.0	27.1	23.4
Шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэл	24.5	49.3	37.8
Үйлчилгээ муу	39.1	54.4	47.4
Аюул эрсдэл их	37.5	39.1	38.3
Тогтсон цагаар үйлчилдэггүй	4.3	4.7	4.5
Үнэ өндөр	2.7	4.7	3.8
Хүүхэд хөгшдөд үйлчилдэггүй	1.1	2.8	2.0
Тогтоосон буудлаар үйлчилж чаддаггүй	0.5	1.4	1.0
Тоо	184	215	399
Нийтийн тээврийн компаниуд хэрэглэгчдийн гомдол, саналыг хэрхэн хүлээж авч шийдвэрлэдэг вэ?			
Огт шийдвэрлэдэггүй	51.0	27.8	40.6
Хааяа л шийдвэрлэдэг	28.0	10.8	20.3
Сайн шийдвэрлэдэг	11.1	1.4	6.8
Гомдол санал гаргаж байгаагүй	9.9	59.9	32.3
Нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо сонгох үнэ*			
Цагаар	8.5	2.9	6.0
Буудлаар	26.0	37.5	31.1
Таксины үнэ тогтоох журмаар	12.0	2.2	7.6
Одоогийн журмаар	53.5	57.5	55.3
Тоо	342	273	615

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.36. Судалгаанд хамрагдсан хэрэглэгч өрхүүдийн нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах талаарх санал

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах талаарх санал*			
Тохилог тээврийн хэрэгсэлтэй болгох	7.9	18.8	12.8
Соёлтой, шуурхай үйлчилгээ	20.2	40.8	29.4
Норм норматив барих	10.2	12.6	11.3
Зохицуулалт, хяналтыг сайжруулах	21.9	12.6	17.8
Аюулгүйн дүрэм барих	6.4	7.6	6.9
Парк шинэчлэлт хийх	5.8	11.2	8.2
Автобус, троллейбусыг нэмэгдүүлэх	11.1	17.7	14.1
Кондукторуудыг сургалтад хамруулах	2.0	2.2	2.1
Микроавтобусыг журамлах	0.0	1.8	0.8
Өрсөлдөөнийг нэмэгдүүлэх	6.1	1.1	3.9
Үнийг өсгөхгүй байхад анхаарах	7.6	4.0	6.0
Байхгүй	14.6	5.1	10.3
Хэлж мэдэхгүй байна	10.2	4.3	7.6
Тоо	342	273	615

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.37. Судалгаанд хамрагдсан хэрэглэгч өрх/өрхийн гишүүдийн тухайн компанийн сүлжээг ашиглаж буй шалтгаан

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Тухайн компанийн сүлжээг ашигладаг шалтгаан*			
Суурь хураамж бага	8.8	15.9	11.9
Ярианы тариф хямд	13.6	29.6	20.5
Мессэжний тариф хямд	4.8	9.3	6.7
Сүлжээ сайн барьдаг	21.7	25.2	23.2
Олон төрлийн үйлчилгээтэй	10.1	10.0	10.1
Урамшуулал сайтай	5.9	10.0	7.7
Харилцагчидтай адил сүлжээнд байхын тулд	52.5	47.0	50.2
Гадаадад хэрэглэх боломжтой	1.7	6.3	3.7
Анхнаасаа хэрэглэсэн	31.1	21.9	27.1
Шинэ оператор учир	0.8	1.5	1.1
Өөрийн сонирхол, шаардлагаар	4.2	3.3	3.8
Тоо	354	270	624

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.38. Судалгаанд хамрагдсан хэрэглэгч өрх/өрхийн гишүүдийн хэрэглэж буй үүрэн холбооны компанийн үйлчилгээнд сэтгэл хангалуун байгаа эсэх, тэдний эрх ашиг зөрчигдөж буй эсэх

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Хэрэглэж байгаа компанийнхаа үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг эсэх			
Тийм	61.2	61.1	61.2
Үгүй	38.8	38.9	38.8
Хэрэглэж байгаа компанийнхаа үйлчилгээнд сэтгэл хангалуун биш байдаг бол, шалтгаан?*			
Үнэ өндөр	72.1	83.5	77.1
Сүлжээ тасардаг	39.6	23.9	32.5
Гомдол санал шийддэггүй	4.5	8.3	6.2
Технологийн шинэчлэл удаан нэвтрүүлдэг	3.0	10.1	6.2
Үйлчилгээ муу	32.1	8.3	21.4
Тоо	134	109	243
Үүрэн холбооны зах зээл дээр хэрэглэгчдийн эрх ашиг зөрчигддөг эсэх			
Их	7.9	9.3	8.5
Дунд зэрэг	27.2	37.8	31.8
Бага	25.5	53.0	37.4
Зөрчигддөггүй	39.4	0.0	22.3
Тоо	354	270	624

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.39. Судалгаанд хамрагдсан хэрэглэгч өрх/өрхийн гишүүдийн үүрэн холбооны өрсөлдөөн болон үйлчилгээг сайжруулах талаарх санал

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Үүрэн холбооны салбарыг хэр өрсөлдөөнтэй гэж үзэж байна вэ?			
Маш өрсөлдөөнтэй	74.0	66.9	70.9
Дунд зэрэг	18.6	30.1	23.6
Огт өрсөлдөөнгүй	7.3	0.7	4.5
Мэдэхгүй	0.0	2.2	1.0
Үүрэн холбооны салбарт өрсөлдөөн нэмэгдсэнээр гарч буй үр дагаврууд*			
Үнэ өсөхгүй/буурч байна	65.1	60.2	62.9
Сонголтын хүрээ тэлсэн	29.7	42.0	35.2
Үйлчилгээ сайжирч байна	39.8	43.5	41.4
Нэмэлт урамшуулал бий болж байна	42.5	42.0	42.3
Эерэг үр дагавар байхгүй	13.1	17.1	14.9
Үүрэн холбооны үйлчилгээг сайжруулах талаарх санал*			
Суурь хураамжгүй болгох	13.8	6.0	10.4
Ярианы тарифыг бууруулах	22.0	32.8	26.7
Үйлчилгээг сайжруулах	13.8	13.8	13.8
Шинэ технологи нэвтрүүлэх	6.2	6.7	6.4
Сүлжээ сайн барьдаг болгох	6.2	7.8	6.9
Үнэ тогтвортой, өсөхгүй байх	3.7	4.5	4.0
Мобикомын монополийг багасгах	6.8	15.7	10.6
Урамшуулал нэвтрүүлэх	6.2	11.2	8.4
Байхгүй	11.6	10.8	11.3
Хариулж мэдэхгүй байна	18.9	7.1	13.8
Тоо	354	270	624

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.40. Судалгаанд хамрагдсан өрх/өрхийн гишүүдийн газрын тосны нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ, үнэ

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Судалгаанд хамрагдсан өрх/өрхийн гишүүдийн хэрэглэдэг түлш шатахуун*			
А-76	10.2	3.3	7.4
А-80	11.7	5.0	8.9
АИ-92	14.8	22.0	17.8
АИ-93	6.7	13.0	9.3
Дизель	6.2	9.0	7.4
Хэрэглэдэггүй	47.6	46.0	46.9
Түлш шатахууны үнэ			
Өндөр	79.1	78.4	78.8
Боломжийн	20.9	21.6	21.2
Тоо	420	300	720
Нийт	100	100	100

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.41. Судалгаанд хамрагдсан өрх/өрхийн гишүүдийн газрын тосны нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж буй компанийн өрсөлдөөнийг тодорхойлсон байдал, энэ зах зээлийг сайжруулах талаарх санал

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Түлш шатахуун нийлүүлж буй компаниуд хэр өрсөлдөөнтэй вэ?			
Өрсөлдөөнтэй	44.5	41.4	43.2
Өрсөлдөөнгүй	55.5	58.6	56.8
Түлш шатахуун нийлүүлж буй компаниудын өрсөлдөөний үр дүнд гарч буй эерэг үр дагаврууд*			
Сонголтын хүрээ нэмэгдэж байна	28.9	31.3	29.9
Үнэ харьцангуй тогтвортой байна	19.6	14.9	17.7
Үйлчилгээ сайжирч байна	30.9	34.3	32.3
Нэмэлт урамшуулал бий болж байна	18.6	10.4	15.2
Чанар сайжирна	8.2	7.5	7.9
Эерэг үр дагавар байхгүй	34.0	34.3	34.1
Түлш шатахууны зах зээлийг сайжруулах талаарх санал*			
Үнийг тогтвортой барих	15.9	20.7	18.1
Чанартай шатахуун нийлүүлэх	5.9	21.3	13.1
Өрсөлдөөнийг нэмэгдүүлэх	7.6	10.0	8.8
Төрөөс зохицуулалт хийх	27.6	21.3	24.7
Үйлчилгээг сайжруулах	12.9	6.0	9.7
Монголд газрын тосны үйлдвэрлэлтэй болох	11.2	16.0	13.4
Зохицуулалт шаардлагагүй	1.2	6.7	3.8
Хариулж мэдэхгүй байна	16.5	12.0	14.4
Тоо	220	162	382

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Хүснэгт 2.42. Өрсөлдөөний талаарх хэрэглэгчдийн ойлголт

Сонгосон үзүүлэлт	Байршил		
	Аймаг	Улаанбаатар	Бүгд
Бүтээгдэхүүний тоо хэмжээ их байвал	23.6	24.7	24.0
Үнэ хямд, уян хатан байвал	22.6	28.7	25.1
Чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байвал	14.3	16.3	15.1
Хэрэглэгч олон, үйлчилгээ сайн байвал	8.8	12.3	10.3
Шударга, тэгш эрхтэй байвал	5.7	11.0	7.9
Зохион байгуулалт сайн байвал	1.9	4.0	2.8
Бие биенээсээ дээр гарахаар өрсөлдвөл	1.7	2.7	2.1
Хэрэглэгчээ дээдэлсэн байвал	1.4	2.7	1.9
Төрийн зохицуулалт сайн байвал	4.8	4.3	4.6
Зах зээлийн жам ёсоороо хөгжиж байвал	3.6	5.3	4.3
Нийлүүлэгч олонтой байвал	20.0	19.7	19.9
Бараа бүтээгдэхүүний стандартыг дагаж байвал	6.2	8.7	7.2
Мэдээлэл сайтай байвал	0.5	0.7	0.6
Зээл, татварын бодлого зөв, уян хатан байвал	1.9	0.7	1.4
Худалдан авах чадвар сайн байвал	0.7	1.3	1.0
Байхгүй	9.0	4.7	7.2
Мэдэхгүй	14.5	2.0	9.3
Тоо	420	300	720

Хавсралт 3

«Монгол улсын эдийн засгийн эрх чөлөө 2007: Монгол улсын зах зээлийн өрсөлдөөний өнөөгийн байдал, түүний үр нөлөө, цаашдын төлөв» тайлангийн хэлэлцүүлгийн тэмдэглэл

Улаанбаатар

2007.11.30

“Монгол улсын эдийн засгийн эрх чөлөө 2007: Монгол улсын өрсөлдөөний өнөөгийн байдал, түүний үр нөлөө, цаашдын төлөв” тайлангийн хэлэлцүүлэг 2007 оны 11 дүгээр сарын 30-ны 16⁰⁰ цагаас “Нээлттэй Нийгэм Форум”-ын хурлын танхимд болов.

Хурлын нээлт

П.Эрдэнэжаргал: /ННФ-ын гүйцэтгэх захирал/ Өнөөдөр ННФ болон МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Бид бүхэн хамтарсан тайлангаа хэлэлцүүлэхээр та бүхнийг урьж, урилга явуулсан байгаа. Урилгатайгаа хамт тайлангийн төслөө мөн илгээсэн. 2005 оноос хойш Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөний асуудлаар гурван тайлан гарсан. Сүүлийн хоёр тайланг МУИС-ийн Эдийн Засгийн Сургуультай хамтран гаргалаа. Эхний тайлан бол онцлогтой. Учир нь олон улсын эдийн засгийн эрх чөлөөний индексийг тодорхойлдог Канадын Фрейзер Институтын арга зүйгээр манай судлаачид өөрсдөө Монгол улсын индексийг анх тооцоолсон. 2006 оноос Фрейзер Институтын судалгаанд Монгол улс албан ёсоор ордог болсон тул ийм ажил хийх шаардлагагүй болсон. Дараа жилээс нь уг институтээс гаргасан судалгаанаас харж байгаад манай улсад аль анхаарал татсан зүйлийг тусгайлан судалж

байгаа юм. Үүний үр дүнд хоёр тайлан гаргалаа. Энэ жилийнх нь зах зээлийн өрсөлдөөний тухай бөгөөд өрсөлдөөнийг тодорхойлж, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын хэтийн төлвийг тодорхойлохыг оролдсон байгаа. Энэ асуудал цаг үеэ олсон байх. Судалгааны баг тайлангаа тавихад бэлэн болсон, манай форумгаас энэ асуудлаар ажилладаг Мөнхсоёл маань энд байхгүй ч өөр оронд ажлаа хийж байгаа юм. Ингээд хэлэлцүүлгээ эхлэе. Хашчулуун доктор тайлангаа “Монголын эдийн засгийн эрх чөлөө ба өрсөлдөөн” сэдвээр хийнэ. Энэ төсөлд МУ-ын ерөнхий сайд асан, профессор Д.Бямбасүрэн гуай зөвлөхөөр ажилласан юм.

Ч.Хашчулуун, М.Уянга, Б.Энхцэцэг /МУИС/ “Монголын эдийн засгийн эрх чөлөө ба өрсөлдөөн” тайлан-илтгэл хэлэлцүүлээ.

Та бүхний гар дээр тайлан очсон тул бид дэлгэрэнгүй тайлбарласангүй, өөрсдийн судалсан чиглэл чиглэлээрээ товч тайлан тавилаа. Та бүхний асуусан асуулт, санал зөвлөгөөг хүлээн авахад бэлэн байна.

П.Эрдэнэжаргал: /хурлын дарга/ Судалгааны багийнханд баярлалаа. Асуулт асууж, саналаа хэлэх хүмүүс өөрсдийгөө товч танилцуулаад дараа нь үг хэлнэ үү.

Д.Байлийхүү: /ТӨХ/ Хэдэн зүйл тодруулах үүднээс асууя. 1. үнийн өсөлтийг шударга бус үйл ажиллагаа гэж үзэж байна уу? 2. зохиомол ба зохиомол биш үнэ гэж ярилаа. Зохиомол, зохиомол бишийг яаж мэдсэн юм бэ? 3. нийтийн тээврийн чухам аль салбарыг нь авч үзсэн юм бэ? 4. торгууль багадаж байна гэж ер нь их ярьж байна. Багадаж байгаа үгүйг бас яаж мэдэж байгаа юм бэ?

Ч.Хашчулуун: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/ Эдгээр асуулт чухал асуултууд байна. 1.үнийн өсөлт болгон шударга бус

байдаггүй. Тухайбал, махны зах зээлийг аваад үзэхэд сүүлийн зургаан жилд гурав дахин өссөн байгаа. Үүнийг хоёр янзаар авч үзэж болно. Нэг талаас мал өссөнөөр махны үйлдвэрлэл ихсэж байна гэсэн дүнтэй боловч нөгөө талаас нь аваад үзвэл шат дамжлага ихтэй, зах зээлд чөлөөтэй нэвтрэх боломжгүй, борлуулалт нь тодорхой хэмжээгээр ченжүүдийн нөлөөнд автагдсан байх боломжтой гэж бид үзэж байна. 2. ямар нөхцөлд бодит үнэ байх вэ гэхээр үйлдвэрлэлийн зардал өссөн нөхцөлд компани яах аргагүй үнээ нэмнэ. Нөгөө талаас төвлөрөл өндөртэй, давамгайл байр суурьтай компаниуд үнэ нэмсэн байгаа нь хэр үндэслэлтэй вэ гэдэг нь өөр асуудал юм. Бид нэгэнт судалгаа хийж буй тул зардлыг тээвэрт, татварт гэх мэтээр үнийн өсөлтийг хэлэх боломжтой. Нэг компани үнээ хэтэрхий нэмээд байвал нөгөө нь орж ирээд унагадаг зарчимтай. Гэтэл бүгдээрээ үнээ нэмээд байх юм бол өрсөлдөөн үгүй болж магадгүй хуйвалдсан байж болох юм. Үүнийг бид тогтоох боломжгүй, чадах ч үгүй. Ийм жишээ дэлхийд бий. Витамины зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлаад их ашиг олсон том картелийг олон улс даяар эрэн сурвалжилж, хэд хэдэн компанийг олоод 850. сая ам.долларын торгууль тавьсан байдаг. Энэ мэт зүйлийг илрүүлэхийн тулд Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газарт эрх мэдлийг нь өгөх хэрэгтэй. Түүнээс биш шууд хараад шударга болон шударга бишийг ялгах боломжгүй юм. Тээврийн холбогдолтой асуултанд манай судлаач хариулна. Торгуулийн тухайд 250.000 бол их ашиг олсон компанид бага мөнгө. Тухайн компанийн зохисгүй үйл ажиллагааг торгуулиар зогсоох хэрэгтэй.

М.Уянга: /МУИС-ийн Хууль Зүйн Сургууль/ Торгуулийг яагаад бага гэж үзсэн бэ гэхээр байгууллагуудаас авсан санал тухайлбал,

“Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар”-аас судалгаа авахад зарим компаниуд энэ торгуулийг төдийлөн ойшоож үздэггүй учир шударга бус үйл ажиллагааг зогсооход нөлөөлдөггүй гэсэн юм. Нөгөө талаар цалингийн доод хэмжээ нэмэгдсэн. Бас тухайн компанийн учруулсан хохирол торгууль хоёр хороондоо зөрүүтэй байгаа тул нэг хэмжүүрээр авч үзэх нь тохиромжгүй мэт санагдсан. Тиймээс учруулж буй хохирлын хэмжээнд нийцүүлэн торгох нь зүйтэй байх.

Т.Оюунбаатар: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/ Нийтийн тээврийн салбарыг судлахдаа автобус, такси, жишээлбэл, төрийн өмчийн автобус 1, 2, 3-р парк, “Цахилгаан тээвэр” ХК-ийг хамруулсан. Бусад хувийн автобусны компанийг судалгаанд хамруулсан. Төвлөрлийн индексийг авч үзэхдээ автобус, такси хоёрыг тус тусад нь ялгаж гаргасан.

Ж.Жаргалсайхан: /Сангийн яам/ 113-р хуудсанд зөвлөмж дотор тендэрийн комиссыг Сангийн яамнаас салгъя, тусад нь байгуулья гэсэн утгатай зүйл бичжээ. Одоо тендэрийн комиссыг бүх яам болон аймгуудад байгуулж байгаа. Сангийн яаманд тендэрийн зохион байгуулах комисс байхгүй. Харин бараа үйлчилгээг худалдан авдаг газар бий. Тэр нь бодлого тодорхойлдог газар юм. Энэ газрыг тусад нь болгъё гэсэн юм уу? Энэ ямар учиртай вэ?

Ч.Хашчулуун: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/ Улсын хэмжээнд тендэр зохион байгуулах эрхтэй 4000 гаруй газар байдаг. Эдгээрийг Сангийн яамны бараа үйлчилгээг худалдан авах газар зохицуулж, хянадаг тогтолцоо бий. Үүнийг олон улсын байгууллагууд үзэхдээ Сангийн яамнаасаа салангид байсан нь дээр хэмээн зөвлөж байсан юм. Том жижиг маш олон тендэр байгааг нэгдсэн байдлаар хянах зорилгоор. Практик дээр төсвийн мөнгөөр хийгдэж буй

ажилд Сангийн яам хяналт тавьдаг. Энэ нь ч зөв байх. Гэхдээ нөгөө талаар Сангийн яамны хараат байх, үгэнд нь орох хандлага бас гардаг. Салбарын яамдууд тендэрээ Сангийн яам зөвшөөрөөгүй байсан ч мөнгө төгрөгөө хуваарилаад дуусчихсан байсан. Сангийн яамны ажлын хүрээнд тендэр байснаар нэг талаар хараат юм шиг боловч нөгөө талаар хяналт арай илүү тавигддаг. Гэвч сүүлийн үед Сангийн яам энэ тал дээр алдаад байгаа. Олон улсын практикт тендэрийн үйл ажиллагааг явуулдаг тусдаа томоохон байгууллага байдаг юм. Зарим хүн үүнийг бас нэг нүсэр байгууллага бий болох нь гэж бодож болох ч улсын төсвийн олон зуун тэрбум төгрөгийг хянах байгууллага байж, тэр нь ерөнхий сайдын мэдэлд ч байж байх нь зүйтэй байж болох юм.

О.Оморбек: /Мобиком-ын хуульч/ Зах зээлийн өрсөлдөөнтэй холбогдолтой чухал асуудлыг хөндөж ярьж байгаад баяртай байна. Өнөөдрийн илтгэлд манай компанийг шударга бус өрсөлдөөнтэй холбогдуулан жишээнд дурдлаа. Үүнтэй холбогдуулан мэдээллийн чанартай хэдэн зүйл хэлье. Үүрэн телефоны анхдагч манай компанийг шударга бусаар өрсөлдөж байна гэж жишээ татсаныг залруулъя. 17-р хуудсанд хэрэглэгчдэд 1 минутын ярианы тарифыг Unitel, Skytel компанийн хүсэлтээр хянан зохицуулах газраар хянуулахад үнийг буулгасан асуудалгүй гэж гарсан атал энд шударга бусаар өрсөлдсөн мэт сэтгэгдэл уншигчдад төрүүлэхээр бичсэн байна. Мөн 77-р хуудсанд Unitel, Skytel, Mobicom гэсэн гурван компани G-Mobile-ийг Улаанбаатарт үйл ажиллагаа явуулахад нь нөлөөлсөн. Шударгаар өрсөлдөөгүй гэжээ. Энэ бол шударга бус өрсөлдөөний асуудал биш байсан, бид шударгаар өрсөлдөө гээд тендэрийг явуулахдаа анхныхаар явуулаач гэсэн хүсэлт гаргаснаас биш, өрсөлдөөний

асуудал биш байсан. Мөн давамгай байдлаа ашиглаж нөгөөгөө шахаж байсан гэсэн утгаар манайхыг жишээнд оруулсан нь уншигчдад сөрөг нөлөө үзүүлэх талтай байна. Иймээс сайн судалж байж бичих хэрэгтэйг хэлье. Манай компани ТТ-ийн охин компани биш, тэгэхээр мэдээлэл бэлтгэхдээ тухайн компанитайгаа ирж уулзаад, судлаад үнэн зөв мэдээллийг хийх нь зүйтэй гэж бодож байна.

Ч.Хашчулуун: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/ Мобиком-ын саналыг хүлээн авч тайлбар хийе. 1. Юуны өмнө Мобиком дээр очиж судалгаа хийе гэхэд татгалзсан гэдгийг хэлэх хэрэгтэй. 2. 1 минутын тарифын тухайд хэрэглэгчдээс авсан судалгаан дээр үндэслэж хийсэн. 3. Охин компани гэдэг муу зүйл биш, хөрөнгө оруулалттай компани гэдгийг хэлсэн, тэгэхээр ТТ-ийн хөрөнгө оруулалттай компани гэж бид залруулан оруулъя. 4. Судалгааны баг хэрэглэгчдээс авсан саналд тулгуурлан судалгаагаа хийсэн учир магадгүй хэрэглэгч буруу ойлголттой, үүнийг нь компанийн зүгээс анхаарч ажиллаагүй, сурталчилаагүй, PR хийгээгүйтэй холбоотой байж болох юм.

Б.Энхцэцэг: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/. Тоон мэдээлэл, жишээ буруу байна гэж хэлж байна. Тоон мэдээллийн олдоц муу байсан. Томоохон компаниуд зөвхөн Мобиком ч биш, Петровис зэрэг компани судалгаанд оролцохоос татаглаж байсан нь бидэнд Монголын зах зээлийн өрсөлдөөний судалгаа хийхэд хүндрэлтэй байсан. Цаашид компаниуд судлаачдын ажлыг ойлгож, хамтарч ажиллавал үр дүнтэй байх болно.

Ш.Хишигсүрэн: /Хуульзүйн Үндэсний төв/ Монгол улсын засаглалын чанар гэдгийг тодорхойлжээ. Энэ юу вэ? Энэ үгийг ямар хүрээнд тайлбарлах вэ?, ямар үгийн орчуулга вэ? Тайлбар тольд засаглал гэдэг үг байдаггүй юм билээ.

Ч.Хашчулуун: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/ Дэлхийн банк 2000 оноос эхлээд улс орнуудын засаглал гэдгийг тодорхойлсон. Засаглал гэдэг нь их өргөн ойлголт бөгөөд төр засгийн сонгох, хянах процесс, төр засгийн хэрэгжүүлэх чадвар, төрд иргэдийн оролцоо гэх мэт олон зүйлээр тодорхойлсон байдаг. Энэ тодорхойлолт тайланд орсон. Засаглал гэдгийн цаад үг нь governance-/засаглал/ гэсэн англи үг байгаа монгол хэлэнд орж ирээд нилээд хэдэн жил болсон. Энэ үгийг Дэлхийн банк хэрэглэдэг. Энэ талаар судалгаа хийхдээ 6 зүйл дээр судалгаа хийдэг.

Д.Гансүлд: /СЭЗДС/ Өрсөлдөөний чанар, төгс, төгс бус гэдэг нь буцаад засаглалтайгаа холбогдож байна. Судалгааны дүнгээс харвал салбар бүрт шударга бус өрсөлдөөн байна гэж гарлаа. Тэгэхээр зөвлөмжийн хувьд санхүүгийн, хуулийн, албан бус институцийн аль нь манайд шударга бус өрсөлдөөнийг хазаарлахад чухал үүрэгтэй вэ?

Ч.Хашчулуун: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/ Аль аль нь үүрэгтэй. Хууль, түүнийг хэрэгжүүлдэг газар бүхэлдээ боловсронгуй болох хэрэгтэй тул бүхэнд хамаатай. Хуулийг сайжруулахад эрүүл өрсөлдөөн бий болно. Тэгэхээр засаглал бүгдэд хамааралтай болно.

Т.Нармандах: /Мэдээлэл харилцаа холбооны технологийн газар/ Манайх өрсөлдөөн нилээд орсон байгууллагын нэг. 1. Монополь, давамгайлалч хоёрыг ялгаж өгнө үү? Манайх жил бүр салбарынхаа давамгайлалчдыг тодруулдаг. 2. Өрсөлдөөнд үнэ чухал. Манай салбарт үүрэн телефонд шинэ оператор орж ирэхэд үнийн доод хэмжээг бусдад тогтоож өгч, үүнээс буулгаж болохгүй гэж байсан. Ингэхгүй бол хуучин компаниуд үнээ хэт буулгавал шинэ операторт хэцүү болно. Энэ талаар та нарын бодол юу вэ?

Ч.Хашчулуун: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/ Танай салбарт өрсөлдөөн сайн явагдаж, үр дүнтэй байгаа. 2006 оноос танайд шинэ компаниуд орж ирж байгаа. Өмнө нь монополь шинжтэй байсныг үгүйсгэж болохгүй, тэгэхээр шинэ компанид тэгш өрсөлдөх боломжийг олгох хэрэгтэй. Мобиком -ын хувьд удтал давамгайл байдалтай байж Скайтэлтэй мессеж хүртэл солилцдоггүй байсан, харин Юнител орж ирснээр байдал өөр болсон. 2. Тарифын хамгийн бага хэмжээг заах нь буруу, өрсөлдөөд үнээ бууруулах нь зөв.

Х.Цэвэлмаа: /МИУС-ийн Эдийн Засгийн Сургууль/ 44-р хуудсанд монополийн тухай тодорхойлолт байгаа. Монголд монополийн онцлог хоёр төрөл байна. Цахилгаан эрчим хүч гээд зайлшгүй төр оролцох шаардлагатай монополь байна. Нөгөө нь зүү тариурын үйлдвэр гэх мэт тодорхой төрлийн зохицуулалт шаардсан үйлдвэр байна. Яагаад гэвэл, жижиг нээлттэй эдийн засагт, тэр дундаа хүн амын тоо багатай, зах зээлийн багтаамж их биш манайх шиг улсад нэг удаагийн зүү тариурын үйлдвэр олон байх шаардлагагүй. Энэ хоёр зохицуулалт бүхий монополиос гадна цэвэр монополь гэж байна. Эдгээр нь зах зээл дээр патент, лицензээрээ ялгарч, давамгайл байдалтай болж байгаа тул үнийг нь хянаж зохицуулдаг. Давамгайл байдал гэдэг нь өөрийн шалгуураар гарч ирж байгаа асуудал. Манайд үйлчилж буй хуулийн заалтын дагуу тухайн зах зээлийн 1/3-ийг эзэлж байвал давамгайл гэдэг.

Н.Мягмарсүрэн /ТЭЦ-3-ийн захирал/ Би хоёр зүйл асууя.1.Нийтийн тээврийн хэрэгсэлд өрсөлдөөн алга гэлээ. Өрсөлдөөнийг яаж бий болгох вэ? Шатахуун өссөн нөхцөлд хуучин үнээрээ байх боломжгүй биз дээ. 2. Эрчим хүчний асуудалтай холбогдуулан бичсэн цахилгааны

хүчдэл, давамж тогтворгүй гэдгийг би ойлгож байна. Ялангуяа захын хороололд цахилгааны утас, холболт муу зэрэг шалтгаанаас гэрэл улайх, хүчдэл багасах үзэгдэл бий. Харин дулааны нийлүүлэлт, цаг уурын орчинд эсрэг байдаг гэдгийг ойлгосонгүй.

Д.Бямбасүрэн: /төслийн зөвлөх/ Манайд чанарын асуудал хоцорч явдаг. Энэ нь эрчим хүчний асуудалд илэрч байна. Зусланд компьютер ажилладаггүй. Гэрэлтэй л бол бусад нь хамаагүй гэж ойлгоод сурчихсан. Энэ бол дангаар ноёрхохын муу тал. Дулааны хувьд хавар гадаа 20° С –ийн дулаан болоход байрыг хэт халаадаг. Энэ мөн л зохицуулалт муугийн жишээ юм.

Х.Цэвэлмаа: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/ Монголд нийтийн тээвэр автобус, таксиний үнэ тогтоох тогтолцоонд дэлхийн туршлагын аль нь ч байхгүй. Өөрөөр хэлбэл, дэлхийн туршлагаар нийтийн тээврийн үнийг тогтоохдоо цагаар, буудлаар, таксины зарчмыг ашиглаж байхад бид эдгээрийн алийг нь ч хэрэглэхгүй байна. Тэгэхээр өрсөлдөөн гэж ярих боломжгүй. Аль чухлыг нь өнөөдөр бид сонгож нэвтрүүлэх ёстой. Автобусны үнийг 300 төгрөг болгосноор асуудлыг шийдэж байгаа юм биш. Учир нь дундаж зардал өндөр гарч байгаа тул зохицуулалт хийх хэрэгтэй. Зохицуулалт сайн хийснээр цаашдаа энэ салбарт өрсөлдөөн бий болох байх гэж бодож байна.

И.Дугармаа: /Мобиком/ Манай компанийн хувьд давамгайл компани гэж хэлүүлэх нь муу зүйл биш байх. Үүрэн телефоны салбар бол хамгийн өрсөлдөөнтэй хэсэг. Гэтэл суурин телефон гэдэг монополийн талаар ярихгүй байгаа нь сонирхолтой байна. Давамгайл байдал гэдэг нь бидэнд бэрхшээл учруулж байгааг ганц жишээгээр хэлье. Хэрэглэгч өнөөдөр чанартай үйлчилгээг

боломжийн үнээр авахыг хүсч байгаа, манайх ч үнээ бууруулахыг хүсдэг. Давамгайл гэдгээсээ болоод манайх үнээ бууруулж чадахгүй байгаагийн учир гэвэл 1 минутын эрхийг 150 төгрөгөөс бууруулах гээд харилцаа холбооны зохицуулах газарт хүсэлт тавьсан. Гэтэл маш удаж байж, сая 8 сарын 1-ээс 100 төгрөг болсон. Та нар давамгайл учир үнийг чинь хянах ёстой гээд ингэж удаасан. Үүнийг хэрэглэгч ойлгохгүй, мэдэх ч үгүй. Өртгөөсөө доогуур ороогүй бол үнийг бууруулж болох юм шиг байна билээ. Энд зөрчилдөөн гарч байна. Түрүүн зөвлөмжинд гарсан зөвхөн давамгайл биш, ижил төрлийн компаниуд нийлж зөвшилддөг байх гэсэн нь зөв юм шиг байна. Манай үнийг бууруулах асуудлыг хойшлуулж байсан нь магадгүй өрсөлдөгч компаниуд ч байсан байж болох юм. Хэрэглэгчид бол үнэ бууруулахыг л хүсч байгаа шүү дээ. Үүнийг хуулиндаа оруулмаар байна.

П.Эрдэнэжаргал: /Хурлын дарга/ Асуулт асуух хүнгүй бол саналдаа оръё. Д.Байлийхүү гуай саналаа хэлнэ үү.

Д.Байлийхүү: /ТӨХ/ 2-3 санал хэлье. Бидний өнөөдрийн ярьж буй зүйл бол зах зээлийн өрсөлдөөн оруулж, үнэ бууруулах асуудал юм. 1. Өрсөлдөөнийг яаж оруулах вэ? гэж асууж байна. Үнэ өндөр байж л өрсөлдөөн орно. Үнэ өсөхийг хорих шаардлага байхгүй, харин социализмын үед болж байсан, зах зээлийн үед бол болохгүй. Зохиомол болон зохиомол биш үнэ гэдгийг би ойлгохгүй байна. Үгийг онож хэрэглэх хэрэгтэй. Ямар үнийг бид зохицуулах вэ гэдгийг мэдэх хэрэгтэй. Аж ахуйн нэгжүүд том жижиг, давамгайл, монополь гээд янз бүр байгаа. Тэгэхээр зөвхөн монополийн үнийг л хянах хэрэгтэй, бусад жижгийг нь орхих хэрэгтэй. Төр ямар үнийг зохицуулах вэ гэдгийг сайтар бодох хэрэгтэй. Үнэ өснө гэдэг нь ирээдүйд буурна гэсэн үг. Шударга

бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газраар үнийг өсгөх ажил хийлгэмээр байгаа юм. Харин монополь, жишээлбэл, төмөр замын үнэ өсч байгаа бол зохицуулах хэрэгтэй. Түүний үнэ 40 хувь өсч байхад бид дуугүй байдаг нь буруу. Эдгээрийг ялгаж ойлгох хэрэгтэй. 2. Демпинг /damping/-ийг засаг дэмжих янзтай, үнэ буурах, демпинг хоёр ялгаатай. Демпинг өртгөөс нь албаар бууруулж байгаа үзэгдэл учир үүний эсрэг байх хэрэгтэй. Зах зээлд ганцаар үлдэх гэсэн бодлого юм. ШБӨХЗГ демпингийг шалгаж тогтоосон, шүүхэд шилжүүлсэн юм байхгүй байх, би л лав мэдэхгүй юм. Хэрэглэгч ч гэсэн үнэ буурангуут яагаад бууруулав гэдгийг сонирхох хэрэгтэй, зүй нь хүн ашиг олохын тулд нэмэх ёстой биз дээ. 3. 2007 онд Монголын эдийн засгийг бусад улстай харьцуулан үзвэл гэрван зүйлээр сайн гарсны нэг нь өрсөлдөөний бодлого байгаа. Хуучин социалист системд өрсөлдөөнийг буруу гэж үзсэн. Гэвч монголчууд одоо өрсөлдөөнийг дэмжиж, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар байгуулсан байгаа нь сайн хэрэг. Үйл ажиллагаа чадавхи нь муу байсан ч байгуулсан нь зөв. Харин дарга Жаргалсайхан нь, үнэ өсөөд бид дийлэхгүй байна гэж ярьж байсан. Энд торгуулийг нэмэхээсээ илүү зах зээлийн янз бүрийн аргыг хэрэглэх нь чухал. Улам их торгоод байвал аж ахуйн нэгжүүдэд их дарамт ирнэ. УИХ-ын гишүүн Шаравдорж энэ тал дээр төрийн оролцоог нэмье гэж хэлснийг би буруу гэж бодож байна. Учир нь бас нэг дарамт үүснэ. Судалгааны багийнхан ШБӨХЗГ-ынхантай адил үнийн өсөлтийг зохицуулах гэсэн байдалтай бичсэн байна. Судалгааны материалыг харж байхад хуулийг чангалъя, торгуулийг нэмье гэсэн санаагаар хийжээ. Энэ нь буруу тийшээ явж байгааг харуулж байна. Захиргааны аргаар бүгдийг зохицуулж болохгүй, судалгааны материалын философиог өөрчлөө.

Г.Болд: /Юнител/ Энэ уулзалтыг зохион байгуулсан хүмүүст талархал илэрхийлье. Энэ сэдэв бидэнд дутагдаж байсан. Энэ уулзалтын явцыг харж байхад диплом хамгаалаад байгаа ч юм уу, шүүх хурал болоод байгаа ч юм уу гэмээр сэтгэгдэл төрүүлж байна. Гол нь бидний зориод байгаа зүйл юу вэ? гарах гарц юу вэ гэдгийг олох хэрэгтэй байх. Зөвлөмжинд гарсан хуулийн төслийг өөрчлөө, хариуцлагын тогтолцоог чангалъя гэдэгтэй санал нэг байна. Учир нь хуульчид хуулиа барих гэхээр хуулийн цоорхойтой учир сайжруулах шаардлагатай байх, хариуцлагын тогтолцоо чанга байж хэрэгжинэ. Үүнийг ахисан түвшинд гаргахаар шийдвэртэй ажил хийж, экспертийн түвшинд хийх хэрэгтэй байна.

Ж.Жаргалсайхан: /Сангийн яам/ Нэг санал байна. Эдийн засгийн эрх чөлөө гэдэг өргөн ойлголт, ялангуяа өрсөлдөөн гэдгээ нарийвчлан зах зээлийн, аж ахуйн нэгжийн гэх мэтээр салгаж судалсан бол арай илүү байх байсан. 2. Өрсөлдөөний төлөв гэж ерөнхийлж үзэх нь таарамжгүй, манай улс шиг жижиг эдийн засагтай, хоёр хөрштэй оронд өрсөлдөх орчин бүрдэж үү гэдэг тал дээр асуудал хандуулсан бол оновчтой байсан байх аа.

З.Батболд: /Шинэ бодлогын хүрээлэн/ Эдийн засгийн эрх чөлөөг гэдгийг товч ойлгоход аливаа үйлдвэрлэл эрхлэгч, ажил олгогчид ямар нэгэн хөндлөнгийн оролцоо бага байхыг хэлэх байх. Дараагийн судалгаандаа эдийн засагт төрийн оролцоог хэрхэн бууруулах тал дээр судлан үзвэл сайн байна. 2. Үнэ буухгүй, үүнтэй яаж ч тэмцээд нэмэргүй. Учир нь 17 жилийн өмнөх ядуурлыг шийдээгүй, иргэдийнхээ орлогыг нь нэмэгдүүлэхийг анхаараагүй байна. Мөн албан татварыг нь бууруулах хэрэгтэй. Манай эдийн засаг Фрейзер сангийнхаар

нилээд ахицтай гарсан, Хэритеж сангийхаар ялгаа гараагүй, энд гарсан хоёр зүйлийн ахиц дээрээ тулгуурлан судалбал дээр байх. Өрсөлдөөн дээр Д.Байлийхүү гуайтай санал нэг байна. Үүрэн холбооны зах зээлийн өрсөлдөөн 95 хувьтай байгаа гэж гарсан нь боломжийн, харин өрсөлдөөнгүй бусад салбараа яаж өрсөлдөөнтэй болгох талаар судлах нь зүйтэй.

Ч.Хашчулуун: /МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль/ Санал хэлсэн бүх хүнд баярлалаа. Д.Байлийхүү гуайтай санал солилцоход, 1. үнэ өсөхөд нийлүүлэлт дагаж өсдөг нь зөв. Үнийн өсөлтөөс зайлсхийгээд байсан зүйлгүй. Харин нийлүүлэлтээ өсгөн үнээ бууруулах үйлдлийг яаж зохицуулах вэ? гэдэгт байна. Гурилын үнэ өсөхөд тариалангийн хэмжээ буурсан, тэгэхээр тариалалтаа ихэсгэх хэрэгтэй болно. Энэ нийлүүлэлтэнд компаниудын нэвтрэн орох чадварыг яаж өсгөх вэ гэдэг нь чухал. Үүнийг хангах хэрэгтэй. 2. өрсөлдөөнтэй компаниудыг хянахгүйгээр бусдыг хяна гэлээ. Гэтэл аль алиныг хянах шаардлага эдийн засагт байдаг. Монополиудыг зохицуулдаг, төрийн том монополиуд хяналтгүй явж буй нь үнэн. Манай судалгаанд бүх салбарыг хамруулах цаг, хүчний боломж байхгүй, сонгож авсан шалтгаанаа та бүхэнд хэлсэн. Үнийг бууруулах нь захиргааны аргаар биш, нийлүүлэлтийг өсгөх замаар хийх ёстой гэж ихэнх хүн ойлгож буй нь сайн хэрэг. Харин хүнс, шатахуун зэрэг эмзэг салбарыг зохицуулахаас өөр аргагүй тул зохицуулж байгаа. Та бүхний өгсөн саналд баярлалаа.

Д.Бямбасүрэн: /Төслийн зөвлөх/ МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн захирал, МУИС-ийн багш нар энэхүү судалгааны аргазүй боловсруулж, нилээд үл үндэстэй судалгаа хийсэн гэж бодож байна. Манай судалгаанд мэдээлэл, тоо баримтаар тусалсан

ШБӨХЗГ, хамтран ажилласан ННФ болон Б.Мөнхсоёл нартаа талархал илэрхийлье. Шударга бус өрсөлдөөн гэдэг бол зөвхөн монополийн тухай асуудал биш, зах зээлд байгаа өрсөлдөөний тухай асуудал юм. 66-67-р хуудсанд мал өсөөд байхад үйлдвэрлэл нь буураад, махны үнэ бас өсөөд байгааг бичжээ. Энэ салбарт ямар ч монопольтгүй мөртлөө ченж хэмээх панзчид гараад ирсэн. Улаанбаатарт 18 ченж махан дээр ажилладаг. Үнэ нэмэх дээр болгоомжтой хандах хэрэгтэй. Үнэ бууж болно. Компьютерийн үнэ анх 1948 онд хийж байснаасаа бенз машины үнэтэй харьцуулбал 48 цент болтлоо буурсан байдаг. Бас үнийн өсөлт болгон муу биш. Орон сууцны үнэ зохиомол хомсдолоос болоод нэмэгдлээ. Үүнийг бид шударга өрсөлдөөн гэж болохгүй. 68-р хуудсан дээр ноолуурын үнэнд Хятадын Бугат хотоос демпинг хийгээд байна. Ингэхээр өрсөлдөөн гэдэг нь харьцангуй, зах зээлийн хуулиараа явахад төр оролцохгүй бол болохгүй зүйл бас байдаг. Торгуулийг ярьж байна. Хэдэн тэрбумыг олж, хэрэглэгчдээ хохироосон бол шүүхэд өгч хариуцлага хүлээлгэх ёстой. 250.000 төгрөг өнөөдөр пальтоны үнэ хүрэхгүй мөнгө учир өгөөд хохироогоод явж бай гэсэнтэй утгатай ижил болж байна. ШБӨХЗГ-ынханд эрх хэмжээг нь өгч, ажиллуулах хэрэгтэй гэж судлаачид маань санал хэлсэн. Монгол ядуу учир хүнсний бүтээгдэхүүн хямд, бусад орны бараа бүтээгдэхүүний үнэтэй харьцуулбал тонгоруу байдаг. Энэ нь яваандаа өөрийн хуулиар засагдах биз ээ. Эдийн засгийн эрх чөлөөний талаар ННФ-оос жил бүр судалгаа хийж байгаа, дараа жилд ямар чиглэлээр судалгаа хийх вэ гэдгийг та бүхэн бодно биз ээ.

У.Батсуурь: /ШБӨХЗГ-ийн дэд бүтцийн газрын дарга/ Энэ 150-аад хуудас судалгааны тайлан хийсэн нь ач холбогдолтой, цаг үеэ олсон, манай хууль гарснаас хойш нилээд

хугацаа өнгөрсөн. Энд эдийн засгийн онолын нарийн зүйл тусгажээ. Сүүлийн үед зах зээлийн тухайд зарим нь ямар ч зохицуулалт хэрэггүй, зарим нь хэрэгтэй гэдэг. Миний хувьд зохицуулах тал дээр нь санал нэг байна. Учир нь өрсөлдөөнийг зохицуулаад дэлхий 200 гаруй жилийн нүүр үзжээ. Гадаадад торгууль өндөр байна гэж ярьдаггүй. Буруу үйлдэл хийсэн картелийг борлуулалтын орлогын 10 хүртэл хувиар торгодог жишээ бий. Мөн энэ материалд эрх зүйн талыг маш тодорхой, олон улсын түвшинд хийсэн байна. Үүнээс авах юм бидэнд байна. Бид шударга бус өрсөлдөөний талаар хуулийн төсөл боловсруулаад УИХ-д өргөн барьсантай та бүхний судалгаа таарч байгаа нь зөв зүйтэй явж байгааг харуулж байна. Манай байгууллагын тухайд хүмүүс янз бүрийн зүйл ярьж байна. Бид ийм юм хийсэн гэж ярих нь гол биш, үйл ажиллагаанаас харагдана гэж бодож байна. Үнийн зохицуулалтын талаар монополийг хянах нь зүйтэй, ноднин төмөр зам 16 зүйл дээр 5-6 дахин үнээ нэмэхээр санал ирүүлснийг бид болиулсан байгаа. Манай хуулинд давамгайл байдлаа ашиглаж, үнээ нэмж байгаа асуудлыг хэрхэхийг оруулаагүй. Алтан тариа, Эрэл цемент зэрэг нь өндөөр зах зээлд үнээ тогтоох чадвартай томоохон компаниуд, тэд 1/3 гэдэг ойлголтод багтдаггүй. НИК хавраас хойш 11 удаа үнээ нэмж байгаа нь дэндүү хөдөлгөөнтэй байгаа учир төрийн зохицуулалт хэрэгтэй. Энэ

талаар хуулинд оруулах хэрэгтэй. Цаашид та бүхнийг зах зээлийн өрсөлдөөний чиглэлээр манай байгуулагатай хамтарч ажиллана гэж найдаж байна.

Б.Оюунцэцэг: /ШБӨХЗГ үйлдвэрлэлийн хэлтсийн дарга/ Батсуурь гуай ерөнхийдөө бүгдийг хэлчих шиг боллоо. Гэвч ганц хоёр зүйл хэлье. Судалгаагаар зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, зах зээлийн судалгаа шинжилгээ, мэдээ мэдээлэл, демпинг, бирж олон зүйлийг хамруулан судалжээ. Иймээс гарсан баримт бичиг маань цаг үеэ олсон зүйл болжээ гэж бодож байна.

П.Эрдэнэжаргал: /Хурлын дарга/ Цаг заваа гарган хүрэлцэн ирж, тайлантай холбогдуулан үнэтэй саналаа өгсөн та бүхэнд баярлалаа. Судалгааны багийнхан та бүхэнтэй санал нэгдэж байгаа зүйлсийг тайландаа тусган оруулна байх. Мөн та бүхний хэлсэн саналыг бид тэмдэглэн авч байгаа, үүнийгээ судалгааны тайлангийнхаа ард бас хавсарган оруулна. Мөн бид жил бүрийн төгсгөлд ирэх жилийнхээ судалгааны сэдвийг аль чиглэлээр байх вэ гэдгээ төлөвлөдөг. Ирэх жилийн сэдэв магадгүй эдийн засагт төрийн оролцооны тухайд байж болох юм. Ялангуяа өнөө үед уул уурхай салбарт төрийн оролцоо их болж байна. Манайх шиг уул уурхайгаасаа ихээхэн хамааралтай улсын хувьд олсон жаахан мөнгөө энэ салбар руу хийгээд байх нь ямар вэ? Энэ тал дээр та бүхэн саналаа хэлээрэй. Баярлалаа. Амжилт хүсье.

Тэмдэглэл хөтөлсөн Г.Гэрэлмаа